



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 - 149
<hr/>	
1. <i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	6 - 88
2. <i>“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	88 - 149

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
5 дугаар сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 30 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Сэргэлэн, Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Ш.Раднаасэд;

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 55 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Д.Тогтохсүрэн, С.Одонтуяа, Ж.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Б.Баярсайхан, Ж.Батжаргал, Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Ц.Туваан, Ц.Сандаг-Очир, П.Анужин, Г.Мөнхцэцэг, Ч.Ундрам, О.Цогтгэрэл, Д.Өнөрболор, Ц.Идэрбат, Б.Энх-Амгалан, Г.Тэмүүлэн, Э.Батшугар нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн

нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Ганбат, Б.Баттөмөр, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	22
Бүгд:	51

56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 19 цаг 47 минутаас хуралдааныг даргалав.

Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Соёлын дэд сайд М.Батбаяр, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Хөгжлийн судалгааны газрын дарга Л.Эрдэнэбаяр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань,

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүү, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн дарга Г.Нямцэцэг, Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга Х.Эрдэнэбулган, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Улс, нийслэлийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Ариунцэцэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Замын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Энхмандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 20 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ж.Чинбүрэн, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Б.Баттөмөр, Б.Энх-Амгалан, Ж.Батжаргал, Б.Саранчимэг, П.Анужин, Б.Жаргалмаа, Ц.Сандаг-Очир, Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, Г.Ганболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Соёлын дэд сайд М.Батбаяр, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 21 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 22 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Улсын Их Хуралд 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /15:53/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяагийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуулийн 5а ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12д ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг, Г.Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Төгрөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12б ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 9а ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 12г анги, 42 дугаар сургуулийн 12а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Амарсайхан нарын урилгаар Багануур дүүргийн 1 дүгээр хорооны залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн нарийн бичгийн дарга М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 25 минут үргэлжилж, 73 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 84.9 хувийн ирцтэйгээр 22 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 5 дугаар сарын 18-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
15 цаг 30 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Өдрийн өдрийн амгаланг айлтгая.

Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байна. Асуудлыг бас нухацтай хэлэлцэж байгаа учраас удааширч байна.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудалдаа орно. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

Тийм учраас Л.Мөнхбаатар даргыг дуудаж байна. Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудал хэлэлцэнэ.

Нэгд, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулан хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэн танилцуулж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын төгсгөлттэй залгаад геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас улбаатай сүүлийн 40 жил тохиолдоогүй инфляцын дарамт урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлого зэрэг нь

манай улсын эдийн засагт томоохон сорилтыг бий болгож байна.

Гэсэн хэдий ч Засгийн газар өнгөрсөн онд экспортыг эрчимжүүлж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 2022 оны нэгдүгээр улиралд 3.9 хувиар агшаад байсан эдийн засаг оны эцэст 4.8 хувиар өслөө. Түүнчлэн 2022 онд 16.9 хувьд хүрч байсан инфляц оны эцэст 13.2 хувьд, 2023 оны эхний 04 сарын байдлаар 11.3 хувьд хүрч харьцангуй тогтворжиж байна.

Монгол Улсын Засгийн газраас сүүлийн 3 жилд хугацаа туулсан арилжааны нөхцөлтэй Засгийн газрын үнэт цааснуудыг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж ирлээ.

Тухайлбал, 2017 онд авсан 800 сая долларын “Гэрэгэ” бондын үлдэгдэл төлбөр болох 368.4 сая долларыг 2023 оны 05 сарын 01-ний өдөр бүрэн төлж барагдууллаа.

Ингэснээр 2021 оноос хойш нийтдээ тэрбум 650 сая ам.долларын өрийн зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлж үр дүнд нь өнөөдөр өрийн дефолтын эрсдэлээс бүрэн сэргийлж чадлаа.

Экспортын сэргэлт үргэлжилж энэ оны 05 дугаар сарын 14-ний байдлаар нүүрсний экспортыг өмнөх оны мөн үеэс 4.6 дахин өсгөж, 20.7 сая тоннд хүргэж чадлаа.

Экспортын голлох бүтээгдэхүүний нүүрсний тээвэрлэлт борлуулалтад үүсээд байсан хүндрэл бэрхшээлийг арилгаж, ил тод, нээлттэй болгох, ашигт малтмал тойрсон авлига, албан тушаалын

хэргүүдийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зэрэг томоохон арга хэмжээг өнгөрсөн 2022 оны сүүлээр эхлүүлснийг энэ онд эрчимтэй үргэлжлүүлж байна.

Монгол Улс анх удаа биржээр нүүрсээ амжилттай ил тод, нээлттэй арилжаалж уурхайн ам нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсийг хил нөхцөлөөр өндөр үнэтэй борлуулж эхлээд байна.

Ингэснээр байгалийн баялгийн үнэ цэнэ өсөж Монгол Улсад орох валютын урсгал нэмэгдэж байна.

Үүний үр дүнд 2022 оны нэгдүгээр улиралд 1 тэрбум ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл энэ оны нэгдүгээр улиралд 79.6 сая ам.долларын ашигтай болж улмаар 2.4 тэрбум долларт хүрч унаад байсан гадаад валютын албан нөөц энэ оны 04 дүгээр сарын байдлаар 3.7 тэрбум долларт хүрч өслөө.

Дэлхий дахинд эрчим хүчний болон хүнсний үнийн өсөлт 2023 оны эхнээс саарсан. Мөн урд хөрш цар тахлын хатуу хөл хориогоо цуцалсан зэрэг нь манай улсын экспортын голлох бүтээгдэхүүний гадаад эрэлт болон үнэд эергээр нөлөөлж байна.

Оюу Толгойн далд уурхайн үйлдвэрлэл эхэлж, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд хэрэгжих боомтын болон дэд бүтцийн томоохон төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжиж байна.

Засгийн газраас эдийн засгийг сэргээх чиглэлээр хэрэгжүүлж байгаа дээр дурдсан арга хэмжээнүүдийн үр дүнд эдийн засгийн өсөлт 2023 онд 6 хувьд хүрч, цар тахлын өмнөх 2019 оны түвшнээс өсөхөөр байгаагийн зэрэгцээ энэ оны эцэс гэхэд төсвийн орлого

төлөвлөсөн хэмжээндээ бүрэн хүрэх хүлээлттэй болж байна.

Бид эдийн засгаа сэргээх, засаглалаа сайжруулах чиглэлээр богино хугацаанд олсон амжилтаа бататган чармайж ажиллавал 2024 онд экспортыг 14.2 тэрбум долларт хүрч гадаад худалдааны ашгийг 4.3 тэрбум долларт хүргэж, эдийн засаг 6.5 хувиар өсөж, инфляц 8 хувьд хүрч тогтворжих зорилт, мөн хүлээлттэй байна.

Цаашид экспортыг нэмэгдүүлэх төслүүдэд гол анхаарал хандуулан төрөлжүүлэх, аливаа гадаадад шокоос эдийн засгийн хамаарлыг бууруулж, эдийн засгийн дархлааг бий болгох нь дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь байх болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд 2024 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 21.1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 22.9 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1.8 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьтай тэнцэж байхаар тооцож Төсвийн тогтвор хортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагууд бүрэн нийцүүлэн төлөвлөлөө.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас макро эдийн засгийн нөхцөл байдлын төсөөлөлд суурилан дунд хугацааны баримтлах төсвийн бодлогын зорилтуудыг тодорхойлох, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлт, төсвийн орлого, зарлагад баримтлах чиглэлүүдтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгжээс хуулийн төсөл нь Тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.4-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх танилцуулга.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолоор баталсан зөвлөлийн

дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж гаргасан дүгнэлт, зөвлөмжөө Төсвийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Засгийн газар үнийн өсөлтийг бууруулах талаар судалгаа хийсэн эсэх, цаашид авах арга хэмжээний талаар, мөн төсвийн төсөөлөлд хуримтлал бий болгох талаар зохицуулалт тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаа хэдий ч өрхийн бодит орлого буурч байгаа тул цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, мөн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын зардал болон Засгийн газрын өрийн хэмжээг өссөн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Хүүхдийн мөнгөний санхүүжилт болон эдийн засгийн өсөлтийг хангах, хүлээгдэж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадельхан Оюу Толгойн гүний уурхай болон Тавантолгойн уурхай ашиглалтад орсноор Монгол Улсад үзүүлэх үр ашиг, байгалийн баяллаас иргэдэд хүртээх өгөөжийн талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Засгийн газрын өрийн хэмжээг нэрлэсэн үнэ цэнээр тооцсон тооцоолол болон өрийн менежерт хийж байгаа эсэх талаар, мөн Оюу Толгойн болон Дубайн гэрээ цуцалснаар Монгол Улсад дунд хугацаанд үзүүлэх үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал баялаг бүтээгчдийн эх үүсвэрийн дэмжлэгийн болон төсвийн орлого, зарлагын тэнцлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Засгийн газрын өрийн хязгаар, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ болон зэсийн байжмалд ногдох алтны хэмжээ,

тооцооллын талаар тодруулан хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, эдийн засагт гарсан нааштай үзүүлэлтүүдийг тогтворжуулах, орлогыг нэмэгдүүлэх талаар, дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллах үр өгөөжийн тодорхой хэсгийг хуримтлал үүсгэх замаар хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжсэн эх үүсвэр бий болгоход анхаарах, мөн зах зээлийн зарчимд нийцсэн эрх зүйн шинэтгэлийг хийх нь зүйтэй гэсэн саналыг гаргасан болно.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувийн саналаар дэмжсэн бөгөөд чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жамбын Батсуурь гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Удтал үргэлжилсэн КОВИД цар тахлын дараа дэлхийн зах зээлд уул уурхайн гаралтай түүхий эдийн үнэ өссөн.

Хятадын тэг КОВИД-ын бодлого суларч, аж үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эрчимжиж, түүхий эдийн хэрэглээ нэмэгдсэн, Оюу Толгойн далд уурхайн үйл ажиллагаа эхэлж, хөрөнгө оруулалт нэмэгдсэн зэрэг нь Монгол Улсын эдийн засгийн суурь үзүүлэлтэд эергээр нөлөөлж эхэлсэн.

Гэвч уул уурхайн хараат эдийн засагтай оронд ийм таатай байдал бас удаан үргэлжлэхгүй. Удалгүй эхлэх Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн төсөв урьдын адил үрэлгэн, оновчгүй, улс төрийн оноо авахад чиглэсэн уур амьсгалтай болох төлөв бүрдэж буйг Ардчилсан намын бүлгийн зүгээс бас сануулж байна.

Сүүлийн хоёр сонгуулийн жилийн улсын төсвийн тэлэлт, ялангуяа чухал шаардлагагүй хөрөнгө оруулалтуудын ажлыг сонгуулийн жилийг угтан төсөвт суулган тууз хайчилсны горьг цэвэрлэж жигдрүүлэх гэж дараагийн парламент нь хэрхэн зүдэрч байдгийг өдгөө ч бас бүгдээрээ харсаар байна.

Ирэх сонгуулиа биш улс орноо бодож, хоноцын сэтгэлээр биш холыг харж ирэх жилийн төсвийг төлөвлөх ёстойг эрх баригч Та бүхэнд бас дахин сануулъя.

Сүүлийн жилүүдэд төсвийн орлого огцом өсөж, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 онд 21 их

наяд төгрөг болж 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2.1 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр харагдаж байна.

Жилийн дотор 2 их наядаар.

Энэ нь 2017 оныхоос огцом буюу 3 дахин тэлэхээр үзүүлэлт.

Уул уурхай давамгайлсан төсөвтэй улс орон нь дэлхийн зах зээл дээрх үнийн таатай үед хуримтлал хийхийг эрмэлздэг. Манай улс ч үүнийг анзааран төсвийн тогтворжуулалтын болон ирээдүйн өв сан байгуулж хуримтлал хийхээр хуульчилсан боловч өнөөдөр тус сангууд төсвийн алдагдлыг нөхөгчийн касс болон хувирсан.

Уул уурхай, эрдэс баялгийн үнэ өсөхөд төсвийн зардлыг огцом өсгөх нь эргээд түүхий эдийн үнэ унаж, эдийн засаг хумигдах үед ямар хүндрэл авчирдгийг нь гашуун түүхийг өнгөрсөн жилүүдэд бид бас олон удаа хамтдаа тулж өнгөрүүлсэн.

Гэвч бид үүнээсээ сургамж авалгүйгээр ирэх жилийн төсвийг 20 их наяд давсан нь их тэлэлттэй, 2 их наядаар тоологдох алдагдалтай, дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувь давсан нь хэмжээтэй байхаар тооцож байна.

Уул уурхай, эрдэс баялгийн үнэ өсөх нь эргээд түүхий эдийн үнэ унаж эдийн засаг хумигдах үед ямар их гашуун хүндрэл авч ирдгийг бид мэднэ.

Иймд нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ, зарлагын өсөлт, хөрөнгийн зардлын хэмжээг бодитойгоор тооцож, холбогдох өөрчлөлтүүдийг хийх нь зүйтэй байна.

Эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнийн савлагаа сөрсөн төсвийн

бодлого нь зарлагыг орлогоос тусгаарлаж их хэмжээний орлого орж ирсэн ч зарлагыг дагуулж өсгөхгүй байх алтан дүрэмтэй гэдгийг бид бүгд бас эргэн нэг санацгаая.

Нийт эдийн засаг дахь төсвийн төр, төсвийн оролцоо аль хэдийн 50 хувиас дээш давж энэ нь хувийн хэвшлийг багалзуурдаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхэд бул хар чулуу болон сүндэрлэж байгааг бид бүгдээрээ мэднэ.

Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог үлэмж бууруулахгүйгээр эдийн засаг сэргэж, иргэд, бизнесийн амьжиргаа дорвитой өсөхгүй нь нэгэнт тодорхой болсон зүйл.

2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 33.3 тэрбум ам.долларт хүрч ердөө 5-хан жилийн дотор улсын нийт өр 6 тэрбум доллароор нэмэгдсэн.

Монгол Улсын гадаад өр олон улсын дундаж зохистой хэмжээтэй харьцуулахад 5 дахин өндөр байгааг Олон Улсын Валютын Сан анхааруулж, Дэлхийн банк Монгол Улс хойч үедээ өр өвлүүлж байна гэж дүгнэсэн.

Хэдийгээр 21.8 тэрбум америк долларыг аж ахуйн нэгжүүдийн өр гэж буй ч үүний цаана Оюу Толгойн гэгдэх 34 хувьд ногдох өр хуульд өөрчлөлт оруулах замаар нуусан төрийн өмчит компаниудын өр, зээл Хөгжлийн банкны бонд зэрэг эдгээрт бас багтаж буйг бид мартаж болохгүй.

Энэ бүхнийг оруулан тооцвол Засгийн газрын өр та бидний мэддэг шиг 8 тэрбум доллароор тогтохгүй.

Олон улсын байгууллагууд, тэр тусмаа Дэлхийн банкнаас 2022 оны 4 сард гаргасан тайландаа Монгол Улсын Засгийн газрын өр 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 81 хувьд хүрсэн ба Хятадын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн үлдэгдэл болох 1.8 тэрбум долларыг оруулан тооцвол Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 92 хувьд хүрэхээр байна гэж дүгнэж байна.

Улсын гадаад өрийн хэмжээ нэмэгдэхэд инфляц, ажилгүйдэл өсөж, хадгаламж буурч, улсын гадаад валютын нөөцийг шавхаж, эдийн засагт чөдөр тушаа бүхэлдээ болон ирээдүй хойч үеийнхний эдийн засгийн өсөлтөөс хүртэх боломжийг хязгаарлаж байгааг бид бас хангалттай сануулсан.

Ийм ч учраас монголчууд бидний өмнө өрийн хавхнаас мултрах нэн хүнд чухал зорилт хүлээж байгаа боловч энэ нь энэ төсвийн хүрээний мэдэгдэлд огт тусгалаа олоогүй нь тун ч харамсалтай.

Өр өсөж, үр ашиггүй зардал нэмэгдэж, төсвийн төлөвлөлт оновчгүй буйн урхаг өнөөдөр төрийн албан хаагч бүрт цалингаа нэмэгдүүлэх шаардлага тэмцлийг эхлүүлж байгаагаар бас илэрч байна.

Нэгдсэн цалингийн өсөлт нь инфляцын шалтгаан болж, инфляц нь үнийн өсөлтөд эргээд цалинг нэмүүлэх шаардлага болон босож байгаа ийм үхлийн цикл өнөөдөр ч бас үргэлжилсээр байна.

Гэвч цалингийн өсөлтийг бүтээмж, чадамжтай уялдуулах бодит шийдэл бодлогын ажлууд харагдахгүй байна.

Ийм ч учраас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс ирэх оны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах асуудлуудыг анхааран үзэх ёстойг сануулъя.

Төсвийг алдагдалгүй төлөвлөж, гадаадын зээл, тусламжийг зөв зүйтэй төсөлд зориулах хөрөнгийн зардлыг бууруулах бүх шатны төсвийн зарцуулалтыг үр ашгийг дээшлүүлэх замаар төсөвт ирэх ачааллыг богино, дунд хугацаанд эрс бууруулах шаардлагатай байна.

Төр, төсвийн эдийн засаг дахь оролцоог үлэмж бууруулж нийгмийн салбарын хувьчлалыг эхлүүлэн улсын үйлдвэрийн газар, компаниудын үр ашгийг дээшлүүлэх зөв менежментийг нэвтрүүлэн ажиллах зэрэг ажлуудыг анхаарах шаардлагатай байна.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танд баярлалаа.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуулийн 5-ын ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүүхэд багачууд Та бүгддээ хичээл сурлагын өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгальмаагийн Одонтуяа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгье.

Г.Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байгаатай холбогдуулаад хэдэн анхаарах асуудал байгаа юм. Тодруулга авдаг юм билүү.

Нэг дэх асуудал нь, яг төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоогүй ч байж мэдэх юм. Сая хөдөө орон нутагт ярихад хөдөөгийн иргэд л яриад байгаа юм даа.

Ж.Ганбат дарга аа, энэ арилжааны банкнаас малчид зээл авахаар арилжааны банкнууд заавал малчдыг нөгөө малын индексжүүлсэн даатгалд заавал хамрагд гэж шахаад ингээд хамруулаад байна гэдэг асуудал яриад байх юм.

Ингэх заавал шаардлага байна уу? Арилжааны банкнаас малчид зээл авахлаар.

Нөгөө талдаа энэ малын индексжүүлсэн даатгал чинь сайн дурын даатгал биз дээ?

Тэгээд сайн дурын даатгалд хамрагдаж байгаа иргэдийг заавал зээл авахаар малын индексжүүлсэн даатгалд хамрагд гээд заавал хамруулаад байх юм.

Тэгээд дараагаар нь малын индексийн даатгалынх нь дагуу нөхөн төлбөр авна гэхээр сумын хэмжээгээрээ 6, 7 хувийн хорогдол гараагүй учраас гээд нөхөн төлбөр олгодоггүй. Тэгсэн атлаа зээл олгохоор заавал малын индексийн даатгалд хамрагдуулаад байх юм гэж нэг асуудал яриад байх юм.

Хоёр дахь асуудал. Зах дээр жижиг бизнес хийж байгаа, худалдаа эрхэлж байгаа иргэд ийм нэг зүйл байнга яриад байх юм.

Татварын тухай хуульд өөрчлөлт ороод нөгөө орлого нь тодорхойлох боломжгүй иргэд гээд татварынхаа хөх дэвтрээр татвар төлдөг байсан. Одоо больчихсон.

Тэгээд одоо энэ жижиг бизнес хийж байгаа, жижиг худалдаа эрхэлж байгаа иргэдийг заавал тайлан гарга гэж шахаад байх юм. Малчид ч гэсэн адилхан.

Тэгэхээр үүнийг заавал ингэж тайлан гаргах шаардлага байна уу, үгүй юу. 50 саяас доош НӨАТ төлөхгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр 50 сая хүрэхгүй байгаа борлуулалтын орлоготой жижиг бизнес, худалдаа эрхэлж байгаа иргэд, малчдыг

заавал тайлан гарга гэдэг ийм шаардлага тавиад байх юм. Үүнийг болиулаач гээд яриад байгаа юм. Үүнийг би өчигдөр Сангийн сайдтай ярьсан. Тийм юм байхгүй дээ. Зүгээр 50-аиас дээш байгаа байх гээд байгаа юм. Үүнийг нэг тайлбарлаад өгөөч. Ер нь заавал тайлан гарах шаардлага байна уу, үгүй юу?

Гурав дахь асуудал, арилжааны банкнуудтай бид бас яримаар байгаа юм. Засгийн газраас ч яримаар л юм шиг байгаа юм.

Орон сууцын зээл ч гэсэн тэр, цалингийн зээл ч гэсэн авсан иргэд тодорхой 2 жилийн хугацаатай хамт бол 2 жилдээ тэнцүү хуваагаад 5 сая төгрөгөө төлнө гээд график тохироод хуваарийнхаа дагуу төлдөг зээлээ. Тэгээд төлөхөөр ерөөсөө үндсэн зээлийг нь ерөөсөө барагдуулахгүй. Зээлийн хүүг нь барагдуулчихаад тэгээд үндсэн зээл барагдахгүй, үндсэн зээл төлөгдөхгүй яваад байх юм. Энэ чинь зээлтэй иргэдийг санхүүгийн хүндрэлд оруулах юм гэдэг зүйл их яриад байгаа юм.

Тэгэхээр зээлийн төлөлтэй холбоотой асуудлыг Сангийн яам Монголбанктай яриад тодруулах, боловсронгуй болгох, чирэгдэлгүй болгох асуудлууд.

Би ирээд Монголбанкныхантай ярьсан. Монголбанкны зээл төлөлтийн нэг журам гаргасан байгаа. Тийм юм байхгүй дээ. Яг л 2 жилийн хугацаатай авсан бол авсан зээлээ 24 сардаа хуваагаад л тэгээд сард оногдох үндсэн зээлийнхээ төлбөрийг, сард оногдох хүүг нь төлөөд байгаа гээд байх юм.

Тэгэхээр иргэд бол үгүй ээ. Үндсэн зээлийг ерөөсөө хасдаггүй. Зөвхөн зээлийг нь төлүүлээд байдаг.

Ингээд үндсэн зээл хэвээрээ байдаг гээд байх юм. Ийм нэг асуудал.

Дөрөв дэх асуудал. Хөдөө иргэдтэй уулзахаар ерөөсөө яах вэ, бага ч гэсэн цалинтай, тэтгэвэртэй улсууд нь бага гэж чамлаад байгаа ч гэсэн бас амьжиргаа нь болоод л байгаа юм байна. Бас арай дээр байна.

Ерөөсөө ажил, орлогогүй 30-аас 50 насны хооронд байгаа иргэд байна. Ажил байхгүй, орлого байхгүй, цалин байхгүй, тэтгэвэр байхгүй. Ийм суманд байгаа ерөөсөө 30-аас 50 насны иргэдийг нэг орлоготой болгох, байнгын ажлын байртай болгох, байнгын орлоготой болгох дээр анхаарахгүй л бол. Энэ улсуудын амьдрал маш хүнд байна гэсэн ийм дөрвөн асуулт байх юм.

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзоригийн асуултад хариулъя.

Тийм. Ойрдоо Засгийн газрын хуралдаанаа та уг нь таслаагүй суугаад л байгаа шүү дээ. Тийм. Та бид хоёр цуг энэ төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн барьсан байгаа.

Таны сая асуусан асуулт дотор Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой нэг ч зүйл байхгүй байна.

Та наад асуултууддаа бүгдэд нь өөрөө Засгийн газрын өмнөөс иргэд сонгогчдодоо хариулах бүрэн боломжтой.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Тийм ээ. С.Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Би Засгийн газрын гишүүнээ мэдэж байна л даа. Засгийн газраас өргөн барьсан төслөө ч мэдэж байна.

Тийм учраас би яг энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой юм асуухгүй, яриагүй шүү дээ.

Гишүүд бүгдээрээ хөдөө яваад л ирсэн. Хэдийгээр Засгийн газрын гишүүн ч гэсэн Их Хурлын гишүүнийхээ хувиар энэ хөдөөгийн иргэдийн ярьж байгаа санал бодлыг чинь уламжлах, яг Сангийн яамны бүрэлдэхүүн орж ирсэн учраас бас санал бодлоо хэлэх эрхтэй шүү дээ.

Тэгээд юм л бол Засгийн газрын гишүүн юу ч дуугарч болохгүй гээд ингээд бас мянган үгний таглаа гэдэг шиг ийм юм байж болохгүй шүү дээ. Сайд нар.

Би бол тэр Монголбанктай тэр зээлтэй холбоотой асуудал, тэр малын индексжүүлсэн даатгалтай холбоотой асуудлыг Сангийн яам, санхүүгийн бодлого барьж байгаа яам ярих л хэрэгтэй шүү дээ.

Тэгэхээр Засгийн газрын гишүүн өөрөө ийм юм ярилаа гээд далимдуулаад байж болохгүй шүү дээ. Тодорхой хэмжээгээр энэ чинь төсөв, санхүүгийн бодлого барьж байгаа газар. Энэ иргэдийн яриад байгаа юманд чинь хариулт, тайлбар өгөх хэрэгтэй шүү дээ.

Л.Мөнхбаатар: Яах юм. Тодруулгад хариулах юм уу? Засгийн газрын гишүүд хоорондоо ингээд бие биеэсээ асуулт асуугаад яваад байдаг.

Д.Ганбат гишүүн өмнөөс нь хариулах юм уу. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр би горимын чанартай юм хэлэх гээд байгаа юм. Сая Улсын Их Хурлын гишүүн тойрогтоо явсан. Бид бүгдээрээ явсан.

Тэгэхээр болдог бол яаралтай Улсын Их Хурал нэг тусгай чуулган хийхгүй бол болохгүй байна гэж би хэлэх гээд байгаа юм.

Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар, холбогдох байгууллагууд сууж байгаад өнөөдрийн тулгамдаад байгаа асуудлуудыг нэг бүрчлэн ярьж ямар гарц шийдэл байх юм бэ. Богино хугацаанд авах арга хэмжээ, шийдлээ гаргамаар юм шиг санагдаад байна шүү дээ.

Бодит байдал дээр энэ өвөл хөдөө орон нутагт өвөлжилт хүнд, хавар маш айхтар зутруу сунгуу их зүтгүүлж. Одоо ч зун болоогүй байна шүү дээ. Өвс ногооны бараа харахаа байсан ийм байдалтай байх юм.

Дээрээс нь цалин, тэтгэвэртэй холбоотой асуудлууд байна. Цалин, тэтгэвэр асар их зөрүү гарчихсан. Ноднингийн тэр тэтгэврийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд чинь улсад 30, 40 жил боловсрол, эрүүл мэндийн бусад салбаруудад ажиллаж байсан ажиллагсдын тэтгэвэр бол үндсэндээ доошоо орчихсон ийм зөрүүтэй байдлууд гарчихсан.

Гэтэл нөгөө талд нь улсад огт ажиллаагүй мөртлөө тэтгэвэр нь 500 мянгад хүрчихсэн ийм нэг зөрүү байгаад байна. Төрийн албан хаагчдынх ялгаа байхгүй.

Тэгэхээр зэрэг давын өмнө энэ зөрүүг яаж арилгах юм, цалин, тэтгэвэр хоёрыг яаж нэмэх юм.

Цаашлах юм бол энэ бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой. Улсын Их Хурал өмнө нь бид шийдвэр гаргасан шүү дээ. Гурван гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг барина, тогтворжуулна гээд хууль, бодлого гарсан.

Гэтэл бодлын амьдрал дээр чинь хуулийн хэрэгжилт тун хангалтгүй байна. Ганцхан жишээ хэлэхэд гурилын үйлдвэрүүд чинь гурилынхаа үнийг нэмчихсэн. Ер санаа зовох юм байхгүй сууж байна шүү дээ.

Үүнийг хянадаг, шалгадаг ийм байгууллагууд байна уу, үгүй юу?

Засгийн газар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлж байгаа бодлого бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой асуудлыг нэг удаагийн төр аргацаасан байдалтай, дотаци хэлбэрээр аргацаахыг оролддог. Гэтэл аж ахуйн нэгж, байгууллагууд чинь бүр сүүлдээ амташчихсан. Хэдхэн компаниуд улсаас, Их Хурлаас шийдвэр гаргаад дотаци өгөхийг нь хүлээгээд гацаагаад сууж байдаг ийм нөхцөл байдалтай байна.

Тийм учраас миний хэлэх гээд байгаа санаа бол онцгой, тусгай хуралдаан чуулган хийгээд. Энэ чинь их ард түмнийг төлөөлсөн бага ард түмэн Улсын Их Хурал байж байгаагийн хэрэг юу билээ дээ.

Ингээд Засгийн газартайгаа. Би хэлж байна шүү дээ. Ерөнхийлөгчтэй. Хамаагүй. Ингээд ойрын хугацаанд авах ямар арга хэмжээ байгаа юм, ямар

боломж нөхцөл байгаа юм. Энэ тэтгэвэр, цалинг нь нэмэгдүүлэхтэй холбоотой, энэ бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг зохицуулахтай холбоотой, энэ хүндэрсэн асуудлуудыг нэг шийдэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авмаар юм шиг ийм юм санагдаад байх юм.

Үүнийг би Их Хурлын даргад, Их Хурлын хуралдаан, чуулганыг даргалж байгаа дэд даргад би хандаж хэлээд байна.

Би бас өчигдөр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороон дээр энэ саналаа би хэлсэн. Даргын зөвлөл үүнийг бүр энэ онцгой анхаарч та нар минь ярилцаач гэж ийм л санал байна. Надад асуугаад байх юм байхгүй. Баярлалаа.

Л.Мөнхбаатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн санал хэллээ. Одоо Баагаагийн Батгөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Батгөмөр: Монгол Улсын төсөв, 2024 оны төсөв орж ирж байна.

Манай эдийн засаг хоёр хөршөөс хамааралтай.

Чимээгүй байгаарай. Хөөш. Та нар. Би яриадахъя.

Хоёр хөршөөс хамааралтай. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засаг 2024 онд 5 хувь, Оросын Холбооны Улсын эдийн засаг 2.2 хувь, Америкийнх 1, Европын Холбоо 1.6 гээд ийм тооцооллыг Олон Улсын Валютын Сангаас гаргасан юм байна.

Нэг юм яримаар байна. Та нар боль л доо.

Ингээд энэ дэлхийн эдийн засагт гарч байгаа эерэг нөлөөнөөс хамаараад

түүхий эд экспортлох манай улсын хувьд бас эерэг ийм нөлөө гарах нь.

Манай эдийн засаг 2024 онд 6.5 хувь байх нь. Энэ бол их өндөр өсөлт. Бүгд Найрамдах Хятад Ард Улсад л ийм өсөлтүүд гарч байгаа.

Харамсалтай нь манай энэ өсөлтүүд нэмэгдсэн өртөг дээр суурилдаггүй дандаа үнийн өсөлтөөр илэрхийлэгдээд байгаа. Бүтээмж, эдийн засгийн хүртээмж, өгөөж улсад, ард түмэндээ байдаггүй. Ийм л байгаа юм л даа.

Манай эдийн засагт 2024 онд их олон эрсдэлүүд байгаа. Энэ эрсдэлүүдээс хоёр том эрсдэл байгаа.

Нэгдүгээрт нь, инфляцын эрсдэл байгаа.

Хоёрдугаарт, нь дефолт гэдэг юм байгаа. Дефолтоос бүрэн гараагүй байгаа шүү. Үүнийг хэлэх нь зүйтэй гэж.

Манай эдийн засгийн өсөлт 4 дүгээр сард 7.9 хувь байгаагаас 5.3 хувь нь шууд уул уурхайтай холбоотой байгаа. 2.6 хувийн өсөлт нь уул уурхайн бус. Тэгэхдээ уул уурхайгаас хамаарч өсөж байгаа.

Бүтээмж тэг байгаа. Өрхийн орлого эхний 4 сарын байдлаар 3.9 хувиар буурчихлаа. Эдийн засаг таагүй байна.

Нэгдүгээр асуулт. Эдийн засгийн өсөлтийг 6.5 гэж байгаа. Энэ өсөлтийн хэдэн хувь нь уул уурхайд хамаарч байна, хэдэн хувь нь уул уурхайн бус байна бүтээмжийн өсөлт нь хэд юм.

Эдийн засгийн өсөлтийн мөн чанар ард түмнийхээ сайн сайхны төлөө

байдаг. Гэтэл манайд энэ шинж чанар ер нь ямархуу байдалтай байна? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт, энэ төсвийн орлого маань нэлээн сайн даваад биелээд яваад байдаг. Одоо өөрөөр хэлбэл төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.1 их наядаар ашигтай гарчихлаа шүү дээ. Эхний 4 сард.

Өнгөрсөн оны мөн үеэс 1.9 их наядаар давчихсан. Энэ бол Эрдэнэс Тавантолгойд гарсан өөрчлөлтөөс л ингэж байгаа. Баялгийн менежментээ зөв хийсэнтэй холбоотой.

2023 оны эхний 4 сард төсвийн орлого 7.1 их наяд төгрөг байгаа. 2023 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл 21.3-аас 22 их наяд төгрөг болохоор байгаа юм.

Гэтэл 2024 оны төсвийн хүрээний мэдэлд 21 гээд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээсээ бууруулж орж ирж байгаа.

Эхний 4 сарын байдлаар чинь үндсэндээ 20-иод сая тонн нүүрс экспортоллоо шүү дээ. Яг энэ гүйцэтгэлээрээ цаашаа явна гэх юм бол оны эцэст энэ чинь бараг 60-аад сая тонныг энэ жил экспортолчих боломж гарч ирж байна шүү дээ.

Гэтэл 50 сая гэж байх юм. Тэгээд яагаад ингэж энэ байж байгаа боломжоос ингэж дутуу төлөвлөж орж ирдэг юм бэ? Монгол Улсын хөгжлийн потенциал чинь асар өндөр шүү дээ.

Ард түмний амьдрал байна. Монгол Улс хөгжихгүй байна. Ирээдүйгээ сайн яагаад харахгүй байгаа юм бэ?

Мөнгөнийхөө бодлоготой яаж явж байгаа вэ? Яаж уялдаж байгаа вэ?

Мөнгөний бодлого маань хараат бус байх ёстой.

4 сард 3.7 их наяд төгрөг их хүндрэлтэй болчихсон байгаа. Хугацаа хэтэрсэн. Энэ нь нөгөө “М2” мөнгөний чинь 15, 16 хувь руу.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсэг үү? Б.Жавхлан гишүүн, Сангийн сайд хариулаад, дараа нь ажлын хэсэгт нэмж хариулж болно. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Б.Баттөмөр гишүүний төсөвтэй холбоотой асуултуудад хариулт өгье.

Ийм байна. Тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг та сая 4 сарынхаар нь хэлэв үү дээ. 1.1 их наяд давсан гээд. Энэ жоохон зөрүүтэй тоо харсан юм шиг байна шүү.

Үндсэн тэнцэл маань одоо 1.1 их наядын нэмэхтэй явж байгаа юм.

Өнгөрсөн онд бид энэ жилийнхээ 4 сарыг төлөвлөхдөө 320-иод тэрбумын хасахтай явна гэж төлөвлөж байсан бол одоо ингээд 1.1-ийн нэмэхтэй явж байгаа гэсэн үг. Яг тэнцвэржүүлсэн орлого бол 344 тэрбум төгрөгөөр давсан яваа.

Тэгэхээр үүнийхээ зөрүүгээр үндсэн тэнцэл маань 1.1-ийн зэрэгтэй явж байгаа юм.

Тэгэхээр бид орлого маань 344-ийг нэмэхдээ давсан. Зардал бид хэмнэлттэй явж байгаа юм. Хэмнэлттэй явж байгаа. Өөрөөр хэлбэл төсөвлөсөн зардлаасаа бид 1.3 их наядыг хэмнэлттэй явж байна гэсэн үг.

Энэ бол дараагийн 2, 3, 4 дүгээр улиралд, ялангуяа сүүлийн хагас жилд гүйцэж гардаг ийм зардлууд байгаа.

Тийм учраас тийм том тоо байхгүй шүү.

Тэгэхээр яах вэ, энэ жилийн эхний хагаст бид өнгөрсөн оны сүүлийн улирлуудад орлого маань бас гайгүй өссөн. Эдийн засаг тогтворжих энэ хандлагуудаа хадгалж чадаж байгаа. Гэсэн хэдий ч бас гадна талд биднээс шалтгаалахгүй эрсдэлүүд байсаар байгаа.

Тухайлбал, эхний 3 сард ер нь сард дунджаар бид 5 сая тонн руу дөхөөд дөхөөд ингээд нүүрснүүд гаргаж байсан бол 5 сард эхний хагасаар уг нь өмнөх саруудтай харьцуулахад 2.5 сая тонн тэр гарчих байсан бол одоогоор 1.4 гээд.

Ингээд бас урд хилүүд дээр биржтэй холбоотой гээд бас нэг жоохон ийм саатлууд гараад буурч байна. Мөн гадна талд байгаа үнэ маань биднээс шалтгаалахгүй бас буурч байна. Бирж дээр бид 180-аар зарж эхэлж байсан бол нэг сард сүүлийн арилжаанууд 150-иас доош орох гээд ийм бас хэлбэлзэлтэй эрсдэлүүд байна.

Тэгэхээр жилийн эцэс рүү яаж гарахыг одоо хэлэхэд арай эрт байгаа юм.

Зүгээр эхний хагас жилийнхээ энэ тогтворжсон байдлыг бид сүүлийн хагас жилдээ хадгалаад явах л их чухал ийм зорилттой ажиллаж байгаа.

Ирэх жилийнхийг та ярьж байна. Ирэх жилийнхыг та хэлэхдээ энэ оны төсөөлөлтэй харьцуулж хэлэх шиг боллоо. Түүнээс биш энэ жилийн яг батлагдсан хязгаар маань 19 их наяд, 2024 оны төлөвлөсөн хязгаар орлого нь

21.1 гээд. Ингээд 2 их наядын өсөлттэй байгаа юм.

Эдийн засгийн хөгжлийн яамтай болсных томоо макро тоо, макро тэнцлүүд, гадаад худалдаатай холбоотой тоонуудаа бүхэл бүтэн яам энд төлөвлөдөг, төсөөллүүдээ хийдэг.

Бид тэндээс тоогоо аваад. Тухайлбал, 2024 онд 50 сая тонн нүүрсийг гаргаж чадна гэсэн байгаа. Мэдээж энэ 50 сая тонн нь бол биет хэмжээ. Үнэ бас ямар байхыг бид шууд тооцоолж биднээс шалтгаалахгүй зүйл.

Судлаад авдаг аргачлалаараа сүүлийн 20 жил дараагийн 3 жил гээд бид тэнцвэржүүлсэн үнээ авахад орж болох орлого нь 21.1 и их наяд гээд энэ бол хязгаар тоо байгаа юм. Хязгаар тоо. Эндээс орлогын хувьд бид давж биелүүлчхэж болно.

Үүнээс шалтгаалаад биет хэмжээ нь гарсан хэдий ч бас дутах эрсдэлүүд ч бас байгаа.

Мөнгөний бодлого харьцангуй маш сайн. Ийм классик агуулгаараа бид нийцэж явж байгаа гэж үзнэ.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу? Тийм ээ. Би зочин танилцуулъя. Дараа нь Шадар сайд нэмж хариулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12-ын Д ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сурагчид Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Би 1 дүгээр сургуульд Б.Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя.

Монгол Улсын Шадар сайд,
Эдийн засгийн хөгжлийн сайд
Ч.Хүрэлбаатар хариулья.

Ч.Хүрэлбаатар: Б.Баттөмөр
гишүүний асуултад хариулья.

Ирэх жил төсөөлсөн эдийн засгийн өсөлт 6.5 хувь байна гэдэг. Энэ хэр бодитой вэ гэдэг асуулт байна.

Тэгэхээр үүнийг бид нэлээд сууж байгаад л төсөөлсөн.

Нэгдүгээрт нь, Олон Улсын Валютын Сан 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2.8 хувиар өснө гэж үзсэн. 2024 оны эдийн засгийн өсөлтийг 3 хувиар авсан байж байгаа.

Тэгэхээр юу ч гэсэн дэлхийн эдийн засгийн байдал нь 2023 оноосоо илүү сайжрах юм байна гэдэг ийм нэг үндэслэл.

Хоёрдугаарт нь, экспортын хэмжээг нэмэгдүүлснээрээ бид эдийн засаг өсгөх бүх боломжийг бүрдүүлж өгч байна гэж үзэж байгаа.

Экспортыг нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн экспорт байна. Уул уурхайн экспорт дээр хувь нэмрээ оруулах нь боомтын шинэчлэлийн арга хэмжээнүүд байна. Хил рүү явсан хоёр ч төмөр зам байна.

Дараагийн зүйл бол уул уурхайн бус экспортын хэмжээнүүдийг нэлээд нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авъя гэж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр ер нь л энэ бизнес эрхлэгчдэд учруулдаг элдэв бусын хориг, саад бэрхшээл, хүнд суртлыг багасгая л гэж байгаа.

Ерөөсөө энэ засгийн гол зорилго бол тэр янз бүрийн зөвшөөрлүүд байдаг

бол үүнийгээ цахим болгоё, тоо хэмжээг нь буулгая. Энэ зөвшөөрлүүдийг авахад шаардлагатай цаг хугацааг бууруулья гэдэг ийм арга хэмжээнүүдийг авч байгаа юм.

Тухайлбал, хөдөө аж ахуйтай холбоотой, ялангуяа манай экспортыг дэмжсэн бодлогуудыг илүү саадгүй, нээлттэй, хялбар болгож байгаа энэ арга хэмжээнүүд нь өөрөө эргээд эдийн засагтаа эерэг нөлөө үзүүлнэ ээ гэж тооцож байгаа.

Дараагийн зүйл. 6.5 хэр бодитой вэ гэхээр 2024 оны эдийн засгийн өсөлтийг тооцсон бусад байгууллагуудын дүнг л хэлье гэж бодож байна.

Дэлхийн банк 2024 онд Монгол Улсын эдийн засаг 6.8 хувиар өснө гэж байгаа.

Манайх чинь 6.5 байна шүү дээ. Дэлхийн банк 6.8 гэж байгаа. Азийн хөгжлийн банк 6.1 гэж байгаа. Олон Улсын Валютын Сан 5.5 гэж байгаа. Европын сэргээн босголтын банк бол бүр 7.5 хувиар Монголын эдийн засаг өснө гээд илүү өөдрөг үзсэн байгаа.

Тэгэхээр манай тооцоо бол тийм бодитой тооцоо гэж бид үзэж байгаа гэдгийг хэлье.

Дараагийнх нь, Оюу Толгойн зэсийн агууламжуудын талаар бас асуусан. Тэгээд би энэ дээрээс энэ тоонуудыг хэлээд өгчихье гэж бодож байна. Зэсийн Оюу Толгойн хоёрдугаар үе шатын үйлдвэрлэл, баяжмалын үйлдвэрлэл, агууламж бол нэмэгдэнэ.

2023 онд зэсийн агууламж 24.4 байсан бол 2024 онд 28.2 хувь болж өсөж байгаа. 2025 онд 28.6 болж өсөж

байгаа. 2026 онд 30.3 хувь болж өсөж байгаа.

Алтны агууламжийнх нь хувьд 2023 онд 7.3, 2024 онд 7.9, 2025 онд 11.7 болж өсөхөөр байгаа.

Тэгэхээр Оюу Толгой гүний уурхай нь ажиллаад эхэлчихсэн. Тэгээд илүү агууламж сайтай ордоо олборлож эхлэх учраас бас энэ элсэлтэд эергээр нөлөөлнө гэсэн ийм тооцоотой байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Миний түрүүн хэлсэн асуудал статистик мэдээнээс би асуусан шүү.

Өнгөрсөн 4 сарын гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.1 их наяд төгрөгийн ашигтай гарсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулах юм бол 1.9 их наяд төгрөгөөр илүү байгаа гэсэн ийм статистик гарсан байна лээ. Үүнийг би асуусан юм.

Дараагийн асуудал, Засгийн газрын өрийн асуудал байна. Энэ хоёр сайдын хэн нь хариулах юм байгаа юм. Энэ 31.9 их наяд төгрөг өнөөгийн үнэ цэнээр шилжүүлснээр 27.7 их наяд төгрөг гэж байгаа юм. Энэ дотоодын нийт бүтээгдэхүүний 2024 онд 51.9 хувь гэж байгаа юм.

Сүүлийн үед энэ паблик өр буюу төрийн өр гээд нийтэд нь авч үздэг болчхож. Энэ төрийн өмчтэй компаниудыг оруулаад. Ер нь ийм статистик манайд байна уу, үгүй юу?

Миний тооцож байгаагаар үүнийг аваад үзэх юм бол дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 70, 80 хувь давхар

байгаа. Олон улсын судалгаагаар төрийн өр 60-аас 70 хувьд хүрвэл эдийн засгийн хүртээмжтэй.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Б.Баттөмөр гишүүний асуултад хэн хариулах вэ? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Б.Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя.

Тэгэлгүй яах вэ. Би тэр тооцоолол дээр, ялангуяа бид эрсдэлийн менежмент талаасаа бүх өрүүдийг аль болох Засгийн газарт эрсдэл учруулж болзошгүй бүх өрүүдийг л нэрлэж тооцдог. Ялангуяа тэр нэрлэсэн үнэ, өнөөгийн үнэ цэнэ, бүгдэнгээр нь л бид тооцдог. Өнөөгийн үнэ цэнээр ч гэсэндээ бид эрсдэлээ тооцоод тэгээд бид 2022 онд буюу өнгөрсөн жил батлагдсан ойрын 3 жилийн өрийн удирдлагын стратегиа бид баримтлахдаа, сахилга баттай явахдаа хамгийн эрсдэлтэй цэгээр нь л тооцдог.

Тэгээд энэ зарчмаа хэлчихлээ. Би тэгээд танд тоонуудаа хэлье.

Улсын секторын өр. Таны асуусан. 39.9 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 67.4 байгаа юм. Тийм. Та яг зөв асуусан. 67.4. Үүн дотор Засгийн газрын үнэ өнөөгийн үндсэнээр 27.7 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 50.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Төрийн өмчийн хувьцаат компаниудын өр цэвэр дүнгээр 7.9 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 15 хувь байгаа.

Л.Мөнхбаатар: Одоо Монгол Ардын намын бүлгийн дарга

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа.

Тэгэхээр яах вэ, энэ 2023 он гарснаас хойш экспорт, импортын хязгаарлалтууд тавигдаад экспорт, импорт сэргэсэнтэй холбоотойгоор сүүлийн үед эдийн засгийн өсөлт гарч байгаа сайн талууд байгаа.

Энэ нь голдуу уул уурхай дээр түшиглэсэн ийм эдийн засгийн өсөлт явж байгаа юм. Хамгийн гол юм сая бид тойрогтоо очиж ажиллаа. Манай иргэдийн хувьд тавьж байгаа хамгийн чухал юм энэ үнийн өөрчлөлт байгаа юм. Өргөн хэрэглээний барааны үнэ бол асар их өндөр өссөн. Зарим нь 100 хувь өссөн.

Яах вэ импортоос хамааралтай барааны хувьд бас ойлгож болох юмнууд бий.

Гэтэл дотооддоо үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийн үнэ маш өндөр үнээр өссөн юм. Тухайлбал, гурилын үнийг ярьж байгаа юм. Гурилын үнийг.

Тэгэхээр манай улс энэ үнийн өсөлт дээр хийсэн судалгаа байна уу? Тухайлбал, үнийн өсөлт ханшаас хамаараад байгаа юм уу, нийлүүлэлтээс хамаараад байгаа юм уу, импортоос хамаараад байгаа юм уу, тэвэр, ложистикоосоо хамаараад байгаа юм уу? Энэ дээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гээд хянадаг, бодитой эсэхийг нь тогтоодог газар байна.

Засгийн газраас энэ чиглэлээр яг тодорхой авсан арга хэмжээ байна уу? Арга хэмжээ аваад тэр дагуу ийм ийм үнүүд дээр үндэслэлгүй нэмэгдсэн гэж үзэж байгаа гэсэн тодорхой тоо баримт

байна уу? Би үүнийг нэгдүгээрт нь асууя гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь, Б.Жавхлан сайд аа, 2024 онд хамгийн чухал юм инфляц өсөөд, үнийн өсөлт гарчихсаны дараа иргэдийн орлогын асуудал байгаа юм.

Тэгэхээр 2024 онд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг ямар хэмжээнд яаж нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа вэ гэдэг асуудал байгаа юм. Бид 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа учраас.

Гурав дахь асуудал. Зээлийн хүүтэй холбоотой асуудал байгаа юм.

Би Эдийн засгийн хөгжлийн сайдаас асуух гэж байгаа юм. Өнөөдөр зээлийн хүү их өндөр байгаа юм. Энэ мэдээж бодлогын хүүтэй холбоотой. Бид бодлогын хүүг 13 орчим хувь дээр бариад байж байгаа.

Тэгээд 2023 онд бодлогын хүүг бууруулах, зээлийн хүүг бууруулах чиглэлээр ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?

Бизнесийнхэн, тэр дундаа хөдөө орон нутгийн бизнесийнхэн зээлийн хүү дээр бас нэлээд хэмжээний реакцтай байгаа юм. Өндөр байна гээд. Энэ чиглэлээр 2023 онд ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Дөрөв дэх нь, ханшийн асуудал байгаа.

Яах вэ сүүлийн үед экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор ханш жаахан сулрах, валютын нөөц нэмэгдэж байгаа сайн тал байна. 2024 онд ханшийг ер нь хэдээр тооцож байгаа вэ? Одоо ямар хэмжээнд буурна гэж үзэж

байгаа юм бэ гэдэг дөрөв дэх ийм асуудал байна.

Тав дахь нь, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөр дүгнэлт гаргасан байгаа юм. 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр.

Энэ дээр хамгийн чухал юм юу байна вэ гэхээр манай дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтийн цонхны үе нээгдэж байна. Цонх үе дээр та нар хуримтлал бий болгох ёстой байна. Олноо зарчих гээд байна гэдэг ийм дүгнэлт хийсэн байна лээ. Тогтвортой байдлын зөвлөлөөс.

Тэгэхээр 2024 онд энэ төсвийн хуримтлал бий болгох энэ чиглэл дээр ямар бодлого орж ирэв ээ гэсэн ийм таван асуултыг би Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд асууж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг, Гочоогийн Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Төгрөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Дараа нь ажлын хэсэг нэмье.

Б.Жавхлан: Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя.

Та нэг талаар цалин нэмэх үү гэж асуулаа. Нөгөө талаар олж байгаа мөнгөө хуримтлуулахгүй юм уу гэж загналаа.

Тэгээд энэ хоёрынхоо тэнцвэр дээр л бид бодлогоо оруулж ирнэ дээ.

Энэ удаа оруулж ирж байгаа маань бол төсвийн дандаа хязгаарууд шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дандаа хязгаарууд нь байгаа юм. Зардлаа ч гэсэндээ бид хамгийн хязгаар дээр нь л тавьчихсан орж ирж байгаа юм.

Тийм учраас одоо бид удахгүй 9 сард 2024 оныхоо төсвийг өргөн барихад цалингийн бодлогоо нэлээн цэгцэлж байгаад. Энэ одоо 10 гаруй жил, бараг 20-иод жил хөрөөний шүд шиг болгочихсон, Засгийн газраас төрийн албан хаагч нарын цалин тогтвортой бөгөөд нэгдсэн бодлогоор барих ямар ч боломжгүй болоод ирчихсэн эрх зүйн орчныг цэгцлэх нь хамгийн түрүүний том асуудал болчихоод байгаа юм.

Уг нь Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, энэ чиглэлийн яам маань зөвхөн төрийн албан хаагч төдийгүй Монгол Улсын цалин, хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг барьж чиглүүлж явж байх ёстой. Гэтэл ийм бодлогын чадамжгүй болтлоо энэ хуулиуд маань тал тал тийш нь энэ бодлогыг хүчгүйдүүлчихсэн байна.

Тийм учраас эрх зүйн орчин дээр бас нэлээн асуудал байгаа. Гэхдээ ямар ч байсан сүүлийн 2-оос 3 жил бид дорвитой төсвийн хүндрэлүүдээс үүдэж цалин, тэтгэвэр, тэтгэмж, бодлогууд дээрээ инфляц, үнийн өсөлтийг давах хэмжээнд өсөлтүүд хийж чадаагүй, хоцорсон байгаа.

Тийм учраас эрх зүйн орчинд нь ч тэр, төсвийн бодлогоор ч тэр цалингийн нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, энэ халамж, хөдөлмөр нийгэм хамгааллын бодлогуудыг үнийн өсөлттэй уялдуулж тодорхой хэмжээний өсөлтүүдийг төсөвлөж орж ирнэ. Ингэж хэлье.

Зээлийн хүү гэсэн. Зээлийн хүү яг цэвэр зах зээлийнхээ жамаар эрэлт нийлүүлэлт дээр тогтдог л асуудал л даа.

Бид санаж байгаа. 2019 оны жилийн эцсээр арилжааны банкнуудын зээлийн хүү дунджаар бараг жилийн 12, сарын 1 хувь руу өөрөө ингэж жамаараа орж ирж байсан. Гэсэн хэдий ч түүнээс цааш бид олон сорилтууд дунд орлоо.

Цаашдаа эдийн засгаа тогтворжуулах, төсвийн алдагдлаа бууруулах, төв банкны валютын нөөцөө өсгөх гээд энэ макро тэнцвэрүүдийг зорьж ажиллаж байгаа маань тэгээд мэдээж энэ зээлийн хүүг буурах энэ макро суурийг бий болгохын төлөө л ингэж зорьж байгаа юм.

Түүнээс биш Засгийн газрын зүгээс бид зээлийн хүүг шууд тэд болгоно гэж онилж явах ийм боломжгүй зүйл байдаг.

Л.Мөнхбаатар: Д.Тогтохсүрэн гишүүний асуултад нэмж хариулья.

Монгол Улсын Шадар сайд Ч.Хүрэлбаатар хариулья.

Ч.Хүрэлбаатар: Хэд хэдэн асуулт байгаа. Үнийн өсөлт гээд.

Үнэхээр ард иргэдийн өрхийн бодит орлогыг бууруулж байгаа зүйл бол энэ үнийн өсөлт байгаа. Ер нь үнийн өсөлтөд нэрвэгдээгүй айл өрх, хувь хүн

гэж Монголд байхгүй гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Ингээд үзэхээр үнийн өсөлтийн 60 хувь нь гаднаас импортлогдож орж ирж байсан гэж үзэж байгаа. Өмнө нь. Яагаад вэ гэхээр гадаад бусад улс орнуудад бас инфляц явагдаж байна. Үнийн өсөлтүүд явагдаж байна. Энэ нь Монголд импортлогдож орж ирж байна. 40 хувийг нь манай дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтүүд байсан.

Одоо энэ харьцаа 50, 50 орчим харьцаатай болоод эхэлсэн байгаа. 60, 40 байсан бол 50, 50. 50 хувь нь гаднаас импортлогдож байгаа инфляц. 50 хувь нь дотоодын нөхцөл байдал.

Тэгээд бусад орнуудын хувьд аваад үзэх юм бол мөнгөний бодлогоор бусад орнууд инфляцынхаа эсрэг тэмцэж байна. Бусад орнуудад инфляц буугаад эхэлчхэж байгаа учраас цаашдаа дотоод дахь үнийн өсөлтөд нөлөөлдөг хүчин зүйлсүүд илүү анхаарал татаж эхлэх болов уу. Үүн дээр илүү анх анхаарал тавьж явах ёстой болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр одоо Монгол Улсад авч хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёр энэ инфляцыг хазаарлах, бууруулах ийм бодлоготойгоо нийцээд явж байгаа.

2022 оны эхний хагаст инфляц 16.1 хувьтай байсан бол энэ 05 сарын 15-ны байдлаар инфляц 10.5 хувьтай байгаа.

Тэгэхээр бид үргэлжлүүлээд авч байгаа бодлогоо хэвээр нь цаашаа үргэлжлүүлээд явбал инфляцаа буулгаж чадна гэж, нэг оронтой тоо руу оруулаад ирэх боломжтой гэж үзэж байгааг хэлье.

Зээлийн хүүгийн хувьд зээлийн хүүг 2023 ондоо буулгана гэж худлаа амлаж чадахгүй.

Яагаад гэвэл зээлийн хүү буулгахад их олон хүчин зүйлсүүд нөлөөлнө. Инфляцын түвшин нөлөөлнө. Инфляц буухгүй бол зээлийн хүү буухгүй шүү дээ. Зээлийн хүү нь инфляцын түвшнээсээ бага байгаад байвал энэ чинь мөнгө цаас л болж байгаагийн илэрхийлэл шүү дээ.

Тийм учраас яах аргагүй инфляцын түвшинтэй уялдана, ханштай уялдана.

Тэгэхээр бид инфляцаа буулгах, ханшаа тогтворжуулах бодлогоо хэрэгжүүлж байж зээлийн хүү бууж явна гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь, банкны салбарын реформ, гадаадын банкныг Монголд оруулж ирэх хууль эрх зүйн орчныг манай Их Хурал баталж өгсөн. Энэ чиглэлээр нэлээн шуурхай ажиллаж, гаднын банкнуудыг оруулж ирэх, өрсөлдөөн бий болгох, шинээр мөнгө татах ийм зүйлүүдийг нэлээд эрчимтэй дагуулаад хийх ёстой гэж ойлгож байгаа.

Гурав дахь асуулт. Ханш ямар байх вэ гээд асууж байгаа.

Төгрөгийн ханш сулрах нөхцөл харагдахгүй байгаа. Валютын нөөц нэлээд бүрдсэн. Экспортын байдал гайгүй байна. Эдийн засгийн өсөлт өндөр байна.

Тийм учраас ханш цаашаагуа унаад байх тийм нөхцөл байдал үүсэхгүй байна гэж үзэж байгаа. Ханшны зах зээл тогтвортой байгаа гэдгийг хэлмээр байна. Төд төд гэж тааж таамааргүй байна.

Гэхдээ тогтвортой байна гэдгийг л би хэлье.

Л.Мөнхбаатар: Одоо Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр манай гишүүд ард түмэнтэйгээ уулзаад, загнуулаад, асуудлуудаа ойлгож ирсэн байна.

Ер нь бид парламентаа чадавхжуулъя л гээд байгаа шүү дээ. Парламент дотроо ярьдаг байя. Заавал гудамжинд хүмүүс жагсаал хийгээд л, ард иргэдийн уур хилэнг хүргэж ингэж юмаа өөрчилдөг биш, бид ерөөсөө парламент дотроо сөрөг хүчнийхээ үгийг сонсдог байя, алдаа дутагдлаа засдаг байя л гэж олон жил ярьж ирсэн байгаа.

Тэгээд би энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй нэлээд нарийн танилцлаа.

Тэгээд хэд хэдэн асуух юмнууд байна. Жишээлэхэд, орлого дээр бол ингэж байна л даа. 2017 оныхоос бараг огцом 3 дахин их өссөн үзүүлэлт харагдаж байна. Энэ 7 жилийн өмнөхөөс 3 дахин өссөн.

Тэгэхээр миний нэг санаа зовоод байгаа нь, бид чинь орлого их үедээ хуримтлал хийе гэж ярьдаг шүү дээ.

Тэгэхээр ирээдүй өв сан хуримтлал хийнэ гээд хуульчилсан боловч өнөөдөр энэ сангууд чинь бүгд төсвийн алдагдлыг нөхөгч болоод хувирчихсан.

Тэгэхээр орлого дээр энэ асуудлуудаа тусгаагүй, бүх л юмаа л зараад байгаа л юм шиг харагдаад байна.

Хоёрт, төсвийн зарлага дээр бол ингэж байна шүү дээ. 2023 оны төсөв чинь зарлага анх удаа 20 их наядын босго давсан байна.

Тэгэхээр энэ чинь бүр 2017 оны зарлагыг бараг 3 үржүүлчихсэн шахуу ийм зардал байгаа байхгүй юу.

Тэгэхээр түрүүн Д.Тогтохсүрэн дарга асууж байна шүү дээ. Ингээд цалингаа, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэхгүй юм уу гэдэг чинь бид заавал тэтгэвэр, тэтгэмжийг нэмснээрээ зарлага ихсээд байна гэж ойлгож болохгүй. Энэ үр ашиггүй зардлуудыг бид багасгах ёстой байхгүй юу.

Өнөөдөр манай гишүүдийн дунд жишээлэхэд ордонд ингээд өдөр болгон нэг том чуулган болдог байхгүй юу. Ямар их өртөгтэй гэж бодож байна. Иймэрхүү маягийн хэрэггүй зарлагуудаа хасах ёстой болохоос зүгээр иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэхгүй бол цаашаа явж чадахгүй ээ энэ улс орон чинь.

Тэгээд би нэг санаа зовж байгаа юм. Манай улс нэг ийм гайгүй орлого олоод ирэхээрээ л бүгдийг нь зүгээр хуугүй л зарах юм.

Тэгэхээр уул уурхайгаас хамааралтай орнууд чинь ингэж хамаа намаагүй зарж болохгүй шүү дээ.

Тэгээд би уг нь Ч.Хүрэлбаатар сайдаас юм асуух гэсэн гараад явчихлаа. Байна уу.

Бирж дээр Ч.Хүрэлбаатар сайд ээ, нэг ийм юм асуух гэсэн юм. Биржийн асуудал үргэлж эхний хэдэн сар шигээ ийм сайхан байх юм уу? Би бол сүүлийн үед бас асуудлууд гараад байна уу гэж харсан.

Тэгэхээр асуудлууд гарвал энэ эрсдэлүүдээ ер нь тооцсон юм уу гэдгийг асуух гэсэн юм.

Өр, зээл дээр ч гэсэн ер нь энэ олон улсын байгууллагууд бас хэлээд л байна шүү дээ. Бараг Хятадын зээл, Засгийн газрын өрөө ярихад бараг дотоодын нийт бүтээгдэхүүний чинь 92 хувьд хүрэхээр байна гээд л байгаа.

Тэгэхээр энэ чинь яах вэ 2021 оны тоо л доо.

Тэгэхээр энэ өрийн хавхнаасаа бид хэр хурдан мултрах юм бэ? Энэ боломж нь ямар байгаа юм бэ гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Гуравт, үнэхээр одоо ингээд орлого сайжраад ирэх юм бол энэ татвар чинь дагуу бас дахиад давхар өсчихсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ ард иргэдийн нуруун дээр байгаа татварыг багасгах юм уу ер нь.

Уул уурхайгаас орлого их орж байгаа үед ард иргэдийн нуруун дээр байгаа татварыг багасгах уу? Аж ахуйн нэгж дээр байна. НӨАТ дээр байна. Нийгмийн өөр бусад татварууд ер нь багасах юм уу?

Сая иргэдтэй уулзахад аж ахуйн нэгжүүд татварын дарамтаас болоод бүгд хаалгаа бариад явлаа гээд. Хамаг юмаа зараад явж байгаа аж ахуйн нэгжүүд зөндөө байгаа.

Тэгэхээр үүнийг асуух гэсэн юм. Дээрээс нь сая бид оёдлын салбаруудаар явлаа. 33 мянган ажлын байртай байсан оёдлын салбар дээр 3 мянга дээр буучихсан байгаа байхгүй юу. Гэх мэтчилэн.

Тэгэхээр энэ салбарууд чинь яагаад ингээд одоо энэ ажлын байр багасаад байна гэхээр ерөөсөө ажил хийдэг хүн байхгүй болж байна. Бүгд гадаадад гарахыг хүсэж байна. Бүгд ажил хийгээд хүртэл ядуурдаг болчихоод байгаа байхгүй юу. Төрийн албанд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулахаас өмнө зочин танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12-ын Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сурагчид Та бүгдэд хичээл сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

С.Одонтуяа даргын асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Дараа нь Ч.Хүрэлбаатар Шадар сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: С.Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид энэ жил жилд орлого нэмэгдээд байна гэж харахаасаа илүү Монгол Улсын эдийн засгийн цар хүрээ тэлж байгаа юм. Нэмэгдэж байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн ч зохих хэмжээнд нэмэгдэж байна. Би хоёр тоо л хэлэх гэсэн юм. Бид 2019 онд 37 их наядын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй байсан бол одоо энэ жил бид 2024 оныхоо төсвийн хүрээн дээр орж ирж байгаа тоог та харж байгаа байх. 58 их наяд хүрэхээр байгаа. 58 их наяд.

Тэгэхээр үүнийгээ дагаад иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ мөн тэлж байгаа. Энэ төрийн үйлчилгээг

санхүүжүүлэхийн тулд бид мөн тодорхой хэмжээнд орлогоо нэмэх ёстой. Орлогоо нэмэх ёстой. Экспортоо нэмэх ёстой.

Үүнийг дагаж бий болж байгаа энэ орлогын бодит дүн маань энэ байгаа.

Тэгэхээр бид үүнийг маш олон жилийн дундаж судалгаа, энэ тренд, энэ жилийн бас сүүлийн хагас жилд эдийн засгийн төлөв байдал маань ямар байх нь вэ. Ирэх жил олон улсын эдийн засгийн нөхцөл байдал ямар байх нь вэ гээд олон зүйлүүд дээрээс шалтгаалж судалж ингэж нэлээн бодит байдал руу дөхүүлж орж ирсэн ийм дүн байгаа.

Таны онцолж асуусан тэр сангуудын хувьд бид яг үндсэн сангуудтай холбоотой хуулийн заалтуудаа маш сайн барьж, ирэх жил та бүхний их асуудаг жишээ нь хүүхдийн мөнгө.

Хүүхдийн мөнгийг төсвийн хүндрэлтэй үед бид Ирээдүй өв сангаас санхүүжүүлж байсан бол 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл дотроо санхүүжүүлж, АМНАТ-аас орж ирдэг, АМНАТ-аас хуваарилагддаг сангуудыг зохих түвшинд нь хадгалж. Жишээ нь, АМНАТ бол 65 хувь нь Ирээдүй өв сандаа, 10 хувь нь Орон нутгийн хөгжлийн сандаа, үлдсэн төсөв дээрээ. Давбал Тогтворжуулалтын сандаа гээд.

Ингээд яг мөчлөг сөрсөн бодлогынхоо хүрээнд хийгдэж орж ирсэн хязгаарын тоонууд байгаа шүү.

Зардал дээр би тангай 100 хувь санал нийлж байна. Төсөв өөрөөсөө хэмнэлтийг эхлэх ёстой.

Тийм ч учраас бид өнгөрсөн жил яг өдийд Төрийн хэмнэлтийн тухай хууль гээд маш сайн хууль баталсан.

Улсын Их Хурал. Та ч гэсэн маш сайн дэмжиж үүнийг баталж өгсөн.

Бид үүнийхээ хүрээнд 2022 онд жишээ нь бид бараг нэг их наядын хэмнэлт гаргаж чадсан. Нэг их наядын. Бодитойгоор шүү. Яг төсөвлөсөн хуулиасаа.

Энэ жилийн хувьд мөн л бид яг энэ хэмнэлтийн хуулиа барьж хийсэн төсөв. Хэрвээ хэмнэлтийн хууль байгаагүй бол одоо энэ орж ирж байгаа тооноосоо ч өндөр ийм тоо орж ирэх байсныг үгүйсгэхгүй.

Тийм учраас зардал эхний ээлжид олон нийтэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг бүрэн санхүүжүүлэх хэмжээний одоо яг ийм төлөвлөгдсөн зардал байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: С.Одонтуяа гишүүний хоёр асуулт байгаа.

Биржээр нүүрс арилжаалагдах асуудал үргэлжлүүлэх эсэх. Түүнчлэн ирэх онд төсвийн орлого нэмэгдэж байгаатай холбогдуулаад татвар багасах боломжтой юу гэсэн ийм асуултууд асуусан.

Үүнд Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулья.

Ч.Хүрэлбаатар: Ч.Одонтуяа гишүүний асуултад хариулья.

Нийтдээ бид биржээр 40 удаагийн арилжаагаар 1.2 сая тонн нүүрс зарчихсан байж байгаа. Энэ бол 2 дугаар сараас хойшилно шүү дээ.

Биржээр зарахаар хэд хэдэн давуу тал үүсэж байгаа юм. Нэгдүгээрт нь, өндөр үнэ хүргэж зарж байгаа.

Хоёрдугаарт, нь ил тод байгаа.

Хуучин юу гэдэг юм нэг гэрээлэгч компанийн захирал хоёр хөшигний цаана сууж байгаад үнэ тохироод гарын үсэг зурчихдаг. Үнээ тайлбарлахдаа гоё шалтгаан олоод хэлчихнэ шүү дээ.

Гэхдээ биржээр зараад олны дунд өрсөлдөөн оруулаад зарахаар нүүрс өндөр үнэтэй зарагдаж байгаа. Үүний ашгийг Монголын төр хүртэж байгаа, ард түмэн хүртэж байгаа.

Тэгэхээр энэ биржээр зарагддаг. Аль болохоор зарахгүй байхыг хичээж хүсэж байгаа хүмүүс асар их олон. Аль болохоор саад болохыг бодно, зогсоохыг хүснэ. Энэ биржийг бол ер нь жоохон миалчих санаатай, муулчих санаатай ийм хүмүүс их байгаа.

Гэхдээ та бид Улсын Их Хурал маань Биржийн тухай хуулийг баталчихсан. 07 дугаар сарын 01-нээс, энэ оны 07 дугаар сарын 01-нээс биржээр бүгдийг нь зарах учиртай. Зэсээ зарна, жоншоо зарна, цайраа зарна, бүгдийг зарна. Төмрөө зарна, нүүрсээ зарна. Ингэж байж энэ уул уурхайг дагасан хардлага, хулгай, авлига энэ бүгд л алга болно шүү дээ.

Тийм учраас манай Их Хурал биржийг тууштай дэмжиж өгч байсанд талархаж байгаа.

Тэгэхээр энэ дээрээс бидэнд өөр сонголт байхгүй. Тийм. С.Одонтуяа гишүүн маш сайн дэмжиж байгаа. Би үүнийг сайн мэдэж байгаа.

Янз бүрийн саад бэрхшээлүүд байна шүү дээ. Амьдрал дээр төгс төгөлдөр тийм цаасан дээр цав цагаанаар хийчихсэн юм шиг тийм сайхан зүйл бол байдаггүй. Дандаа хүндрэл бэрхшээл дотор амьдрал явдагтай адилхан бирж дээр явж л байгаа. Бид бас журмаа сайжруулах, бага сага юмаа өөрчлөх ийм ажлууд тасралтгүй хийгдээд явж байгаа.

Тэгээд 07 сарын 01-нээс Монголын бүх бараа, бүтээгдэхүүн, уул уурхайн бүтээгдэхүүн биржээр зарснаар өндөр үнэтэй болно, ил тод болно. Хардлага сөрдлөг алга болно. Энэ ч гэсэн төрийн нэр төрийг, нэр цэвэрлэхэд ч гэсэн хэрэгтэй шүү дээ.

Тийм учраас ийм хариулт хэлмээр байна.

Хоёрдугаарт, нь татварын тухай асуудал. Одоо бид хувийн хэвшлийнхний нервээр тогломооргүй байна. Амгалан тайван байлгамаар байна. Татварыг өөрчилнө, энэ тэр гэж янз бүрийн юм хиймээргүй байна.

Зүгээр л сайхан хэдүүлээ тогтвортой амгалан тайван ажиллацгаамаар байна шүү дээ. Тэгж байж Монгол Улсын эдийн засаг хөгжинө л гэдгийг би хэлмээр байна.

Одоо сонгууль дөхчихсөн. Янз бүрийн популист амлалтууд хэрэггүй. Монгол Улсын эдийн засаг, төсөв, санхүү хүчтэй байж байж энэ улс хөгжинө шүү дээ.

Тийм учраас янз бүрийн илүү хөдөлгөөн хэрэггүй болов уу л гэж би дотроо бодож байна.

Л.Мөнхбаатар: Тодруулахаас өмнө зочин танилцуулья.

Нийслэлийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 9-ийн А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Багш, сурагчид Та бүгдэд сурлага өдрийн өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа тодруулж асууя.

С.Одонтуяа: Ч.Хүрэлбаатар сайд аа, энэ ингээд бүх юм сайхан байна гээд л та сайхан тайвшруулаад байна л даа.

Гадаа чинь амьдрал өөр байгаа байхгүй юу. Жишээлэхэд, аж ахуйн нэгжүүдийн татварыг нь буулгахгүй байж болно. Гэхдээ асар их дарамттай байгаа байхгүй юу. Байсхийгээд л торгоно, байсхийгээд л хаана.

Өчигдөр гэхэд л над руу хүн ярьж байна л даа. Ганцхан сар төлөөгүй нийгмийн даатгал байхад л дансыг нь хаагаад л, янз бүрийн зарлаад л, зээлийн өр төлбөртэй ангилалд оруулж. Ингээд аж ахуйн нэгжүүд чинь ийм дарамттай байна гэдгийг ганцхан би хэлээгүй юм. Цаашдаа сайхан сайхан л байна.

Тэгэхдээ та нарын яриад байгаа энэ өсөлт чинь ард иргэдийн хаалгаар орохгүй байна, аж ахуйн нэгжийн хаалгаар орохгүй байна гээд байгаад л бухимдаад байгаа.

Дээрээс нь Б.Жавхлан сайд хэлж байна шүү дээ. Тэр төсвийн хэмнэлт сайн болсон гээд. Би бол энэ дунд шатанд та нар арай хэтэрхий жоохон туйлширчхав уу гэж харсан.

13 мянга 45 хүн өөрийн хүсэлтээр төрийн албанаас 2022 онд гарлаа гэж байгаа.

Тэгэхээр би жишээлэхэд Баянгол дүүргийн Засаг дарга хийж байсан. Төсвийн хэмнэлт нэрээр бүх машиныг нь хурааж аваад ганцхан Засаг дарга нь машин унадаг болж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хэн хариулах юм. Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Б.Жавхлан: С.Одонтуяа гишүүний асуултад нэмж хариулья.

Бид хэмнэх зүйлээ хэмнэх л хэрэгтэй. Тэр ялангуяа төрийн алба дунд, дээд шатын дарга нарын илүү тийм тохилог гэх юм уу, тансаг хэрэглээнүүдийг танах, хэмнэх. Бид тэндээсээ л эхлэх ёстой шүү дээ. Тэндээсээ л эхлэх ёстой байгаа.

Тийм учраас тэр машины хэрэглээг хязгаарласан. Тэр чинь зүгээр унаж давхидгийг нь хязгаарлаж байгаа шүү дээ. Албандаа.

Түүнээс биш бусад үед шаардлагатай бол Засгийн газрын баазаас дуудлагаар унадаг, төлбөртэй унадаг гээд тэр зохицуулалтуудыг нь бүгдийг нь хийсэн байгаа. Тийм.

Тэгэхээр энэ яг нүдээ олсон ийм зохицуулалт болсон гэж харж байгаа. Олон хэмнэлтүүд хийсэн. Тэрний нэг нь л тэр юм байгаа юм.

Харин төрийн албан хаагч нарын хувьд бас хөдөлгөөнүүд гарч байна.

Ер нь цаашдаа бас төрийн албаны зөвхөн хувийн сектор ч төдийгүй төрийн албанд ч бас энэ боловсон хүчний

дутагдал энэ асуудлууд бас яалт ч байхгүй л нүүр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Тийм ээ. Одоо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Ж.Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл орж ирж байна.

Жил бүр л орж ирдэг л дээ. Тэгээд сайд нар маань хамгаалаад л, би ч жаал жуул юм яриад л, шүүмжлээд л, хэлэхдээ хэлээд л, саналаа хэлээд л.

Тэгээд нэг их айхтар өөрчлөлт гаргахгүйгээр ингээд л батлагдаад л явдаг.

Түрүүн гишүүд яриад л байна. Өрхийн орлого ерөөсөө хөдөөд жишээ нь 16 хувиар буурчхаад байна. Хотод 7, 8 хувиар буурлаа гэж байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж барьцаалсан зээл. Энэ бүр 50 хувиар нэмэгдчихлээ. Бүр эсрэгээр. Орлого буураад байдаг. Орлогогүй ард иргэд яах вэ, мэдээж цалин, тэтгэврээ барьцаалж байгаад л зээл рүү л орчхоод байна шүү дээ.

Сая бид бүх сум, аймгуудаар явлаа. Бүх л тойргуудаар явлаа. Мэдээж хоёр сайд бас аймаг, тойргоор очоод энэ ард иргэдийн амьжиргаа юмнуудыг бас сайн мэдэж байгаа. Сонссон л байлгүй.

Тэгэхээр би энэ төсвийн хүрээний мэдэгдэл бол яах вэ, та бүхний хэлж байгаатай адилхан санал нийлж байгаа. Яг ямар хэмжээний орлого улсад маань орж ирж байна.

Мэдээж сүүлийн үед орлого нэмэгдэж л байгаа юм байна. Уул уурхай болон Засгийн газраас авсан арга

хэмжээний хүрээнд нэмэгдэж л байх шиг байна.

Дагаад зарлага өсөж байгаа. Мэдээж. Зарлага яах юм. Энэ чинь бас л ард иргэдийн хэрэгцээ, төсвийн үйлчилгээ, төрөөс гарч байгаа зарлага адилхан л үүнтэйгээ уялдаад л явж л байна л даа.

Гэхдээ энэ инфляцтай холбоотой асуудал, энэ үнийн өсөлттэй холбоотой асуудал, энэ төсвийн хүрээнийхээ мэдэгдэлтэй дагалдаад эсвэл хууль оруулж ирэх ёстой юм уу? Улсын Их Хурлын тогтоол орж ирэх ёстой юм уу?

Ямар нэгэн байдлаар асуудлыг шийдэх нэг ийм шийдлүүд байх хэрэгтэй байна л даа. Бид асуудгаа Та бүхнээс асууна. Та бүхэн хариулдагараа хариулаад. Тэр тусмаа Сангийн сайд мэдээж хамгаалаад л гаралгүй яах вэ дээ. Бухимдахдаа бухимдаад л ингээд л хамгаалж л байгаа байх.

Тэгээд би Эдийн засаг, хөгжлийн яам, сайдаас нь асуумаар байх юм. Үндсэндээ энд сууж байгаа С.Бямбацогт, тэнд Б.Батгөмөр гишүүн. Бид хэд Үндсэн хууль хэлэлцэж байгаад ярилцаж байгаад тийм институт Засгийн газрын дэргэд, Засгийн газарт тодорхой хэмжээний Эдийн засаг, хөгжлийн яам байх ёстой гэсэн саналуудыг бид гурав гаргасан шүү. Гаргаж байж энэ яам бий болсон шүү.

Одоо үндсэндээ энэ яам тэндээс төсвийг нь бодоод ингээд орлого зарлагаа бодож байгаа бол та үүнтэй уялдуулаад эдийн засгийнхаа гаргалгаануудыг л гаргаж байх хэрэгтэй байгаад байна.

Тэгээд одоо жишээ нь үнийн өсөлттэй холбоотой асуудлууд мэдээж инфляц буураагүй байхад бид тэр банкны зээл энэ тэр байхгүй байх. Хэцүү л байх.

Гэхдээ учир шалтгааныг нь алга болгох ийм арга хэмжээнүүд дагалдаж орж ирмээр байна шүү дээ.

Бид энэ удаагийнхыг батлаад л ярилцаад л өнгөрнө. Үүний ард тэгээд ганцхан гаргалгаанууд хэрэгтэй байх юм. Хариулт хариултаараа яваад л байна.

Тэгээд үнийн өсөлттэй холбоотой асуудлуудыг яах юм. Одоо энэ махны өсөлттэй холбоотой асуудлууд. Жил болгон хэдүүлээ намар нь тарган мах идээд л, хавар нь мацаг бариад л сууж байх уу? Үүнтэй холбоотой Хөдөө аж ахуйн яам, хөдөө аж ахуйн бодлогууд чинь энд гарч ирэх ёстой байдаг юм уу. Эсвэл энэ жил ер нь бас нэг хариулдаа. Б.Жавхлан сайд. 2024 онд тэр махныхаа үнийн өсөлтийг дарах, эсвэл нөөцийн мах бэлдэхэд хэдэн төгрөг. Мах болон гурилын үнийг барихад хэдэн төгрөг суусан юм уу, суугаагүй юм уу. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, мэдээж нөөцийн мах бэлдэх дээр мөнгө сууж л таараа. Ганцхан мөнгө суугаад яваад байх юм уу, эсвэл зөрж тэнд нь арга хэмжээ авахгүй ингээд л яриад хэлбэл явах юм уу?

Гурилтай холбоотой асуудал хөдөө аж ахуйн сайд маань юу гэж байгаа билээ. Ер нь бид бололцооны гурилаа идээд байгаа л гэж хариулт байгаад байгаа шүү дээ. Үгүй шүү дээ. Бид сонгуульд орохдоо өчнөөн амлалт аваад л орсон шүү дээ.

Тэгэхээр энэ дагалдсан.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулсны дараа тодруулж болно.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ?

Ч.Хүрэлбаатар сайд. Монгол Улсын Шадар сайд Ч.Хүрэлбаатар хариулья. Дараа нь ажлын хэсэг нэмж болно.

Ч.Хүрэлбаатар: Эдийн засгийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам байх ёстой гэдэг санал гаргаад бий болгож өгсөнд баярлалаа.

Ер нь нэг сайдаар нь оччихоод энэ яам хэрэгтэй гээд байгаа ч биш.

Ер нь цаашдаа Монгол Улс өөрөө хөгжлийн бодлого нь тогтвортой, бодлого нь тогтвортой байя. Эхлээд юмаа төлөвлөдөг байя. Тэгээд төлөвлөснийхөө дараа түүндээ нийцсэн арга хэмжээг авч явуулдаг байя гэвэл энэ яам чухал. Хөгжлийн явцад Эдийн засгийн хөгжлийн яам хэрэгтэй гээд.

Бусад яамдынх нь амбиц нь хэтрээд эхлэх үед хэрэггүй гээд ингэж явдаг байсан цаг бий. Тэгээд энэ яам байгуулагдаад бас боломжийн хэрээр ажиллахыг хичээгээд явж байгаа гэдгийг хэлье.

Та түрүүн хэлчихлээ. Сангийн яам орлого, зарлагынхаа дээд талын хэмжээгээ заачхаад тэр дотор нь Хөгжлийн яам юмаа төлөөлнө гэж. Яг эсрэгээрээ. Та бүгдийн концепц нь ч яг эсрэгээрээ. Эхлээд эдийн засгаа хөгжүүлэхийн тулд ийм ийм арга хэмжээ аваад, өсөлтөө ийм болгоно.

Тэгээд ийм орлого олно. Энд орлого олсон. Тэгээд дараа нь тэнцэлтэй нийцүүлээд Сангийн яам нь төсвийн хүрээгээ боловсруулаад явах нь илүү зөв бодлого юм гэж үзэж байгаа.

Тийм учраас үүнтэйгээ нийцүүлээд энэ бодлогын арга хэмжээнүүдийг төлөвлөж орж ирж байгаа гэдгийг би нэгдүгээрт нь хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: Болдын Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн ээ. Энэ удаа хязгаар орж ирж байгаа учраас үнэ тогтворжуулагч гэдэг юм уу, аль аль хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал гээд нарийн задаргаануудаа чиглэлийн яам нь төлөвлөж амжаагүй л байгаа хугацаа л даа.

Тэгэхээр 2024 оныхоо төсвийг бид намар өргөн барихад энэ бүх зүйлээ задлаад нарийн төсөвлөөд ингээд орж ирнэ. Яах вэ, энэ жилийн хувьд жишээ нь зүгээр мах, гурил дээр хөнгөлөлттэй зээл. Ийм хөтөлбөр явж байгаа. Энэ дээр 12.8 тэрбум төгрөгийг төсөвлөөд одоо яг ингээд гүйцэтгэл нь улирлын шинжтэй гараад явж байгаа.

Зүгээр яах вэ миний бодол. Цаашдаа энэ үнийн тогтолцоон дээр Засгийн газар төсвөөс ялангуяа татвар төлөгчдийн мөнгөөр оролцдог энэ байдлыг аль болох багасгах хэрэгтэй. Яах вэ, одоо бид жишээ нь хаврын тариалалт дээр нь үр тариа нь дутагдаж байвал тэр дээр нь туслалцаа үзүүлж байна. Мөн зун, намрын ар ургац хураалт гээд тэр үед ямар огцом зардлууд гарах нь вэ. Бензин, түлш ямар байх нь вэ.

Мөн хаврын ургац хураалт маань алдагдалгүй хэр хэмжээнд авч чадах нь вэ. Нөөц ямар байх нь вэ гээд эдгээр бодлогууд дээр нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам оролцоод явах нь мэдээж.

Яг эцсийн дүндээ зах зээл дээрээ ямар үнэ тогтохыг тэр бүр захиргаадлын аргаар Засгийн газар, төр оролцох нь

хүчирч дийлэх ч үгүй. 100 хувь тэрийг хяналтдаа байлгах ч боломжгүй юм.

Л.Мөнхбаатар: Тодруулахаас өмнө зочин танилцуулья.

Нийслэлийн ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 12-ын Г анги, 42 дугаар сургуулийн 12-ын ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Багш, сурагчид Та бүгдэд хичээл сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Махны үнийн өсөлттэй холбоотойгоор хөдөө аж ахуй буюу мал аж ахуй чинь хөгжиж тогтворжоогүй цагт бид махны үнийг тогтворжуулах дээр 5 төгрөг тавиад явахаас өөр арга байхгүй шүү.

5 жил, 10 жилдээ ингэж явахаас өөр арга байхгүй.

Тэгэхээр энэ чинь сууж л таараа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, төсвийн хүрээний мэдэгдэл дотор нийгмийн даатгалын багц хууль хэрэгжиж байгаа. Хэрэгжих гээд байгаа. Хууль нь явж байгаа. Үүнтэй холбоотойгоор 2024 онд 700-аад тэрбум төгрөг гээд туссан байгаа. Энэ ер нь туссан байгаа юу гэсэн ийм асуултыг Сангийн сайдаас асууя.

Хоёрдугаарт, Ч.Хүрэлбаатар сайдаас бие биедээ талархаад яах вэ.

Ер нь Эдийн засаг, хөгжлийн яам бол үндсэндээ том амбицаар нь харах

ёстой гэдэгт санал нийлээд байгаа шүү дээ. Байх ёстой. Гагцхүү үүнийг дагаад одоо тэр таны төсөөлөөд байгаа, таны тэр тодорхойлоод томьёолоод байгаа тэр эдийн засгийн өөрчлөлт яг өнөөдөр ийм хүнд нөхцөл дээр бас нэг дагаад нэг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Сангийн сайд Болдын Жавхлан эхлээд хариулья. Дараа нь Шадар сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулья.

Нийгмийн даатгалын багц яг хэлэлцэгдээд явж байгаа. Хууль яаж гарахыг нь одоо хэлэхэд арай эрт байна. Гэхдээ ямар ч байсан бид улсын нэгдсэн төсөв болон тэнцвэржүүлсэн төсөв дотроо бүх хязгаар тоонуудаа аваад орчхож байгаа юм.

Тэгэхээр хууль ямар гарахаас үл хамаараад ямар зохицуулалт шаардлагатай байна бид энэ хязгаар дотроо л 2024 оныхоо төсвийг төлөвлөөд хугацаанд нь танилцуулна.

Тэгэхээр тэр үед таны саяын асуусан 700-г яаж суулгах вэ, яаж суусан бэ гэдэг талаар илүү тодорхой ярих боломж гарна гэж бодож байна. Тийм.

Хууль яаж гарах нь вэ тэрийг дагаж орж ирнэ.

Л.Мөнхбаатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмж хариулья. Ч.Хүрэлбаатар сайдад нэмж хариулья.

Ч.Хүрэлбаатар: Талархсан үгээ буцаагаад авчихъя.

Хөгжлийн бодлогын бичиг баримтуудыг бид жилийн төлөвлөгөөтэйгөө өгчихсөн. Урьд нь

зүгээр арга хэмжээний жагсаалтууд байдаг байсан юм. Одоо бид 2024 оны бодлогын тэргүүлэх чиглэл гэж.

Ер нь юун дээр гол анхаарал тавих юм бэ гэдгээ хийгээд, иргэдийн төсөв гэдэгтэйгээ адилхан ингээд нэлээд юу хийгээд өгчихсөн.

Дараа нь жилийнхээ төлөвлөгөө гээд нэлээд бас энгийн ойлгохоор, ойлгомжтой байхаар хийгээд. Ийм юу хийгээд. Дараа нь бодлогын арга хэмжээ, бусад хөгжлийн бодлогуудтайгаа яаж холбогдсон юм, ямар мөнгө шаардлагатай юм, ямар хугацаа ордог юм гэсэн матриц гэсэн ийм 3 бичиг баримтыг давхарт нь оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр тэгээд үүнийг хэрэгжүүлэхэд энэ төсвийн хүрээ энд зарцуулагдана гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн тодруулах юм уу? Талархсанаа илэрхийлсэн. Талархлыг нь буцаачихсан. Одоо яах юм бол?

Ж.Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Талархаад талархлаа буцааж авч яах вэ.

Тэртээ тэргүй байгуулагдаад та ажиллаж байгаагаас хойш ажиллах ёстой шүү дээ. Хоёулаа нэг их юу яагаад яах вэ.

Гол нь сая Эдийн засгийн байнгын хороогоор наад төлөвлөгөө чинь орж ирсэн. Би наад төлөвлөгөөг чинь сайшаагаад байгаа шүү дээ. Та тэгээд өгөөдөөд өөдөөс юу яагаад байх юм.

Наад дотор чинь тэгвэл тэр өсөлттэй холбоотой, инфляцтай холбоотой эдийн засгийн яг өнөөгийн

нөхцөл байдал хүндрээд байгаа нөхцөл байдал дээр би тодорхой арга хэмжээ энэ төлөвлөгөөнд чинь туссан юм юу байгаа юм? Тэгвэл тэрийг нь асууя л даа. Үнийн өсөлттэй холбоотой, үнийн өсөлтийг буулгахтай холбоотой. Энэ мах, гурилын үнэ чинь нэг дахин нэмэгдээд байгаатай холбоотойгоор асуудлуудыг би дагалдаж сугалж авчирч хийж өгөөч ээ л гэж хэлээд хүсээд байгаа байхгүй юу даа.

Түүнээс биш таны төлөвлөгөөг чинь бид Эдийн засгийн байнгын хороогоор үзсэн шүү дээ. Наадхыг чинь үзсэн. Дэмжсэн. Тийм.

Тэгэхээр ер нь аливаа хуульд дагалдаж тогтоолууд орж ирдэг шүү дээ. Түүн шиг энэ нөхцөл байдал дээр тогтоолоо оруулж ирж болохгүй юм уу л гэж би асуугаад байгаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Тийм. Ийм л юман дээрээ тогтчихмоор юм шиг байгаа юм. Жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл, бодлогын баримт бичиг гэдэг зүйлүүд дээрээ л бүх юмаа суулгачихмаар юм билээ.

Тусад нь тогтоол гэдэг юм уу, өөр юман дээр хийхээр чинь хүн яг үүнийгээ л үзнэ шүү дээ. Хөгжлийн төлөвлөгөөгөө үздэг. Нөгөө тогтоолыг нь үзэхгүй.

Тэгэхээр тогтоолд суулгах ёстой санаа оноо байвал хөгжлийн төлөвлөгөөндөө суулгаад л явчихъя гэдэг ийм л зүйл хэлье.

Л.Мөнхбаатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн нэлээн хурц хурц асуулт асуучхаад хариултаа сонсохгүй босож яваад байх юм. Сууж хариултаа сонсьё.

Одоо Дамбын Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй танилцлаа. Бас нэлээн өөдрөгөөр харсан төсөөлөл байна гэж харж байгаа.

Тэгээд үүнтэй холбоотой хэд хэдэн асуулт байна. 2021 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байх үед бид төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2024 онд 2 хувьд байна гэж төсөөлж тооцож оруулж ирсэн байна.

Тэгтэл өнөөдрийн оруулж ирж байгаагаар болохоор 2024 онд 2.8 хувьтай, 2025 онд 2 хувьд хүрнэ гээд тооцчихсон байна.

Тэгэхээр бид жилийн өмнө тооцсон тооцоолол өнөөдрийн тооцоолол хоёр ингээд зөрчихсөн байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө Засгийн газар тодорхой зорилт руу чиглэсэн арга хэмжээгээ авч хэрэгжүүлээд тэр зорилтоо бүрэн дүүрэн хангаж чадаагүй гэж ойлгож болох юм уу?

Ер нь энэ зөрүү гарах шалтгаанаа нэг тайлбарлаач. Яагаад ингэж зөрүүтэй төлөвлөөд байгаа юм бол гэж. Мэдээж энэ хувийн хувьд нэг жижигхэн хувь мэт боловч тоон илэрхийллээр нэлээн том дүн байгаа шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх.

Хоёрт нь, олон улсын агентуудын судалгаагаар Монгол Улсын зээлжих зэрэглэл эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын

эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа гэдгийг гаргаж ирсэн байна.

Гэтэл Засгийн газар өөрөө өрийнхөө бодлогыг тогтвортой барина, өрийн бодлогоо бууруулна гэж зорьж байгаа мөртлөө 2025, 2026 онд өсгөөд тавьчихсан байгаа. Өрийн таазад тулгаад тавьчихсан байна.

Тэгээд энэ ямар учиртай ийм өрийн тааз тулгаж тавьсан юм бол гэдэг дээр нэг хариулт өгөөч ээ.

Гуравдугаарт нь, бид бас сая иргэдтэй уулзалт хийгээд явж байхад иргэд маань нэлээн бухимдаж байгаа асуудлууд байна. Тэр нь бол ерөөсөө тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө, хүүхдийн мөнгөний хасалт, инфляцтай холбоотой асуудал болж хувирч байгаа юм.

Тэгэхээр бид одоо жишээлбэл нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ гээд бид 22.9 их наяд төгрөг тавьсан байна л даа. Ноднингийн мөн үетэй харьцуулах юм бол 2.4 их наядар нэмэгдэж байх жишээтэй.

Энэ нь өөрөө яг юунд зарцуулагдахаар нэмэгдэж байгаа юм? Энэ цалин, тэтгэврийн нэмэгдэл хүүхдийн мөнгөндөө орж байгаа юм уу?

Хүүхдийн мөнгөнөөс хасагдсан хүүхдүүдийн мөнгийг нь нөхөн олгох асуудлууд ер нь ямар түвшинд яригдаж байгаа юм? Засгийн газрын түвшинд. Энэ дээр нэг хариулт өгөөч ээ.

Инфляцтай холбоотой асуудал. Ер нь бид ингээд цалин, тэтгэвэр нэмэгдүүлээд байдаг. Инфляцтай, үнийн өсөлттэй холбоотой асуудлаа барьж чадахгүйгээс шалтгаалаад нөгөө цалин,

тэтгэврийн нэмэгдэл нь хүний амьдралд ерөөсөө наалдаж өгөхгүй байгаа юм.

Тэгэхээр инфляцтай холбоотой, үнийн өсөлттэй холбоотой асуудлыг хязгаарлах дээр Засгийн газар өөрөө ямар бодлого барих юм бэ?

Энд бичсэн байна л даа. Хэрэглээний үнийн өсөлтийн түвшинг 8 хувьд хүргэнэ гээд. 2024 онд. Энэ хэр бодитой вэ?

Бид өнөөдөр гол нэрийн бараа, бүтээгдэхүүнийхээ үнийн өсөлтийг ч бүрэн дүүрэн хангаж чадахгүй байгаа шүү дээ. Барьж чадахгүй байгаа.

05 сарын 01-ний өдөр байсан хонины махны үнэ гэхэд долоо хоногийн дараа гэхэд 500, 600 төгрөгөөр нэмэгдээд явчихсан байх жишээтэй байгаа шүү дээ. Ингээд байнга л өсөөд байна л даа.

Тэгэхээр энэ өөрөө хэр бодитой төлөвлөлт юм бэ? Ямар үйл ажиллагаа, арга хэмжээ авсны үр дүнд бид өнөөдөр ийм тогтвортой байдлыг хангана гэж ойлгож, зорьж төсөөлж, төлөвлөж байгаа юм бэ гэдэг дээр хариулт авъя. Дараа нь тодруулья.

Л.Мөнхбаатар: Д.Батлут гишүүний асуултад хариулья. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Д.Батлут гишүүний асуултад хариулья.

Үндсэн тэнцэл буюу энэ төсвийн алдагдал маань Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагуудын тоо байгаа шүү. Д.Батлут гишүүн ээ. Түүнээс энэ бол төсөв биш. Төсвийн хязгаарууд байгаа юм.

Өөрөөр хэлбэл 2024 онд хуульд заасан хязгаарлалтын дагуу та нар төсвөө дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьд тэнцэх хэмжээнд төсөвлөж оруулж ирнэ шүү гэж бид нарт даалгавар өгч байгаа гэсэн үг. Хязгаарыг нь.

Ингээд тэр хуулиараа бүр он дараалалтай заачихсан байгаа шүү дээ. 2024 онд 2.8, 2025 онд 2 хувь, 2026 онд 2 хувь гээд. Түүнээс цаашаа дахиад 2-оос доош оруулах ёстой шүү гээд бүр хуульд он дараалалтай нь заачихсан байгаа. Тэр тоонууд байгаа юм. Тийм.

Тэгэхээр үүнийгээ харин энэ дотроо энэ хязгаар дээрээ барих уу, үүнээс бага алдагдалтай байх уу гэдгийг хэдүүлээ 2024 оны төсөв батлахдаа намар батална. Нарийн тоотой. Тийм.

Тэгэхээр тэр дүн бол намар хэдүүлээ яригдана.

Үнэлгээний хувьд Д.Батлут гишүүн ээ, бид өнгөрсөн 3 жил маш хүнд үеийг давж ирлээ шүү. Манайтай ижил зэрэглэлтэй, “В+” зэрэглэлтэй олон улсууд доошоо унасан. Доошоогоо унасан.

Бид сүүлийн 3 жил, 4 жил яг энэ үнэлгээ дээрээ тогтвортой байж байна.

Өнгөрсөн жилд ялангуяа төсвийн алдагдал үлэмж болчихсон, Хөгжлийн банк үндсэндээ дампуурчихсан, гадаад өр, зээлүүд тулчихсан, Монгол Улс маань валютын нөөц 2 тэрбум доллароос доош орох маш өндөр эрсдэлтэй болчихсон ийм үед Засгийн газар цаг алдалгүй хэд хэдэн арга хэмжээнүүдийг авчадсан.

Хөгжлийн банкны үйл ажиллагааг тогтворжуулж чадлаа. Экспортоо тултал нь нэмлээ. Төлбөрийн тэнцлээ энэ оны нэгдүгээр улиралд гэхэд бид нэмэх

гаргаж чадлаа. Монгол Улсын валютын нөөц 2 биш бүр 3.4 тэрбум долларт хүрлээ.

Үүний үр дүнд бид энэ зээлжих зэрэглэлүүдийгээ хэвээр нь хадгалж чадсан. Унагаагаагүй. Цаашдаа бид шат дараатай нэмэх зорилго тавиад явж байгаа.

Засгийн газар ингэж мөс хагалагч үүргээ гүйцэтгэсний үр дүнд хувийн хэвшлүүдийн **корпорэйт бондууд** маань гадаад нь зах зээл дээр **yield**_[өгөөж]-үүд нь бас харьцангуй сайжирсан байгаа.

Хувийн хэвшлүүд гадаад зах зээл дээр гарах боломжууд нь энэ хэмжээгээр эрсдэл нь буурч боломжууд нь нэмэгдэж байна гэсэн үг.

Тэгэхээр чамлахаар чанга атга. Энэ үзүүлэлтүүд харин ч яг энэ хүнд үед сайн үзүүлэлтүүд байгаа шүү гэж.

Өрийн тааз. Энэ бол бас хязгаар шүү. Энэ чинь одоо бид 51 хувьтай явж байгаа. Уг нь боломж нь бид 65 хувьтай, 60 хувьтай байх боломжтой. Бид 51 хувь дээрээ барьж байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлбэл энэ хэмжээгээр бидэнд бас менежмент хийх орон зай байна л гэсэн үг. Хязгаараа тавьчихсан байгаа. Бид энд тулгах уу, тулгахгүй юу гэдэг тусдаа асуудал байгаа юм. Хязгаар тоонууд шүү. Та нар эндээс давуулж болохгүй шүү л гэдэг ийм тоонууд юм.

Мөн энэ бол тэр алдагдлын хэмжээтэй адилхан яг тусгай шаардлагаараа яг он дараалалтай ингээд шат дараатай бууруулна гэхчхэн ийм хуулийн даалгавар аваад явж байгаа.

Мөн хүүхдийн мөнгөний асуудал байна. Бид ноднин хэдхэн сарын өмнө

2024 оныхоо төсвийг өргөн барихад бидэнд ерөөсөө хоёр сонголт л байсан. Энэ гадаад өрийн маш том өндөр эрсдэлтэй тийм цаг үе байсан.

Олон Улсын Валютын Сан руу тусламж аваад очих уу, эсвэл Монгол Улс дефолт зарлах уу гэдэг ийм л сонголт дээр байсан. Тийм үед Улсын Их Хурал маань 2023 оныхоо Засгийн газрын өргөн барьсан хуулийг бид баталцгаасан.

Хэрвээ Олон Улсын Валютын Сан руу ороод дефолтоос зайлсхийж тийшээ орсон бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. **Б.Жавхлан** сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Хэрвээ бид Монгол Улс маань дефолт, ийм эрсдэлд ороод Олон Улсын Валютын Сан руу очсон бол өнөөдөр хүүхдийн мөнгө 91 биш бүр 60, 50 хувь руу орох ч ийм өндөр эрсдэл, ийм өндөр шаардлага дунд байсан.

Харин энэ хүнд байдлаас бид өнөөдөр гарч чадсан. Монгол Улс гадаад өрийн эрсдэлээс хамааралтай дефолтод орох ямар ч эрсдэлгүй болсон. Төсвийн тогтвортой байдлаа бид маш сайн барьж ирлээ. Макро олон тэнцвэрүүд маань сайжирлаа.

Тийм учраас одоо харин бид эргээд хүүхдийн мөнгө, цалин, тэтгэвэр, тэтгэмж эдгээр зүйлүүдээ эргэж харах ийм боломж нөхцөл бүрдэж байна гэдгийг хэлье.

Тэгээд яг нарийн тоон дээр ярих асуудал бол төсөв өргөн барих энэ үед илүү их тодорхой яригдана.

Одоо бид төсвийн хязгаараа ямар ч байсан хүүхдийн мөнгөө

өнөөдрийнхөөсөө илүү хэмжээнд тавьж болохоор ингэж хязгаартай оруулсан байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмэх юм уу? Шадар сайд Ч.Хүрэлбаатар нэмж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Товчхон хариулъя.

Инфляцаа 8 хувьдаа барьж чадах юм уу. Та бүгд энэ дээрээ 8 хувь гэж оруулж ирсэн байна гэдэг ийм асуулт байгаа.

Тэгэхээр ер нь төсвийн хүрэн дээр тавигдсан тоо болгон өөрөө агуулгатай. Тэрийг биелүүлэхийн төлөө л Засгийн газар ажиллах ёстой. Худлаа тоо тавьж болохгүй. Эсвэл юу гэдэг юм, үүнийг зорино ч гэж ярьж бүр болохгүй.

Тэгэхээр 8 хувь буюу нэг оронтой тоонд оруулахын төлөө ажиллана. Оруулчих ч болов уу гэж бодож байгаа.

2022 оны 6 дугаар сард, эхний хагаст бол инфляц 16.1 хувь байсан. Оны төгсгөлөөр 12.2 болсон. Одоо 5 сарын 15-ны байдлаар 10.5 байгаа юм. Инфляц.

Тэгээд түрүүн хэлсэн. Өнгөрсөн жилийн инфляцуудад гол нөлөөлж байсан зүйл нь нөгөө импортлогдож орж ирсэн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт 60 орчим хувьтай. Дээр нь манайх чинь нөгөө төгрөгийн ханш унаад байсан учраас энэ нь эргээд тэр инфляцыг хөөрөгдөхөд их хувь нэмэр оруулчихсан байгаа. Одоо бид нарт тэр ханш хөдлөх, унах тийм эрсдэл маш бага байгаа.

Тэгээд мөнгөний бодлого зөв явж байна. Төсвийн бодлого зөв явж байна. Тэгээд эдийн засгаа тэлэх, энэ хувийн хэвшил дээр очдог янз бүрийн саад

бэрхшээл, хүнд суртал, энэ бүгдийгээ бууруулах, илүү чөлөөтэй байх энэ бодлогын арга хэмжээнүүдийг аваад явуулчихад болчихно л гэж үзэж байгаа. Үүнийг зорьж ажиллаж байна.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу?

Ер нь нарийвчилсан тодорхой тоо ярихад арай болоогүй байгаа байх. Энэ бол 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, ерөнхий хязгаар. 2025, 2026 оны төсвийн төсөөлөл шүү дээ. Тийм ээ.

Ийм учраас эдгээр хязгаар дотроо ярина. Дамбын Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Ер нь КОВИД цар тахлын өвчлөл, бас дэлхийн хоёр улс орны дайн тулаантай холбоотой амаргүй цаг хугацаа туулсан гэдгийг би ойлгож байгаа.

Улсын Их Хурал, Засгийн газар хамтран ажилласны үр дүнд бид энэ КОВИД цар тахалтай холбоотой, эдийн засгийн уналттай холбоотой асуудлууд дээр маш богино хугацаанд үр дүн гаргаж чадсан. Чадсан уу, чадсан.

Өнөөдөр энэ өсөлтүүд нь ингээд хангагдаад явж байгаа юм. Би яах вэ зүгээр төлөвлөлттэй холбоотой асуудал дээр л асуулт асуусан. Тухайлах юм бол төсвийн хүрээний мэдэгдэл байгаа. 2021 оны.

Энэ төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь ноднин 2021 онд батлуулахдаа 2024 онд 2 хувь байхаар гэж оруулж ирж байсан.

Гэтэл өнөө жил оруулж ирэхдээ 2.8 болоод нэмэгдчихсэн байх юм. Яагаад

ийм алд зөрүүтэй мэдээлэл оруулж ирж байгаа юм бэ гэдэг асуулт асуусан байхгүй юу.

Тэгэхээр сайд энэ дээр бас буруу зөрүү ойлголт авсан байж магад.

Л.Мөнхбаатар: Д.Батлут гишүүний тодруулгад хариулъя. Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Д.Батлут гишүүн ээ, та өөрөө орлого гээд тэгээд байх юм.

Наадах чинь тэнцэл байхгүй юу. Алдагдал гэсэн үг.

Энэ жил одоо бид нар оруулж ирж байгаа тоо маань 2024 оных.

Та одоо яг хамгийн сүүлийн батлагдсанаараа хуулиа хараарай. Нэг жилээр хойшлуулчихсан байгаа. Бүгдийг нь хойш нь нэг нэг жилээр бүгдийг нь хойшлуулчихсан.

Тийм учраас 2.8 нь одоо яг 2024 он дээр таарч байгаа. Одоо хамгийн сүүлд батлагдсанаараа яг ийм байгаа. Тусгай шаардлагууд.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Миний асуух асуулт 2020-2025 онд эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд орсон, туссан ажлуудаа асуухыг хүсэж байна.

Нэгдүгээрт, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд “**Боомтын сэргэлт**”-ийг Засгийн газар хийж байгаа.

Энэ дээр Арцсуурь боомтын асуудлыг ярьж байгаа. 2006 он хүртэл Завханы иргэд малаа гаргаад, махаа гаргаад оронд нь бензин тос, гурил будаа

гээд хүнсний бүтээгдэхүүнээ оруулж ирдэг байсан. Энэ боомтын зэрэглэлийг бууруулснаараа өнөөдөр энэ боомт ямар ч ажиллагаагүй болсон.

Тэгэхээр өнөөдөр Завхан аймаг импортыг дэмжихгүй гэж хэлээд байгаа юм биш. Үнэхээр импортоо дэмжээд Завхан хүртэл тэр хямд үнээр. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын иргэдийн гурил авч байгаа үнээр Завхан аймагт нийлүүлж чадаж байвал болж байна. Гэтэл чадахгүй байна.

Өнөөдөр Улаанбаатар хотоос Архангай аймаг даваад л наашаа гарахад Завхан аймгийн иргэдийн бензиний үнэ 300-аас 500 төгрөг байгаа.

Тэгээд өнөөдөр яг зэргэлдээ байгаа хөрш Увс аймаг маань бас энэ Боршоо боомтоо нээгээд шатахуунаа импортолж байгаа.

Тэгээд би Эдийн засгийн хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар сайдаас та хөрш аймгаа яг Увс аймгийн энэ иргэд шиг хямд бензин хэрэглэх, хямд хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх боломжоор хангаж өгөөч ээ.

“Боомтын сэргэлт”-ийн хүрээнд Арцсуурь боомтыг яаралтай нээх асуудал, зэрэглэлийг нь буцаагаад нэмэх асуудал дээр анхаарч өгөөч ээ.

27-хон боомттой. 75 мянган хүн амьдардаг Завхан аймгийнхны аятай таатай амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, би өөрөө Б.Баярсайхан гишүүний тэр төсөвт санаачлан тусгуулсан Нөмрөг, Сонгиноос Арцсуурь боомт хүртэлх 167 километр авто замын ТЭЗҮ-г зуруулсан байгаа. Дуусчихсан байгаа. Мөн Идэр сумын төв

замтай холбогдох 12 километр замын зургийн ажил дууссан.

Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөнд энэ орсон юм уу? Надад харагдахгүй байна.

Улиастайгаас Алтай хүртэлх 42 километр зам гэхихсэн байх юм. Үүнийг Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд хийгдэх гэж байгаа энэ ажлыг Улиастайгаас Алтай хүрэх тэр гол зам хүртлээ 42 километр гээд байгаа юм уу? Энэ бол 160 хэдэн километр зам байх ёстой. Энэ нь ямар учиртай юм бэ? Үүнийг тайлбарлаж өгөөч.

Завхан аймгийн иргэдийн хамгийн их асууж байгаа зүйл Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт ороод Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Дарханы арьс шир, нэхий боловсруулах үйлдвэр ямар шатдаа явж байгаа юм бэ? Энэ үйлдвэр хэзээ босох юм бэ гэдэг асуултыг асууж байна.

Тавдугаарт нь, Алдархаан сумд байгаа Донойн нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэлтэй болгоно гээд үндсэн чиглэлд тусчихсан байсан.

Сая одоо энэ хөгжлийн төлөвлөгөөнд харахаар нөгөө л нэг аймгууд нь ороод ингээд л миний зураг байдаггүй юм гэдэг шиг дандаа Завхан аймаг энэ хөгжлийн том мега төслүүдээс чинь яагаад ингээд хасагддаг юм бэ? Энэ дээр хариулт авъя.

Тэгээд Доной нисэх буудал, мөн Тосонцэнгэлийн нисэх онгоцны буудлын зэрэглэлийг буцаагаад сэргээх, сайжруулах. Тэр 200 хэдэн сая төгрөгөөр 2020 онд ажил хийгдчихсэн юм шүү дээ.

Тэгээд манай аймаг руу онгоц нисдэггүй. Зөвхөн Баян-Айраг уул

уурхайн ажилчдыг зөөдөг нэг онгоц долоо хоногт нэг удаа явдаг. Ийм нөхцөл байдалтай байж байна.

Тэгээд Завхан аймаг бүх энэ аймгуудын ард үлддэг байдлыг үнэхээр зогсоомоор байна. Энэ дээр хариулт авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Б.Баярсайхан гишүүн таван асуулт асуулаа.

Зарим асуулт нь дараагийн хэлэлцэх асуудал буюу Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах асуудалтай холбоотой асуултууд байх шиг байна. Хэн хариулах вэ?

Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Одоо төсвийн хүрээ ярилцаж байгаа. Дараагийн асуудал жилийн төлөвлөгөө хэлэлцэнэ.

Тэр дээр ихэнхэд нь хариулъя. Боршоо боомтоор гурил орж ирдэггүй. Яг л Улаанбаатараас үнэтэй гурилыг тэр баруун аймгийн ард иргэд идэж байгаа. Бензиний үнэ Завхан аймаг хоёрын бензиний үнэ яг адилхан.

Харин хямдхан гэвэл хажуу талд бас нэг өөр аймаг байгаа. Тэнд хямдхан байгаа. Яг адилхан үнэтэй. Бас их өндөр үнэтэй ийм бензин.

Төв газар, суурин газраас Улаанбаатартай харьцуулаад үзэх юм бол Завхан аймгийнх ч тэр, Увсын ард иргэд бензин бол 300-аас 500 төгрөгөөр илүү үнэтэй бензин хэрэглээд л явж байгаа. Ийм л байгаа гэдгийг хэлье.

Ер нь цаашдаа гэхдээ би Б.Баярсайхан гишүүний хэлж байгаа ерөнхий агуулгатай санал нэг байна.

Энэ боомтуудыг илүү чөлөөтэй болгоод, тэр боомтуудаараа худалдаа хийж энэ боломжуудыг бий болгож өгөөч ээ. Боломж хийвэл тэнд чинь өрсөлдөөн бий болно. Тэгж байж юмны үнэ бууна гэж хэлж байгаа Б.Баярсайхан гишүүний хэлж байгаа зарчимтай санал нэг байна.

Гэхдээ бид бас нэг зүйл ерөөсөө мартамгүй байгаа юм. Саяхан гялгар уут барьчхаад, элс хийчхээд хатгаад Монгол Улс бол ерөөсөө нэгхэн боомтоор гадагшаагаа гарах ёстой гэдэг бодлогыг барьж байлаа шүү дээ. Барихыг шаардаж ард түмний тархи угаадаг байсан.

Харин одоо эсрэгээрээ боомттой ойрхон байж. Түүгээрээ нээлттэй чөлөөт худалдаа хийгдэж байж тэр бүс нутгийн ард иргэдийн амьдрал сайжирдаг гэдгийг бид гашуун ч гэсэн тодорхой хугацааны дараа ойлгож байгаа.

Тэгэхээр тэр Арцсуурь нь ч нээгдэг, Даянгийн боомт нь ч нээгдэг. Тэр бичигт бүх боомтууд нь нээгдэж ажиллах ёстой.

Одоо Монгол Улс махаа гаргая, арьс ширээ гаргая. Ганцхан боомтоор гарч байгаа шүү дээ. Одоо бол Замын-Үүдээр. Нөгөө баялгаа их олон боомтоор гаргахгүй нөгөө гялгар уутаа элсээр дүүргэхээд барьдаг бодлого явуулаад ирчихсэн.

Харин одоо энэ махаа, одоо тэр арьс ширээ эд нарыг тэр бүх Монголын гаргаж болох бүх боомтуудаараа л гаргадаг болох чиглэлээр энэ Засгийн газар ажиллаж байгаа.

Ингэж байж бүс нутгийн ард иргэдийн амьдрал сайжирна. Тэгэхгүй бол зөвхөн Замын-Үүдээр бүх юмаа гаргачхаад тэр дээрээсээ Монгол Улс

хөгжинө, ард иргэдийн амьдрал хөгжинө гэж хүлээвэл маш их хугацаа орно шүү дээ.

Тийм учраас урьд өмнө явж ирсэн бодлогын хувьд алдаануудаа. Би бол тэнэглэл гэж ярьдаг. Иймэрхүү зүйлүүдээ болих хэрэгтэй. Тэгж байж энэ явна.

Тийм учраас Б.Баярсайхан гишүүний хэлж байгаа саналуудтай би санал нэг байна. Боомтуудаа нээж тэр орон нутгийн ард иргэдэд боломжийг илүү нээж өгч, бизнес эрхлэх боломжийг нээж өгч байж улс хөгжинө, ард иргэдийн амьдрал сайжирна шүү дээ гэж бодож байна. Санал нэг байна. Үлдсэнийг нь тэр жилийн төлөвлөгөө ярихаар хариулья.

Л.Мөнхбаатар: Б.Баярсайхан гишүүн тодруулж асуух уу? Тодруулж асууя. 1 минут.

Б.Баярсайхан: Яах вэ, Завхан аймгийн иргэд шинээр боомт нээж өгөөч ээ гэж хүсээгүй. Ажиллаж байсан. Зүгээр л хэвийн ажиллаж байсан, 2006 хүн он хүртэл бизнес эрхлэгчид нь шатахуунаа гаргаад хоорондоо бараа, бүтээгдэхүүнээ солилцоод явж байсан энэ боомтоо л буцаагаад хэвийн ажиллахад нь хангаж өгөөч ээ л гэж байгаа.

2021 оны төсөв батлахад энэ талаар ярьж байсан. Би Сангийн сайдад Засгийн газарт бас хүсэлт хүргүүлж байсан. Энэ боомтын зэрэглэлийг сайжруулаад, тэр боомтын дэд бүтцийн ажлыг хийхэд 8.5 тэрбум төгрөг шаардлагатай байна гээд.

Ингээд КОВИД болж байна. Дараа дараагийн жилүүдэд шийднэ гээд л хойш нь тавьсан л ийм асуудал байгаа шүү дээ. Сая өнгөрсөн зун Тувагаас иргэд орж ирээд манай Завхан аймгийн халуун рашаан дээр бүгдээрээ эмчлүүлээд явахад

л тэнд бас жоохон ч гэсэн эдийн засгийн жижиг жижиг боломжууд хүртэл гарч ирж байгаа эерэг нөлөө харагдаж байгаа.

Тэгэхээр бидэнд үнэхээр Улаанбаатар хот холоос.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмж мэдээлэл өгье. Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Аль болох гишүүдийнхээ асуултад мэдээлэл өгөх гээд л хичээгээд байгаа юм шүү. Тэгэхдээ шууд төсвийн хүрээний мэдээлэлтэй холбоотой асуудал биш байна.

Бид бас Боомтын сайдтай болсон. Дараа илүү их мэдээлэл өгөх боломж гарах болов уу гэж бодож байна.

Би өөрийнхөө мэдэж байгаа мэдээллийн хүрээнд хариулт өгье.

Бид Азийн хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээлээр Ховд аймгийн төв, Улаангом, Увс аймгийн төв чиглэлийн 163.3 километр хатуу хучилттай зам.

Мөн Улиастай Алтайн чиглэлийн 198 километр хатуу хучилттай замууд барихаар төлөвлөөд хэлэлцээрт орчихсон явж байгаа. Замын хувьд ийм байна.

Боомтын хувьд ёстой төлөвлөгөө дээр Боомтын сайдыг ирүүлж байгаад тодорхой илүү мэдээлэл өгье.

Замын хувьд бид ямар ч байсан зээл хөөцөлдөж байна гэдэг маань.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Дараагийн хэлэлцэх асуудал дээр энэ хөгжлийн

төлөвлөгөө хэлэлцэхэд Засгийн газрын гишүүд байлцсан.

Тэр дотроо Боомтын асуудал хариуцсан сайдыг байлцуулаарай. Их Хурлын Тамгын газрынхан. Б.Тулга сайдыг байлцуулаарай.

Их тодорхой хариулт өгөх шаардлагууд бас байгаа. Дараагийн гишүүн асуултаа асууя. Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр 2024 оны нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсөөлөл орж ирж байгаа юм. Мэдээж энэ орж ирсэн хязгаар, тооцооллуудыг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Гэхдээ нарийсгаж харах ёстой юмнууд байх шиг байна, бидэнд. Дан дамаа энэ цаг үед энэ жоохон эдийн засгийн нааштай үзүүлэлтүүдийг тогтворжуулах тухай нэг асуудал байна.

Хоёрдугаарт, бидний энэ заяагдмал баялаг гэж яригдаад байдаг уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ ханш, дээр нь экспортын хэмжээ нэмэгдэж байгаатай холбоод төсөвт орж ирэх ёстой, тэр хувь хэмжээгээрээ орж ирэх ёстой орлогууд нь нэмэгдэх бололцоо боломжууд байгаад байх шиг байгаа юм.

Тийм учраас бид энэ алтныхаа асуудлыг нарийсгаж тооцож үзэх тухай асуудал. Үүнийг нарийсгаж тооцоод үзэх юм бол Тогтворжуулалтын сан хийгээд Ирээдүйн өв сан тал руугаа бас тодорхой хэмжээний орлого нэмэгдэх бололцоо боломж байгаа юм биш үү гэдэг ийм зүйл харагдаад байгаа юм.

Энэ тал дээр ямархуу байдлаар тооцоо юмнууд нь хийгдсэн юм. Үүнийг нэг тодруулж асуух зайлшгүй шаардлага байна гэж.

Хоёр дахь зүйл. Нэгэнтээ тодорхой сангууд руу орлого татаад, энэ үр өгөөжүүдийг бид эдийн засгаа тэлэх, баялаг бүтээгчдээ дэмжих үйл ажиллагаа руу бас чиглүүлдэг энэ бодлогын чиглэл юмнуудаа их тодорхой болгох ёстой.

Тийм учраас би энэ баялаг бүтээгчдийг дэмжих хөрөнгийн эх үүсвэр талаа энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөлдөө ер нь ямархуу байдлаар анзаарч оруулав гэдэг асуудал байна.

Гурав дахь зүйл, би сая гишүүд нэлээдгүй ярьчихсан учраас давтаж яриад хэрэггүй байх гэж санаж байна. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө энэ үнэ ханштай холбоотой юмнуудыг тов тодорхой холбогдох арга хэмжээнүүдийг нь авч хэрэгжүүлэе.

2024 оныхоо төсвийн зардал талд анхаарсан хүрээнийхээ мэдэгдэл хязгаар дотор бас бодлогын авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд чиглэгдэх хөрөнгийн хэмжээ юмаа анзаарсан гэдэг ийм байдлаар би сая энэ мэдээлэл юмнуудаас ойлгогдсон гэж.

Одоо бидэнд нэгдсэн төсвийн тэнцлийн асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр зэрэг ерөөсөө тэнцлийг бид ямар хэмжээний алдагдалтай гаргана тэр хэмжээгээр бид гадаад эх үүсвэр ашиглах тухай асуудал яригдана. Буцаагаад өрийн асуудал яригдана.

Тийм учраас Монгол Улсын Засгийн газар маань 2023 оны төсвөө батлуулах гэж оруулж ирэхдээ төсвийн хүрээний мэдэгдэлд заагдсан хувь

хэмжээнээсээ доош алдагдлын тухай оруулж ирээд Их Хурал дээр бас түүнийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ аваад 1.4 их наядын алдагдалтай 2023 оны төсөв бид баталсан.

Тэгэхээр 2024 оны төсвийг ер нь биет хэмжээгээр нь 2023 оны батлагдсан төсвийн алдагдлаас л доош баталж байж бид энэ улсын өрийг нэмэгдүүлэхгүй байх, төсөв эдийн засгийнх нь зөв бодлого эрүүлжүүлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ л гэж ингэж хараад байгаа юм. Энэ тал дээр ямархуу байдлаар тооцоолол судалгаануудыг хийж байна вэ гэж.

Дээр нь Засгийн газрын гадаад өрийн тухай асуудал байгаа юм. Тэр Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиудын байж болох хязгаар буюу 60 хувиар аваачиж тавиад 39 их наядын тухай тоо тавьчхаад болж өгөхгүй байгаа юм. Одоо өнөөдрийн бодит байдал нь 51 хувиа гэж ярьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зэрэг суурь 51 дээрээ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одоо 18 гишүүн асуулт асуухаар байна. Дараа нь үг хэлэх цаг байгаа.

Өмнө нь бас нэлээн олон гишүүд, 10 гаруй гишүүд асуулт асуусан. Ж.Батжаргал гишүүн бол асуулт давхцаж байгаа асуултуудаа татаад авчихлаа. Тэгээд гишүүд бас давхцаж байгаа асуултуудаа жоохон цөөлөөд яваарай гэдгийг сануулж хэлье.

Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ер нь санаа зовж байгаа асуудалтай санал нийлж байна. Үе үеийн Сангийн сайд нар яаж энэ алдагдлаа бууруулах вэ л гэж санаа зовж ирдэг. Бид ямар ч байсан хязгаараа тусгай шаардлагын дагуу бариад ороод ирж байгаа юм.

2.8 хувь буюу 1.8 их наяд. Та их сайн санаж байна. Ажлын хэсэгт ажиллаж байсан учраас 2023 оныхыг бид аль болох мөн яг төсвөө төсөвлөхдөө батлахдаа байж болох хуулийн хэмжээнээс нь багасгаад ороод ирсэн. Энэ бол яах аргагүй мөчлөг сөрсөн бидний Засгийн газрын бодлого байсан. Их Хурал маань ч энэ дээр их сайн ажиллаж ийм төсөв баталсан байгаа.

Тийм учраас ирэх оны төсвөө намар бариад ороод ирэхэд хэдүүлээ задалж байгаад л энэ дээрээ ярилцъя даа гээд. Боломжит хуулийн хязгаар маань энэ байгаа. Хязгаар тоо бол ийм байна. Хил ийм байна гэсэн үг. Энэ хилийг бид давж чадахгүй.

Гэхдээ нэг ийм зүйл байгаа. Бид зардал 2.4 их наядар нэмэгдэх хязгаар байгаа юм. Хязгаар. Хуулийн дагуу шүү. Хуулийн дагуу төрийн үйлчилгээнүүдийг нэмэгдэж байгаа бодит зардлын доод хэмжээ маань 3.4 их наяд. Цаана нь дахиад бид 900 тэрбумын зардлаа яаж шингээх вэ гэдэг ийм даалгавартай бид ажиллаж байгаа.

Тэгэхээр ирэх жилийн хувьд төсвөө хэрхэн төсөвлөж орж ирэх вэ. Тэрийг би яаж шингээх вэ гэдэг маш том сорилт болж ирж байна. Бидэнд төсвөө өргөн барих хүртэл бас хугацаа байна.

Тэгээд бид яамдтайгаа ажиллана. Эхний ээлжид мэдээж цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөний асуудал,

мөн 2024 оны жилийн хувь өмнө давтагдахгүй шинэ ажлууд. Жишээ нь, олимп байна. Гэх мэт салбар салбарыг нь тоочих юм бол нийтдээ 11 зайлшгүй төсөв нэмэгдэж байгаа ийм ажлууд байгаа шүү гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, энэ өрийн хязгаарыг Ж.Батжаргал гишүүн ээ, энэ 39 их наяд гэдэг маань нөгөө ирэх жил 58 их наяд хүрэх дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувь буюу өрийн дээд хязгаар байхгүй юу. 39 их наяд. Тэгээд түүнээс биш энд бид хүртэл өрөө нэмнэ гэсэн өрийн бодлогын асуудал бол энэ биш. Хязгаарыг нь. Үүнээс хэтрүүлж болохгүй шүү гэдэг ийм хязгаарын тоо байгаа юм. Тийм.

Одоо бид 31 буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 51 хувьтай. Үүнийгээ л бид бариад явна. Засгийн газрын өрийн бодлого, өрийн стратеги, Их Хурлаас Засгийн газарт гурав гурван жилээр нь өгдөг гэрийн даалгаврынхаа хүрээнд бид ягштал явж байгаа.

Тийм ч учраас бид олон улсын гурван ч зээлжих зэрэглэл тогтоодог агентлагууд дээр улсынхаа зээлжилж зэрэглэлийг амжилттай, тогтвортой хамгаалж явж чадаж байгаа ийм хүнд үед. Тийм.

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Өнөөдөр төсвийн хүрээний мэдэгдлийг ярьж байна.

Тэгэхээр 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг Чилийн сайн жишээн дээр авч Олон Улсын Валютын Сангийн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж эхэлсэн.

Тэгэхээр Чили бол уул уурхайтай. Тэгээд төсөв нь тийм савлагаатай. Дандаа савлаж байдаг. Үнэнээсээ болоод.

Тийм учраас Олон Улсын Валютын Сангийн зөвлөмжийн дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрэгжүүлээд бас тодорхой үр дүнд хүрсэн. Тэгээд тэр дагуу 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг Олон Улсын Валютын Сангийнхан бас энэ сайн жишээ гэдэг утгаараа манай Монгол оронд хэрэгжүүлж эхэлсэн.

Тэгээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд төсвийн хүрээний мэдэгдэл орж ирдэг. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл маань жил болгон л хавар орж ирээд батлуулдаг. 3 жилийнхээ ерөнхий төлөв байдлыг гаргадаг.

Харамсалтай нь 2010 оноосоо өгсүүлээд л жил болгон төсвийн хүрээний мэдэгдэлдээ өөрчлөлт хийдэг. Тэгээд намар төсөв орж ирэхэд л дахиад өөрчилдөг. Өөрчилж байгаад янз янзын зардлаа гаргадаг.

Ер нь яах вэ, Ч.Хүрэлбаатар сайд танайхан эхэлсэн гэж хэлж магадгүй.

Ер нь 13 удаа төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчилсөн тохиолдол байгаа юм. Тэгээд 2011 оноос өгсүүлээд л төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд тэгээд л Их Хурлын гишүүд, Засгийн газар өөрсдөө тааруулаад л бүх юмаа хийгээд л явдаг ийм л нөхцөл байдал байгаад байгаа юм.

Тэгээд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдлийн бас нэг гол амин сүнсүүдийн нэг бол 4 том заалт байгаа.

Тэр 4 заалтын шаардлагын чинь 2 нь хамгийн гол нь шүү дээ. Төсвийн алдагдал 2 хувиас хэтрэхгүй байна. Засгийн газрын өр 40 хувиас хэтрэхгүй байна.

Тэгээд үүнийгээ өөрчлөөд л төсөв дээрээ янз янзын зардлаа нэмэгдүүлэх тэр бүх зүйлүүдийг хийгээд л явсны гор нь өнөөдөр гараад байгаа байхгүй юу.

Яг тогтвортой энэ байдлаа хэрэгжүүлээд Чили шиг явсан бол өнөөдөр Чили 317 тэрбум долларын эдийн засагтай орон болчихсон байж байна шүү дээ. Тийм ээ.

Өөрөөр хэлбэл байгалийн баялгаа зөв төсөвлөж хуваарилсны үр дүнд өнөөдөр бас нэлээн хөгжингүй орны тоонд орчихсон явж байгаа.

Тэгээд өнөөдөр бид тэртээ тэргүй намар төсөв орж ирнэ. Намар төсөв орж ирэхээр ерөөсөө дахиад л Төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчилнө шүү дээ. Тэгээд дахиад л нөгөө баахан зардлаа тавьж байгаад. Тэгээд энэ жил бүр нэн ялангуяа энэ намар дахиад өөрчилнө.

Яагаад гэвэл 2024 онд сонгуультай учраас маш олон зардлуудыг нэмж гаргана.

Тэгэхээр өнөөдөр үүнийг хэлж ярьсны ямар ч шаардлага байхгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгээд энэ Их Хурлын гишүүд нь бас юм хумаа ойлгож байгаа ч юм байхгүй. Тэгээд юун тэр нөгөө махны экспорт. Энэ асуудлыг тэгээд энд ярих ямар ч шаардлага байхгүй шүү дээ.

Тэгээд одоо хөдөө орон нутагт очоод л ярьдаг. Цалин нэм л гэдэг, тэтгэвэр нэм л гэдэг. Тэгээд янз янзын

зардал эх үүсвэртэй холбоотой асуудлуудыг та нар ч тавьдаг. Тэгээд энэ чинь тэгээд төсвийн хүрээний мэдэгдлээ л байнга өөрчилдөг. Тэгээд л энэ бүх зардлуудыг нэмдэг. Түүнээсээ болоод асуудал гардаг. Энэ л зүйлтэй чинь шууд холбоотой шүү дээ.

Л.Мөнхбаатар: Төсвийн зарлагын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж үг хэллээ. Тийм ээ. Тийм үү. Хариулах юм уу? Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Б.Жавхлан: Бид Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, ялангуяа энэ хуулийн тусгай шаардлагууд дээр маш тогтвортой байх ёстой гэдэг таны үндсэн агуулгатай 100 хувь санал нийлж байна. 100 хувь санал нийлж байна.

Энэ өөрчилсөн зүйлүүдийг. Нэгэнт та хөндөж байгаа учраас цагаан дээр хараар биччихсэн юмыг хэлэхээс өөр яах вэ. Энэ хууль маань өөрөө 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж байжээ.

Өрийн хязгаар тэр 40 байсан гэдэг нь үнэн шүү. 40 байж байгаад 60 болгочихсон юм байна лээ. Энэ 2015 онд хийгдсэн. Тийм. 2015 онд хийгдсэн энд хамгийн том тоонууд нь өөрөө энэ байгаа юм.

Тэгэхээр одоо бид 60 байх ёстой юмыг харин 51 хувь дээр бид буулгаж ирээд үүнээсээ өсгөхгүйгээр сүүлийн бид 2 жил тогтвортой ингэж явж байгаа шүү. Тийм.

Л.Мөнхбаатар: Төсвийн зарлагын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: 2023 оны төсөв батлагдсан. Тэр төсвөөрөө тэгээд л бүх юмаа л тооцоод л хийсэн гэж би ойлгож байгаа.

Тэгтэл энэ жил нэг жоохон экспорт нэмэгдээд, орлого нэмэгдэж байгаа. Одоо тэгээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг явуулахын тулд, эрх мэдлээ өөрсдөө авахын тулд хоёрдугаар хэлэлцүүлгийн өмнө цалин нэмнэ, тэтгэвэр нэмнэ, хүүхдийн мөнгийг 100 хувь олгоно гэж очиж байж л, тэгж байж л та нар Үндсэн хуулийн өөрчлөлтөө хийнэ.

Дахиад 2024 онд дахиад сонгууль болно. Тэрүүгээрээ баахан юм нэмнэ.

Тэгээд л нэг их ард түмэнд хайртай хүн болно. Яг сонгуульд гарч авангуутаа тэгээд л будилуулаад л завааруулдаг яг л тэр арга барилаараа л явж байна даа. Өөр юу хэлэх вэ дээ та нарт.

Л.Мөнхбаатар: Үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Иргэд их бухимдалтай байна. Арга ч үгүй юм даа. Амьдрал ахуй нь аягүй хүнд байна шүү дээ.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүнийг очихоор л, гишүүдийг очихоор л зовлон жаргалаа ярих юм л даа. Аргагүй л дээ. Өөрсдийнх нь сонгосон төлөөллийн хүмүүс болохоор өөрийнхөө хамаг л боддог, санадаг тэр юмаа л ярьж байна. Тухайлбал, манай Дорж гуайг хэлэхийг. Орон даяар л тарсан байх. Эв нь нийлсэн 50, 60 хүн бол аятайхан аваад явчихна даа энэ улс орныг гээд байсан.

Уг нь тэр Дорж гуай бол 2016, 2020 онд 60 хүнийг нийлүүлээд өгчихсөн байгаа юм шүү дээ. Хүчийг нь нэгтгээд. Тэгээд та хэд маань ингээд 7, 8 жил эв нь нийлээд явж байгаа нь энэ.

Тэгээд өнөөдрийн төсвийн хүрээний мэдэгдэл бид ярьж байна.

Тэгээд энэ улс орон 2024 онд ямар байх юм бэ, яах юм бэ гэдэг асуудлыг ярьж байна. Одоо яах вэ, нөхөн сэргээгдэхгүй баялаг байгаа шүү дээ.

Уул уурхайн баялгийн орж ирж байгаа хэдэн төгрөгийн юунд л 7.9 хувийн өсөлттэй байх шиг байна. Эхний юу. Тэр хулгай зэлгийгээр гардаг байсан юм хум нь зарим нэг нь ил тод болж байгаа гэж ойлгож байна. Өчнөөн их мөнгө, өчнөөн их нүүрс л алга болдог байсан юм байна шүү дээ. Гардаг юм гардгаараа л ирж байгаа гэж ойлгож байгаа.

Түүнээс биш төмөр зам нэмж тавиад л, гарц марц нь сайжраад л байгаа юм байхгүй шүү дээ. Нөгөө гардаг гарцууд. Тэр хэвээрээ л явж байгаа.

Би зүгээр нэг ойлгомжтой хэдэн зүйлийг тодруулаад өгчхөөч ээ гэж. Энэ төсвөө алдагдалтай баталж болдоггүй юм уу?

Энэ 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдлийн ярьж байгаагаар бол бас л алдагдалтай л явах юм байна шүү дээ. Өмнө нь алдагдалтай л байсан. Цаашдаа алдагдалтай л байх юм байна.

Энэ алдагдлын чинь зөрүүг чинь тэгээд энэ ард түмэн л үүрч байгаа шүү дээ. Энэ инфляц, энэ үнийн өсөлт, энэ банкны бодлогын 13 хувийн хүү. Хувийн хэвшил чинь хаана нь орон зайд нь ажлаа хийх юм бэ?

Бүх юмыг төр дээрээ төвлөрүүлээд ингээд үүрчихсэн та нар. 200, 300 мянган хүн төрийн албан хаагч гээд байж байна. Энэ төрийн албанд чинь бас ажилладаг хүнгүй ч болж байгаа юм шиг байна лээ.

Монголд нэг хүн 2024 онд та бүхний төсвийн хязгаараар. Та нар чинь одоо бараг дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувийг өөрсөд дээрээ авч авчхаад байна шүү дээ. Ийм маягаар бараг 7, 8 жил ажиллалаа.

Ахиад үлдэж байгаа нэг жилд нэг их гайхуулаад өөрчлөгдөөд байх юм байхгүй юм байна гэж ойлголоо.

Тэр эрчим хүчээ гаднаас авдгаараа л байх юм байна. Нөгөө үнэтэй бензин шатахуунаа авдгаараа л байх юм байна. Хамгийн л үнэтэй бензин шатахууныг хэрэглэж байгаа шүү дээ.

Асууж байна лээ. Бүгдийг нь л тэгшитгэж байгаа. Гучин хэдэн жил ажилласан хүн ч гэсэн тэр нийгмийн даатгалынх нь мөнгө нь өөрийнх нь л мөнгө шүү дээ. Одоо аж ахуйн нэгжүүд цалингаа нэмж чадахгүй байгаа.

Яагаад гэвэл нийгмийн даатгалын татвар гээд бас татвартай. Уг нь тэр хүний хувийн л мөнгө шүү дээ.

Одоо нийгмийн даатгалын сан ямар ч алдагдалтай байдаг юм. Тэрийг нь та нар яаж зарцуулаад байгаа юм. Бүү мэд.

Нөгөө талаар монгол хүн өнөөдөр 2024 онд 800 мянган гэр бүл байгаа гэж бодъё. Ер нь хэчнээн төгрөгөөр амьдрах юм бэ. Өнөөдөр хэрэглэж байгаа юм нь гурил, мах хоёр шүү дээ. Хамгийн наад захын хэрэглээ.

Уг нь юм юм хэрэглэмээр байгаа л даа. Тэр нь 3, 4 мянган долларын цалин авдаг тэр жишигтэй. Авч байгаа тэтгэвэр өнөөдөр тэгшитгэчихсэн. 30 жил ажилласан хүн ч гэсэн 500 мянгыг авна. /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Гишүүн ээ, энэ оруулж ирж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувьтай тэнцэх үндсэн тэнцэл маань хуулийн л тоо шүү. Тусгай шаардлага дээр байгаа.

2024 онд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 2.8-аас хэтрүүлж алдагдалтай төсөв баталж болохгүй шүү гэдэг хязгаарын тоо л хуулиас шууд автомат тавигддаг тоо нь энэ байхгүй юу.

Тэгэхээр бид өөрөөр хэлбэл намар төсвийн хуулийг өргөн барихдаа төсвийн алдагдал эндээс хэтрүүлэхгүйгээр бид өргөн барина гэсэн даалгавар авч байгаа юм.

Өргөн барьж ирсэн хууль дээр Улсын Их Хурал ажиллаад Улсын Их Хурал бол төсөв батлах бүрэн эрх нь энд байдаг.

Тэгээд энэ дээр Улсын Их Хурал ажиллана л гэсэн бид ийм төлөвлөгөөтэй ажиллана.

Харин жишээ хэлэхэд 2023 оны тусгай шаардлагаар бид 3.6 хувийн алдагдалтай байж болохоор байгаа. Засгийн газраас өргөн барьсан Төсвийн хууль дээр Улсын Их Хурал ажиллаад үүнийг та нар 3.6 биш ээ. Буулгаад 2.6-д

барь гээд ийм хууль баталсан. Жишээ нь. Тийм.

Тэгэхээр бидэнд цаашаагаа төсвөө өргөн барина, Улсын Их Хурал дээр батална гээд ажлууд бидний өмнө байгаа. Ингээд төсвийн алдагдлыг бууруулах.

Тэгээд Улсын Их Хурал дээрээс харж байгаад энэ энэ төсвийн зардлуудаа хэмнэж болох юм байна гээд ингээд бас төсвийн зардлуудаа багасгах ийм боломжууд байгаа.

Тэгэхдээ би нэг зүйлээ дахиад хэлэхэд хүн амын өсөлт болон төрийн үйлчилгээ, энд хэлж байгаа эд нарыгаа дагаад төсвийн урсгал зардал бүр 3.4 их наяд дээр шууд нэмэгдэхээр байгаа юм.

Тэтгэвэр, тэтгэмжийн тоо шууд хүн амынхаа өсөлтөөр шууд нэмэгдээд явчхаж байгаа юм. Цалин байна. Эд нарыг нэмэх юм бол нийтдээ 3.4 их наядаар бид хуулийн дагуу зайлшгүй нэмэгдэх урсгал зардал нэмэгдэж байгаа. Гэтэл энэ хязгааруудаараа бид 2.5 их наядыг л нэмэх боломжтой байгаа.

Тэгэхээр ийм хайчнууд дунд бид 2024 оныхоо төсвөө намар өргөн барина. Тийм. Тэрний өмнө нэлээн хатуу ийм хязгаар даалгавруудыг авч байгаа гэж ойлгож болно. Тийм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүн тодруулж асуух уу? 1 минут.

Д.Ганбат: Ингээд асуугаад байвал олон юм байна. Гэхдээ яах вэ товчхон асуучихъя гэж бодож байна.

Та нарын хийгээд байгаа төсвийн хүрээний мэдэгдэл энэ хэмжээнд чинь тэгээд ямар аж ахуйн нэгж яаж ажиллаж чадах юм бэ? Тийм орон зай байгаа юу? Нэг.

Хоёрт, монгол хүн өөрийнхөө авах ёстой тэжээл, хамаг юмаа аваад, тэгээд калори юу байдаг юм нэг хүн шиг амьдрах тийм боломж нь байгаад, тийм цалинтай, тэтгэвэртэй байж чадах уу? Тэгж тооцоолж байгаа юу? Тийм тооцоо байдаг л байлгүй дээ, та нарт. Тийм.

Хамгийн наад захын хүний хэрэгцээг хангахаар цалин пүнлүү нь байх уу, тэтгэвэр нь байх уу? Тэр хүүхдийн сургалтын зардал энэ тэр нь байх уу? Хувийн хэвшлүүд та нарын байгаа энэ орон зай дээр ажиллаж чадах уу?

Тэр бодлогын хүү нь 13 хувь байна. Та нар тэр татвараар хамаг юмыг нь татаад авчхаж байна. Тэгээд бараг л социализм л байгуулаад байна шүү дээ. Ер нь. Би ингэж л хараад байна л даа.

Тэгээд нөхөн сэргээгдэхгүй баялгаар.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асуулаа. Асуултад хариулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя.

Бид 2019 онд өмнөх 4 жил Татварын багц хуульд нэлээдгүй өөрчлөлт оруулаад реформ хийсэн.

Одоо байгаа татварынхаа тогтолцоог бид ер нь нэлээдгүй хугацаанд. Дунд хугацаанд шүү. Ер нь 8-аас 10 жилийн хугацаанд тогтвортой явах нь зүйтэй.

Энэ хүрээнд яг суурь гол татварууд дээр ямар ч өөрчлөлт ороогүй байгаа. Төсвийн орлого нэмэгдэж байгаа маань эдийн засгийн өсөлт болон тэрийг дагаад татвар төлөгч, тэр суурь тэлж байгаатай л холбоотой. Түүнээс хувь хэмжээ нэмэгдээд тэр нь татварын орлогод нөлөөлж байгаа зүйл огт байхгүй.

Тэгээд эдийн засаг маань илүү их идэвхжиж байна л гэсэн үг байгаа юм.

Төсвийн үндсэн зорилго олон нийтдээ төрийн үйлчилгээг хүргэх. Үүнийг бүрэн санхүүжүүлэх л нэгдүгээр үүрэгтэй байгаа юм.

Л.Мөнхбаатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Сая нэлээдгүй хугацаанд энэ Төв аймагтаа ажиллалаа. Бүх 27 сумаараа ажиллаж дууслаа. Энэ хавар.

Тэгээд сая Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгээр бүр багууд руу орж малчид, тариаланчид, ногоочид гээд нэлээн детальный орж уулзлаа л даа.

Тэгэхээр ер нь бухимдал их байна. Бид нарт маш их зүйлийг хэлж ярьж байна. Малчид бол энэ маш хүнд хавар болсон. Малын хорогдол маш их байна. Төлийн хорогдол бол зарим газар ямааны төл бараг аваагүй, хониных гэхэд бүр 40 хувьтай байна.

Тэгээд яг үүнтэй зэрэгцээд өвс тэжээл, хивгийн үнэ асар өндөр болсон. Үүнтэй холбоотой маш их бухимдлууд байна.

Дээрээс нь арьс ширээ өгөх асуудал дээр авах үйлдвэр байдаггүй. Үнэгүй болсон. Арьс шир.

Тэгэхээр иймэрхүү бухимдлууд байна. Ногоочид дээр бол энэ хүнсний ногооны урамшуулал олгож эхэлсэн. Тэгээд энэ урамшууллыг авахад тэр НӨАТ-ын татвар энэ тэртэй, падаан, бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой хүндрэлүүд бас гарч байна гэж.

Дээрээс нь бидний яриад байгаа нөгөө хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой энэ хөтөлбөрийн чинь зээл яг анхан шатдаа хүрч чадахгүй байна, хүмүүс дээрээ хүрч чадахгүй байна гээд нэлээн ийм бухимдлууд байна.

Дээрээс нь бас гол бухимдуулж байгаа юм бол сая ингээд Үндсэн хуулиараа 152 гээд очиход 152-тоо ч биш байна лээ.

Ер нь бухимдал нь энэ үнийн өсөлт, юмны үнэ өссөн, цалин, тэтгэвэр нэмэгдэхгүй, амьжиргаанд нь энэ хэдэн төгрөг нь олдохгүй байгаа бухимдлыг л гаргаад байна лээ шүү дээ. Бид бүгд гишүүд очиж уулзсан. Бүгдээрээ л тэр хүмүүстэйгээ нүүр тулсан.

Тэгэхээр энэ дээр энэ төсвийн хүрээний мэдэгдэл маань яаж, энэ тал руу яаж чиглэгдэж байгаа вэ? Өөрөөр хэлбэл үнийн өсөлтийг барих, бууруулах, дээрээс нь цалин, тэтгэвэр нэмэх энэ тал руу яаж орж байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, бухимдлууд дотор энэ хүүхдийн мөнгө. Бид маш олон удаа хэлсэн. Боль. Үндсэн хуулийн зөрчил. Үүнийгээ хэмнэж байхаар өөр юмнаас хэмнэ гээд. Яг л үүнтэйгээ нүүр тулж байгаа юм. Маш их бухимдал байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг хэзээ яаж шийдэх юм бэ? Тодотгол орох юм уу, яах юм?

Дээрээс нь иргэдийн цалин, тэтгэвэр бага байгаагаас гадна цалин, тэтгэврийн ялгамжтай байдал гэж юм маш их бухимдуулж байна. Ялгаатай. Одоо жишээлбэл боловсролын салбар гэхэд сая 5, сая 50 мянгаас дээш явж байдаг. Эрүүл мэндийн салбар гэхэд 780 мянгаас эмчийн цалин явж байдаг. Соёл, урлагийн салбарынх. Одоо энэ жагсаж байгаа улсууд гэхэд бүр дахиад доошоо. 570 дээрээс эхлээд явж байх жишээтэй.

Тэгэхээр цалингийн ялгамжуудаа арилгах бодлого төсвийн хүрээний мэдэгдэл дээр яаж орж ирж байгаа юм?

Дээрээс нь нийгмийн даатгалын багц хууль орж ирсэн. Энэ хуулийн хүрээнд ойролцоогоор 1.4 их наядын хууль батлагдаад л бол шууд шаардагдах зардал байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ мөнгийг төсвийн хүрээний мэдэгдэлд яаж оруулж байгаа юм? Тусгадаг юм уу, яадаг юм?

Тэгэхээр энэ тэтгэврийн зөрүү гэж ахмадуудыг бухимдуулдаг хоёр том сэдвийн нэг байна. Нөхөн төлбөрөө тооцуулчихсан. Сайн дураар төлчихсөн хүн 500 мянга, насаараа 30, 40 жил ажиллаад нийгмийн даатгал төлчихсөн хүн 500 мянга.

Тэгэхээр энэ дээр бас энэ төсвийн хүрээний мэдэгдэл маань яг энэ рүү яаж орох гэж байна аа?

Тэр сургууль, цэцэрлэг дээр бид мэдсээр байгаад чихгүй юм шиг явж байгаа нэг юм бол цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө, сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны

мөнгөний асуудал. Энэ дээр ер нь.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Инфляцын хувьд Төв банк манай Эдийн засгийн хөгжлийн яамнаас тооцоолол бодлогын зорилт нь энэ жилийн эцэг эхэд ямар ч байсан нэг оронтой тоо руу. Ирэх жил бүтэн. Төв банкнаас 2024, 2025 оны мөнгөний бодлогын зорилтот орчноо батлуулсан байгаа.

Тэр дээр 6 нэмэх, хасах 2 гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл три диапазон дотор, 8 дотор орж ирнэ гэсэн зорилго. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлоготой уялдуулсан, нийцсэн ийм зорилт орж ирж байгаа.

Хүүхдийн мөнгөн дээр би түрүүн хэлсэн байгаа. Бид өнгөрсөн жил маш хүнд нөхцөл байдлын дунд 91 хувь гэж төлөвлөж орж ирсэн. Тэр үед хэрвээ бид гадаад зээлийн эрсдэлээс болж дефолт руу явж орсон бол Олон Улсын Валютын Сан дээр очоод энэ бүр 60-аас доош орох, 60 хувь, магадгүй бүр 50 хувиас ч доош орох ийм өндөр эрсдэлтэй байсан.

Тэр үед харин бид нэлээдгүй бас үүнийг төлөвлөж, эндээс бид өөрсдөө Засгийн газар энэ гадаад өр зээлийнхээ бодлогыг тогтвортой барьж, ялангуяа төлбөрийн тэнцэл, энэ экспорт дээр онцгой анхаарах. Нүүрсний гадаад худалдааг нэлээдгүй либерал болгож, ил болгож, энд байгаа далд эдийн засаг, далд орлогыг бид дайчлах ийм хатуу зорилго тавьж, үүндээ ч тодорхой хэмжээнд

амжилт гаргаж хүрсэн гэж ингэж харж байгаа.

Харин тийм учраас өнөөдөр бид зайлшгүй эргэж харах ёстой, эхний ээлжид харах ёстой зүйлүүд таны ярьж байгаа энэ зүйлүүдтэй би санал нийлж байна. Ялангуяа хүүхдийн мөнгө, цалин, тэтгэвэр, тэтгэмж.

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг ярихаас өмнө таны хэлсэн сая тэр цалингийн ялгамжтай байдал. Тэр тэтгэврийн хоёр ч том зөрүү байгаа. 90-ээд он, 2000 оноос өмнө тэтгэвэрт гарсан ахмад настнуудынхаа тэр үеийн нэрлэсэн үнэ. Өнөөдрийн бодит байдал. Энэ хоёрын хоорондох зөрүүг арилгах асуудал байна.

Мөн ноднин орсон өөрчлөлтөөр үүссэн зөрүүний асуудал байгаа. Эдгээр асуудлуудыг эхний ээлжид бид тохируулга хийх ёстой байгаа юм.

Ингээд цаашаага ямар нэг зөрүү байхгүйгээр жил бүр үнийн өсөлт, инфляцтай уялдуулж хэрүүл маргаангүйгээр автомат шууд нэмээд явдаг тогтолцоо руугаа бид орно. Та үүнийг л ярьж байх шиг байна.

Тэгэхээр би санал нийлж байна гэж ойлгож байна.

Цалингийн хувьд. Та сая дурдлаа. Соёл. Дээрээс нь манай спортын салбарынхан байна. Дээрээс нь бараг 3 мянга хүрээд байна. Энэ багийн Засаг дарга нарын цалин. 600-хан мянган төгрөгийн цалинтай. Өөртэй нь цуг ажилладаг нийгмийн ажилтан, бусад ажилтан. Хэдхэн ажилтан байгаа шүү дээ. Гурав, дөрөвхөн.

Тэд нар өөрсдөөс нь илүү цалинтай ийм орчинд л ажиллаж байгаа.

Тийм учраас эхний ээлжид эдгээр тулгамдсан асуудлууд, энэ ялгамжтай байдлуудыг тохируулан хийх нь тулгамдсан асуудал байгаа.

Нийгмийн даатгалын багц хууль хэлэлцэгдээд явж байна. Таны ярьж байгаа шиг төсөв дээр ирэх бодит хүндрэлүүд байгаа. Хууль энд батлахдаа та хэд маань, та ч одоо яг энэ шаардлагыг тавиад, энэ боломж нөөцийг бас хараад энэ дээр их зөв эрүүл хандаасай гэж бодож байна.

Тэгэхдээ хууль яаж гарч ирэх нь вэ, бид хуулийн хүрээнд л. Гэхдээ төсвийнхөө хязгаар дотор багтаагаад л ингээд төсөвлөж цаашдаа явна. Тийм.

Л.Мөнхбаатар: Ц.Туваан гишүүн тодруулах юм уу? Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ц.Туваан: Хүүхдийн мөнгөний шийдвэр ингээд эргэх юм шиг байна.

Тэгэхээр энэ дээр яг тодорхой хугацаанд аваагүй хүүхдүүд байгаа. Энэ дээр нөхөн олгох уу гэдэг асуултыг асууя.

Түүрэн хэлсэн. Хүүхдийн хоолны мөнгөний асуудал. Засгийн газар шийдвэрээ гаргачихсан, салбарын яам нь гаргаагүй байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдэх юм бэ? Одоо жишээлэх юм бол цэцэрлэгийн хүүхдийн хоол 2475 төгрөг. Нэг хуушуур аваад, нэг аяга цай авахад 25 төгрөг дутах мөнгөөр хүүхэд өдөржин хоол идэхээр байгаа.

Тэгэхээр энэ тэрийг бас нэг яг энэ төсвийн хүрэн дээр манай сонгогчид, иргэд маань хэлээч ээ. Үүнийг яаж ийм

бага байж болох юм бэ гэж хэлээд байгаа юм.

Тэгэхээр миний яриад байгаа энэ асуудал байгаа юм.

Тэгээд дээр нь бас энэ гурилын үнэ. Үнэ тогтворжуулах хууль батлаад бензин, мах, гурил дээр 550 тэрбум гэж миний санаж байгаагаар. Үүний үр дүн жишээлбэл хаана байна?

Л.Мөнхбаатар: Ц.Туваан гишүүн 3 асуулт асуулаа. Хэн хариулах вэ? Сангийн сайд байгаа юу. Б.Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Ц.Туваан гишүүний асуулт нэмж тодруулья.

Хүүхдийн мөнгөн дээр бол ийм байгаа шүү. Бид үнэхээр боломж байгаа бол ямар ч байсан бид энэ шийдвэрээ эргэж хараад энэ нөхцөл боломж эдийн засгийн нөөц бий болж байна. Цаашаагаа яаж хийх вэ гэдгийгээ, явуулах вэ гэдгийгээ эхлээд шийдээдэхье.

Мэдээж боломж байвал таны саяын хэлсэн асуудлуудыг бас нэмж шийдэх боломж гарахыг үгүйсгэхгүй.

Гэхдээ бид одоо энэ тогтворжиж ирж байгаа жоохон нөөц гарч боломж ирж байгаа юмаа цаашаагаа тогтвортой байх уу, үгүй юу гэдгийгээ баталгаажуулж авч байж савныхаа хэмжээнд л цаашаа тогтвортой явахыг эхний ээлжид шийднэ.

Хоолны мөнгөний асуудал. Та зөв хэллээ. Засгийн газар шийдвэрээ гаргасан. Чиглэлийн сайд цаашаагаа үүнийг хэрэгжүүлэх ёстой. Тэгээд нэг зүйл тодруулж хэлье. Тэр хүүхдийн хоолны мөнгө маань хоолны юу гэдэг юм цэс нь.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Энэ бас чухал асуултад хариулж байна. Гүйцээгээд хариулчихъя. Б.Жавхлан сайд аа. Тийм. Сая гурван асуулт асуусан. Гурвууланд нь хариулчихъя.

Б.Жавхлан: Тэгэхээр энэ бас буруу нэрлээд байгаа юм. Энэ хүүхдийн хоолны мөнгө гэхээр цэс дээр байх тэгээд хоолны тарифын мөнгө гэж хараад байгаа юм. Энэ бол тийм биш шүү.

Энэ нэг хүүхдээр тооцож очиж байгаа урсгал зардлын хэмжээ байгаа юм. Хүнсний орцуудыг нь худалдаж авах. Тэрэнд зарцуулах урсгал зардал байхгүй юу.

Түүнээс биш тэр хоолных чинь тарифт ордог. Тэнд байгаа хөдөлмөрийн зардал, тэр эрчим хүч, цахилгааны зардлыг гэх мэт зардлуудыг шингээгээгүй зөвхөн бөөний үнээр хүнс худалдаж авахад нэг хүүхдэд ногдох урсгал зардлын хэмжээ байгаа юм.

Тэгэхдээ бид ирэх жил. Би зовлонгоо ярьж байна. Тийм ээ. Энэ хязгаараар нэмэгдэх урсгал зардал маань 2.5 их наяд. Бид зайлшгүй хуулиараа нэмэх зардал 3.4 их наяд.

Тэр дотор нэг хүүхдэд ногдох урсгал зардал, хүүхдийн энэ хоолны урсгал зардлыг бас бид нэмчихсэн байгаа. Тодорхой хэмжээнд. Нэмчихсэн байгаа. Үүнийгээ яаж шингээж оруулж 2024 оны төсөв өргөн барих вэ гэдэг дээр бид яг сууж байна.

Үнэ тогтворжуулах хууль дууссан шүү дээ. Ц.Туваан гишүүн ээ.

Энэ чинь 2022 оны 12 сарын 31-нд дууссан. Үр дүн бол Засгийн газар дотроо бид Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай

Сангийн яам хамтарч ажилласан зүйл маань энэ бензин шатахуун. Ялангуяа түлш дээр. Бид намрын ургац хураалттай холбоогдоод түлш болон 93 дээр. Тодорхой зорилтот түлш, бензиний үнэ дээр маш тогтвортой барьж чадсан шүү дээ. Бид. 2400-д өнгөрсөн оны 12 сард дуустал. Одоо ч гэсэн яг энэ бензин тэрнээс хойш том тэгж нэмэгдээгүй байгаа.

Харин гадаад зах зээл дээр нефтийн үнэ харьцангуй тогтвортой байна. Сүүлийн саруудад бууж ирж байна. Тэр бууж ирсэнтэй зэрэгцээд гадна яг жижиглэнгийн үнэ дорвитой буухгүй байна.

Харин энэ дээр бид буулгах арга хэмжээг бас авах ийм орон зай гарч байна гэж харж байгаа. Энэ дээр чиглэлийн яамнаас илүү бодлогоо ойлгомжтой тайлбарлах болов уу гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр сая Б.Жавхлан сайд аа, би юуг ч ойлгосонгүй.

Ирэх 09 сарын 01-нээс тэгвэл саяын энэ хүүхдийн хоолны чинь тариф одоо энэ бараа, бүтээгдэхүүний үнэ ханш өсчихсөн учраас яагаад ч тэр үнэндээ багтахгүй байгаа учраас 09 сарын 01-нээс тэр зөрүүг нь эцэг, эхчүүдээс гаргуулах асуудал нь юу болж байгаа юм бэ? Гаргуулахгүй бол засгаас оногдуулсан энэ үнэ тариф чинь ерөөсөө нөгөө хүүхдүүдийн илчлэг, хоолны асуудал яривал хаанаа ч хүрэхгүй байгаа юм билээ.

Үүнийг орон нутгаас маш их санал гомдол ярьж байна.

Үнэхээр төрөөс зөрүүг нь өгч чадахгүй бол эцэг, эхчүүдээс өөрөөс нь гаргуулах асуудлыг нь яг яаж шийдэх юм. 09 сарын 01-нээс эртхэн бодлогоо гаргаад ингэнэ гэгчихвэл бараг эцэг, эхчүүд.

Хуучин бол 100 хувь төлөөд л явж байсан юм шүү дээ. Энэ дээр та нэмэлт хариулт хариулт өгөөч ээ гэж.

Миний асуулт энэ өрийн асуудал байгаа юм. Үгүй ээ, энэ Чингис, Самурай, Гэрэгэ гээд л, своп бонд гээд л төлөөд барагдууллаа гээд байх юм. Тэгээд барагдуулсан хэрнээ жил ирэх тусам Засгийн газрын төлөх өр чинь нэмэгдээд байгаа байхгүй юу.

Тэгээд ирэх жил гэхэд гурав аравны хэдэн их наядаар гээд энэ ямар учиртай юм бэ? Төлж барагдуулаад байгаа хэрнээ Засгийн газрын өр чинь буурах ёстой байтал улам нэмэгдээд байх юм.

Тэгээд энэ нь ямар учир начир байна аа? Энэ дээр та нэг хариулт өгөөч ээ гэж.

Нөгөө талаар энэ Засгийн газраас олгож байгаа жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаар олгож байгаа ажлын байр нэмэгдүүлэх зээл чинь ерөөсөө орон нутагт сая очоод ажиллахад хувийн хэвшлийнхэнтэй уулзахад яг тэр хувийн хэвшлийнхэнд авах ёстой юм хийх гээд байгаа нөхдүүдэд гар дээр нь үнэхээр очихгүй байна. Хүртэхгүй байна. Босго шалгуур нь өндөр байна гэж.

Тэгэхээр цаашдаа ер нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгож байгаа ажлын байрыг дэмжих, хамгаалах, шинээр бий болгох, энэ төсөл, хөтөлбөрүүдэд олгож байгаа хүртээмжийг нь эзэнд нь очдог байх

асуудлыг явал нэг зөв голдиролдоо орох юм бол.

Одоогийнх шигээ явбал ер нь яг бодитой ажлын байр. Энэ халамжийн сангаар олгож байгаа ажлын байр нэмэгдүүлэх зээл чинь бол яг үнэнийг хэлэхэд амьдрал дээр ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр үр дүн гарахгүй байгаа юм байна лээ шүү.

Та бүхэн энэ дээр ер нь нэг дүн шинжилгээ хийж үзсэн юм байна уу? Энд ер нь хэдэн төгрөг зарцуулж байна. Жилдээ. Тэгээд хэдэн ажлын байрыг яг бодитой бий болгож байна. Тэрнээс өөрөөр бодлогоо хийж хэрэгжүүлэхгүй бол өнгөрсөн хугацаанд явсан арга хэмжээ чинь нэг л үр дүнд хүрэхгүй байна гэдгийг хоёрт асууя.

Нөгөө талаар энэ НӨАТ-ын асуудал. Мөн л адилхан иргэдээс сая хувийн хэвшлийнхэнтэй уулзахад. Энэ Нарантуул, Дүнжингарав, Хархорин гээд гол худалдааны төвүүдээс Улаанбаатар хотоос ингээд 21 аймаг, 330 сум, нийслэлийн алслагдсан дүүргүүд чинь гол бараа, бүтээгдэхүүн, найман нэрийн дэлгүүрүүд чинь бараа, бүтээгдэхүүнээ авдаг юм байна.

Тэгээд эд нар нь тэр контэйнер, бөөний худалдааны төвүүд нь гарал үүслийн бичиг гэдэг юм уу, тэр юмнуудаа НӨАТ-аа өгдөггүй. Тэгээд очоод найман нэрийн дэлгүүр дээр яг очингуут нөгөө мэргэжлийн хяналтынх нь гарал үүслийн бичгийг гаргаад ир гэж ингэж нэхдэг, дарамталдаг.

Тэгээд нэгэнт л улсын хэмжээнд тэр бөөний төвүүд нь зарах эрхтэй юм бол заавал тэр найман нэрийн дэлгүүрүүдэд гарал үүслийн бичиг нэхэх шаардлага байна уу, үгүй юу гэдэг ийм асуудлыг, энэ дарамт шахалтаа багасгаж

болдоггүй юм уу гэдэг ийм асуудлыг энэ хувийн хэвшлийнхэн, тэр наймар нэр, зургаан нэрийн дэлгүүр ажиллуулдаг улсууд нэхэж байна лээ шүү. Энэ дээр нэг та бүхэн ямар бодлоготой байна?

Магадгүй зүгээр яг үндсэн чиглэлтэй холбоогүй асуулт байж магадгүй. Гэхдээ амьдрал дээр байна.

Нөгөө талаар жил бүр алдагдалтай төсвөө ахиад л ирэх жил батлах нь л дээ. 1.8. Уг нь бид 2023 онд чинь 1.4 их наядын алдагдалтай төсөв баталчихсан юм шүү дээ. Тэгээд ирэх жил ахиад л нэмэгдүүлээд ороод ирсэн байна.

Ер нь алдагдалгүй төсөв батлах бололцоо боломж байхгүй байна уу? Уг нь том утгаараа макро эдийн засгийн түвшинд үзүүлэлтүүд сайжраад.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Хүүхдийн хоолны мөнгө энэ жилийн хувьд төсөвлөгдсөн хэмжээндээ л санхүүжилтүүд нь хийгдээд явна.

Харин яг сургууль бүр дээр эцэг, эх ч юм уу, эсвэл өөр хаанаас байдаг юм нэмэлт орлогуудыг бид нэгдсэн төсөвт төвлөрүүлэхгүй шүү дээ. Татахгүй. Тэрийг захиран зарцуулах нь сургуулийн захирал, эцэг, эхийн зөвлөл хамтарч шийдэх асуудал байгаа юм.

Үүнийг яаж шийдэх вэ гэдгийг боловсролын сайдын шийдвэрээр явна. Харин ирэх жил бид төсвийн бодлогын хүрээнд нэг хүүхдэд ногдох хоолны мөнгөний урсгал зардлыг нэгжээр нь нэмэгдүүлэх тооцооллыг хийж байгаа гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир гишүүн ээ, тэр өрийн хязгаар 35.4 их наяд, ирэх жил 39.2 их наяд болж өсөх гэж байгаа гэж та Засгийн газрын өр нэмэгдэх гэж байна гэж андуураад байх шиг байна. Энэ бол хязгаарын тоо шүү. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх 60 хувь буюу хязгаарын нэрлэсэн дүн нь 39 их наяд байгаа юм.

Түүнээс биш одоо манай Засгийн газрын гадаад өр өнөөгийнхөө ханш, өнөөгийн үнэ цэнээрээ 31 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 51 хувьтай байгаа.

Ингээд буураад явж байгаа. Энэ бол хязгаар. Өөрөөр хэлбэл та нар энэ хязгаараас давж болохгүй шүү гэдэг Төсвийн тогтвортой байдлын хууль дээр байгаа тусгай шаардлагын хуулийн тоо байхгүй юу. Хуулийн тоо маань ингэж орж ирж байгаа. Тэрийг дотоодын нийт бүтээгдэхүүнээс хувилаад тооцохоор ийм дүн гарч ирж байна гэсэн үг.

Харин ч хязгаартаа хүрэлгүй. Одоо энэ чинь бараг 8 их наядын зөрүүтэй ийм бага хэмжээнд Засгийн газрын өрөө бариад явж байгаа гэсэн үг.

Тэр НӨАТ, найман нэрийн барааны дэлгүүрийн бүтээгдэхүүний гарал үүсэл гээд та мэргэжлийн хяналттай холбоотой асуулт асуучих шиг боллоо.

Тэрийг чиглэлийн сайдаас нь илүү тодруулах нь зөв байх.

Алдагдлын хувьд бас ийм байна. Ц.Сандаг-Очир гишүүн ээ.

Энэ тоонууд чинь бас л хязгаар нь. Төсвийн тогтвортой байдлын хууль дээр байгаа нөгөө тусгай шаардлагын

хязгаарууд шүү дээ. Бид хуульчилчихсан. Энэ хуулийг тэр тоонуудыг олон гишүүн асуугаад байгаа юм. Би зүгээр нэг удаа үүнийг уншаад танилцуулчихъя гэж бодлоо.

Одоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9 дээр ингэж байгаа юм. 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жил нь дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь нь 2017 онд 10, 2018 онд 9.5, 2019 онд 6.9, 2020 онд 12.5, 2021 онд 8.8, 2022 онд 5.1, 2023 онд 3.6, 2024 онд 2.8, 2025 оноос цаашаа 2 хувь буюу түүнээс доош байхаар ингээд хуульчилчихсан тэр хуулийн хязгаар тоонууд байгаа юм.

Намар бид төсөв өргөн барьж орж ирэхэд үүнээс дотор л бид барьж орж ирнэ. Эцсийн төсвийг энэ Их Хурал дээрээ бид ярилцаад батална. Гэхдээ би дахин дахин хэлээд байгаа нэг зовлон маань ийм байна шүү.

Төсвийн зардал 2.5-аар нэмэгдэх хязгаар байна. Их наядаар. Гэтэл бид хуулийн хүрээнд зайлшгүй нэмэх урсгал зардал 3.4 их наяд. 3.4 их наяд. Бүр даруй 900 тэрбумаар давж байгаа. Үүнийг яаж шингээх вэ гэдэг л бидний 9 сар хүртэлх толгойны өвчин байна.

Тэгээд ямар ч байсан төсөвлөөд оруулж ирнэ. Тэгээд энэ дээрээ хэдүүлээ ярилцана даа.

Л.Мөнхбаатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Асуулт асуухгүй ээ. Би зүгээр саналаа хэлье, байр сууриа илэрхийлье.

Яах вэ, ер нь хүнд үед ажиллаж байгаа Сангийн яам, сайд байгаа. Ойлгож

байгаа. Маш хүнд үед, КОВИД-той, амны хаалт, масктай, эдийн засаг нь хасах 4 хувьд хүрчихсэн, өдөр шөнөгүй өр зээл нь нэхэгдсэн, дефолт зарлачих хэмжээнд тулчихсан ийм л улс орныг авсан уу. Үнэн. Тэгээд өнгөрсөн хоёр жилийн хугацаанд харьцангуй хатуу бодлого барьж ирсний хүчинд энэ Засгийн газар бас том утгаараа эдийн засгийн үзүүлэлтүүд нааштай гарч ингэж харагдаж байгаа.

Түүнээс хасах 4 хувьтай байхад юун цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэх асуудал ярих вэ. Одоо бас ингээд эдийн засаг жоохон тэлээд, нэмэгдээд орлого ашиг нэмэгдээд ингээд ирж байгаа тохиолдолд цалин, мөнгө нэмэгдүүлэх бололцоо боломж одоо л жоохон гарч байна.

Тийм учраас би Засгийн газрыг, Сангийн яамыг чамгүй боломжийн хэмжээнд ажиллаж байгаа гэж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Үг хэллээ. Б.Жавхлан сайд аа, ер нь их олон гишүүдийн Ц.Туваан гишүүнээс эхлээд нэлээн олон гишүүдийн асуултад гараад байгаа гурилын үнийн өсөлттэй холбоотой асуудлаар.

Өнөөдөр бол яах вэ, хэлэлцэх эсэхийг шийдэж байгаа. Тийм ээ.

Анхны хэлэлцүүлэг дээр нь та яг мэргэжлийн яам, холбогдох албан тушаалтнуудыг нь байлцуулж байгаад нэг тодорхой хариулт өгөхгүй бол одоо энэ дээр үр тарианых нь үнэ өсөөгүй байхад гурилын үнэ хоёр дахин өслөө гэдэг ийм гомдол, саналыг иргэд ч ярьж байгаа. Гишүүд их олноороо ярьж байгаа учраас энэ дээр дараагийн хоёр дахь хэлэлцүүлэг дээр мэргэжлийн хүмүүсийг нь байлцуулаад асуултыг тодорхой

хариулт өгье. Иргэд олон нийтэд ч тодорхой ойлгог.

Одоо Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужин асуултаа асууя.

П.Анужин: Баярлалаа.

Сая Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гишүүд тойрог дээрээ ард иргэдийнхээ санал авах уулзалтыг хийхэд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт яах вэ, энэ цалин, тэтгэвэр, тэтгэмжийн суурь шинэчлэлээ хийнэ гэсэн яасан бэ, нийгмийн даатгалын багц хуулийн асуудлыг өмнөөс асууж байсан.

Энэ үүднээсээ нийгмийн даатгалын багц хууль шийдэх санхүүгийн хэд хэдэн асуудлууд байгаа. Би энэ дээр тодруулж асууя гэж бодож байна. Бид тэтгэврийн итгэлцүүрийг жил бүр шинэчилнэ гэдэг нэг зүйл хэлж байгаа.

Энэ дээр 235 тэрбум төгрөг. Тэгээд нэрийн дансыг мөнгөжүүлнэ гэж байгаа. Дараалсан 7 жилийг 5 болгоно гэсэн энэ зүйлийг бол ард иргэд маш их хүлээж байгаа. Үүн дээр 91 тэрбум төгрөг. Хамтын тэтгэврийн 20 хувийн нэмэгдүүлэлт үүн дээр 7 тэрбум төгрөг.

Инфляцтай уялдуулан тэтгэврийг үнэ цэнтэй болгож тэтгэврийг өөрчилнө гэсэн ийм зүйлүүд ороод нийтдээ 1.1 их наяд төгрөгийн асуудал гарч байгаа.

Эдгээр асуудлаас бусад нийгмийн даатгалын бусад хуулийн зүйл, заалтууд маань нэлээн удаан хугацаанд боловсруулагдаад чамбай явж байгаа. Гол бид шийдэх асуудал бол энэ асуудал байгаа.

Тэгэхээр энэ маань төсвийн хүрээний мэдэгдэлдээ тусгагдаж орж ирсэн үү гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарх нь, гишүүд ер нь сүүлийн үед хөнддөг болсон байна. Энэ хүүхдийн хоолны асуудал. Хүүхдийн хоолны үнэ, өртгийн асуудал. Энэ бол талархалтай.

Тэгэхдээ энэ удаагийн Их Хурал бас нэг удаа нэмсэн гэдгээ мэдээлэл муу байгаа юм уу, мэдэхгүй байгаад байна.

Тэгээд миний бие энэ ажлын хэсгийг ахлаад тэгээд тодорхой хэмжээнд 1500 төгрөг болтол нь нэмүүлэх ажлыг бол бид хийж, хүүхдүүдийн хоолны зардал бас нэмэгдсэн юм шүү. Огт нэмэгдээгүй биш. Энэ удаагийн Их Хурлаар нэмэгдсэн байдаг юм.

Гэхдээ хэдийгээр бид нэмэгдсэн ч гэсэн инфляц энэ гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлттэй холбоотойгоор энэ мөнгөний маань үнэ цэнэ байхгүй унасан гэдэг ийм л асуудал байгаа.

Тэгэхээр нөхцөл байдал ийм байгаа учраас энэ хүүхдүүдийн маань ер нь энэ **“Хүнсний аюулгүй байдал”**, **“Эрүүл монгол хүн”** гээд л Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн үндэсний хэмжээний хөтөлбөрүүд байна. Энэ хөтөлбөрийн чинь гол хэрэгжүүлэх амин сүнс нь бага балчир хүүхдүүд, сургуулийн насны хүүхдүүдээ эрүүл хоол хүнс, шим тэжээлтэй хоол хүнсээр хангах асуудал.

Тэгэхээр бид үүндээ өөрчлөлт хийж чадахгүйгээр **“Эрүүл монгол”** хүний асуудлыг ярих ямар ч боломж байхгүй. Хүнсний хувьсгалыг ч ярих нь утгагүй.

Тийм учраас эдгээр зүйлүүдтэй уялдаж энэ хоол, хүнсний асуудлыг, тэр дундаа дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн хоол, хүнсний шим тэжээлд түүнд зориулагдах төсвийн асуудал яг бодитойгоор тусгагдсан уу гэдгийг асуух гэсэн юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулахаас өмнө зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар Багануур дүүргийн 1 дүгээр хорооны залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Асуултад хариулья. П.Анужин гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Б.Жавхлан: П.Анужин гишүүний асуултад хариулья.

Хүүхдийн хоолны мөнгө нэмж байсныг сануулж өгсөнд баярлалаа.

Энэ удаа бид эдийн засгийнхаа өсөлтийг бодит хязгаар маань ийм юм гэж тогтоож аваад тэрийг дагасан төсвийн орлого маань ийм байгаа юм, энэ хүрээндээ зардлаа нэмнэ шүү гээд хязгаарууд ороод ирсэн байгаа юм.

Тэр зардлын маань нэмэгдэх хязгаар нь 2.5 их наяд. Миний байн байн хэлээд байгаа тоо хуулиар нэмэгдэх ёстой урсгал зардал маань 3.4 их наяд. Бид 1.8 их наядын алдагдалтай хийгээд хийгээд цаана нь дахиад 900 тэрбум төгрөгөөр

хуулиар санхүүжигдэх нягт урсгал зардлаа эх үүсвэр дутаж байгаа ийм зовлон байгаа юм.

Тэгэхээр тэр нэмэгдэж байгаа 3.4 их наяд дотор таны саяын хэлсэн нийгмийн даатгалын багц хуулиар нэмэгдэж болзошгүй ийм зардлууд байгаа гэдгийг дуулгая. Яагаад вэ гэхээр нийгмийн даатгалын багц хуулийг Засгийн газар дээр санаачилж, тэнд бид бүх тооцоогоо хийж, Сангийн яам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай өдөр шөнөгүй хоёр жил дамжиж хийсэн ийм хуулийн төсөл.

Тийм учраас бид нэлээн хариуцлагатай хандаж байгаа. Нэгэнт хууль батлагдвал бид хуулийнхаа хүрээнд төсөвлөх ёстой. Ийм зовлон байгаа шүү П.Анужин гишүүн ээ.

Тийм учраас ямар ч байсан 9 сард бид 10 сард өргөн барих хууль дээрээ нийгмийн даатгалынхаа шаардлагатай нэмэлтүүдийг, батлагдах хязгаарынхаа хүрээнд багтааж оруулж ирнэ.

Тэгээд 2024 оныхоо төсвийн хууль дээрээсээ шинэ нийгмийн даатгалынхаа багц хуулийг баримтлаад явна даа.

Л.Мөнхбаатар: П.Анужин дарга тодруулж асуух уу? 1 минут.

П.Анужин: Сангийн сайд тодорхой хариулт өгсөнд баярлалаа.

Ер нь улсын төсвийн асуудал хэмжээ хязгаартай. Бид тэтгэврийн суурь тогтолцооны шинэчлэл хийхэд тодорхой хэмжээний үнэ өртөг шаардлагатай байгаа гэдгийг ард иргэдтэй уулзаж явж байхдаа хэлж байгаа.

Түүнээс биш зөвхөн сайн сайхан юманд итгүүлээд төсвөө даахгүй,

дийлэхгүй ийм зүйлүүдийг бас энэ ажлын хэсгийнхэн ярьж яваагүй ээ гэдгийг та гадарлаж байгаа байх.

Ард иргэд маань ч гэсэн бас тодорхой хэмжээний ойлголттой байгаа. Гэхдээ бид улсын төсвийг яриад л ард иргэдийнхээ амыг хаагаад байж болохгүй. Үүнийг хийе гэсэн сэтгэл эрмэлзэлтэй л байх ёстой.

Тэгэхдээ энэ талаасаа Сангийн сайд үргэлж дэмжиж энэ хуулийг бас явуулахын төлөө гарц гаргалгааг ярилцаж байгаад би талархаж байгаагаа илэрхийлье. Ямар ч байсан гэ гэрэл гэгээтэй зүйлүүд сүүлийн үед нийгмийн даатгалын багц хууль дээр сонсогдож байгаа. Баярлалаа танд.

Тэгээд ямар ч байсан баярлах нь яах вэ. Үүнийг явуулах л шаардлагатай байна.

Л.Мөнхбаатар: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороон дарга Гомпилдоогийн Мөнхцэцэг асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хоёр зүйлийн асуулт байна.

Тэгэхээр бид 2021 онд Соёлын тухай хуулийг шинэчилсэн найруулгаар баталсан. Хууль маань хэрэгжээд 2 жил гаруй болж байна.

Ер нь энэ хуулийн гол заалт, онцлох зүйлчлэл нь юу байсан бэ гэхээр ер нь соёл, урлагийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид, ажиллагсдын 5 жил тутамд олгодог мөнгөн тэтгэмжтэй холбоотой асуудал гэдгийг бас зохицуулж өгсөн зохицуулалт орсон.

Дээр нь соёл, урлагийн байгууллага өөрсдөө давсан орлогоороо санхүүждэг. Мөн дээрээс нь шинэ уран бүтээлээ туурвих ийм бололцоо нөхцөлийг нээж өгсөн ийм том зүйл, заалтуудыг тусгаж өгснөөр Соёлын хууль амин сүнс нь оршиж байгаа гэж үзсэн.

Тэгэхээр өнөөдөр манай Соёл, урлагийн байгууллагын ажилчид маань тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх вэ. Тэмцэж байна. Тэмцэхээс өөр аргагүй байдалд ч хүрч байна.

Бид цалинг чинь нэмнэ ээ гээд нэг үгээр хааж болохгүй.

Тэгэхээр өнөөдөр 2025-2026 оны төсвийн төсөөлөл дотор ер нь соёл, урлагийн байгууллагын ажилчдын цалинг ямар шатлалбараар нэмээд, ямар түвшинд хүргэнэ гэсэн тооцооллыг Та бүхэн маань хийсэн бэ гэж энэ асуултыг асууя.

Дээр нь Боловсролын багц хууль цогцоороо шинэчлэгдэх гээд явж байгаа. Энэ салбарт энэ хууль хэрэгжих хөрс суурь нь яалт ч үгүй эдийн засгийг дэмжих хөшүүрэг нь чухал байгаад байгаа юм.

Мөн багш, ажилчдын цалин. Мөн дээрээс нь тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлууд бас тусаж байгаа, яригдаж байгаа.

Бид одоо бас цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг сайжруулна гээд олон жил, ингээд жил дараалангийн төсөв дээр л яриад байдаг.

Гэтэл соёл, урлагийн салбарт, боловсролын салбарт огт дуусаагүй барилга байгууламжууд маш олон байна. Үүнийгээ 2024 он гэхэд дуусгаж барах уу? Ямар тооцоо юмнууд хийгдсэн бэ?

Улсын хэмжээнд хэчнээн барилга байгууламж байна. Үүнийгээ дуусгахгүй, царцчихсан барилга байгууламж хөдөө орон нутагт маш их байгаад байгаа. Үүнийг хэзээ дуусгаж барагдуулах вэ?

Соёлын аялал жуулчлалыг бид сэдэлжүүлнэ. Ер нь зураг, төлөвлөлтийг нь хийнэ ээ гээд л ингээд ярьж байгаа юм. Аялал жуулчлалыг маш ихээр татаж байж улс орны эдийн засагт дорвитой өөрчлөлт орно гээд ингээд үзээд байгаа.

Тэгэхээр мөнгө шаардагдах ажлууд бас бий. Энэ мөнгө шаардагдахгүй ажлууд ч бас байдаг.

Ер нь тэгэхэд энэ талын хөрөнгийг хэрхэн шийдэж байгаа юм бэ?

Ер нь судалгаа юмнууд хэрхэн хийгдэв. Ялангуяа соёлын аялал жуулчлалыг хийхэд бүсчилсэн байдлаар хөгжүүлнэ гэдэг. Энэ дээр яг ямар төсвийн төсөөлөл хийгдээд байгаа вэ гээд ийм 3 зүйлийн асуултыг тавьж байна.

Л.Мөнхбаатар: 18 цаг болсон байна. Ажлын цаг дууссан. Гэхдээ өнөөдөр хэлэлцэх асуудал дуусаагүй байгаа тул чуулганы нэгдсэн хуралдааныг сунгаж хуралдуулахаар шийдвэрлэлээ. /алх цохив/

Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн асуултад хариулъя.

Энэ дээр их сайн мэдээтэй байгаа шүү. Яг энэ соёлын хуулийн дагуу Г.Мөнхцэцэг гишүүн маань ч өөрөө нэлээн энд оролцож байж баталсан хууль. Одоо ингээд тэр 5 жил бүр авах нэмэгдэл

маань энэ долоо хоногт, одоо өнөө маргаашгүй яг соёл, урлагийн салбарын албан хаагч нарын гар дээр очно.

Өчигдөр Засгийн газрын хуралдаанаар журам нь батлагдсан. Соёлын сайд журмаа оруулаад баталсан. Төсвөө бид бэлдсэн. Төсвийн эрх нээгдэхэд бэлэн байна. Өнөөдөр бараг журам нь албажаад гарч байгаа байх. Маргаашаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн дансаар дамжаад явна. Нэг, хоёр хоног мэдээж энд шаардагдана.

Тийм учраас таны батлалцсан хууль бол бодит хэрэгжилт нь эхлээд явлаа.

Ашгүй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд ороод ирсэн байна. Энэ цалингийн асуудал дээр та нэмж яриарай.

Төсвийн хувьд бид 2024 оныхоо хязгааруудыг аваад ороод ирсэн. Урсгал зардлаа нэмж болох хамгийн том тоогоо бариад л ороод ирж байгаа юм. 2.5 их наядаар бид нэмэхээс өөр аргагүй болж байна. Энэ бол тэгж тохиолдлоор нэмж байгаа тоо биш. Энэ нь дандаа хуулиар нэмэгдэх ёстой урсгал зардлууд байгаа юм.

Дээрээс нь Боловсролын хууль, Соёлын хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд гээд салбарын маш том хуулиуд явж байна.

Эдгээр хуулиудыг дагаж нэмэгдэх зардал, санхүүжилт, төсвийн ачааллууд нэмэх зүйлүүд ч байгаа. Тэгээд энэ хаврын чуулгаар багтаад энэ том хуулиуд батлагдах ёстой.

Өөрөөр хэлбэл ирэх оны төсвийг төлөвлөх хугацаанд энэ хууль батлагдаад гарчихна гэж хүлээж байгаа. Ингээд 2024

оныхоо төсөв дээр хуулийн дагуу төсвөө төлөвлөнө.

Дутуу барилга, байгууламжууд, ялангуяа соёлын салбарууд, хөдөө орон нутагт баригдаж байсан зүйлүүд дээр бол. Энэ бол нийтлэг зарчмаар шүү. Г.Мөнхцэцэг гишүүн ээ. Үүнийг яг тэр соёлын байгууллага, тэд нарыг нь сугалж аваад түрүүлээд ашиглалтад оруулчихна гэж худлаа амлалт яримааргүй байна. Бид энэ дутуу барилгуудыг гүйцээхийн тулд энэ жил бид нэг ч шинэ хөрөнгө оруулалтууд, шинэ байшин барилга тавиагүй.

Тийм учраас ер нь бид чинээгээрээ л дутуу барилгуудыгаа гүйцээх гэж энэ жил дандаа үргэлжлэх төсвийн хөрөнгө оруулалтуудыг тавьсан байгаа. Тэр ч бүү хэл 323 тэрбум төгрөгийн нэмэлт үнийн өсөлтүүдийг ч тусгасан байгаа. Энэ дотор соёлын байгууллагуудын хөрөнгө оруулалтууд бас нэлээдгүй байгаа.

2024 онд ч гэсэн аль болох үргэлжилж байгаа төсвүүдийг нэг мөр дуусгах зорилготой ажиллана.

Энэ жил харин гишүүд маань энэ төсвийн бодлогыг маш сайн дэмжиж шинэ хөрөнгө оруулалтууд тавиагүй.

Тийм учраас ирэх жил дуусгах ажлууд маань нэлээн тийм зорилтдоо хүрсэн үр дүн гарах болов уу гэж ингэж бодож байна.

Соёлын аялал жуулчлалын хувьд бид ер нь **Welcome to Mongolia** гээд ганц соёлын ч биш байгалийн, мөн манай түүх, соёл гээд. Тэр ч бүү хэл Монгол Улс маань дөрвөн улиралтай. Өвөл нь мөн жуулчид хүлээж авах ийм боломжуудаа дайчилж энэ жил, хойтон жил гээд ойрын хугацаанд томоохон хөтөлбөр боловсруулаад ажиллаж байгаа.

Энэ дотор манай соёлын аялал жуулчлал нэлээд томхон байр суурьтай байгаа.

Тийм учраас бид.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одоо Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Энэ төсвийн хүрээний мэдэгдэлд 2024 оны төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 22.9 их наядаар төлөвлөж оруулж ирсэн байна. Энэ нь 2023 оны батлагдсан төсөвтэй харьцуулах юм бол 1.5 их наядаар нэмэгдсэн байна л даа.

Тэгээд инфляци болохоор 8 хувьд барина гэсэн ийм зорилт тавиад ороод ирсэн байна.

Тэгэхээр бид чинь эдийн засаг агшиж байх үед мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлээд төсвөө тэлээд, хүүхдийн мөнгө олгоод ажилласан. Одоо эдийн засаг өсөж байгаа үед төсвийн хумих бодлого барихгүй юм уу? Тэгэхгүй болохоор энэ инфляц чинь 8 хувьдаа барихгүй юм шиг л надаа харагдаад байна л даа.

Тэгээд энэ зарлагаа дахиад ийм өндөр болгоод ороод ирэхээр. Мөн гишүүд ярьж байна. Цалин, тэтгэврийн асуудлууд гээд ярьж байна. Тэгээд бид чинь ингээд л төсвөө тэлээд л байх юм бол инфляцаа барьж чадахгүй дахиад л нөгөө нэмсэн цалин нь үнэгүйдээд л төгрөг цаас болоод л явах юм биш үү.

Хоёрдугаарт, нийгмийн халамжийн хэмжээг бас ингээд нэмэгдүүлээд ороод ирсэн байна л даа. Тэгээд бид чинь **“Халамжаас хөдөлмөрт”** гээд л баахан хурал хийгээд л одоо энэ халамжийг цэгцэлнэ, нэг хүнд 2, 3, 4 төрлийн халамж явж байна. Тийм ээ. Давхардсан тоогоор бараг 700 гаруй

мянган хүн халамж авч байна гээд яриад байдаг.

Тэгэхээр энэ асуудлыг та хэд засаг дээр юу гэж ярьсан юм бэ?

Гуравт нь, орлого талдаа Дубайн гэрээг цуцлаад гүний уурхайг ашиглалтад оруулсантай холбоотой манай орлого 2024 онд нэмэгдэх үү? Гүний уурхай нь яг хэзээ бүрэн ажиллаад бид зэсийн экспорт маань нэмэгдээд орлого бодитой нэмэгдэх юм бэ гэсэн ийм гурван асуулт байна.

Л.Мөнхбаатар: Ч.Ундрэм гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Ч.Ундрэм гишүүний асуултад хариулъя.

Төсвийн бодлогоор бид мөчлөг сөрсөн ийм хатуу бодлогыг сүүлийн КОВИД-ын хүнд үед ч тэр, энэ дайны нөлөө нэлээдгүй орж ирж байгаа энэ үед ч гэсэн бид барьж ирлээ.

Тэгсний үр дүнд макро тэнцвэр маань бас харьцангуй сайжирч гарч ирж байна.

Таны саяын ярьсантай ер нь агуулгын хувьд үе үеийн Сангийн сайд нар л санал нийлэх байх гэж бодож байна.

Гэхдээ өнгөрсөн 2-оос 3 жил энэ төсвийн хүндрэлтэй байх үед ялангуяа энэ цалин үнийн өсөлттэй уялдуулж хангалттай бид өөрчлөлт оруулж чадаагүй. Ийм боломж ч бидэнд байгаагүй.

Та нэг талаар цалингаа ярилаа. Нөгөө талаар хуримтлалаа үргэлжлүүлэхгүй юм уу гэж ярилаа.

Тэгэхээр яг энэ хайчин дунд л бид тэнцвэртэй шийдвэр гаргах ёстой гэж бодож байна.

Энд оруулж ирж байгаа энэ тоонууд байж болох хязгаарууд шүү гэдгийг л дахиж хэлье.

Эдийн засгийнхаа өсөлтийг бид ингээд тодорхойлчихож байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ. Тэрийг хангасан төсвийн маань нийт орлого, түүндээ хязгаарлагдах зардлын хязгаарууд маань энэ байгаа юм шүү.

Гэхдээ та бүхэн нэг тоог хараарай. Үүнийг гишүүд маань бас анхааралдаа хараасай гэж би хүсэж байна. Тэр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ дандаа буурч байгаа шүү. Дандаа буурч байгаа. Хувь хэмжээ нь. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нэрлэсэн дүнгээр 19 их наядаас 21 их наяд руу өсөж байгаа боловч дотоодын нийт дүнд эзлэх хувь хэмжээ нь 35-аас 32 хувь руу буурч байгаа.

Зарлагын дээд хэмжээ 37 хувиас 37.6 шүү. Бараг 38 хувиас 35 руу буурч байгаа. Зардлын өсөлтийн хувь хэмжээ ч гэсэн 4.7-гоос 3.9 рүү буурч байгаа.

Гадаад өрийн тааз. Яах вэ, энэ бол яг хуулиараа бид 65-аас 60 хувь руу шилжиж хязгаар маань багасаж ирж байгаа. Гэхдээ бид 51 хувь дээр барьж чадаж байгаа.

Тэгэхээр дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх хэмжээгээр зардлын эзлэх хувь хэмжээ нь дагаад өсөж төсөв маань хэт тэлж байгаа нь ирэх жилийн төсөв дээр харин ч эсрэгээрээ буурах зөв хандлага руугаа орж ирж байгаа гэдгийг хэлье.

Нийт халамжийн хэмжээ абсолют дүнгээр нэмэгдэж байгаа юм. 1.9 их наядаас 2.1 их наяд гээд. Энэ бол ерөөсөө хүн амын өсөлттэй холбоотой шүү. Хүн амын механик өсөлттэй холбоотой хувь хэмжээ.

Х.Булгантуяа сайд нэмж хэлээрэй. Халамжийн эдийн засгийн төрөл зүйл бол огт нэмэгдээгүй байгаа. Нэмэгдээгүй байгаа. Гэхдээ бид яг энэ нийгмийнхээ зорилтот бүлэг дээр хэрвээ орлого, төсвийн боломж нэмэгдэж байгаа бол яг энэ рүүгээ чиглэсэн халамжийн бодлогыг ерөөсөө огт орхиж болохгүй. Огт орхиж болохгүй.

Харин халамжаас хөдөлмөр лүү шилжих энэ бодлогоо ч бас түлхүү явуулах ёстой. Үнэхээр авах ёстой иргэддээ бид цаашдаа үүнийг онцгой анхаарч төсөв дээрээ байнга авч явах нийгмийн томоохон хариуцлага байгаа гэж бодож байгаа. Тийм.

Оюу Толгой. Үнэхээр бид 12 жил хүлээсэн далд уурхайн үндсэн баялаг руугаа, 80 хувь руугаа л хүрч эхэлж байна. 6 сард эхлэх ёстой байсан. 2 сарын өмнө бид 4 сард эхлүүлж чадсан.

Харин энэ маань шат дараатай төсөвт орлого нь нэмэгдэх учиртай байгаа юм шүү.

Л.Мөнхбаатар: Асуултад гүйцэтгээд хариулъя. 1 минут.

Б.Жавхлан: Оргил үе нь 2028-2030 онд очих юм.

Гүний уурхайд эхэллээ гэмэгц төсөв дээр ерөөсөө ингээд л томоохон орлогууд орж ирнэ гэсэн ийм хүлээлт байгаад байх шиг байна. Энэ бол бас яг тийм биш байгаа юм шүү.

Ямар ч байсан бид том, яг үндсэн агуулга, биет рүүгээ ингээд очиж байна. Одоо уурхай маань яг технологийн хувьд бол буцах ямар нэг тийм эрсдэл байхгүй. Цаашаагаа дандаа нэмэгдээд явах юм.

2023 оных дээр бид 6 сараас далд уурхай нэмэгдээд 50 тэрбумын. Өмнөх жилүүдээсээ нэмэх өсөлт байгаа.

Хойтон 100 гаруй болно. Ингээд нэмэгдсээр нэмэгдсээр яг оргил үе нь 1.5 сая тонн олборлох үе нь 2028 оноос эхэлнэ. Тэр үед одоо байгаа хэмжээнээсээ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. **Б.Жавхлан** сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Оргил үедээ 1.5 сая тонн хүрнэ.

Одоо байгаа өнөөдрийнхөө зэсийн ханшаараа байх юм бол орж байгаа орлогоосоо бүр 2-оос 3 дахин нэмэгдэх. Жилдээ 500-аас 700 тэрбум төгрөгийн төсөвт төрөл бүрийн татварууд төвлөрүүлдэг. Энэ хэмжээ 2-оос 3 дахин нэмэгдэнэ.

Одоо байгаа ханш дээрээ байвал ер нь 3 дахин нэмэгдэх боломжтой. Тийм.

Л.Мөнхбаатар: Одоо Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Ирэх жилүүдийн төсвийн хүрээ хязгаарын тухай яригдаж байна. 2024 онд төсвийн зарлага 22.9, 23.0 их наяд болж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дотор цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нийт сангийн өсөлт ер нь хэд байгаа юм бол? Одоо жишээлбэл эндээс гардаг нэг асуудал

цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгддэг. Дагаад тодорхой хугацааны дараа мөнгөний ханш унадаг, инфляц болдог. Дахиад энэ нь дараагийн өсөлтийг шаарддаг нэг ийм үхлийн тойрог гэмээр зүйл тасардаггүй.

Тэгэхээр энэ бодлого дотор ер нь саяын тэр буруу тойргийг, буруу циклийг таслах, тэр худалдан авах чадвар нь нэмэгдэх энэ бодит өсөлт, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн бодит өсөлт болох. Дагаж үнийн өсөлтөд нөлөөлөхгүй байх чиглэлээр ер нь ямар арга хэмжээ бодож байгаа юм.

23 их наядад тодорхой хэмжээгээр мэдээж тэр сан нь нэмэгдэж байгаа байх.

Тэгэхээр энэ нь өөрөө бүтээмжтэйгээ яаж холбогдох юм. Тэр бодит өсөлт хэрхэн яаж бий болох чиглэлд бодож байгаа юм бол.

Хоёрдугаарт нь, одоо дахиад төсвийн тухай ярьж байна. Гэтэл төсөв ярьсаар байтал төсвөөс гадуур баахан зардал бид явчихдаг. Эрдэнэтээс баахан мөнгө явдаг. Бараг 1 их наядар нь цахилгаан дулааны мөнгө дааж байна, жорлон сууц барьж байна. Бүгд төсвөөс гадуур явж байдаг.

Эрдэнэтээс, Эрдэнэс Тавантолгойгоос гээд төсвөөс гадуур баахан зардал явчихдаг. Тэгээд энэ нь энэ бүгдэд яригддаггүй.

Тэгэхээр иймэрхүү төсвөөс гадуурх, тэгээд төсвийн шинжтэй арга хэмжээнүүд ирэх оны төсвийн төсөөлөл, олон зүйл дотор хумигдаж байгаа юу? Ийм зүйл байгаа юу?

Гуравдугаарт нь, дахиад төсвийн тэнцлийг аятайхан харагдуулдаг, тэрийг гоёчилж харагдуулдаг өнгөрсөн жил

гарсан нэг зүйл Ирээдүй өв сан, Тогтворжуулалтын сангийн 1.5 их наяд байлуу? Нэлээн их хэмжээний мөнгийг үндсэндээ төсвийн орлогод тооцоод явчихсан.

Тэр чинь уг нь төсвөөс тусдаа бүртгэгдэж байх ёстой сан байх. Гэтэл өнөө жил яг саяын сангуудыг тэр АМНАТ-ийн орлого болоод бусад зүйлүүдийг саяын хоёр сангийн орлого, зарлагууд төсөвт ямар байдлаар, энэ төсөөлөлд ямар байдлаар тусгагдаж байгаа юм бол? Эдгээр асуудлуудыг тодруулъя.

Л.Мөнхбаатар: О.Цогтгэрэл гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Цалин орлоготой холбоотой, үнийн өсөлттэй холбоотой яах аргагүй ийм чөтгөрийн тойрог руу дэлхий нийтээрээ явж орсон.

КОВИД-ын хүнд үед тээвэр ложистикийн хязгаарлалттай байдал, улс орнуудын хил хаалттай байснаас болоод ер нь нийлүүлэлтийн шинжтэй инфляцтай бид хоёр жил явж ирсэн.

Сүүлийн жил үндсэндээ энэ хилүүд нээгдээд тээвэр ложистикаас хамааралтай зардлууд нь буураад эрэлтийн инфляц руугаа орж ирсэн. Эрэлтийн инфляц руугаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл цаашдаа бид өмнөх учирч байсан инфляцуудаасаа илүү их орлогоос хамаарсан их эмзэг инфляцын бүтэц рүү орж явсан. Тантай 100 хувь санал нийлж байна.

Энэ дэлхийн улс орнуудад бүгдэд нь учирч байгаа маш том сорилт болж байгаа. Цалин нэмлээ. Үнэ өслөө.

Энэ цалин нэмсэн ямар ч үр дүн гарахгүй байх иймэрхүү томоохон макро бодлогын сорилт руу орж ирж байгаа.

Тийм учраас **төсвийн бодлого, мөнгөний бодлого** хоёрыг маш сайн уялдуулж явах нь хамгаас чухал байгаа.

Гишүүд бүгд л ярьж байна. Цалин нэмье гэж байна. Нөгөө талаас хуримтлалаа бүр зузаалах ёстой шүү. Орлого нэмэгдэж байх үед гээд.

Тэгэхээр энэ хайчин дунд л зөв тэнцвэртэй бодлого явуулах нь бодлогын том сорилт болж ирж байгаа.

Тэгэхээр бид цалингийн өсөлт, энэ юмнуудаа ч тодорхой хангана. Мөн хуримтлалаа ч цаашаа үргэлжлүүлж явна.

Тэр хуримтлал гэдэгтэй таны тэр сүүлийн асуулт нь бас уялдаж байна.

Тэгэхээр бид ирэх жил АМНАТ-ийн орлогуудыг таны саяын хэлсэн **Тогтворжуулалтын сан болон Ирээдүй өв сан, Орон нутгийн хөгжлийн сан** руу санхүүжүүлдэг яг тэр хуучин загвараараа төсөвлөсөн байгаа юм. Тэрийг хэлье.

Төсвөөс гадуур хийгддэг хөрөнгө оруулалтууд. Энэ дээр бид 2022 оноос эхлээд шүү. Өнгөрсөн оны төсвөөс эхлээд нэлээн хатуу бодлого барьж ирж байгаа.

Үүнийг төсвийн бодлогодоо уях, ялангуяа төсвөөс гадуур маш том эдийн засаг үүсгэж байгаа учраас төсвийг эцэслэн баталдаг Улсын Их Хурал дээр энэ асуудал яригддаг байх энэ хязгааруудыг тавьж өгсөн байгаа.

Тэр хязгаар тоонуудыг Ж.Ганбат даргаас хэлээдэх.

О.Цогтгэрэл гишүүн тэр юуг ойлгочихлоо. Тийм ээ. АМНАТ-ын орлогыг тэнцвэржүүлсэн орлого руу авахгүйгээр сангуудаа 100 хувь санхүүжүүлдэг тэр бүтцээрээ, хуучин бүтцээрээ буцааж 2024 онд хязгаартаа оруулсан байгаа гэсэн үг. Тийм.

Ер нь энэ КОВИД-ын хүнд үед бид төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагуудыг хүртэл түдгэлзүүлэх тусгай заалт байдаг юм шүү дээ. Засгийн газар тийм эрх байдаг.

Тэр эрхийн хүрээнд КОВИД-ын хүнд үед бид тодорхой зарим ийм хатуу шаардлагуудыг түдгэлзүүлэх, мөн сангуудыг урсгал зардал, хүүхдийн мөнгө тавьж өгөхөд зарцуулсан. Хүнд үеийг ингэж давсан байгаа. Ирэх жилээс яг сангуудад нь санхүүжилтийг нь хийгээд явна гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Н.Наранбаатар гишүүн байхгүй байна. Тодруулах юм уу?

Ажлын хэсэгт нэмж хариулах уу? 82 дугаар микрофон өгье. Ажлын хэсэг хариулья.

Ж.Ганбат: О.Цогтгэрэл гишүүний асуултад нэмж хариулья.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу төсвийн тусгай шаардлагыг хангасан байдлыг нь хэд хэдэн үзүүлэлтээр тооцож үздэг. Эхнийх нь тэнцвэржүүлсэн орлого гэдгийг ингэж тооцсон.

Бид тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо хуульд заасан аргачлалын дагуу тооцдог. Энэ дээр тэнцвэржүүлсэн

үнийг 2024, 2025, 2026 онд зэс, нүүрс хангана гэж тооцоолж байгаа. Энэ дагуу бид хуримтлал үүснэ гэж.

Тэнцвэржүүлсэн тэнцэл, хуулийн хязгаар маань 2024 онд төсвийн алдагдал дотоодын нөхцөлд эзлэх нь 2.8 хувь, 2025 онд 2 хувь, 2026 онд 2 хувь. Энэ бүгдийг бид хангана гэж тооцсон байгаа.

Мөн тухайн жилийн нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хувь нь 2024 онд 12.3 хувь, 2025 онд 4.1 хувь, 2026 онд 7.3 хувь байна гэж тооцсон байгаа.

Тэгээд тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж нь 2024 онд 12.8, 2025 онд 11.0 хувь, 2026 онд 10.3 хувь байна гэж тооцсон байгаа.

Дараагийнх нь, Засгийн газрын өрийн хязгаар байгаа. Мөн энэ дээр тусгай шаардлагыг хангах ёстой гээд. Хуулийн хязгаар нь 2024 онд Засгийн газрын өр 60.0 хувьтай байх ёстойг бид хангана.

2025 онд мөн 60.0 хувь байх ёстой. 2026 онд мөн 60.0 хувиас хэтрэхгүй байх ёстой гэсэн тусгай шаардлагуудыг бид хангаж төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулсан байгаа.

Л.Мөнхбаатар: О.Цогтгэрэл гишүүн тодруулж асууя. 1 минут.

О.Цогтгэрэл: Ер нь манай Сангийн яам, Эдийн засгийн яам, Засгийн газраас саяын хэлдэг цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамжийн нэмэгдэл, үнийн өсөлт, дахиад худалдан авах чадварын бууралт, дахиад өсөлтийг шаарддаг энэ чөтгөрийн тойргийг таслах чиглэлд яг бодитой нэг тийм үйлдлүүд ерөөсөө харагдахгүй.

Тэр нь бүтээмжтэй холбогдсон, бодит өсөлттэй холбогдсон биш. Тэнд нэг уул уурхай, түүхий эдийн үнэ өсдөг. Тэрийг авчраад бусад салбарт түгээгддэг. Энэ нь дахиад бодит эдийн засаг, бодит сектор, хувийн сектортойгоо уялддаггүй. Яг нэг ийм чөтгөрийн тойрог.

Бид энэ дээр нэг томоохон бодлого дэвшүүлж л үүнээс хөндийрөх л хэрэгтэй байна л даа.

Зарим урьдчилсан мэдээллээр төсвийн тодотгол 2.5 их наядын цалингийн сангийн нэмэгдэл гээд л мэдээллүүд явж байна лээ.

Үүний нөгөө талд бодит эдийн засгийн бодит зүйлээ л бид ярихгүй бол ийм эдийн засгийн тэнцвэр алдагдсан.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Б.Жавхлан сайд. Б.Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: О.Цогтгэрэл гишүүн, уг нь та асуухдаа 2024 оныхыг асуусан.

Сая хэлэхдээ харагдахгүй байна гээд өнгөрсөн цаг дээр ярьчих юм. Тэгвэл би тэр дээр нь тодруулга өгье.

2021, 2022 онд бид мөчлөг сөрсөн бодлогыг маш амжилттай хэрэгжүүлсэн шүү. Маш амжилттай хэрэгжүүлсэн.

2022 онд бид төсвийн хуулиараа 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарах хязгаартай байсан. Тэгвэл бид 900 тэрбум төгрөг болтол 1.5 их наядар бууруулж чадсан. Өөрөөр хэлбэл тийм хэмжээгээр орлого нэмэгдсэн байхгүй юу. Орлого нэмэгдсэн хэмжээгээр бид зарлагаа өсгөөгүй учраас өнөөдрийн энэ төсвийн тэнцвэртэй байдал хангагдсан юм.

Өөрөөр хэлбэл 2022 онд төсвийн бодлого, мөнгөний хатуу бодлого, төсвийн хэмнэлтэй бодлого яв цав нийцсэний үр дүнд өнөөдрийн макро энэ сайн үзүүлэлтүүд, сайжирсан үзүүлэлтүүд гарч ирсэн юм шүү.

Л.Мөнхбаатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Ирэх онуудад Монгол Улсын эдийн засгийг 5.4-өөс 6.5 хувиар, хэрэглээний үнийн өсөлтийн инфляцийг 6-аас 8 хувиар төсөөлж байгаа юм байна.

Манай улсын өрийн эмзэг байдлын шинжилгээний 5 индикаторын 3 дээр нь анхааруулах дээд түвшнээс давсан дүр зурагтай байна.

Тэгээд өнөөдөр дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, эрсдэлтэй байдал өнөөдөр манай Монгол Улсын эдийн засагт нөлөөлж байгаа нөлөөллийг давхар тооцож анхаарахыг олон улсын байгууллагууд анхааруулсаар байгаа.

Тэгээд Олон Улсын Валютын Сангийн тооцооллоор дэлхийн эдийн засаг ирэх 5 жилийн өсөлт нь 3 орчим байх юм байна гэж төсөөлж байгаа юм байна. 20 жил энэ дундаж болох 3.8 хувиас бага байх төлөвтэй гэж энэ дээр ингэж тооцоо гарчээ.

Тэгэхээр гадаад орчны эрсдэл. Мөн өрийн нөхцөл байдал. Тийм ээ. Манай улсын хувьд маш эмзэг байгаа. Тэгээд дэлхийн эдийн засаг ийм бага өсөлттэй байгаа энэ нөхцөлд яг ямар үндэслэлээр манай эдийн засгийн өсөлт маань 5 хувь байна гэдгийг батлаад байгаа юм бэ? Энэ талаар тодруулъя.

Төсвийн хувьд зарлагаа энэ оны түвшнээс 3 их наядаар нэмэгдүүлээд орж ирж байгаа юм байна. Үүн дээрээ орлогоо тэр хэмжээгээрээ өсгөөд орж ирж байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгээд манай улс 2000 оноос хойш төсвийн зардлын бүтэц бараг өөрчлөлт ороогүй. Урсгал зардал нийт төсвийн 80.0 орчим хувийг эзэлж ирсэн. Хөрөнгийн зардал 20.0 хувийг эзэлж ирсэн гэдэг маань зардлын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 40.0 хувь руу орлоо.

Уг нь Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсан. Ач холбогдлоор нь аваад үзэх юм бол эдийн засаг, макро гол үндсэн үзүүлэлтийнхээ талаас, эдийн засаг талаасаа. Сангийн яам нь төсөв талаасаа ч байдаг юм уу үүнийг нэгтгээд маш том дорвитой шинэчлэл, өөрчлөлт хийнэ байх гэсэн том хүлээлттэй байсан.

Гэтэл 15 жилийн хугацаанд өр үйлдвэрлэж ирсэн. Алдагдалтай. Өөрөөр хэлэх юм бол 2024 онд хасах 1.8 их наядын алдагдалтай, 2025 онд хасах 1.4 их наядын алдагдалтай, 2026 онд хасах 1.5 их наядын алдагдалтай гэж оруулж ирж байгаа энэ байдал нь өнөөг хүртэл бид алдагдалтай төсөв баталж ирсэн талаар ерөөсөө бүгдээрээ л шүүмжилж байсан.

Тэгээд яг ийм адилхан жишгээр өнөөдөр энэ төсвийнхөө төсөөллийг оруулж ирж байгаад эмзэглэж байна.

Ер нь макро эдийн засгийн үзүүлэлтүүд маш сайн болсон. Бид үнэхээр эдийн засаг өсөөд байна л гэж хэлээд байгаа боловчиг хэзээ хүмүүсийн, ард иргэдийн амьдрал дээр энэ нь өөрөө нөлөөллөө үзүүлэх вэ?

Өнөөг хүртэл энэ их алдагдал, энэ их өр төлбөр, энэ инфляц, энэ үнийн өсөлт болгоныг чинь өнөөдөр ард иргэд өөрийнхөө нуруун дээр энэ ачааг үүрч ирлээ. Одоо үнэхээр хангалттай. Үүнээс цаашаа бид үнэхээр чадахгүй нь ээ гэдэг асуудлыг ард иргэд ярьж байна шүү дээ.

Бид уулзахад энэ бухимдал дээд цэгтээ хүрсэн байна. Бид арай жаахан хөрсөн дээрээ бууж ажиллах ёстой юм биш үү? Энэ төсвийнхөө шинэчлэлийг хэзээ хийх юм бэ?

Тэгээд сая тэр орон нутагтай холбоотой асуудлаар хүүхдийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Д.Өнөрболор гишүүний асуултад хариулъя.

Эдийн засгийн өсөлтийн хувьд ийм байгаа шүү. Манайх үйлдвэрлэгч орон биш ээ.

Бид худалдааны эдийн засагтай. Үндсэндээ сүүлийн 30 жил, 1990 оноос хойш ингэж явж ирлээ.

Тийм учраас эдийн засгийн өсөлтүүд ерөөсөө шууд манай экспортын хэмжээтэй шууд холбоотой. Импортын хэмжээтэй шууд холбоотой.

2022 онд бид түүхэндээ анх удаа экспортын хэмжээ маань хоёр орон тоотой гарч байсан. 12.5 тэрбум доллар. Импортын хэмжээ ч мөн дагаад өссөн л дөө. 7-гоос 9. Гэхдээ гадаад худалдаа маань 2.5 тэрбум долларын ашигтай гарсан.

Энэ нь урьд өмнө нь хүрч байгаагүй ийм тоо байгаа юм.

Үүнийгээ доор хаяж хадгалах. Үүнийгээ 2024 онд шүү. 2024 онд өсгөх ийм зорилготой орж ирж байгаа.

Мэдээж “Шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд цэвэр шууд гадаад худалдаанаас хамааралтай төлбөрийн тэнцэлтэй явах биш, дунд урт хугацаанд үйлдвэрлэгч орон болъё гэдгийгээ бид тодорхойлоод явж байгаа.

Тэр бол 10 жилийн хугацаанд яригдах үр дүн, асуудал байгаа. Ойрын хугацаанд бид энэ хүндрэлээс гарахын тулд гадаад худалдаа, тэр дундаа экспорт.

Манай гадаад худалдаа, экспортын 93 хувь нь шууд уул уурхай. 93 хувийнх нь бүр 53.0 хувь нь дан ганц нүүрстэй холбоотой ийм хамааралтай болсон.

Тийм учраас 2022 оны гурав, дөрөвдүгээр улирал, энэ жилийн эхний хагаст явж байгаа экспортынхоо тогтвортой байдлыг хадгалаад, өсгөөд энэ жил нүүрсийг жишээ нь 45 саяд. Энэ жил 36-г бид 45, ирэх жил 50 сая тонн нүүрс экспортолно гэж ийм прогноз зорилт тавиад, түүнтэй холбоотой эдийн засгийн өсөлт байгаа юм шүү.

Гол өсөлт маань ер нь түүгээр хангагдана гэсэн үг.

Зардлын хувьд энэ бол хязгаар. Төсвийн тогтвортой байдлын хууль дээр байдаг тусгай шаардлагын хязгаар. Түрүүн би яг он оноор нь дурдаж хэллээ.

Хойтон 2.8, 2025 онд 2 хувь. Түүнээс хойш дээд хязгаар нь 2.

2-оос доош буулгах ёстой гэсэн бид хуулийн дагуу хязгаараа тавьж орж ирсэн.

Намар төсөв өргөн баригдана. Энэ хязгаар дотор өргөн барина. Тэгээд эцэслэн Улсын Их Хурал дээр хэлэлцээд батална.

Орлого, зардал гэж байна. Энэ маань бас л эдийн засгийн өсөлтийг тооцоолоод тэр хүрээнд олж болох орлогоо дайчлах бүх боломжит орлогуудаа тавиад эндээ хязгаарлаж бид зардлаа тавьж байгаа юм.

Би түрүүн Ч.Ундрам гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх хэмжээгээр энэ зардал 2024 онд өсөхгүй байгаа шүү. Харин ч буурч байгаа. Би түрүүн тоог хэлсэн. Зардал 38-аас 35 болж буурч байгаа. Хувь нь. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх.

Орлого маань 35-аас 32 хүртэл буурч байгаа.

Тэгэхээр энэ зөв хандлага руугаа явж байна гэсэн үг. Алдагдал, өсөлт, орлого, зардал. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол яг өнөөдөр бид ард иргэдэд очиж ярьж байгаа, хэлж байгаа энэ зүйлүүд маань 2024 оны төсөв дээр ер нь яаж тусаж байгаа юм бэ гэсэн тэр ярьсан, хэлсэн зүйл маань үнэхээр үнэн юм ярьж байна уу, худлаа ярьж байна уу

гэдэг илэрхийлэл үүгээр гарч ирнэ ээ л гэж харж байгаа юм.

Тэр дээр улсын төсөв дээр бид орлого, зарлага гээд хоёр том юм. Эндээс тэгээд төсвийн алдагдал хэр байх вэ гээд олон зүйлүүд гарч ирнэ.

Орлого дээр өнөө өглөө Монгол Улсын Ерөнхий сайд “**Топ 100**” аж ахуйн нэгжийн арга хэмжээн дээр хэлэхдээ эхний хагас жилийн байдлаар 1.1 их наяд төгрөгийн төсвийн давсан орлоготой болж ирж байна гэсэн ийм зүйлийг ярьсан байна лээ.

Тэгэхээр энэ бол хулгай зэлгий, хамаг юмтай хийсэн юмны тэмцэл. Гэхдээ энэ зөвхөн нүүрс дээр байгаа байх.

Тэгэхээр орлого нэмэгдүүлэх дараагийн бас томоохон хүчин зүйлүүд юу байгаа вэ гэж Монгол Улсын Засгийн газар харж төлөвлөж байгаа вэ? Дараагийн салбарууд юу байх вэ? Орлого нэмэгдүүлэх гэдэг дээр би асууж тодруулья гэж бодож байна.

Зарлага дээр 5.6 их наяд, дахиад 3.3 их наядаар нэмэгдэнэ. Тэр нь хүн амын өсөлттэй холбоотой гээд хийж байна.

Ер нь бид төсвийн байгууллагуудын урсгал зардал гэдэг юм жилээс жилд нэмэгдээд явна.

Ер нь нэг апдэйт хийж үзвэл ер нь яасан юм бэ? Хамгийн сүүлд ер нь яг энэ урсгал зардал дээр ер нь яг бид оновчтой хийж чадаж байна уу, үгүй юу? Хэмнэх ямар бололцоо байна вэ? Магадгүй хэмнэсэн төсвийн ерөнхийлөн захирагчид тэр байгууллагадаа тэр хэмнэсэн зардлаас нь тодорхой хувийг нь ашиглах бололцоог нь нээж өгөх, нэг ийм хэмнэх

тогтолцоо руу оруулах, мотивацжуулах юм хийж үзвэл ер нь яасан юм бэ?

Би өнгөрсөн жил Хэнтий аймагт хийгдэж байсан нэг туршлагыг ярьж байсан. Хэнтий аймгийн төсвөөс зөвхөн халаалтын зардлыг нь л судлаад үзэхэд 1.2 тэрбум төгрөг хэмнэж байх жишээтэй юмнууд гарч байсан байхгүй юу.

Тэгэхээр улсын хэмжээнд энэ бол нэлээн тоо гарах болов уу гэж бодоод байгаа юм.

Хувийн хэвшлийнхний ярьж байгаа зүйл бол Монголбанкнаас удахгүй тэгээд л Улсын Их Хурал дээр орж ирж батлуулах энэ мөнгөний бодлого, энэ зээлийн хүүгийн асуудлууд, энэ хатуу бодлого хэзээ зөөлрөх вэ гэсэн ийм зүйлүүд яаж төлөвлөгдөж байгаа вэ?

Бидний ер нь томоохон анхаарах зүйл энэ юмны өсөлтийн араас бид цалин, тэтгэврийг нэмээд ер нь гүйцэхгүй байдалтай байна. Энэ юмны өсөлтийг зогсоох тал дээр ер нь дорвитой ямар бодлого авах вэ?

Бид импортын барааны өсөлтийг ойлгож байна. Валютын ханш янз янзын юмнууд нөлөөлөх байх. Дотооддоо үйлдвэрлэж байгаа гурил маань 50 хувь өсөөд 32 мянгаар зарагдаж байсан 25 килограмм гурил өнөөдөр сумдад 60 мянга болчихоод байгааг юу гэж ойлгох вэ?

Тэгэхээр юмны үнийн өсөлт маань бид хамаг юмаа шавхаад цалин нэмдэг, тэтгэвэр нэмдэг. Тэгээд алинд нь ч сэтгэл ханамж байхгүй. Төр хамаг юмаа шавхаад цалин нэмчихдэг. Дагаад юмны үнэ өсчихдөг. Төр ч дахиж нэмэх юмгүй, ард иргэд тэтгэвэр, цалингаа авч байгаа хүмүүс нь ч ямар ч сэтгэл ханамж

байхгүй, худалдан авах чадвар нь уначхаад байгаа.

Энэ том асуудлыг бид шийдэх, бас нэг тодорхой хэмжээнд дорвитойхон арга хэмжээ авахгүй бол зах зээл нь ийм юм гээд ингээд яваад байж болохгүй санагдаад байгаа юм.

Цаашдаа бид иргэдэд ярьж байгаа нэг зүйл энэ цалин, тэтгэвэр гэдэг зүйл 04 сарын 01 гэхэд автоматаар нэмэгддэг. Улс төрөөс хамааралгүйгээр ийм тогтолцоо руу бид аажимдаа шилжих томоохон зорилт тавиад явж байгаа гээд орон нутагт яриад явж байгаа. Энэ болгон маань 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлээс эхлээд ер нь суугаад явж байгаа юу гэсэн ийм үндсэн асуултуудыг асууя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Бид хэмнэлтийн горимд хуулиараа ороод нэг жил гаруй болж байна. Бид 2023 оны гүйцэтгэлээ энэ хуулийн хүрээнд 1 их наяд төгрөгийн хэмнэлттэй гарсан. Яг тэр хэмнэсэн зардлын эдийн засгийн бүтэц, тэр ангиллаар 2023 оныхоо төлөвлөлтийг хийсэн.

Үргэлжлээд 2024 оны төлөвлөлт мөн яг энэ хуулийн хүрээнд хийгдэж байгаа. Урсгал зардал талдаа ч тэр, хөрөнгө оруулалтын зардал дээрээ ч тэр.

Тийм учраас бид энэ хэмнэлтийг бас учиртай хийх ёстой. Хамаагүй туйлширч болохгүй. Урсгал зардал гэдэг маань энэ төрийн байгууллагуудын ард иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг санхүүжүүлж байгаа ийм хэлбэр.

Тийм учраас төрийн үйл ажиллагаа, Төрийн үйлчилгээ зогсох хэмжээнд бид хамаагүй хэмнэж тэгж туйлширч болохгүй.

Тэгэхээр хэмнэлтийн хуулиа л бид ягштал бариад явах нь чухал байгаа шүү.

Энэ дээр төсвийн ерөнхийлөн захирагч нар, төсвийн шууд захирагч нар бүгд шат шатдаа анхаарах ёстой.

Мөнгөний бодлогын хатуу төлөв хэзээ зөөлрөх вэ, бодлогын хүү хэзээ буурах вэ гэж байна.

Үүнийг илүү мэргэжлийн байгууллага нь, Төв банк оновчтой хариулт өгөх байх.

Бид гол нь мөнгөний бодлоготой төсвийн бодлогоо нийцүүлэх л чухал ийм даалгавартай байгаа.

2022 онд төсвийн бодлого, мөнгөний бодлоготой яв цав нийцсэн. Бид 2.4 их наядын алдагдалтай гарах байсан. Үндсэн тэнцэл маань 900 тэрбум буюу 1.5 их наядаар бид төсвийн хэмнэлт хийсэн гэсэн үг.

Өөрөөр хэлбэл энэ хэмжээний орлого давсан. Үүгээр бид тэр хэмжээгээр зардлаа нэмэлгүйгээр, өөрөөр хэлбэл мөнгөний бодлогын мөнгө нийлүүлт нэмэхгүй байх хатуу бодлоготой яв цав уял уялдуулсны үр дүнд өнөөдрийн энэ макро тэнцвэрүүд бий болсон юм гэдгийг хэлье.

Инфляц ч гэсэн мөн адил. Ямар ч байсан энэ тоонуудыг та харж байгаа байх. 2024 онд мөнгөний бодлогын зорилтот түвшин 8 хувь дээр барина. Эдийн засаг маань ийм байх нь ээ гэж орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл энэ тоо

ерөөсөө шууд Төв банкны тоо гэж харагдана.

Тэгэхээр бид үүнтэй аль болох бодлогоо уялдуулсны үр дүнд Төв банкны энэ зорилтот түвшин дээр очиход бид төсвийн бодлого нэмэр болно л гэж ингэж зорьж байгаа.

Л.Мөнхбаатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Хэмнэлтийн хуультай холбоотой асуудлыг би хөндөөгүй юм.

Ер нь дулаан, цахилгаан гээд энэ чинь хамаг юмнууд тийшээгээ л явчихдаг л даа. Хэмнэлтийн хууль бол гаргаж байгаа зардлууд дээр бас нэлээн хэмнэлт үүсгэсэн.

Ер нь одоо ингээд төсвийн тодотгол яригдаж байгаа үед хэмнэлтийн хууль дээр байгаа ялангуяа сумдад ажиллаж байгаа, тэр анхан шатад ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажлаа хэвийн явуулахад шаардлагатай байгаа зардлыг бас энэ хэмнэлтийн хууль дээр эргэж харахгүй бол төрд хүн ажиллахгүй байгаа тэр гол шалтгаануудын тодорхой хувийг энэ хэмнэлтийн хууль дээр юутай ийтэй нь ингээд хорьчихсон нь бас нөлөөлж байгаа юм билээ.

Гэхдээ хэмнэлтийн хууль дээр байгаа тэр олон дарга цэрэг, тэр олон дарга нарын хэрэглээ юмнуудыг танасныг би зөвшөөрч байна. Яг анхан шатандаа хэмнэлтийн хууль бас нэлээн хатуу туссан юм билээ шүү.

Тэгэхээр 2024 оныхоо төсвийг төсөөлөхдөө хэмнэлтийн хууль дээр анхан шатанд ажиллаж байгаа тэр хүмүүсийн ажиллах хэвийн нөхцөл.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулах уу? Санал юм уу? Одоо Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Та бид Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байна л даа.

Бид сая тойргоороо ажиллаад ирлээ. Хөдөө үнэхээр ард иргэдийн амьжиргаа, амьдралын түвшин маш хүнд байна.

Хэд хэдэн зүйл асуугаад байгаа юм. Одоо ингээд “Хөдөөгийн сэргэлт” гээд хөтөлбөр хэрэгжүүлж байна. Та бүхэн маань. “Боомтын сэргэлт” гээд эдийн засгаа сэргээх ийм хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Тэгээд үүний чинь хүрээнд хөдөө ажиллах гэж байгаа аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт олгоно. Хөдөө очиж ажиллаж байгаа боловсон хүчнүүдэд ипотекийн 3 хувийн зээл олгоно гээд байдаг. Ийм хөтөлбөр хэрэгжүүлнэ гээд байдаг.

Гэтэл хөдөө ирээд ипотекийн зээл авъя, би энэ орон нутагтаа ажиллая гэхээр зэрэг чи 6 сар ажилласан байх ёстой гэдэг шаардлага тавиад байдаг. Энэ чинь харилцан уялдаагүй, хэрэгжих боломжгүй ийм болоод байна шүү дээ.

Ингээд дээрээ, дундаа, доороо бодлого чинь зөрүүд байна шүү дээ. Үүнийг яах юм бэ гэж асуугаад байгаа юм. Нэг дэх нь энэ.

Хоёр дахь нь, үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд л баахан хэрэгжүүллээ. Тогтворжсон юм хаана байгаа юм бэ? Энэ бензин тосны чинь үнэ энэ зах

хязгаарт чинь Улаанбаатар хотоос 400-аас 700 төгрөгөөр үнэтэй байна шүү дээ.

Үүнийгээ дагаад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ ханш чинь өсөөд талийлаа шүү дээ. Цалин, мөнгө, тэтгэвэр, тэтгэмж чинь хаанаа ч хүрэхгүй байна шүү дээ. 500 мянган төгрөг чинь хаанаа ч хүрэхгүй байна. Эмийн мөнгөө ч авч хүрэхгүй байна. Одоо яах юм бэ гэдэг асуудал ярьж байгаа юм.

Тэгэхээр нөгөө “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” дээр хамрагдсан компани, тэр аж ахуйн нэгж, үнээ өсгөөд байгаа хүмүүс дээр арга хэмжээ авахгүй юм уу гэдэг асуудал ярьж байгаа юм. Зах хязгаартаа яах юм бэ гэдэг асуудал.

Гурав дахь нь, энэ зах хязгаар нутаг чинь эзгүйрлээ. Энд ирж ажилладаг эмч ч алга, багш ч алга боллоо. Залуучууд төв рүү нүүгээд алга боллоо. Өмнө нь говийн нэмэгдэл, бүсийн нэмэгдэл гэж өгдөг байсан. Одоо байхгүй болчихсон. Үүнийг цаашдаа яах юм бэ? Ялгавартайгаар тогтоохгүй юм уу? Энэ зах хязгаарт чинь эмнэлгийн үйлчилгээ, чанартай боловсрол авах бололцоо боломж алга байна шүү дээ.

Тийм учраас залуучуудад нүүхээс аргагүй. Залуу малчдын халаа гэж байхгүй боллоо. Ингээд энэ бодлогоо цааш нь төр засаг хэрэгжүүлэхгүй юм уу гэж асуугаад байгаа юм л даа.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр цаашдаа ер нь ямар арга хэмжээ авах гэж байна? Ийм гурван асуултад хариулаадхаач.

Сүүлийн асуулт. Бид намын мөрийн хөтөлбөр дээрээ нэг сүрхий тунхагласан. Нөгөө “Нутгийн зам” гээд

нэг ганц нэг хөтөлбөр хэрэгжүүлбэ гэсэн. Бүгд байхгүй болчихсон. Энэ 2024 оноос ганц нэг нутгийн зам хөдлөх нь үү? Тавигдаж болох нь уу? Үүнийг нэг хариулаадхаач.

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Сайд. Ажлын хэсгээр хариулах юм уу? Сайд юм уу? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Ажлын хэсэгт нэмж хариулж болно.

Б.Жавхлан: Энэ удаа бид төсвийн хүрээний мэдэгдэл буюу төсвийн хязгаар макро тоонуудаа ярьж байгаа.

Тэр “Нутгийн зам” гээд асуулаа. Яг хөрөнгө оруулалттай холбоотой маань ирэх жилийн хөгжлийн төлөвлөлттэй холбоотой. Тэрийг ярих үед илүү дэлгэрэнгүй ярилцах байх. Тэгэх ч ёстой байгаа юм.

Ирэх оны төсөвт хэрхэн яаж тусгагдсан бэ гэдэг асуудлыг бид намар ярина. 2024 оны төсөв ярих үед. Эдийн засгийн хөгжлийн яамнаас төлөвлөгөөндөө яаж оруулсан байгаа юм. Тэр талаар нь нэмээд хариулна биз.

Эсвэл яг төлөвлөгөөгөө тусдаа ярихдаа. Маргааш хэлэлцэх билүү. Үргэлжлээд үү. Үргэлжлээд төлөвлөгөө яригдах юм байна шүү дээ. Тэр дээр илүү мэдээллүүдийг өгөөрэй. Тийм.

Үнэ тогтворжуулах хууль юу байх вэ. Өнгөрсөн оны 5 сард бидний баталсан зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байхад шаардлагатай арга хэмжээнүүдийг авах тухай ийм хууль баталсан.

Хууль маань 12 сарын 31-нд дууссан. Өнгөрсөн оны. Харин энэ хугацаанд Сангийн яамны хувьд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай нягт

хамтарч ажиллаж намрын ургац хураалттай холбоотой, уул уурхайн манай гол орлого оруулж байгаа салбарын гол хэрэглээ түлштэй холбоотой үнийг тогтвортой байлгах нэг удаагийн ийм онцгой арга хэмжээнүүдийг бол бид амжилттай авч хэрэгжүүлсэн.

Ингээд бид түлш дээрээ он дуустал тогтвортой тэр хүнд үеийг барьж давж чадсан гэж хэлье. Тэр хуулийн үйлчлэл дууссан.

Ер нь бид аль болох л зах зээлийнх нь жамаар л явуулах ёстой байгаа юм. Бид бензинийг цаашдаа тогтвортой байя гэвэл дотооддоо л үйлдвэрлэдэг болох хэрэгтэй. Одообаригдаж байгаа нефть боловсруулах үйлдвэрээ яаралтай хугацаанд нь ашиглалтад оруулах хэрэгтэй.

Хөдөө аж ахуйн хувьд ч гэсэндээ Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөрийн хүрээнд бид дотооддоо бүрэн бүх хүнсээ үйлдвэрлэдэг болох нь л хамгийн чухал байгаа юм.

Цалин, мөнгө болон тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлууд дээр бид яг хүрээтэй холбогдуулж асууж байгаа бид боломжит бүх зардлынхаа хязгаарыг энэ хүрээн дотроо тавиад орж ирж байгаа.

Нэг бүрчлэн ярина гэвэл бид. Энэ 2024 оныхыг ярьж байгаа шүү. 2023 оны төсвийн гүйцэтгэл, тодотгол бол ердөө огт энд хамаагүй асуудал.

2024 онд бид энэ хязгаартаа багтааж цалингийн өсөлт, тэтгэврийн өсөлт, энэ бүхнийгээ тогтвортой, тэнцвэртэй байдлыг нь хангаж ингэж төсөвлөж орж ирнэ ээ гэж ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан тодруулж асууя.

Л.Энх-Амгалан: Би маш тодорхой асуугаад байгаа юм л даа.

Зах хязгаар чинь эзгүйрээд байна. Энэ говийн нэмэгдэл, бүсийн нэмэгдэл гээч юм өгөхгүй юм уу? Ийм ялгавартай бодлого тогтоохгүй юм уу? Тэгэхгүй бол энэ зах хязгаарт чинь хүнд тогтохоо байлаа гээд асуугаад байна л даа.

Тэгэхээр үнэ тогтворжих хөтөлбөр дуусчихсан. Одоо ингээд яах вэ, бензин нь өсвөл өснө л биз. 500, 600, 700 болно л биз. Одоо тэгээд ер нь зах зээлийнхээ жамаар явья гэвэл энэ зах хязгаарт чинь хүн амьдрахгүй юм байна шүү.

Хоёр дахь нь, тэр “Хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд чинь ипотекийн 3 хувийн зээл авья гэхээр өгөхгүй байна гэдгийг яах юм бэ? 6 сар ажилласан байх шаардлага тавиад байгаа юмыг яах юм бэ? Энэ 2 дээр нэг тодорхой хариулаадхаач.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: 3 хувийн ипотекийн зээлийн Б.Энх-Амгалан гишүүн ээ, хөдөө орон нутагт тогтвортой амьдрах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийн энэ хүрээний бодлого шүү дээ.

Тэгэхээр тэр зээлийг авахын тулд хотоос гүйж очоод тэгээд нэгхэн хоночхоод, нэгхэн сар болчхоод тэр зээлд хамрагдаад байж болохгүй шүү дээ.

Тэгэхээр тэндээ оршин суудаг. Хэрвээ нүүж очсон бол доор хаяж 6 сар амьдраад төрөөс үзүүлж байгаа ийм хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрх нь нээгдэх нь зүйн хэрэг.

Бусад шаардлагууд нь тэр 6 хувь байхад тавьж байсан нийтлэг тэр банкнаас тавьж байгаа шаардлагууд нь тавигдаад л явж байгаа.

Яг дахиж тодруулж хэлэхэд хот, хөдөөгийн тэнцвэртэй, мөн орон нутгаас Улаанбаатар луу хэт дахин ингэж нүүж ирж байгаа энэ байдлыг нь л орон нутагт нь тэнцвэртэй байлгах, тэнд нь амьдар ирж байгаа улсууд нь ч тэр, эндээс нүүж очиж байгаа улсууд нь.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тэр хөгжлийн хөтөлбөртэй холбоотой асуулт нь хоёр дахь асуудал байгаа.

Хоёр дахь асуудлыг хэлэлцэх үед Эдийн засгийн яамныхан нэмээд хариулчхаарай.

Одоо Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Тэгэхээр бид Байнгын хорооны хуралдаан дээр ярьсан. Хоёр, гурван зүйлүүдийг Байнгын хороон дээр хэд хэдэн гишүүд тодруулж асуусан.

Үүнтэй холбоотойгоор гол үндсэн асуудал маань энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу тооцсон нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон тооцооллыг дахин нягтлах ёстой байна гэдэг асуудлыг тавьж байсан.

Ямар ч бай ирэх онд тодорхой хэмжээнд эдийн засаг эрчимжих, уул уурхайн экспортууд тодорхой нэмэгдэх. Энэ дотор Оюу Толгойн далд уурхайн үйлдвэрлэл эрчимжих гэдэг тооцоолол гарч ирж байгаа.

Тэгэхээр уул уурхайг дагасан үйлдвэрлэл болоод тодорхой энэ тээврийн салбарууд нэмэгдэх нь боломж бололцоо байна гэж харж байгаа.

Бид бүхний хувьд гол сонирхож байгаа зүйл яах вэ, экспортын нөгөө биет бүтээгдэхүүн хэмжээгээрээ нэмэгдэх тусам. Тэр дундаа гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд нэмэгдэнэ гэж тооцож байгаа.

Эндээс тодруулах гээд байгаа гол асуудал маань Тогтвортой байдлын тухай хуулиар тооцдог нөгөө тэнцвэржүүлсэн орлогууд маань нэлээн нэмэгдэх хандлагатай байгаад байдаг.

Оюу Толгойн далд уурхайн олборлолт нэмэгдээд зэсийн баяжмал дахь алтных нь агуулга нь нэмэгдэнэ гэсэн тооцооллыг гаргаж ирээд байгаа.

Тэгэхээр та бүхэн маань алтныхаа олборлолтыг 20 мянган тонн байна гээд тооцоод оруулаад ирсэн. Энэ дотор би ямар ч бай тооцоолоод аваад үзэхэд өмнөх жишгээрээ 20 мянган тонн гэж авч үзээд байгаа. Энэ дотор яг Оюу Толгойн далд уурхайн зэсийн баяжмал дахь алтны агуулга тооцогдоогүй байна гэдэг асуудлыг тодруулах гээд байгаа юм.

Тэгэхээр би Уул уурхайн яамнаас тодруулаад үзэхээр 2024 онд 6.7 тонн байна. 2025 онд 14 мянган тонн байна гээд байгаа юм. 14 тонн байна гээд.

Тэгэхээр хэрэв Оюу Толгойн зэсийн баяжмал дахь алтных нь

агууламжийг нь бид бүрэн тооцоод аваад үзэх юм бол нийтдээ 26, 27 тонн тонн алт гарах гээд байдаг.

Энэ маань өөрөө нөгөө талдаа гол бидний тэнцвэржүүлсэн орлого тооцдог, эргээд нөгөө гол нэр төрлийн бүтээгдэхүүн маань бас орлогын 3 хувьд хүрээд ингээд тэнцвэржүүлсэн орлого өөрөө нэмэгдээд яваад байх, ирээдүй өв санд орох орлого өөрөө нэмэгдэх энэ боломж бололцоо байна гэж хараад байгаа юм.

Өнөөдөр хэд хэдэн гишүүд ч гэсэн энэ асуудлуудыг хөндөж ярьж байна л даа.

Бид бүхний хувьд яах вэ нэг талдаа ийм цонх үе үүсэж байгаа, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа, үйлдвэрлэл нэмэгдэж байгаа энэ цаг үе дээр хуримтлалаа бий болгох асуудлуудаа тавья.

Зөвхөн зэс, нүүрс гэж ярьдаг байсан бол энэ алтны тоо хэмжээ маань өөрөө тогтвортой байдлынхаа хуулийн дагуу боловсруулсан энэ тэнцвэржүүлсэн орлогод тооцогдох гол нэр төрлийн бүтээгдэхүүнд өөрөө алт орж ирэх гээд байна гэдэг асуудал тавих гээд байгаа юм.

Тэгэхээр энэ тэгвэл сайн гэх гээд байхгүй юу. Сайн. Гурав дахь бүтээгдэхүүн гарч ирэх гээд байна. Энэ маань өөрөө яг орлогынхоо 3 хувьдаа хүрэх гээд байж магадгүй гэдэг тооцоолол байгаа юм. Та бүхэн маань энэ дээр ер нь яаж тооцоолсон юм бэ? Ямар аргачлалаар тооцоолсон юм бол?

Алт өөрөө одоо юу гэдэг юм, 27 тонн хүрэх юм бол яг л тогтвортой байдлынхаа хуулийн дагуу тэнцвэржүүлсэн орлогод тооцогдох гол

нэр төрлийн бүтээгдэхүүн болох гээд байдаг.

Тэгэхээр ирээдүйд, бид нөгөө “Ирээдүйн өв сан”-д орох хуримтлалын мөнгө маань өөрөө, түүнд тооцогдох орлого маань өөрөө нэмэгдэх гээд байгаа.

Тэгэхээр бидний ер нь хүсэж байгаа зүйл маань цаашдаа бас нэг тогтвортой хуримтлалтай болгох, Төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу орлогыг бүрдүүлэх, хуримтлалыг бий болгох асуудлууд байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хариултыг өгөөч ээ л гэж хэлэх гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Г.Тэмүүлэн даргын асуултад ажлын хэсэг хариулъя. Хэд вэ? 89 дүгээр микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд асуултад оруулаарай.

Л.Энх-Амгалан: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан.

Алтны экспортын тухайд хоёр янзын тоо байгаа. Нэг нь, 20 тонн алт гэж байгаа. Монголбанк худалдаж аваад түүнийгээ Монголбанк мэдэж экспортлох тоо. Үүнийг техникийн түвшиндээ Монголбанктэй зөвшилцөөд 20 тонн гэж төсөөлж байгаа.

Өнгөрсөн жилүүдийн экспортын динамик нь дундаж нь бас 20 орчим тонн байдаг.

Энэ тоог алтны экспорт гэж Сангийн яаманд хүргүүлсэн байгаа.

Мөн Оюу Толгойн алтны тухайд баяжмал дотроор явдаг. Оюу Толгойн

агууламж нэмэгдэж байгаа. Үүнтэй холбоотой АМНАТ-ийн тооцоо Сангийн яаман дээр тусдаа явж байгаа байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Хариулт болсон уу? Тийм ээ. Нэмж хариулах юм уу? 88 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсгийн 88 дугаар микрофоныг өгье.

Б.Тэлмүүн: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан гол нэр төрлийн баялагт алт тооцогдох эсэх дээр алтны тоо хэмжээ ерөнхийдөө алтнаас төвлөрүүлэх орлого 700 орчим тэрбум төгрөг байж энэ 3 хувийг давахаар байгаа.

Үүн дээр Монголбанканд тушаахаар тооцсон 20 тонн алт. Дээрээс нь Оюу Толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламжид тооцогдож байгаа 6.3 тонн алтыг нэмээд тооцохоор энэ дүндээ хүрэхгүй байгаа.

Тэгэхээр 2024 оны хувьд гол нэр төрлийн эрдэс баялагт бол тооцогдохгүй.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье. Сангийн сайд Б.Жавхлангийн микрофоныг өгье.

Б.Жавхлан: Байнгын хороон даргын асуултад хариулъя. Г.Тэмүүлэн гишүүний асуултад.

Тэгэхээр одоо байгаа ханш дээрээ алт тушаалт 40 тонн хүрч байж нөгөө 3

хувийнхаа босгыг давахаар байгаа юм. Үнэхээр давчихвал их сайн л байгаа юм. Алт бол үнэхээр манай Төв банкны гадаад валютын бүр нөөцөд албан ёсоор байдаг ийм валют. Хамгийн хөрвөх чадвартай ийм валют байдаг.

Монгол Улсын хувьд стратегийн түүхий эд. Бид хөрсөн доороо валютын нөөцтэй ийм улс.

Тийм учраас алт олборлолтыг бид онцгой анхаарч байдаг нь энэ. Одоо бид нүүрсэн дээр, хүдэр дээр нөгөө жишиг үнэ гээд л, АМНАТ гээд л тэнд бөөн л асуудал үүсээд байдаг бол алт бол ямар ч асуудал байхгүй Лондоны биржийн ханшаар АМНАТ-аа авдаг ийм үнэ цэнэтэй металл байгаа юм.

Тэгэхээр ойрын хугацаанд 20 тонноос нэмэгдэх ийм прогноз ерөөсөө гарч ирэхгүй байгаа. Буурчих вий л гэдэг эрсдэл байгаад байгаа. Учир юу вэ гэвэл нөгөө урт нэртэй хуулиар болон сүүлийн жилүүдэд манай хайгуулын бодлого энэ завсар гарснаас болж нэмэлт нөөц, одоо “А” лиценз, олборлох ийм уулын ажлын төлөвлөлтүүд ойрын жилүүдэд байхгүй юм билээ.

Нөгөө хуучин уурхайнууд дээрээ л бага сага ухаад л ухаад л. Гар дээр байгаа алтаа ингээд л дуртай дургүй Монголбанканд дээр аваачиж тушаагаад л. Ингээд нэг жил бүр яаж ийж байгаад л 20-доо хүргээд яваад байгаа юм. Сүүлийн 5, 6 жил.

Оюу Толгойн хувьд 6.5 бол ойрын хугацаанд нэмэгдэхгүй юм билээ. Энэ яг нөгөө өндөр агууламжтай хэсэг нь буурчихсан. Хүрчихсэн. Ингээд жоохон буурч байгаа.

Дараа жилийн далд уурхай руугаа орсонтой холбогдуулж алтны ойрын

хугацаанд прогноз ямар байгааг би шууд хэлж мэдэхгүй байна.

Эдийн засгийн хөгжлийн яаманд тэр мэдээлэл байвал нэмж хэлээрэй.

Мэдээж үнэхээр 40 тонноос дээш болоод ирвэл энэ чинь ерөөсөө маргаангүй шууд 3 хувь босгоод авчих учраас бид үнийг нь ч гэсэн тэнцвэржүүлсэн үнээ аваад гол манай стратегийн бүтээгдэхүүн болоод. Төсвийн хувьд шүү.

Ингээд төсөв төлөвлөлтөд гол нөлөө үзүүлээд явдаг болно. Тийм.

Л.Мөнхбаатар: Г.Тэмүүлэн дарга тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Алттай холбоотой хоёр, гурван зүйлийг тодруулаад асуугаадахъя. Мэргэжлийн хүмүүс байгаа дээр нь.

Нэг тонн алтанд ногдох алтны төсөвт үзүүлэх дүнг ер нь яг хэд гэж тооцсон байдаг бол?

Алтнаас яг ямар ямар татвар авч байгаа вэ? Татварын ачаалал маань ер нь хэдэн хувьтай байгаа вэ л гэсэн үг болчхоод байгаа юм л даа. Жишээ нь, Оюу Толгой компанийн алтнаас орох аж ахуйн нэгжийн татварын ачаалал ер нь хэд гэж тооцож байгаа бол. Хэд байгаа вэ?

Хоёр дахь асуулт, нь би зүгээр нэг зүйлийг асуух гээд байгаа юм. Бидний хувьд гол анхаарах асуудал Засгийн газрын өрийн асуудал. Тэгээд сүүлийн жилүүдэд 60 хувиас буурахгүй байгаа. Тодорхой нэг дүгнэлт хийх цаг нь болчихсон гэж хараад байгаа.

Яах вэ, та бүхний тооцооллоор ирэх 2024 онд 49.2 хувьтай гэж тооцоо байсан байх.

Тэгэхээр ер нь магадгүй Засгийн газрын өрийн үлдэгдлийг 50 хувиар ч гэдэг юм уу, тооцож бууруулах энэ боломж бололцоо ер нь байх уу? Энэ хоёр асуудалтай та бүхэн нэг хариу өгөөч.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. 88 дугаар микрофон өгье. Ажлын хэсгийн. Б.Тэлмүүн дарга хариулъя.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн Г.Тэмүүлэн даргын асуултад хариулъя.

Алтны хувьд Монголбанканд тушааж байгаа 20 тонн алттай холбоотойгоор энэ аж ахуйн нэгж компаниудтай холбоотой гол төлөвлөдөг татварууд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, АМНАТ-ийн татвар байгаа.

Дээрээс нь эдгээр аж ахуйн нэгжүүд алтны борлуулалттай шууд бус холбоотой гардаг. Хувь хүний орлогын албан татвар болон бусад бүх төрлийн татварыг төлдөг.

Ойролцоогоор нэг алтнаас ерөнхийдөө 14, 15 орчим тэрбум төгрөгийн татварын орлого гардаг.

Оюу Толгой компанийн хувьд зэсийн баяжмалд агуулагдаж байгаа алтны хэмжээгээрээ АМНАТ-ийн татварыг төлж байгаа.

Орлогын татварын хувьд одоогоор алдагдалтай байгаа учраас ирэх онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгдөхгүй. Бусад шууд бус татварууд

Оюу Толгойн төлдөг бүх татварт шингээд явдаг.

Л.Мөнхбаатар: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Яг бодит гүйцэтгэлээрээ 52 хувьтай байгаа. Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ.

Хэрвээ бид энэ жилийн Хөгжлийн банкны 9 сарын евро бондыг амжилттай өөрөөр нь Хөгжлийн банк ингээд зохицуулалт хийгээд явбал 2024 онд бодит гүйцэтгэл 50-иас доош нь 49 хувь руу орох ийм боломж байгаа.

Гэхдээ үүнийг яг зорилтот түвшинд тавиад үүнийг онилоод явах бол бас их төвөгтэй. Маш олон зүйлээс шалтгаална. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс сүүлийн жилүүдэд маш их шалтгаалж байна.

Хойтон 2024 онд дотоодын бүтээгдэхүүний нэрлэсэн төлбөр 58 их наяд руу хүрнэ гэж тооцоолж байгаа. Өөрөөр хэлбэл багтаамж маань тэлчих учраас энд эзлэх өрийн хэмжээ ингээд буураад явна.

Цаашдаа өрийнхөө нэрлэсэн дүнг хэрвээ бид өсгөхгүй барьж чадваас.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Б.Жавхлан сайд гүйцээгээд хариулчихъя.

Б.Жавхлан: Тогтвортой өрийнхөө хэмжээг барьж чадваас дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ маань дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх хэрээр багасаад явах ийм бүрэн боломжтой байгаа.

Тийм учраас зорилго бол ерөөсөө бид 2021-2024 оны хооронд баримтлах Өрийн удирдлагын тухай хуулиар гадаад өрийнхөө дунд хугацааны стратегиэ л чанд баримтлаад явах юм бол энэ эрсдэл харьцангуй буурч ирж байгаа.

Бид 2022 он, 2023, 2024 онуудад ямар ч байсан гадаад өрийн эрсдэлээс хамаарах дефолтоос бүрэн гарсан байгаа. Тийм. Энэ бол их том үзүүлэлт.

Л.Мөнхбаатар: Одоо Инновац, цахим бодлогын байнгын хороон дарга Энхбаярын Батшугар асуултаа асууя.

Э.Батшугар: Баярлалаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны нэгдүгээр улиралд 7.9 хувиар өссөн. Үүнээс уул уурхайн өсөлт нь 5.3 хувийг эзэлж байгаа юм.

Тэгэхээр нь юу харуулж байна вэ гэхээр энэ өсөлтийн дийлэнх нь уул уурхайн экспорттой хамаатай. Нэг харамсалтай зүйл нь уул уурхайн экспорт шууд бодит эдийн засагт нөлөөлөх нь харьцангуй бага. Ялангуяа хүмүүсийн амьдралд, орлогод нөлөөлөхгүй.

Тэгэхээр газрын баялгийг зөв хуваарилдаг механизм бол Байгалийн баялгийн сан байгаа юм.

Тэгээд яах вэ Гаина гээд Латин Америкийн улс байдаг. 2019 оноос 2021 он хүртэл 2 жилийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүн нь хоёр дахин нэмэгдсэн. Харамсалтай нь ард иргэдийн хармаанд нь орж байгаа орлого нь нэмэгдээгүй хэвээрээ үлдчихсэн. Зүгээр цэвэр статистикийн мэдээллээр бол хоёр дахин нэмэгдчихсэн байгаа юм.

Тэгэхээр энэ зүгээр санал хэлж байгаа юм.

Баялгийн сангаа бид яаралтай байгуулах ёстой гээд.

Үнийн өсөлт өнөөдөр эхний 4 сардаа 11.3 хувь байна.

Инфляц болоод төсвийн орлого богино хугацаандаа шууд нөлөөлдөг. Харамсалтай нь эергээр нөлөөлдөг. Ялангуяа НӨАТ-ын орлогын сувгаар дамжуулж.

Тэгээд энэ 11.3 хувийн инфляцыг харахад бараг 42 хувь нь шууд хүнсний инфляц. Энэ хүнсний инфляцынх нь дийлэнх хувийг нь шууд дотооддоо үйлдвэрлэж байгаа хүнсний бараа, бүтээгдэхүүн байгаа юм.

Тэгээд 2022 оныг харахад дотооддоо үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгчдийн инфляц 25 хувьд хүрчихсэн байна. Энэ нь юу харуулж байна гэхээр нийлүүлэлтийн сувагт бид нарт алдаа байна.

Тэгээд ялангуяа мах болон бусад дотооддоо үйлдвэрлэдэг бараа, бүтээгдэхүүн яг нийлүүлэлтийн суваг нь ажиллахгүй. Энэ дээр шинэчилсэн нэг шинэ механизм хийх ёстой нь шууд харагдаж байна.

Нөөцийн мах үйлдвэрлээд, бүрдүүлээд тэгээд ченжээр дамжуулах ямар нэгэн байдлаар нөлөөгөө хангалттай өгч чадахгүй нь харагдаж байна л даа.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн бодлого шинээр баримталж байгаа юу гэж асууя.

Гурав дахь асуудал, мөнгөний бодлого болон төсвийн бодлого хоорондоо хэр зэрэг уялдаж байгаа вэ?

Яагаад гэвэл манай Монгол Улсын болон бусад улс орнуудын эдийн засгийн үндсэн тулгуурууд нь мөнгөний бодлого болон төсвийн бодлого байдаг. Тэгээд Монголбанкийг харахад хатуу мөнгөний бодлого баримталж байна.

12 сард Төв банкны үнэт цаас 4.2 их наяд байсан. Өнөөдөр 6.9 их наяд болж 2.7 их наядар нэмэгдсэн. Энэ нь шууд цэвэр эргэлтэд орж байх мөнгө Төв банкны үнэт цаас болоод гагцхихсан байна.

Тэгэхээр үүнтэй уялдуулж Засгийн газрын төсвийн бодлого нь яг яаж ямар байдлаар уялдаж явж байгаа вэ гэж асуумаар байна.

Дараагийн асуулт. Гадаадын хөрөнгө оруулалт тодорхой хэмжээгээр Монгол Улс яалт ч үгүй хэрэгтэй. Өнгөрсөн онд 1 тэрбум доллар орсон. 1 тэрбум доллароос 800 сая доллар нь Оюу Толгой. Зөвхөн 200 сая доллар нь бусад гадаадын хөрөнгө оруулалт орсон.

Тэгэхээр үүн дээр эдийн засгийн хөгжлийн шинээр агентлаг байгуулагдсан гэж харж байгаа юм. Хуучин FIFTA /Foreign Investment and Foreign Trade Agency/ байсан.

Үүний үйл ажиллагаа нь хэр зэрэг жигдэрч үйл ажиллагаа явж байгаа вэ? Ялангуяа нэг цэгийн үйлчилгээ гэдгээрээ байгаа юу? Гадаадын хөрөнгө оруулагчид зориулсан.

Эд нар ярихдаа маш их том хүнд суртал байна, бичиг цаасаа хүлээх гэж нэг сар, хоёр сар хүлээж байна гэсэн тийм гомдол их ирж байна.

Тэгээд яалт ч үгүй өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсын үндсэн тулгууруудын нэг болох

ёстой. Оюу Толгойн бус гадаадын хөрөнгө оруулалт. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Э.Батшугар даргын асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Э.Батшугар гишүүний асуултад хариуль.

Үндсэн хуулийн 6.2-т заасанчлан газрын хөрсөнд доорх баялаг бүх ард түмнийх.

Үүнийг харин эдийн засаг тэлэх хэрээр, газрынхаа баялгаас бид ашиг орлого авах хэрээр ард олон нийтэд хүртээлтэй байх ёстой. Үүний гол бодлогын суваг нь энэ Үндэсний баялгийн сан юм гэдэгтэй санал нийлж байна.

Тийм учраас үүний хууль эрх зүйн зохицуулалтыг яаралтай бид сайжруулж шинэчлэхийг нь шинэчлээд явах ёстой. Болбол энэ хавартаа энэ хуулийг шинээр өргөн бариад батлах төлөвлөгөөтэй Засгийн газар ажиллаж байгаа гэдгийг дуулгая.

Инфляц. Мэдээж төсвийн орлогод тодорхой хэмжээнд нөлөөлж байдаг ийм хүчин зүйл.

Төсөв, мөнгөний бодлого хэрхэн нийцэж байна вэ гэж. Бид Засгийн газрынхаа түвшинд үнийн инфляц, бодлогын хүү, энэ бүх зүйл юу гэдэг юм Төв банкны өөрийнх нь зорилгод ийм бодлогын функц гэж ингэлгүйгээр Төв банктайгаа зэрэгцээд яг Засгийн газар өөрөө хариуцаж хийх ёстой ажил. Ялангуяа төлбөрийн тэнцэл, гадаад худалдаатай холбоотой энэ асуудлууд дээрээ маш идэвхтэйгээр Төв банкныхаа бодлоготой нийцэж ажиллаж байгаа.

Төв банкны валютын нөөц нэмэгдүүлэх асуудал дээр Засгийн газар шийдвэртэй арга хэмжээнүүд авсны үр дүнд тодорхой зорилтот түвшинд хүрч нэмэгдлээ.

Төлбөрийн тэнцэл дээр Засгийн газар маш анхааралтай ажиллаж. Энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яам шинээр байгуулагдсан. Бүхэл бүтэн институт энэ дээр бодлогоо чиглүүлээд Монголбанктайгаа хамтраад бодлогоо нийлүүлээд явж байна.

Мөн сүүлийн жилүүдэд өндөр хэмжээнд байх байсан эрсдэл ажилгүйдлийн эсрэг эдийн засгаа ч, тэр эрүүл мэндээ ч тэр тогтвортой байлгах 10 их наядын хөтөлбөр гээд.

Энэ бүх зүйлүүд дээр мөнгөний бодлого, эдийн засгийн салбарын санхүүгийн салбартаа хийдэг гол институтууд Төв банк, Санхүүгийн зохицуулах хороотой ч тэр маш нягтарч бодлогуудаа нийцүүлж явж байгаа.

Бодлогын хүү цаашдаа буурах эсэх нь саяын миний ярьдаг төсвийн бодлого, мөнгөний бодлого хэрхэн нийцэхээс их шалтгаална. Гол нь инфляц байна. Үнийн өсөлт.

Энэ жилийн хувьд бид 4 дүгээр улиралд жилийн эцэс гэхэд нэг оронтой тоо руу дөхүүлэх, 2024 онд мөнгөний бодлогын зорилтот түвшинд тэр 8 хувьд хүргэх ийм зорилттой байгаа.

Тэр үед мэдээж бодлогын хүү буурах, мөнгөний бодлогын энэ хатуу төлөв зөөлрөх ийм орон зай нээгдэх болов уу гэсэн ийм төлөвлөгөөтэй, хүлээлттэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт FIFTA-тай холбоотой асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам хариулах байна.

Л.Мөнхбаатар: Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар асуултад нэмж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг байгуулах шийдвэр Засгийн газраас гарчихсан.

Одоо Төрийн албаны хуулиараа даргыг нь сонгон шалгаруулалтаар тавих ёстой. Тэгээд сонгон шалгаруулалтыг зарлуулахаар хүсэлт өгч явж, нааш цаашаа явсаар байгаад саяхан зарлагдсан байгаа гэдгийг хэлье.

Түр орлон гүйцэтгэгч тавих гэхээр зайлшгүй яг дотор нь ажиллаж байгаа хүнийг түр орлон гүйцэтгэгч тавих ёстой.

Гэтэл нөгөө шинэ агентлаг учраас тэнд нь ширхэг ч хүн байхгүй байгаа учраас энэ ингээд удирдлага байхгүй байгаа учраас энэ агентлаг ажиллаж чадахгүй байгаа гэдгийг хэлье.

Гэхдээ энэ дээр нэг л зүйл байна. Иймэрхүү зүйл дээр. Одоо манай яам Төрийн нарийн бичгийн дарга аа зарлуулж чадахгүй байгаа.

Ингэхээр энэ Төрийн албаны зөвлөлөөс нэг бол ийм математикч хүн манай яамны Төрийн нарийнаар тавиагч гээд байгаа юм. Эсвэл хуульч хүн тавиагч гээд байх юм. Манай Эдийн засгийн яамны. Би эдийн засагч хүн авмаар байдаг.

Ядахдаа өрсөлдөөн гэдэг юмаа мэддэг, үнэ тогтох механизмаа мэддэг, үнэ бага байлгаад байвал ямар хортой байдгаа мэддэг, ханшаа мэддэг ийм хүн тавимаар байдаг.

Намайг хуульчид авч тавиагч гээд байгаа юм. Хуульч. Нэг бол математикч

гээд. Одоо хүртэл төрийн нарийн зарлуулж чаддаггүй. Төрийн албаны зөвлөлтэй холбоотой бухимдах юмнууд гарах л юм.

Гэхдээ удахгүй жигдэрчих байх л гэж бодож байгаа.

Мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёр нийцэж явж байгаа. Яг инфляц ийм юм өндөр байгаа үед энэ улс орнууд янз янзын л бодлого авч хэрэгжүүлсэн. Тэгээд явж явж эцэстээ тэгээд л мөнгөний бодлого, төсвийн бодлого гээд яг эдийн засгийнхаа сонгодог бодлогууд дээрээ л очиж тулж байгаа.

Тэгэхээр яг инфляц өндөр үед мөнгөний хатуу бодлого, төсвийн нөгөө праймэри баланс дандаа нэмэх явах гэсэн энэ хоёр зарчмыг баримталж явахаас өөр арга байхгүй. Тэгэхгүй бол инфляцаа алдана.

Тийм учраас инфляц бууна гэдэг нь юу гэдэг юм нэг өдөр хүрчихдэг үр дүн биш. Зөв бодлогыг тууштай хэрэгжүүлж байж инфляцыг буулгана гэдгийг л би хэлмээр байна.

Жоохон мөнгө олонгуут л зарахаа бодох биш эдийн засгийнхаа тогтвортой байдлыг хангах чиглэл дээр нь нэлээд анхаарал тавьж ажиллах ёстой. Их Хурал маань үүнийг дэмжиж өгнө гэдэгт итгэж байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Ирцээ өгье. Ж.Чинбүрэн гишүүнээр тасаллаа.

Г.Амартүвшин гишүүн үг хэлье.

Г.Амартүвшин: Баярлалаа. Би товчхон ярина.

Ер нь Ч.Хүрэлбаатар сайд, Б.Жавхлан сайд хоёрын хариултыг сонсоход мэдээж хэрэг үнийн өсөлт бол том асуудал. Үнийн өсөлт зөвхөн манай эдийн засагт биш ер нь дэлхий даяар их том сорилт бий болсон.

Гэхдээ бид үнийн өсөлтийг өрхийн хэмжээнд дэмжихийн тулд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэх асуудлыг бас нэлээн нухацтай болгоомжтой хандах нь зөв байх шүү.

Яагаад гэвэл одоо бид ингээд жоохон эдийн засаг нь гайгүй болоод валютын нөөц нь өсөөд, ханш тогтворжоод ийм байгаа нөхцөлөө аягүй хурдан эсрэг чиглэл рүү чиглүүлчхэж бас эрсдэлтэй байгаад байна л даа.

Өөрөөр хэлбэл нөгөө инфляцаа бид буцаад буулгах биш улам өсгөөд. Инфляц өснө гэдэг чинь нөгөө Монголбанк бодлогын хүүгээ бууруулахгүй харин үргэлжлүүлээд бодлогын хүүгээ нэмэгдүүлэх. Үүнийг дагаад арилжааны банкнуудын зээл нь ч гэсэн хүү нэмэгдэх тийм магадлал байна.

Үүний үр дагавар нь юу вэ гэхээр эдийн засгийн өсөлт ч гэсэн саарч эхэлнэ. Импортын хэрэглээ нэмэгдэх тийм эрсдэл байна. Энэ нь буцаад ханшиндаа нөлөөлөөд ханш маань тогтворжиж байснаа буцаад сулраад төгрөг үнийн өсөлтөө бүр илүү том нөлөө үзүүлээд явчих вий дээ.

Өөрөөр хэлбэл бид үнийн өсөлтийн худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ гэж бодож байсан боловч бүр эсрэгээрээ үнийн өсөлт нь бүр 2024 онд 8 хувь гэж төсөөлж байснаас шал өөр зүг рүү л явчих тийм эрсдэл байна гэдгийг би хэлмээр байна.

Тийм болохоор энэ 2024 оны төсөв, урсгал зардал дээрээ Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам нэлээн тийм судалгаа, урт хугацааны бодлоготой л хэрэгжүүлээрэй гэж хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: Одоо Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Ер нь энэ эдийн засгийн өсөлт ч бай, цаашдаа Засгийн газраас хийж хэрэгжүүлж байгаа ажил бол ер нь ард түмний амьдралд мэдэгдмээр байгаа юм л даа.

Хөрсөн дээрээ буумаар байгаа юм.

Тэгээд энэ чинь л болохгүй болохоор нөгөө ард түмэн чинь. Аягүй бага хэрэгцээтэй ард түмэн шүү дээ. Энэ чинь одоо нэг гурил будаа гайгүй шиг үнэтэй байгаад л.

Тэгээд хавар зун нь аятайхан болоод л ингээд л байж байвал болдог ард түмэн байхгүй юу. Тэгээд янз янзын юм шаардаад байдаггүй. Тэгээд энэ юмыг нь хааж чадахгүй байна.

Харин яах вэ харж байхад энэ Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд хоёр бас зах зээлийн эдийн засгаа мэддэг хүмүүс байх шиг байна. Тийм. Яриа хөөрөө хийж байгаа ажлыг нь хараад байхад.

Тэр бирж нь болж байна гэж ойлгож байна.

Та нар хэд хэдэн юмаа бас хийчих. Цаашдаа. Тэр мухар төмөр замаа янзал аа.

Гадаадын хөрөнгө оруулалт алга. Энэ инфляц гэдэг юманд чинь хамаг юм тэгээд цохигдоод байхгүй болж байна. Тэрийг мөнгөний бодлого, төсвийнхөө

бодлоготой уялдуул. Тэгэхгүй бол Монголбанк нь чангалаад байдаг. Бодлогын хүү нь 13 байгаад байхад тэгээд аж ахуйн нэгж ямар хүүтэй зээл авах юм?

Нөгөө талаар хамаг төсвийн мөнгө дотоодын нийт бүтээгдэхүүний бүх Монгол Улсын мөнгө төгрөгийн 50 хувийг нь төсөв дээрээ татаад ирчихсэн. Тэгээд бараг социализм байгуулах гэж байгаа юм шиг ийм маягтай яваад байдаг. Үүнийгээ больсон нь дээрээ. Социализм бол бүтэхгүй болчихсон юм шүү дээ.

Аль болохоор хувийн хэвшилээ дэмж, ажиллуул. Тэгээд төр л ажлын байр бий болгодог, одоо тэрийг авч явдаг ийм юм шиг ойлголт өгөөд байдаг.

Тэгээд Засгийн газар энэ хулгайч нартайгаа тэмц ээ. Тэгэхгүй бол энэ 76 гишүүнийг хулгайч гээд байна шүү дээ. Би ямар ч юм хулгай хийгээгүй мөртлөө за за яршиг яршиг гээд л дуугүй л байж байх юм. Заримдаа. Юу хулгайлсан юм гээд л асуучихмаар байгаа юм.

Тэгээд та нарын өмнөөс болоод заримдаа асууж чадахгүй байна шүү дээ.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүн ээ, хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбогдуулаад үгээ хэлээрэй та.

Д.Ганбат: Үгүй. Би ард түмний үгийг л дамжуулаад байгаа шүү дээ. Тийм.

Ингээд үгийн хүч сулруулаад байгаа юм. Та одоо.

Тэгээд Засгийн газар танхимын зарчмаараа ажилламаар байна.

Нэгэнт та нар шийдвэрээ гаргачихсан юм бол наад танхимын

сайдууд чинь тэгээд янз янзын юм яриад байдгаа болимоор байна.

Тэгээд түрүүн би хэлсэн. Манай сонгогчид ч гэсэн, манай Баянхонгорынхон ч гэсэн хэлж байна лээ. 40, 50 хүний эвийг нь нийлүүлээд явуулчихсан. Тэгээд аятайхан аваад явчихдаг гэсэн. Тэгээд харагдахгүй л байгаа байхгүй юу. Энэ Засгийн газарт дээлийг нь нөмрөглөө. Давхар дээлтэй болголоо. Хүссэн бүх юмыг нь өглөө шүү дээ. Одоо сайн ажиллах л үлдсэн байна. Одоо нэг жил гаруйн хугацаа үлдэж байна. Энэ хооронд бас их сайн амж ажил амжуулах хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол одоо энэ иргэд чинь ерөөсөө хүнсэндээ нөгөө толгой шийрээ авч идээд л, тэгээд их үнэтэй юм орж ирэх юм даа. Ямар ч чанаргүй. Тэрийгээ аваад л.

Энэ 500 мянган төгрөг чинь ёстой хаанаа ч хүрэхгүй байна шүү дээ. Тэгээд тэр 30 жил ажилласан хүн ч гэсэн адилхан тэтгэвэр авдаг, 3 жил ажилласан хүн ч адилхан тэтгэвэр авдаг. Ингээд тэгшитгэхсэн. Ямар ч ялгаа байхгүй.

Иймэрхүү бодлогын алдаа хийгээд байна. Ийм байвал хэн нийгмийн даатгалаа хөтлөх юм. Энэ хулгай зэлгий чинь их байвал хэн татвар төлөх юм. Гэмт хэрэгтэй гээд тэмцэхгүй байна.

Тэмцсэн ч тэгээд нэг шоу, хурал цуглаан, уриа лоозон. Иймэрхүү юмаар л энэ сайхан алтан цаг хугацааг өнгөрөөгөөд байх юм. Эцсийн эцэст манай Монголчууд чинь өнгөрсөн хугацаанд ч олигтой амьдарсан юм алга. Одоо ч олигтой амьдарч байгаа юм алга. Цаашид ч гэрэл гэгээ харагдахгүй байна шүү дээ. Яг энэ маягаараа ажиллах юм бол.

Жоохон бодлогын өөрчлөлт хиймээр байна. Тэр зах зээлийн зарчим, энэ хувийн хэвшил дээрээ тулгуурлаж ажиллах ийм зүгтэй ажил. Тэгэхгүй бол болохгүй байна. Энэ залуучууд чинь энэ улс орноос чинь дайжиж байна шүү дээ.

Төрийн албанд чинь ч ажиллах хүн алга, хамгийн чадалтай чадвартай хэсгүүд нь гадагшаа гараад явж байна. Уг нь бид чинь маш таатай үед байгаа байхгүй юу. Уул уурхайн бүтээгдэхүүний супер циклийн үе. Энэ залуучуудын яг ид насны ажиллах хүчний супер циклийн үе.

Энэ хүмүүс чинь Солонгосын эдийн засгийг хөгжүүлэхийн төлөө гаднын улс оронд хүнд хэцүү ажил хийхээр л яваад өгч байна шүү дээ. Ингэмээргүй л байна шүү дээ. Хараад үнэхээр хэцүү юм.

Та нар маань ингээд 8 жил ингэж явлаа. Одоо улсын 24.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хоёр гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана.

Гишүүд танхимдаа орж ирээрэй. Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлье.

Б.Баттөмөр: 2024 он манай Монгол Улсын хувьд нэлээн таатай он байна гэж үзэж байгаа.

Манай худалдааны гол түнш Хятад Улсын эдийн засгийн өсөлт 5 хувь. Тун удахгүй 6-аас 7 жилийн дараа дэлхийн хамгийн том эдийн засаг болно. Монголд үйлдвэрлэсэн бүх зүйлийг л авъя гэж байгаа шүү дээ.

Ийм таатай боломжтой ийм цаг үед Монголчууд бид ухаалаг зөв ажиллаж чадах юм бол хөгжлийн маш их тийм боломж байна гэж үзэж байгаа.

Би өнөөдрийн энэ тавьж орж ирж байгаа тоо бол доод талын тоо байгаасай гэж, доод хязгаар байгаасай гэж бодож байгаа.

Эдийн засгийн татварын орлогын хэмжээ 2 их наяд төгрөгөөр нэмэгдээд инфляц нь 8 хувьтай байна гэдэг бол Монгол Улсын эдийн засагт өөрчлөлт гарахгүй. Ард түмний амьдралд өөрчлөлт гарахгүй. Яг энэ төлөвлөлтөөр.

Тэр 2 тэрбум төгрөгийн орлого чинь нөгөө үнийнхээ өсөлтдөө л яваад өгнө шүү дээ.

Тийм учраас Монгол Улсын хөгжлийг өөдрөг хараач ээ гэж.

2023 оны төсвийг баталж байхад би хэлсэн юм. Хэдхэн арга хэмжээ авахад 1.5 их наяд төгрөгийг төсөв дээр нэмэх боломж байна. Тэгээд 200 тэрбум төгрөг нэмсэн. Одоо энэ Г.Тэмүүлэн мэдэж байгаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 1 их наяд төгрөгийн ашигтай байгаа шүү. Статистик яриад байгаа шүү. Би өөрөө санаанаасаа зохиогоогүй шүү. Яагаад ийм ашигтай гарч байна, орлого яагаад нэмэгдэв ээ гэхээр бид нэг их том бодлого явуулаад л, их мундаг юм хийчихсэн юм бол байхгүй шүү дээ. Нүүрсний үнэ. Тэр үнэ, тооны өсөлтөөс л гарч ирж байгаа шүү дээ.

Нүүрсний үнэ унаж байна л гэж байна. Үгүй ээ. Унаагүй байгаа. Монголын нүүрсний үнэ унаад байгаа. Үүнийг яагаад ингэж байна гэхээр нөгөө биржийн үйл ажиллагааг эсэргүүцэж байдаг хүмүүс холбогдох тэр авдаг хүмүүстэй нь очиж нийлээд биржээр нүүрс авахгүй гэсэн ийм л бодлого яваад байгаа байхгүй юу.

Биржийн хуулийг нь батлаад өглөө. Засгийн газар тэр нүүрс авдаг улсуудтай уулзалт хийсэн үү. Тохиролцоо хийсэн үү.

Монголд ийм хулгай зэлгий гараад байна. Биржээр худалдъя. Үүнийг дэмжээд өгөөч ээ гэж уулзалт хийсэн үү. Байхгүй шүү дээ.

Энэ оны 4 дүгээр сард 19.6 сая тонн нүүрс гарсан. 20 сая нүүрс гарчихсан. Үлдэж байгаа 8 сард яг энэ эрчээрээ ажиллах юм бол 60 сая гарах боломж байгаа. Гэтэл 50 гээд л ороод ирж байгаа.

Эхний 4 сард 7.1 их наяд төгрөгийн орлого Монголын төсөвт орж ирсэн. Яг 2023 онд энэ эрчээрээ ажиллах юм бол 21.3 их наяд орчим орлого олох боломжтой. Гэтэл 21.1 гээд ороод ирж байгаа байхгүй юу.

Хөгжлийг ингэж гутранги харж төлөвлөж болохгүй шүү дээ.

Манай улс эхний 4 сард Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 5.7 тэрбум долларын худалдаа хийсэн. Үлдэж байгаа 8 сарын хугацаанд энэ эрчээр байвал 17 тэрбум долларын худалдаа хийх ёстой. Тэгтэл 14 тэрбум доллар гээд байгаа юм.

Энэ сүүдрийн эдийн засагтайгаа тэмцээч ээ. Энэ далд эдийн засгаа ил болгооч ээ. Сүүдрийн эдийн засгаа наранд гаргах боломжууд байна. Маш их хэмжээний далд эдийн засаг байна. Орлого дайчлах боломжууд байна. Энэ дээрээ ажиллах хэрэгтэй шүү дээ.

Монгол Улсын төсөв мөнгөтэй болох хэрэгтэй, хуримтлалтай болмоор байгаа юм. Энэ хуримтлалдаа хүнийхээ

хөгжилд, улсдаа хөрөнгө оруулах шаардлага байна.

Эдийн засгийн өсөлтийн хүртээмж алга. Өгөөж байхгүй. Манай эдийн засгийн өсөлт ядуурлыг дэвэргээд байгаа шүү.

Нэг хувийн эдийн засгийн өсөлт ядуурлын 0.06 хувиар өсөх гэж байна гээд нэг судлаачийн гаргачихсан тоо байгаа шүү.

Ингээд 8 хувийн инфляцтай байдаг. Манай гол бизнес дотоод руу чиглээд явж байгаа. Дотоод руу чиглэж бизнес хийж байгаа улсууд 8 хувийн инфляцтай байхад хөгжих асуудал байхгүй шүү. Нэг бол шударга бус үнэ тогтоно, нэг бол үнийн өсөлт гаарна.

Ийм л байдалтай байна даа. Энэ Оюу Толгой төсөлтэйгөө маш сайн ажиллах шаардлагатай байна.

Энэ сайдууд нь алга болчих юм. Ингэж яриад байх хэрэгтэй ч юм уу, хэрэггүй ч юм уу.

Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандмаар байна. Засгийн газар.

Хөгжлийн сайд нь алга, Сангийн сайд нь алга.

Эсвэл үл тоогоод байгаа юм уу.

Монгол Улсын хөгжлийг ингэж гутранги харж та нар болохгүй шүү.

2024 онд Монгол Улсын төсвийг 22-оос 24 их наяд төгрөг болгох боломж байгаа шүү.

Л.Мөнхбаатар: Одоо Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлье.

Ж.Чинбүрэн: Өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр энэ эрүүл мэндийн салбартай холбоотой зүйлүүд дээр бас нэмж үг хэлье гэж бодож байна.

Би бас Сангийн яаманд их талархалтай хандаж байгаа.

Ер нь эрүүл мэндийн салбарын том өөрчлөлтийг эхлүүлж чадсан. Тэр дотроо нөгөө чанартай гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн салбар маань ямар ч байсан энэ сайн хүн эмчлүүл санхүүжилтээ авч чаддаг ийм тогтолцоо руу шилжсэн.

Энэ шилжилтийн амжилттай явах гол амин сүнс нь Эрүүл мэндийн даатгалын сан өөрийнхөө санхүүжилтийг нэмэгдүүлэх нь эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээ буюу 3.4 сая иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хийхийн гол үндэс нь.

Тийм учраас энэ төсвийн хүрээний мэдэгдэлдээ 2024 онд бид Эрүүл мэндийн даатгалын санг 2 их наяд доор хаяж хүргэж байж энэ тусламж, үйлчилгээ иргэн бүрд саадгүй, нөгөө мөнгө нь хүрдэггүйгээс болоод Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар гүйцэтгэлийг хасдаг энэ тогтолцоо байхгүй болно.

Ингэж чадах юм бол эрүүл мэндийн салбарын ажилчид нэгд цалин хөлс нэмэгдэнэ.

Хоёрт, стратегийн худалдан авалтаа хийж, салбарын хөрөнгө оруулалтууд, тоног, төхөөрөмжийн шинэчлэл заавал улсаас тендер зарлаж тоног төхөөрөмж авч өгөхгүйгээр

эмнэлгүүд өөрсдөө хийгээд явах бүрэн боломж бүрдэнэ.

Тийм учраас энэ дээр онцгой анхаараарай. Энэ хийсэн, эхлүүлсэн сайн ажлын амин сүнс нь даатгалын сан өөрөө нэмэгдэх нь чухал.

Тийм учраас Эрүүл мэндийн сайд ч энд байна.

Ер нь Эрүүл мэндийн даатгалын сан 2 их наяд төгрөгт хүрч байж бид тусламж, үйлчилгээ иргэддээ сайн хүргэнэ шүү.

Ялангуяа эмчилж чадахгүй гээд байгаа гадаад руу явж байгаа хүмүүсийн эмчилгээг бүрэн даах, энэ тогтолцоог бүрдүүлэхэд бас энэ даатгалын сан бол өөрөө чухал үүрэгтэй.

Хоёр дахь чухал хэлье гэж байгаа санаа бол энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдаж авах хуулийн төсөл нэмэлт, өөрчлөлт яваа. Энэ дотор бол нэг чухал оруулж байгаа зүйл бол бид эмийн чанарыг, эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанарыг нэгд тавина гэдэг энэ том бодлого оруулж байгаа.

Тэр утгаараа чанартай бүтээгдэхүүн өөрөө үнэтэй байдаг. Ялангуяа оригинал бүтээгдэхүүнүүд маш үнэтэй байдаг учраас даатгалын сан мөн л ялгаагүй нэмэгдэж байж энэ үнэтэй эмүүдийг худалдаж авах, иргэддээ чанартай сайн эмийг өгөх энэ боломж бүрдэнэ.

Тийм учраас энэ дээр С.Чинзориг сайдын санаачилсан бараа үйлчилгээ худалдаж авах ажиллагаан дээр чанарыг нэгд тавьдаг үйл ажиллагаа хэрэгжээд эхэлбэл нөгөө зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орж байгаа, нөгөө 2020

оны өмнө 27 тэрбум төгрөг байсныг өнөөдөр 89 тэрбум болгосон энэ мөнгө мөн ялгаагүй нэмэгдэх ийм хандлага байгааг бас анхаараарай.

Дараагийн хэлэх гэсэн зүйл бол ер нь Б.Жавхлан сайдад бүр зориуд хэлье гэж бодож байна.

Энэ дүүрэг, аймгийн эрүүл мэндийн газруудад төсвийн хэмнэлтийн хуулиар асар их үйл ажиллагаанууд нь хязгаарлагдаж байна.

Ялангуяа нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа хийх боломж нь энэ хэмнэлтийн хуулиар хасагдчихсан.

Манай эрүүл мэндийн салбарын сургалт гэдэг бол дандаа онлайн хийх боломжгүй. Ялангуяа сувилахуйн тусламж, эх баригч, бага эмч нарын сургалт бол дандаа гардан үйлдлүүд байдаг учраас энэ дээр энэ хэмнэлтийн хуулиар хасагдсан зардлуудаа буцаж суулгах их чухал байгаа шүү.

Энэ дээр бас онцгой анхаараарай.

Дараагийн чухал зүйл бол түрүүн Б.Энх-Амгалан гишүүн бас ярьж байна. Алслагдсан сумдад ажиллах боловсон хүчингүй болчихоод байгаа. Бүр эмч ч байхгүй. Бага эмч нь эмчээ орлоод ажиллаж байна.

Тийм учраас энэ дээр бүр онцгойлон боловсон хүчин, тэр тусмаа алслагдсан сумдад ажиллах боломжийг нэмэх бодлого хэрэгтэй байна. Энэ дээр Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Эдийн засгийн яам хамтарч энэ дээр бодлого гаргаж 2024 оны төсөвтөө үүнийг бүр анхааран суулгаж өгөөсэй гэж хүсэж байна.

Тэгээд дараагийн бас нэг хэлэх гэж байгаа зүйл бол ер нь бид энэ даатгалын санхүүжилтээр гүйцэтгэлийг худалдаж авдаг тогтоол руу илүү орох ёстой.

Түүнээс нэг тендер зарладаг. Бүтээгдэхүүн худалдаж авахаасаа илүүтэй сайн тусламж, үйлчилгээг чанартай сайн өртгөөр нь худалдаж авдаг энэ тогтолцоо руу орох үйл ажиллагааг сайн дэмжээрэй.

Цахим шилжилт бол үнэхээр нурсан. Би Б.Жавхлан сайдын өмнө үнэхээр ичгүүртэй байна. Бид Сангийн яам, манай Инновац, цахим бодлогын байнгын хороон дээр энэ цахим шилжилт реформыг хийнэ гэж хэлээд Эрүүл мэндийн яам энэ ажлыг эхэлсэн.

Одоо тэгээд аль ч үгүй болсон. Үргэлжлэх боломжгүй болсон. Харин 2024 оны төсвийн тодотгол дээр цахим шилжилтийг дэмжихээр төсөв мөнгө тавьсан байна. С.Чинзориг сайд.

Тэгвэл одоо нөгөө хийж чадаагүй улсууддаа хариуцлага тооцдог байх хэрэгтэй. Энэ дээр бид ч гэсэн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явагдана.

Санал хураалтад бэлтгэе. Гишүүд суудлаа эзэлье. Үүдэнд байгаа гишүүдийг танхимд орж ир гэж хэлээрэй. Санал хураалтад бэлтгэе.

Г.Тэмүүлэн, Б.Энхбаяр, Э.Бат-Амгалан дарга, Ц.Сандаг-Очир гишүүн Н.Наранбаатар гишүүн. Бүлгийн дэд дарга нар ирцээ бүрдүүлээд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

56.9 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Одоо хоёр дахь асуудалдаа орёе.

Г.Занданшатар: Дараагийн асуудалд орно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд үүний дараа Төрийн байгуулалтын байнгын хороо Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаа үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Сая ажлын хэсэг хуралдаад томьёолол дээрээ зарчмын хувьд санал нэгдлээ.

Маргааш 09.00 цагаас өнөөдөр хуралдах байсан Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хуралдахаар даргын дэргэдэх зөвлөлөөс шийдвэрлэсэн болохыг мэдэгдье. Энэ хоёр асуудлаа хэлэлцэнэ.

Өглөө 09.00 цагаас Эдийн засгийн байнгын хороо жилийн төлөвлөгөөгөө,

Төсвийн байнгын хороо төсвийн хүрээний мэдэгдлээ хэлэлцэнэ.

Ингээд дараагийн асуудалд орёе.

*Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/*

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Ч.Хүрэлбаатар: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.2-т заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа хуульд заасан шаардлагын дагуу “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “**Шинэ сэргэлтийн бодлого**”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй тус тус уялдууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолын 2.3 дахь заалтад

улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ Хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлж, хөгжлийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгахаар заасныг хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд өрхийн орлого нэмэгдүүлэхийг гол зорилгоо болгон экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, засаглалыг сайжруулах, ногоон хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах зэрэг 8 бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойллоо.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүй ашиглан боловсруулсан бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, үндсэн хариуцах байгууллагыг тус тус тодорхойлон тусгалаа.

Яамд, агентлаг болон нутгийн захиргааны байгууллагуудаас нийтдээ

80.2 их наяд төгрөг бүхий 1047 төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн шаардлага, баримтлах зарчимд үндэслэн мөн Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 8 бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд 184 төсөл, арга хэмжээнд нийтдээ 13.4 их наяд төгрөгийг санхүүжүүлэхээс Улсын төсвийн хөрөнгөөр 2.3 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0.2 их наяд төгрөг, гадаадын зээлээр 1.3 их наяд төгрөг, гадаадын тусламжаар 0.5 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.5 их наяд төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар 3.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээр 1.6 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн боловсрууллаа.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна. Д.Өнөрболор гишүүнийг.

Д.Өнөрболор: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан нийт 13.4 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 8 тэргүүлэх чиглэл, 184 төсөл, арга хэмжээг тусгаж, үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 2.3 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0.2 их наяд төгрөг, гадаадын зээлээр 1.3 их наяд төгрөг, гадаадын тусламжаар 0.5 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.5 их наяд төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар 3.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээс 1.6 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Тогтоолын төслийг **D-Parliament.mn** цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг төлөвлөгөөний төсөлд экспорт болон өрхийн орлогыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх төслүүдийн талаар, Оюу Толгойн гүний уурхай ашиглалтад орсноор эдийн засагт үзүүлэх үр дүн, өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хил холболт хийгдээгүй төмөр замыг холбох төслүүдийн талаар болон нүүрс угааж баяжуулан нэмүү өртөг шингээх талаар, Дарханы арьс ширний үйлдвэрийн цогцолбор, үйлдвэрлэл, технологийн паркуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, хушны самар экспортын

асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төлөвлөгөөний төсөлд төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдаалах асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Газрын багц хуулийг хэзээ өргөн мэдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг дотоодын эрчим хүчний хэрэгцээг хангах, эрчим хүч экспортлох төслүүдийг хэрэгжих боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл төсөлд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэдэн хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийхээр төлөвлөсөн болон төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин боомтын суурьшил, боомт доторх авто зам, эрчим хүчний асуудлыг хэн хариуцах талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд гадаадын хөрөнгө оруулалт татах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх, зарцуулах хүрээнд хийхээр төлөвлөж байгаа арга хэмжээний талаар, нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн тэтгэвэр, тэтгэмж, арга хэмжээний талаар, нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Алтанбулаг чөлөөт бүсийн хэрхэн хөгжүүлэх, Дархан арьс ширний үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалт, ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн байгууламжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих,

боловсруулалтын түвшнийг ахиулах, эрчим хүчний эх үүсвэрийн чадлын дутагдлаас гарах, чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих, боомтын дэд бүтцийн асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг хөгжлийн төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хоорондын уялдаа холбоог хангах, хөгжлийн бодлогыг бодитой төлөвлөх, үр дүн хэмжихүйц, тодорхой байх, хүрэх үр дүнд суурилж төлөвлөх, төсөвлөх гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Зандашатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Сангийн сайд Болдын Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн хаана байна? Боловсрол

шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан хаана байна?

Л.Энх-Амгалан сайдыг дууд. Яасан их дэмий тэнэдэг юм.

Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хаана байна? Дуудъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Жамьянхорлоогийн Сүхбаатар, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын Үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Н.Учрал сайд хаана байна?

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга, Соёлын дэд сайд Мөнхөөгийн Батбаяр, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Жигжидсүрэнгийн Сандагсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сүхбаатарын Цогтгэрэл, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Чулуунборын Гандирваа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Лхагвасүрэнгийн Балчинлуvsан, Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Хилийн

боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга Хишигбаярын Эрдэнэбулган, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны хөгжлийн судалгааны газрын дарга Лувсанжанцангийн Эрдэнэбаяр, Эдийн Засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Дэмбэрэлийн Очирваань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж. М.Санжаадорж дарга чинь Төрийн нарийн бичгийн дарга болчихоогүй билүү?

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Идэшийн Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Батчулууны Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн дарга Гантулгын Нямцэцэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Улс, нийслэлийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Сумъяагийн Ариунцэцэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Замын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Баатаржамбын Энхмандах.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Гочоогийн Ганболд гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ингээд тогтоолын төсөл ярьж байгаа юм байна. Үгүй ээ, одоо ингээд л баахан цаас яриад л батлаад л байдаг. Хурал цуглаан хийгээд л байдаг.

Тэгээд энэ дарга нар чинь яасан ч гоё гоё цол, гуншинтай хүмүүс юм бэ дээ. Тийм. Юу юуны хөгжлийн дарга нар ч гэнэ вэ?

Нөгөө Өвөр Монгол хүүхнүүдийн нэр шиг л юм байна шүү дээ. Аан..? Тийм. Аан?

Г.Занданшатар: Юу гэнэ вэ?

Д.Ганбат: Тийм. Тэгээд энэ сайхан дарга нарын цол гуншингаар бид хөгжчихмөөр л юм.

Тэгээд асууя. Их л олон дарга нартай. Ард түмэн үнэхээр бухимдалтай байна.

2024 онд манай Улсын Их Хурлын бүрэн эрх дуусна. 6 сард. Энэ Засгийн газар ч гэсэн 2024 оны 6 сар хүртэл ажиллах байх. Та нөхдүүд ч гэсэн.

Тэгээд яг тоймтой юу юу хийчих юм бэ?

Ер нь 8 жил болоход ард түмэнд хэрэгтэй яг юу босчихсон юм? Тэр нефтийн үйлдвэр чинь хэзээ орох юм? 2024 онд орох юм уу, орохгүй юм уу? Нэг.

Хоёрт, зэсийн үйлдвэр барих юм уу, үгүй юм уу? Тэр арьс, ширний үйлдвэр чинь босох юм уу, үгүй юм уу? Энэ хууль, эрх зүйн ийм орчинтой, ард

иргэдийнхээ амыг хаадаг, жагсахаар зоддог, нүддэг ийм орчинтой.

Амаараа нэг юм ярьдаг. Хууль биелүүлдэггүй ийм байхад гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх юм уу? Орж ирэх үү? Үгүй ээ. Баахан түгжрэлийн сайд, юу юуны сайд, боомтын сайд.

Үгүй ээ, тэгээд одоо юу сайхан болчихсон юм бэ? Аан. Одоо яг ийм ийм сайхан болчихсон гээд надад хэлээдэх дээ.

Үгүй ээ, энэ Улсын Их Хурлын гишүүдийг бид нарыг очихоороо ард түмэн асууж байна. Асуухгүй яах юм бэ. Хэлэхгүй яах юм бэ. Бухимдлаа гаргахгүй яах юм бэ.

Энэ чинь итгэсэн хүндээ л юмаа ярьж байна шүү дээ.

Энэ олон дарга нар хөдөө орон нутагт очиж ажилламаар байх юм. Бид нарт л үнэнээ хэлэх юм байна шүү дээ. Зовлонгоо гишүүдэд.

Тэгэхээр нэг их хөгжөөд бариад байгаа юм алга. Харагдахгүй байна. Лав л тэр санал, шүүмжлэл тавьсан манай н.Дорж гуай, н.Содномдаржаа гуай, өчнөөн хүмүүсийн амьдрал бол юу ч мэдрэгдэхгүй байна.

Амьдралд нь хүрэлцэхгүй байна. Өнөөдөр хоол, ундаа яая л гэж байна. Одоо яг 2024 онд ийм ийм юм хийчихнэ гээд хэлээдэх дээ.

Энэ олон түмэн сонсож байгаа байх.

Яг юу орох юм? Юу ашиглалтад орох юм? Тэр хүнд яаж мэдрэгдэх юм?

Одоо манай Баянхонгорын Баян-Овоо сумын н.Мэргэнд яаж мэдрэгдэх вэ? Тэрийг хэлээд өгөөч, надад. Энэ тогтоолыг баталчихсанаараа.

Энэ тогтоол дээр яг юу нь орох юм, өмнө нь юу орчихсон юм?

Би бол одоо нүдэн дээр тийм бүтээн байгуулалт босчихсон, барьчихсан, хүмүүсийн амьдралд яачихсан юм мэдэхгүй л байна. Ганц нэг хувийн хэвшлүүдийн хийсэн ажлыг л тэр энэ гэхгүй бол.

Тэр мухар төмөр зам чинь хэзээ орох юм? Тэр зөв хөрөнгө оруулалт байсан юм уу, үгүй юм уу?

Та нар 8 жил энд байж байгаа шүү дээ. Тэгээд Ардчилсан нам бол бараг дагуул нам болчих гээд л, жам болоод л явлаа. Одоо сэхэх юм уу, үгүй юм уу бүү мэд.

Тэгээд охин намтайгаа та хэдийн 60 хэдэн эвлүүлчихсэн нөхдүүдийн хийж байгаа ажил энэ 8 жилд юу хийчихсэн юм. Ахиад нэг жилд нь юу хийх юм. Энэ тогтоол батлаад яг юу болох юм. Энэ дарга нар нэг хариулмаар байх юм.

Тэр яг орон нутагт байгаа иргэнд хүрэхээр 2024 онд таны амьдралд ийм юм хийчихсэн байна, ийм юм хүрнэ ээ гэдгийг л надад нэг хэлээд өгчих.

Тэгээд намайг сонгосон хүмүүс ямар ч байсан бидний асуултыг дамжуулж байна хэлж байна гээд ойлгоод сууж байгаа байх гэж ойлгож байна.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар. Монгол Улсын Шадар сайд түгээд Эдийн засаг, хөгжлийн сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Д.Ганбат гишүүний асуултад хариулья.

Өвөр монгол хүүхнүүдтэй уулзаж учирч яваагүй болохоор нэрийг нь сайн мууг нь мэдэхгүй юм байна.

Тэгээд дээр нь дөнгөж байгуулагдсан яамдын залуучуудыг элдвээр хэлээд хэрэггүй байлгүй дээ.

Ер нь нэг л зүйл би энд онцлон хэлчихмээр байх юм. 76 гишүүндээ хандаад.

76 хулгайч гэдэг нэрийг бид бие биедээ л өгч байна шүү дээ. Бид нарыг Д.Ганбат нь байна уу, Ч.Хүрэлбаатар нь байна уу ялгахгүйгээр 76-гийн нэг л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр хэдүүлээ бас бие биедээ хандахдаа арай жоохон юу гэдэг юм, бид бие биеэ хүндлэхгүй бол бусад нь юу гэж хүндлэх вэ дээ гэдгийг хэлье.

Тэгээд бас амаргүй энэ КОВИД-ын жилүүдийн ард талд гарч ирсэн. Монгол Улс.

Зүгээр энэ КОВИД-ын үед ер нь юу юу авч хэрэгжүүлсэн юм бэ гэдгээ л эргээд аваад үзье л дээ. Хүн амынхаа 90 хувийг бид вакцинжуулсан. Тэгээд нэг тун ч биш. Заримд нь 2 тун, 3 тун. Зарим нь шаардлагатай гэж үзэх юм бол 4 тун хийлгэсэн.

Үүнд чинь 1.1 их наяд төгрөг зарцуулсан. Хүүхдийн мөнгө 20 мянга байдаг байсан. Үүнийг 5 дахин өгөөд, 5 дахин ихэсгээд 100 мянгаар ингээд 3 дахь жилдээ өгөөд явж байна.

1.1 сая хүүхдэд 12 сарын турш 100, 100 мянгаар өгөөд явна гээд та бүгд бодоод үз л дээ. Зөвхөн нэг жилд нь 1.4

их наяд шүү дээ. 3-аар үржихэд 4.2 их наяд.

Энэ мөнгийг би Монголын ард түмэн, Монголын ард түмний хүүхдүүдэд нь зориулагдаж байгаа л гэж хэлж байна. Бодож байгаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэлээ. Хүн амын орлогын албан татварыг тэглэлээ. Айл өрхүүдийн, аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний төлбөрийг төр хариуцаж даалаа.

Тэгээд энэ бүгд чинь тэгээд л бас л 3, 4 их наяд төгрөг.

Эндээс нэг л юм харагдаж байгаа. Төрөөс өгөөд байдаг, даагаад байдаг. Ингэснээр ард түмний амьдрал сайжирдаг юм байна уу гэвэл үгүй л байгаа.

Яахаар сайжрах вэ гэхээр бид эдийн засгаа өсгөж, хувийн хэвшлийг дэмжиж, яг Д.Ганбат гишүүний түрүүн хэлдэг гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, оруулж ирж байж монгол хүмүүсүүдийн амьдрал сайжрах юм байна гэдгийг л харуулж байгаа юм.

Улсаас үнэгүй юм өгөөд, халамж өгөөд, тэтгээд ард иргэдийн амьдрал сайжирдаггүй ээ гэдгийг энэ хил хаалттай КОВИД-ын 3 жил бидэнд ойлгууллаа шүү дээ.

Хувийн хэвшлийг хаадаг боодог, зөвшөөрлөөр хүнд суртал гаргадаг, зөвшөөрлөөр бүх юм зохицуулна гэж боддог энэ бүх хандлагыг бид ардаа орхих ёстой.

Хувийн хэвшлийг дэмждэг, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг. Ингэж байж улс орон хөгжинө гэж бодож байгаа.

Нефтийн үйлдвэр орно. Ашиглалтад орно. КОВИД-ын үед амаргүй л байсан. Тэр Энэтхэг хүмүүс КОВИД-ын үед орж ирсэн шүү дээ. Тэгээд ажиллаад явж байна. Орно.

Зэсийн үйлдвэрийг Оюу Толгой компани гүний уурхайг нээсэн өдрөө Эдийн засаг, хөгжлийн яамтай санамж бичиг зурсан. Зэс хайлуулах, цэвэр зэс боловсруулах үйлдвэр барина гэж.

Солонгосын хөрөнгө оруулагч сонирхож байна. Бүгд Найрамдах Хятад Улсын хөрөнгө оруулагч нар сонирхож байна.

Харин төр барихгүй. Хувийн хэвшил барина. Төр хийвэл нэг хулгайч нь очоод л элдэв бусын мөнгө аваад эхэлнэ шүү дээ.

Тэр нь олон жилийн дараа харагддаг. Хувийн хэвшил хийгээд явна. Гадаадын хөрөнгө оруулалтыг татна. Мухар төрөл зам гэж. Хил рүү 500 километр төмөр зам тавьчихсан байна. Холбож байна. Холбох ажил нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна. 1 минут.

Д.Ганбат: Ингэж асуулаа гэж ард түмэн л надаас нэхээд байгаа шүү дээ.

Тэгээд л түүний дагуу асуусан. Жоохон атар онгон байна уу, үгүй юу.

2024 онд одоо тэгээд яг юу орчих юм бэ л гэж би асуугаад байгаа шүү дээ. Хэрэгтэй юм нь.

Нөгөө талаар КОВИД-ыг тэгээд туулсан туулсан. Тэгээд тэр Хятадын

вакцин хийгээд л. Тэрийг чинь дэлхий даяар хүлээн зөвшөөрөхгүй л байсан шүү дээ. Би хэлж байж л еврей хүн ямар юм хийдэг юм. Тэрийгээ хий гээд л. Тэгээд тэр Фазерыг л авчирч хийлгүүлээ биз дээ.

Тэгээд бас аль аль нь хэлээд яриад зөв буруугаа олоод явах нь зөв л байхгүй юу даа. Энэ л энэ Улсын Их Хурал дутагдаад байгаа шүү дээ. Тийм.

Тэгээд үлдэж байгаа хугацаандаа үр дүнтэй ажил хий. Ойлголт зөв байна гэж бодож байна. Таныг бол.

Өвөр Монгол бүсгүйчүүдтэй уулзах, уулзахгүй нь яах вэ таны хувийн асуудал. Тийм ээ.

Ер нь хувийн хэвшил дээрээ л түшсэн нь дээрээ. Тэр талаар ойлголт нэг байна. Энэ бол зөв байна.

Гэхдээ яг бодитой барьцтай.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт өгье. Ч.Хүрэлбаатар сайд. Чимэдийн Ч.Хүрэлбаатар сайд. Шадар сайд.

Ч.Хүрэлбаатар: Ингээд хоёр бичиг баримт Та бүгдэд бүгдэд нь хэвлүүлээд өгчихсөн байгаа.

Урьд өмнө нь нэг авах арга хэмжээний л жагсаалтууд байдаг байсан. Одоо бол бид бодлогын тэргүүлэх чиглэл гэдгээ гаргаад, бас хөгжлийн төлөвлөгөө гэж гаргаад, дахиад түүн дээрээ бид авах арга хэмжээнүүдээ бусад хөгжлийн бодлогуудтай нь яаж холбогдож байгаа юм, ямар санхүүгийн эх үүсвэр шаардагдах юм зэрэг бүгдийг нь хийгээд өгчихсөн байгаа.

Тэгээд Д.Ганбат аа, үүнийг Их Хурлынхаа бүх гишүүдэд хүргүүлчихсэн байгаа. Та бүгд уншиж танилцаарай.

Би эндээс заримыг нь уншиж болж л байна л даа. Одоо жишээлбэл боомттой холбоотой, боомтын сэргэлттэй холбоотой нэлээд цогц арга хэмжээнүүдийг энд тавьчихсан байж байгаа. Үүнийгээ би нэг товчхон хэлээдэхмээр байна.

Одоо Гашуунсухайт, Ганцмод боомтын хил дамнасан 18.9 километр төмөр зам, ачаа терминал.../минут дуусав/

Г.Занданшатар:
Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Би энд эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, өвчлөл, нас баралтыг бууруулна гээд 3.3 дахь зүйл дээр асуулт асуух гэсэн юм.

Бид илүү их эмнэлгийн тусламж, үйлчилгээ дээрээ их анхаарч байгаа. Арга ч үгүй.

Ер нь эмнэлгүүд их хуучирсан, зориулалтын биш. Дээрээс нь багтаамж нь хүрэхгүй байгаа учраас тэлэх, нэмэгдүүлэх шаардлагатай.

Энэ дотор бид гол анхаарах ёстой чиглэл хуучнаар хоёрдугаар шатлал буюу аймаг, дүүргийн эмнэлгүүдийн чадамжийг сайжруулах нь их чухал.

Тэгэхээр энэ аймаг, дүүргийн эмнэлгүүдийн чадамжийг сайжруулах чиглэлд ямар бодлого энэ тогтоолд орох юм бэ.

Хийх ажлын жагсаалтаа ингээд харахаар жишээлбэл Засгийн газрын

мөрийн хөтөлбөр дотор манай Баянзүрх дүүргийн эмнэлгийг барих асуудал 300 ортой эмнэлгийн асуудал байгаа.

Тэгэхээр бид бас энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үүнийг хийх боломж хууль нь 07 сарын 01-нээс хэрэгжээд эхэлнэ.

Тэгэхээр энэ дээр Баянзүрх дүүргийн эмнэлэг гэдэг зүйл ороогүй байгаа юм. Хамгийн их хүн амтай. 400 гаруй мянган хүн амтай. Тэгсэн хэр нь ээ нэг эмнэлгийг нь хувьчлаад авчихсан. Тэр нь иргэдийг очихоор байнга мөнгө нэхдэг. Тэгээд тусламж, үйлчилгээ авч чаддаггүй, хэвтүүлдэг ор байхгүй ийм байгаа.

Тэгэхээр үүнийг нөгөө түншлэлийн юун дээрээ оруулж өгөөч ээ. Тогтоолдоо оруулж өгөөч ээ гэдгийг хүсэх гэсэн юм.

Хоёр дахь зүйл бол, бид нийгмийн эрүүл мэндийн чиглэлд нэлээн том бодлогууд явуулах ёстой. Тухайлах юм бол энэ халдварт өвчинтэй яаж тэмцэх юм.

Өнөөдөр сүрьеэгүй дэлхий болно гээд 2030 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зарлачхаад байгаа. Жишээлбэл, хамгийн их хүн амтай Энэтхэг Улс гэхэд 2025 он гэхэд сүрьеэгүй болно гэж байгаа юм.

Энд бол яах вэ, сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх гээд орсон байгаа боловч яг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийг дэмжих нийгмийн эрүүл мэндийн том төслүүдээ энд оруулж өгөхгүй юм уу?

Дээрээс нь бэлгийн замын халдварт өвчнүүд байна. Сүүлд гарч байгаа халдварт өвчнүүд байна.

Эдгээртэй ер нь хэрхэн тэмцэх талаар нийгмийн эрүүл мэндийн чиглэлд ямар бодлого орох вэ? Энэ дээр хариулт авъя.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Ер нь эмнэлгүүдийг эрүүл мэндийн салбараа бид ер нь яаж авч явах вэ гэдэг л ийм асуудал байгаа юм.

Ер нь бүх салбар дээр бид бодлогоо эхлээд ер нь нэлээд зөв болгож явах ийм шаардлагатай байгаа.

Тэгээд одоо яг энэ дээр та бүгд маш сайн харах юм бол эрүүл мэндийн эмнэлгийн асуудлууд хүндрэлтэй, бараг хүндрэлгүй аймаг гэж ер нь байхгүй. Бүх л газар хүндрэлүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр бид яг үнэндээ бол одоо юу гэдэг юм хөгжлийнхөө хөтөлбөрт тойрог, тойрог болгоноор нь эмнэлгийг нь заагаад явбал урд өмнөх нөгөө бодлогын баримт бичгүүд шиг ингээд баахан урт жагсаалт. Тэгээд дараа нь энэ нь хэрэгжиж өгдөггүй ийм л зүйл болчих байгаа юм.

Тийм учраас ерөнхийдөө эрүүл мэндийнхээ салбарын санхүүжилтийн тогтолцоогоо ойлгомжтой болгох, яг тулгамдаад байгаа асуудлуудаа шийдвэрлээд явчих юм бол дараа нь олон олон асуудлуудыг шийдвэрлэх боломж нь бүрдчих болов уу гэсэн ийм бодол байна.

Тэр сүрьеэ эд нартай холбоотой зүйлийг хэн хариулах вэ? Манай С.Чинзориг сайд нэмээд хариулчих.

Г.Занданшатар: Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулъя.

С.Чинзориг: Жилийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбартай холбоотой хэд хэдэн асуудал оруулж байгаа.

Ж.Чинбүрэн гишүүний яриад байгаа тэр Баянзүрх дүүргийн эмнэлэгтэй холбоотой асуудлыг би маш сайн ойлгож байгаа.

Өмнө нь Ерөнхий сайд очоод бас ярьж байсан асуудлууд гээд байгаа. Гэхдээ бидэнд эрүүл мэндийн салбарт эхний ээлжинд оруулах хөрөнгө оруулалтыг нь тэргүүлэх чиглэлийг гээд тодорхойлоод үзэхээр яах аргагүй энэ хавдрын эмнэлгийг барих асуудлыг шийдэх, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг шийдэх зайлшгүй шаардлага байгаа юм.

Тийм учраас бид эрэмбэлээд ямар ч байсан 2024 жилийн төлөвлөгөөн дээр эрүүл мэндийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтуудаа эхний ээлжид энэ хавдрын эмнэлэг барих асуудлыг.

Хоёрдугаарт нь, энэ эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгыг оруулъя гэдэг ийм санал Засгийн газар дээр яригдаад орсон байгаа.

Хоёрдугаарт, би тантай санал нэг байна.

Ер нь бид сүүлийн жилүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ дээрээ хэт их анхаарал тавиад, нийгмийн эрүүл мэндийн асуудал, анхан шатын тусламж, үйлчилгээний асуудлыг нэлээн орхид орхигдуулчихсан юм байна гэж үзэж байгаа. Би эртгээд чуулган дээр гишүүдийн асуултад хариулахдаа хэлж байсан.

Ер нь бусад орнуудын туршлага, жишгээр үзэхэд нийгмийн эрүүл мэнд,

анхан шатын тусламж, үйлчилгээндээ хөрөнгө санхүүгийнхээ 50-иас 80 хувийг хуваарилдаг.

Манай улс үүний уруу яваад байгаа юм билээ. Нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатын тусламж, үйлчилгээ дээрээ хөрөнгө, санхүүгийнхээ 19.5 хувийг л хуваарилж байна.

Тийм учраас бид нийгмийн эрүүл мэндийн асуудал, анхан шатын тусламж, үйлчилгээ дээр нэлээн өөрчлөлт, ахиц гаргах ёстой гэж.

Энэ хүрээндээ яах вэ, жилийн ажлын төлөвлөгөөнд оруулаагүй юм. Хууль эрх зүйн орчинг нь бүрдүүлэх дээр бид анхаарч байгаа.

Одоо удахгүй яамдаас санал аваад дуусаж байгаа. Ирэх долоо хоногт Засгийн газрын хуралдаанд оруулахаар бид итгэж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай гэсэн салбарын суурь хууль, ийм анхдагч хуультай болохыг зорьж байна.

Хоёр дахь асуудал, энэ гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой юман дээр ч гэсэн бид бас цаашдаа жоохон боловсронгуй болгож, өөрчлөлтүүд хийх асуудлууд байна.

Ялангуяа халдварт өвчний тандалт судалгаа, шинжилгээ, илрүүлэлттэй холбоотой асуудлыг бид шууд улсын төсвөөс санхүүжүүлэх зарчмаар явахгүй бол одоогийн явж байгаа энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн арга гэдгээр энэ халдварт өвчинтэй тэмцэх асуудал бас тийм оновчтой болохгүй.

Ялангуяа манай Халдварт өвчин судлалын төвд тэр хэвтэн эмчлүүлэх нь

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээ аваад явдаг.

Яг тэр тандалт судалгаа, илрүүлэлттэй холбоотой асуудал нь улсын төсвөөс шууд санхүүжилт аваад явдаг ийм бас санхүүжилтийн арга тогтолцоондоо өөрчлөлт хийхийг бид зорьж байгаа.

Сүрьеэгийн илрүүлэг, халдварт бус өвчний илрүүлэгтэй холбоотой асуудал дээр би тантай санал нэг байна.

Ер нь сүүлийн хоёр, гурван жил бид КОВИД-той нэлээн ач холбогдол өгөөд. Бусад халдварт өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ нэлээн орхигдсон юм билээ. Одоо ингээд сүрьеэгийн нөхцөл байдлыг аваад үзэхээр сүрьеэгийн илрүүлэг 2012 оныхоо түвшинд очтолоо уначихсан байна гэсэн ийм судалгаа гараад байгаа. Сүрьеэгийн илрүүлэг.

Тийм учраас сүрьеэ болоод бусад ялангуяа энэ бэлгийн замын халдварт өвчний илрүүлэг, эмчилгээн дээр бид нэлээн өөрчлөлт оруулах, ялангуяа санхүүжилтээр дэмжих ийм бодлогууд, өөрчлөлт хийнэ гэж бодож байгаа.

Тэгээд амжвал бид Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хаврын чуулганаар оруулах чиглэлээр ажиллаж байна.

Дээр нь шинэ технологи нутагшуулахтай холбоотой асуудлыг бид яаралтай шийдэх хэрэгтэй байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулаад удахгүй Засгийн газарт оруулна.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя. 1 минут.

Ж.Чинбүрэн: Би Ч.Хүрэлбаатар Шадар сайдад бас юу хэлье гэж бодож байна. Та бол эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог хийхэд бас Сангийн сайд байхдаа чухал үүрэг гүйцэтгэсэн.

Тэгэхээр энд хамгийн чухал зүйл бол гүйцэтгэлийн санхүүжилтийг зөв, өртгийг нь зөв тооцож нэмэх нь өөрөө чухал юм.

Тийм учраас Эрүүл мэндийн даатгалын санг нэмэх нь манай энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг илүү худалдаж авах. Түүнээс Эрүүл мэндийн яам, Засгийн газар нэг байшин сав барьж өгөх нь чухал биш ээ.

Гэхдээ үнэхээр эрхтэн шилжүүлэн суулгах, хорт хавдрын төв энэ тэр бол энэ бол улсын хөрөнгө оруулалтаар хийхгүй л бол зөвхөн өөрсдийн гүйцэтгэлээр хийх тийм боломж байхгүй. Асар их өртөг зардалтай.

Тийм учраас энэ бодлого бол болж байна.

Харин Баянзүрх дүүргийн эмнэлэг барих асуудал дээр төр, хувийн түншлэлийн хүрээнд үүнийг хийчих бүрэн боломжтой.

Тийм учраас санхүүжилтийг нь шийдэхэд энэ тогтоолд оруулж өгнө үү гэж би бүр тусгайлан хүсэж байна.

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг. Ялангуяа сая С.Чинзориг сайд хэллээ. Сүрьеэтэй холбоотой асуудлаар Монгол Улс хамгийн их.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Ер нь яам хоорондын уялдаа холбооны асуудал өнөөдрийн үүсэж байгаа бүх юмны зангилаа нь гэж би хараад байгаа юм.

Ер нь ямар ч уялдаа холбоогүй байгаад байна л даа. Одоо бид иргэдтэйгээ ер нь байнга уулзаж байна. Очоод уулзахад хамгийн их хөндөж байгаа асуудал эрүүл мэндэд, эм, тарианд зарцуулж байгаа мөнгө, мах, гурилд зарцуулж байгаа мөнгө өрхийн орлогыг бараг үнэхээр хамгийг нь хамж явж байна.

Одоо үнэхээр ядуурал дээд түвшинд хүргэж байна гээд яриад байгаа. Энэ бодит үнэн байгаад байгаа юм.

Гэтэл одоо энэ дахиад л санхүүжилтийг нэмэх тухай яриад байдаг. Үнэнийг хэлэхэд эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт гэдгээр анхан шатанд ч, хавдрын эмнэлэг дээр ч гээд бид уг нь нэмж өгөөд байдаг. Бүр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг нь 1.4 их наяд болгосон.

Гэтэл өнөөдөр эзэндээ очоогүй. Нөгөө эмийн хөнгөлөлт гэсэн чинь эмийн сангаараа дамжуулаад иргэдэд очдог хөнгөлөлтүүд нь Эрүүл мэндийн даатгалын сангаасаа очихгүй байна гээд энэ мөнгө буруу замаар яваад байна.

Тэгэхээр С.Чинзориг сайд аа, бид ирэх оны хөгжлийн төлөвлөгөө хийж байна. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль гэсэн. Одоо хүртэл орж ирээгүй.

Энэ нь уг нь бид нөгөө эмийн агентлаг байгуулаад энэ эмийн чанар

үнээ хянаад ард түмэндээ чанартай эмээр, хямд төсөр үнээр үйлчилнэ гэсэн энэ ажил унтчихаад байна.

Тэгэхээр үүнийг яаж энэ төлөвлөгөөнд тусгаж зохицуулж оруулж ирэх вэ? Нэгдүгээрт үүнийг асууя гэж бодож байна.

Хоёрт нь, Шадар сайд аа, одоо яг хүн бүхэн бид энгийн амьдрал руугаа орчихлоо. Ажлын байрыг нэмэгдүүлэх. Аль болохоор хүмүүсийг ажлын байраар хангах асуудал чухал байна.

Гэтэл хөдөл хөдөлмөрийн зах зээл унтчихсан байна. Х.Булгантуяа сайд аа. Яаж энэ хөдөлмөрийн зах зээлийг идэвхтэй болгож, энэ унтамхай байдлаас гаргах вэ гэдэг өөрөө маш чухал.

Тэгээд энэ 2024 оны төлөвлөгөөний нэг гол зүйл нь хүний хөгжлийн асуудал гээд нэгд тавьчихсан байгаа. Гэхдээ бид газрын тосны үйлдвэрээ, эрчим хүчээ, агаар түгжрэлээ шийднэ гэж байгаа.

Энд асар их мөнгө явна. Гэхдээ яаж энэ өрхийн орлогыг нэмэгдүүлэх вэ? Үнэ ханш ийм өндөр. Тэгээд инфляц ийм байгаа үед өнөөдөр бараг 12 хувьтай 11.6 байж байна.

Эдийн засгийн өсөлтийг багаар тооцож орж ирсэн байна л даа. Одоо жишээлбэл, 8.1 гэж байхад 2024 оныхыг 6.5 хувьтай гээд бас аягүй их болгоомжилж оруулж ирсэн байна л даа.

Тэгэхээр бид бодитоор тооцож оруулж ирэхгүй бол болохгүй. Яаж, хэчнээн байраар ажлын байрыг нэмэгдүүлж. Эндээс өрхийн орлогыг тэдэн хувиар нэмэх бололцоо харагдаж байна гэсэн тооцоо судалгаа яг бодитоор

хийсэн байгаа юу? Тэгээд эндээ энэ дээр нэг хариулт авъя гэж бодож байна.

Гуравт нь, Эдийн засаг, хөгжлийн сайд яамаараа дамжуулж ер нь хяналт тавихгүй бол. Одоо жишээ нь, Ц.Даваасүрэн сайдаар ахлуулаад гэр хорооллын дэд бүтцийн асуудал, гэр хорооллыг төлөвлөх асуудлыг хийнэ гээд Барилга, хот байгуулалтын сайдаар ахлуулсан Үндэсний хороо билүү, ажлын хэсэг сая гарсан гээд Ерөнхий сайд гэр хороололд ажиллахдаа зарласан.

Энд орж ирэхэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээр байна л даа 6.2.2.2, 6.2.2.3 гээд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн гуравдугаар үе шатыг хэрэгжүүлнэ гээд.

Гэтэл хоёрдугаар үе шат нь өөрөө бас хэрэгжээгүй. Сая 2020 оноос хойш нөгөө КОВИД, цар тахал гээд энэ бүр зогсчихсон. Энэ гэр хорооллын дахин төлөвлөлт, энэ дэд бүтэцжүүлэх ажлыг шийдэхгүйгээр бид өнөөдөр хавдрын тухай яриад ч хэрэггүй байгаа шүү дээ.

Яагаад гэвэл хөрс, ундны усаар дамжиж эрүүл мэндэд асар их хохирол учруулж байна. Үүнийг дамжаад хүмүүст нөгөө яриад байгаа хавдар чинь үүнээс үүдэлтэй байгаад байдаг.

Гэтэл хавдар үүссэнийх нь дараа хэдэн тэрбумаар нь бид мөнгө зарцуулаад үр дүн байхгүй. Бид сүүлийн 20 жилийн судалгааг авахад хавдрын өвчлөл буураагүй. Харин ч илүү нэмэгдээд дэлхийн хэмжээнд эхний 3-д хүртэл ороод яваад байна л даа.

Тэгэхээр бид маш зөв санхүүжилт, тэр учир шалтгааныг нь сайн олж байж тэгээд зохион байгуулалтыг сайн хийхгүй бол болохгүй байгаад байна.

Тэгэхээр одоо үүнийг зорилтот түвшин 2024 онд 80 хувь гэж байгаа. Энэ гэр хорооллын Улаанбаатар хотын хөгжүүлэх. Энэ чинь өөрөө хөрсний бохирдлоос салах асуудал.

Тэгээд сая Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд хүртэл энэ хөрсний бохирдлын асуудал гарч ирж байна шүү дээ. Бүх өвчлөлийн, бүх зүйлийн шалтгаан нь хөрсний бохирдол болж байгаа.

Тэгээд үүнийг жишээ нь Барилга, хот байгуулалтын яам нь юм уу, эсвэл энэ дээр нийслэл гэгчихсэн байна л даа. Тэгээд хариулт хэлье.

Г.Занданшатар: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

Ч.Хүрэлбаатар: Тэргүүн гэсэн үг бол байхгүй ээ гэдгийг хэлчихье.

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Ер нь л бид ажлын байрыг хар. Хувийн хэвшлийг л дэмжиж байж, эдийн засгийг тэлж байж л бид бий болгоно.

Одоо энэ 2022 онд Монгол Улсын эдийн засаг 4.8 хувиар өссөн. Одоо та бүгд дотроо бодоод үзээрэй. 4.8 хувиар өсөхөд шинээр 32 мянга 300 ажлын байр бий болсон байгаа. 32 мянга 300 ажлын байр.

Бид 2023 онд одоо ингээд аваад хараад үзэж байхад ажлын байрны захиалга гээд 50 мянга орчим ирж байгаа.

Тэгэхээр 2024 ондоо шинээр бий болгох ажлын байр 60 орчим мянга ч юм уу гэж одоогоор тооцож явж байгаа.

Тэгэхээр үүнтэй нь нийцсэн бас бид энэ сургалтын хөтөлбөрүүдийг бид хэрэгжүүлэх ёстой юм байгаа юм.

Одоо ингээд их дээд сургууль дээрээ анхаардаг. Яг үндсэндээ тэр мэргэжлийн ур чадвартай сургалтын тэр механизм маань ерөөсөө нэг их анхаарал тавигдаж явж ирээгүй учраас та бүгдийн жилийн төлөвлөгөөг аваад үзээрэй.

КООСЭН[Коото сэнмон гакко, технологийн коллеж] Гээд яг боловсон хүчин бэлддэг ийм тогтолцоо руу нэлээд их хэмжээний төсвийн мөнгө зарцуулъя. Энэ дээрээ гол анхаарлаа тавья гэдэг ийм санал, санаачилга гараад явж байгаа шүү гэдгийг би хэлье.

Дараагийн зүйл, тэр гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой зүйлүүдийг холбогдох яамных нь хүмүүс байгаа байх. Тэд нар нь хариулаад явчих байх.

Ерөнхийдөө гэр хорооллын дахин төлөвлөлт, гэр хороолол дээр дэд бүтцийн юунууд хэрэгжүүлсэн шүү дээ. Тэр л их зөв тогтолцоо юм болов уу л гэж би дотроо бодож байгаа.

Тэгээд амжилттай явж байгаа зүйлүүдийгээ тэлээд, туршилт маягтай ч юм уу, амжилтгүй ч юм уу, газар чөлөөлөлт нь болж өгдөг ч үгүй ч юм уу тиймэрхүү зүйлүүдээ төр хараад түдгэлзүүлээд явахаас өөр аргагүй болов уу л гэж би дотроо бодож байгаа.

Эмийн нийлүүлэлт, эмийн худалдан авалтыг сайжруулах чиглэлээр бүр онцгойлон анхаарч ажиллахгүй бол энэ өндөр үнэтэй, үйлчилдэг ч юм уу, үйлчилдэггүй ч юм уу эм хэрэглээд байдаг тогтолцоог бид шууд халаад явах ёстой.

Тэгэхээр энэ чиглэлээр С.Чинзориг сайд дээр яригдаад явж байгаа зүйлүүд байгаа гэдгийг хэлье.

Яг тэр агуулгаараа энэ дотроо суучихсан байгаа эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулах гэдэг зүйлийг энэ дотроо оруулаад өгчихсөн байгаа гэдгийг хэлье.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг тодруулж хариулъя. Нэмж хариулъя.

С.Чинзориг: Эмийн чанар, үнэтэй холбоотой асуудал үнэхээр иргэдийн дунд асуудал байгаа.

Ер нь бид 30 жил стратегийн бүтээгдэхүүнийг төрийн оролцоо хяналтгүйгээр, дээр нь төрийн туслалцаа, дэмжлэггүйгээр хувийн хэвшлийн нуруун дээр даатгаад орхиод явсан нь үнэхээр дутагдалтай буруу бодлого байна гэж бодож байгаа.

Би саяхан Шадар сайдтай хамтарсан ажлын хэсэг гаргаад Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, манай яам, Эмийн хяналт, зохицуулалтын агентлаг хамтарсан ажлын хэсэг гаргаад эм ханган нийлүүлэлтийн байгууллагууд, эмийн сангууд дээр шалгалт явуулсан.

Шалгалтын дүн урьдчилсан байдлаар сонссон.

Нэгдүгээрт, импортоор оруулж ирж байгаа эм, бөөний үнэ, жижиглэнгийн эмийн сангаар борлуулагдаад иргэдийн гар дээр очихдоо хоёр дахин үнийн өсөлттэй байна гэсэн судалгаа гарсан байна лээ.

Гэхдээ нь нөгөө КОВИД-ын үеийн хил, гааль хаалттай байсантай холбоотой, валютын ханшны өсөлттэй холбоотой, тээврийн зардалтай холбоотой асуудал байсныг үгүйсгэхгүй.

Цаашдаа эмийн үнэ хоёр дахин өсдөг тогтолцоог өөрчлөхөөс өөр үг байхгүй гэж бодож байна.

Би Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах хуульд зарчмын зөрүүтэй хэдэн санал оруулж байгаа. Гишүүд эхнээсээ дэмжсэн.

Ер нь эмийн худалдан авалт дээр хэмнэлттэй байх, бага үнийн санал эмийн худалдан авалт дээр үйлчлэхгүй байхаар тэр хуульд оруулж өгсөн. Эмийн худалдан авалт дээр чанар ба үнийн хосолмол шалгуураар эмийн худалдан авалтыг явуулдаг байх гэсэн зарчим оруулж байгаа. Энэ нэлээн том өөрчлөлт орох байх.

Хоёрдугаарт, үйлдвэрлэгч гадаадын өндөр чанартай, стандартад нийцсэн эм үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчээс нь болон олон улсын байгууллагуудаас шууд эмийг худалдан авдаг байх тогтолцоонд орохоор тэр хууль нь зарчмын зөрүүтэй санал гаргаад Төсвийн байнгын хороо дэмжчихсэн байгаа.

Үүнийг анхны хэлэлцүүлэг дээр нь гишүүд дэмжээд өгөх юм бол эмийн чанар үнэтэй холбоотой асуудал нэлээн өөрчлөлт гарах болов уу гэж бодож байна.

Бид эмийнхээ хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа. Удахгүй Засгийн газарт оруулна.

Одоо эмийг малын эм, хүний эмийг нэг хуулиар зохицуулж байгааг тусад нь хуулиар зохицуулдаг болгоё.

Тэгээд ер нь цаашдаа нэгдсэн худалдан авалтын тогтолцоо руу шилжье гэсэн зарчмаар асуудалд хандаж байгаа.

Манай дээр хүндрэлтэй юм нь эмийн чанарт хяналт, баталгаажуулалт хийдэг лабораторийн хүчин чадлыг, боловсон хүчнийх нь нөөц чадавхыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Энэ дээр тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байгаа.

Саяын хамтарсан шалгалтаар үзэхэд эм ханган нийлүүлэлтийн байгууллагууд гаднаас импортоор авч байгаа эмийн 85 хувийг нь 10-хан компани нийлүүлж байгаа. Тийм өрсөлдөөн байхгүй байна гэсэн нөхцөл байдал харагдаж байгаа.

Хоёрдугаарт, бас нэг дутагдалтай асуудал. Энэ эм ханган нийлүүлэлтийн тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдөө маш олон тооны эмийн сан ажиллуулж өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаануудад явуулж байгаа асуудал гарсан.

Тийм учраас өрсөлдөөнийг хязгаарласан байдлыг нэлээн өөрчлөх. Аль болохоор үйлдвэрлэгчээс нь болоод олон улсын байгууллагуудаас шууд худалдан авдаг байх тогтолцоо руу нь.

Манайд НҮБ-ын хүүхдийн сан гэхэд дэлхийн 138 оронд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлдэг томоохон бэлээхэн худалдан авалтын систем байна. Үүнийг ашиглаад бид шууд худалдан авалтаа хийдэг.

Ялангуяа төрийн эрүүл мэндийн байгууллагууд, Эрүүл мэндийн

даатгалын сангаас иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг төр өөрөө хүүхдийн сангийн худалдан авалтын системийг ашиглаж шууд худалдан авалт хийдэг байх тогтолцоо, систем рүү оръё гэж хуульд өөрчлөлт оруулаад явж байгаа юм.

Ингэж чадах юм бол бид эмийн үнэ, чанартай холбоотой асуудал дээр маш том эргэлт хийх байх.

Хоёрдугаарт, дараагийн нэг асуудал нь. Иргэдийн зохистой эмийн хэрэглээг төлөвшүүлэх.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя. 1 минут.

М.Оюунчимэг: С.Чинзориг сайд аа, одоо бүгдээрээ хамтраад л эмийн чанар, үнэ дээр үнэхээр хувьсгал хийхгүй бол энэ бодлого алдагдаад цөөн хэдэн хүний ашиг, бизнес болоод байгаа гэдгийг үнэхээр анхаарах хэрэгтэй байгаа шүү.

Хоёрт нь, энд хотын орлогч Ж.Сандагсүрэн дарга сууж байна.

Шадар сайд хэлээд байгаа нь Барилга, хот байгуулалт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хоёрын хооронд Улаанбаатар хотын гэр хорооллын төлөвлөлт, хөрөнгө оруулалттай холбоотой, санхүүжилттэй холбоотой асуудлууд гацчихаад байгаа юм.

Нийслэлд ярихад манай дээр ямар ч юм суугаагүй. Барилга, хот байгуулалтын яам болохоор яг энэ дэд бүтэцжүүлэх. Сая Ч.Хүрэлбаатар сайдын хэлж байгаа тэр дэд төвүүд. Үүний бодит жишээ Чингэлтэй дүүргийн 7 дугаар

хороонд бид 230 айлын дунд хэрэгжээд үнэхээр сайн явж байгаа.

Бусад дэд төвүүд зогсчихсон. Сэлбэ өнөөдөр явахгүй байгаад байна. Гэтэл хүлээж авахад бэлэн гэж байгаа юм.

Дэнжийн мянгын дэд төв байна. Энэ хөрсний бохирдол чинь өөрөө хотын төвийн хүмүүсээсээ эхлээд бүх хүнийг хатуу металл маш их байдаг учраас бүх өвчний үндэс болж байна гэж яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг уялдаа холбоог нь яах вэ? 2024 онд жишээ нь нийслэл үүнийгээ хариуцаад явах юм уу?

Л.Мөнхбаатар: М.Оюунчимэг гишүүний тодруулгад хариулья. Хэн хариулах вэ?

Нийслэлийнхэн хариулья. Микрофон дээр очъё. Ажлын хэсгийн 95 дугаар микрофон өгъе.

Албан тушаал, нэрээ хэлээд асуулгад хариулаарай.

Ж.Сандагсүрэн: М.Оюунчимэг гишүүний асуулгад хариулья.

Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн байна.

Нийслэл болон Барилга, хот байгуулалтын яаман дээр бид хамтарсан төлөвлөгөө боловсруулсан.

Хамтарсан төлөвлөгөө боловсруулсан. Нийт Улаанбаатар хотод байгаа 230 гаруй мянган гэр хорооллыг яаж орон сууцжуулах болон бусад эх үүсвэрийг шийдэх вэ гэдэг дээр бид нэгдсэн төлөвлөгөө гаргасан.

Энэ хүрээнд бид нарт мэдээж хязгаарлагч хүчин зүйлүүд байгаа нь нөгөө эрчим хүчний хязгаарлагч хүчин зүйлүүд нэлээн хүчтэй энд нөлөөлж байгаа.

2024 оны төлөвлөгөөнд сая М.Оюунчимэг гишүүн өөрөө дурдлаа. Сэлбэ дэх станц байгаа. Түүн дээр нэмэх нь Дэнжийн мянга болон Дамбадаржаа дахь бие даасан эх үүсвэрүүдийг бид төлөвлөж байна.

Энэ нь гэр хорооллыг инженерийн дэд бүтцийг дэмжих төслийн 2 болон 3.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг гүйцэтгээд хариулчихъя. Ж.Сандагсүрэн дарга.

Ж.Сандагсүрэн: Баярлалаа.

Тэгэхээр ирэх жилүүдэд Толгойт болон Сэлбэ, Баянхошуу дууссан. Үүний дараа Дамбадаржаа гэсэн дэд төвүүд хэрэгжиж байна.

Үүний дүнд 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцэд холбоно гэсэн төлөвлөгөө улсын төлөвлөгөөнд орсон байна.

Энэ бол шууд орон сууцжуулна гэхээсээ илүү дэд бүтцэд холбогдох боломжоор 55 мянган өрхийг холбох төлөвлөгөө байна.

Үүнээс гадна орон сууцжуулах бодлогууд мэдээж төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Улаанбаатар хотод тусдаа хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа юм. Энэ хүрээнд асуудлуудаа шийдэж ингэж явна.

Яг тэр дулааны эрч. Хэдийгээр одоогоор эрчим хүчний хязгаарлагдсан

зүйлүүд байгаа ч гэсэн бид бие даасан эх үүсвэрүүдийг ирэх жилүүдэд 2-ыг жишээлбэл ашиглалтад оруулаад тэгээд түүгээрээ инженерийн шугам сүлжээг бий болгох төлөвлөгөө ирэх 2024 оны төлөвлөгөөнд орсон байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одоо Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Монгол Улсыг ирэх жилүүдэд хэрхэн хөгжүүлэх тухай хөгжлийн төлөвлөгөөний тухай ярьж байна л даа.

Тэгэхээр үүнийг ярихын тулд ер нь өнгөрсөн арван жилд юу болсон юм бэ гэдгийг зарим тоонуудыг эргэж санавал.

2013 онд Монгол Улсын төсөв 4.5 их наяд байж. Өнөөдөр 20 гарчихлаа.

Сүүлийн 10 жилд Монгол Улсын төсөв 5 дахин өсөж. Монгол Улсын нийт эдийн засгийн хэмжээ багахан хэмжээгээр өссөн. Харин энэ үед ядуурал гэдэг зүйл арван жилийн өмнө гурван хүний нэг нь ядуу гэж байж. Өнөөдөр бараг тэрнээсээ ихэсчихлээ.

Тэгэхээр хөгжлийн төлөвлөгөө, хөгжлийн бодлого ярьж байгаа үед үүний цаана юу харагдаад байна. Төсөв нь арван жилд 5 дахин томорчихдог. Ядуурал нь улам нэмэгдэж байдаг.

Эдийн засаг нь тодорхой хэмжээгээр томорч байгаа.

Тэгэхээр ямар бодлогын алдаанууд үүний цаана гарчхаад байна вэ? Төсөв 5 дахин нэмэгдсэн байхад ядуурал нь 5 хувь ч буурдаггүй.

Тэгэхээр энд ямар бодлогын алдаа болоод, ирээдүйд яаж засагдах юм? Бид

мянга хөгжлөө, дэвшлээ, хөгжлийн төлөвлөгөө олон зүйл яриад нийгмийн нэг хэсэг нь ядуу гэдэг ангилал нь улам буурахгүй. Магадгүй дээр тодорхой сүүлийн үеийн тоо баримтууд хэд байдгийг мэдэхгүй. Зарим тоо баримтаар арван жилийн өмнө гурван хүний нэг ядуу байсан бол одоо хоёр хүний нэг ядуу болчихлоо гэдэг албан бус тоо баримт ч их ашигладаг.

Тэгэхээр энд ямар бодлогын алдаа гарчхаад байна вэ? Үүнийг засахгүйгээр мянга тэнд гоё гоё зүйл яриад иргэд нь ядуу, ядуурал нь ихсээд байдаг. Тэр нь хүн амынх нь асар өндөр хувь руу оччихсон үед гоё гоё хөгжлийн төлөвлөгөө хийнэ. Олон зүйл үнэхээр амьдралаас хол тасархай зүйл болж хувирна л даа.

Тэгэхээр энэ дээр хөгжлийн бодлого төлөвлөгөө олон зүйл дээр яг асуудлуудыг яаж зассан юм. Магадгүй үүний цаана орлогын ялгаа. Орлогын ялгааг дагаад олон зүйлүүд амьдралын ирээдүйн боломжийн ялгаанууд, олон зүйлүүд үүний цаана агуулагдаж байгаа байх.

Тэгэхээр яг хүрээнд хөгжлийн төлөвлөгөөн дээр бодлого чиглэлийнхээ хувьд, зарчмын хувьд ямар зүйл тусгагдаж байгаа вэ? Энэ алдааг хэрхэн яаж засах ёстой вэ? Цаашид гэдэг дээр нэг хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Ядуурлын тоо хэмжээ байгаа юм.

2007, 2008 он гэж байхад Монгол Улсын ядуурлын хэмжээ 33 хувьтай

тэнцүү байна. Гурван хүний нэг нь ядуу байна гэдэг зүйл яригдаж байсан.

2019 оны нөхцөл байдлаар хийсэн тоо, судалгааны дүн 2020 онд гарсан.

Ядуурлын хэмжээг би буруу санаагүй бол 26 хувь гэж байсан юм. 26 хувь хүртлээ буусан. Яах вэ тэр үед нэлээд ажлууд хийгдээд.

Тэгээд яг үндсэндээ КОВИД-ын 3 жил хил хаалттай үед эргээд өсчихсөн. Зөвхөн 2022 оны дүнг аваад үзэхэд Монгол Улсын хувьд нийт өрхийн бодит орлого 0.7 хувиар буурсан байгаа. Энэ дотроо хөдөөгийн өрхүүдийн орлого бодитойгоор 16 хувиар уначихсан байгаа.

Гэтэл бид орлогыг 10 хувь өсгөхөд нэлээдгүй хугацаа зарцуулдаг. Тэгээд тэр КОВИД-ын бодлогуудын үргэлжлэлийн эцэс дээр 16 хувиар уначихсан байж байх жишээтэй. Яах вэ, одоо зүгээр энэ 2023 оны эхний улирлын тоог харахад уналт нь багасаад 4, 5 хувь руу ороод ирчихсэн харагдаж байна.

Гэхдээ л өмнөх жилтэй нь харьцуулаад үзвэл унасан байж байгаа.

Тийм учраас нэг ийм нөхцөл байдал болоод байгаа юм. Энэ дээр би учиргүй бодлогын том алдаануудаасаа илүүтэйгээр КОВИД-ын нөхцөл байдал, 3 жилийн хугацаанд хил хаалттай байсантай голдуу холбоотой.

Тэгээд энэ хооронд хүүхдийн мөнгийг 5 дахин нэмэгдүүлээд л, 20 байсныг 100 болгож өгөөд л, цахилгааныг нь тэглээд л, одоо юу гэдэг юм, нийгмийг даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварыг нь тэглээд л байсан хэр нь л ингээд л доошоо яваад байгаа юм.

Тэгэхээр үнэхээр энэ КОВИД-ын үед хил хаалттай. Хилээ хааж боож байж байж улс орон хэзээ ч хөгжихгүй.

Тэгэхээр нээлттэй бодлогыг сайн явуулж, хувийн хэвшлийг дэмжиж, ер нь хувийн хэвшлийнхэнд учруулдаг дарамтыг л багасгаж байж улс орон хөгжинө гэдэг нь ойлгомжтой юм гэж харагдаж байгаа.

Би тэгэхээр энэ дээр О.Цогтгэрэл гишүүний хувьд яг том бодлогын алдаануудаасаа илүүтэйгээр энэ КОВИД гэдэг зүйл юм болов уу гэж би бодож байна.

Тэгээд удахгүй дэлхий нийтээр КОВИД-ыг яг дэлхийн нийт улс орнуудад ямар нөлөө үзүүлэв ээ гэдэг судалгаа хийгдэж байгаа юм байна лээ. Үүнтэй холбоотой Монголын талаар дүгнэлтүүд гараад ирэх үед бид олон улсын эрдэмтэн, судлаачдын дүгнэлтүүд гараад ирэх байх гэж бодож байгаа.

Бодлогын хувьд алдаатай зүйлүүд байгаа гэвэл байгаа байгаа. Зөндөө алдаа бий. Жишээлбэл, хил рүүгээ экспортын бүтээгдэхүүний төмөр зам барих ёстой байтал тэс хөндлөн тавьчихдаг.

Монгол Улс чинь өөрөө баян биш. Санхүүгийн эх үүсвэр нь хангалттай биш. Тэр үед аваачаад ингээд хаашаа ч хамаагүй төмөр зам тавьчихдаг. Яг нөгөө зах зээл рүүгээ гардаг мөнгө олдог төмөр замаа барихгүй байх ийм бодлогын алдаа байж байх жишээтэй.

Эсвэл дэлхий нийтээр инфляц яваад эхлэхэд яаралтай мөнгөний бодлогынхоо хүүгээ нэмэх ёстой байсаар байтал Монголд инфляц өөрийн гэсэн онцлогтой гээд яг цаг тухайд нэмдэггүй. Өнгөрөөчхөөд бүтэн бараг 7, 8 сарын дараа тийм юм шиг байна гээд нэмж

эхэлдэг гэх мэт алдаанууд байгаа юу гэвэл байгаа.

Дандаа төгс төгөлдөр явсангүй ээ. Алдаанууд байгаа байгаа.

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

Нөхцөл байдал, бодит байдлыг харахад КОВИД саяхны хоёр, гурван жилийн л явдал. Арван жилийг харахад төсөв 5 дахин өсчхөөд байхад ядуурал нь буурдаггүй. Ядуурал нь арван жилийн дүнгээр өсчхөөд байна гэдэг л өөрөө асар том бодлогын алдаа үүний цаана манайд байгааг л илэрхийлж байна.

Төсөв 5 дахин өсчхөөд байхад, 500 хувь өсчхөөд байгаа шүү дээ. Тэнд, 500 хувь өсчхөөд байхад.

Тэгэхээр дахиад таны хэлж байгаа зөвхөн нэг төмөр зам тавихаар ядуурал буурчихна. Төмөр зам тавиад нүүрс зараад нүүрсний мөнгөө авчраад бид халамжаар өгчихөөр яг ийм л бодлогоор явахаар бид тэр жирийн иргэд чинь ядуурлаасаа гаргахгүй. Тэд нарт эдийн засгийн шинэ боломжууд нээгдэхгүй. Тэд нарыг хэрхэн яаж чадавхжуулах юм. Хэрхэн яаж тэд нар эрх чөлөөг эдэлж, өөрснөө баяжих юм. Тэд нар хэрхэн яаж хувийн хэвшлийн бизнесийн оролцоонд оролцох юм гэдэг энэ бодлого бид нарт өнгөрсөн хугацаанд байхгүй. Зөвхөн уул уурхай нүүрс зарна.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад нэмж хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Тийм ээ тийм. Бодлогын алдаанууд байгаа байгаа.

Дээр нь энд тэндээс хулгай хийдгээ л больчих хэрэгтэй. Нүүрснээс

хулгай хийнэ. Хөгжлийн банкнаас элдэв нэрээр зээл шаацгаана. Эрх мэдэл, албан тушаалаа ашиглана.

Иймэрхүү юмнуудаа л болих хэрэгтэй. Бид нар.

Түүнээс биш бүгдийг нь юу гэдэг юм төр лүүгээ шидээд, буруутгаад байж болохгүй. Алдаатай зүйлүүд бий.

Нүүрсний хулгайн дээрээс л тодорхой харагдаж байна шүү дээ. Амаргүй л үр дүнд хийсэн шүү дээ. Шийдвэрүүдийг гаргахад амаргүй л байсан шүү дээ. Хүний өөрийнгүй боорлоцгоогоод л. Боорлосон нь одоо ч гэсэн үргэлжлээд л явж л байна.

Гэхдээ иймэрхүү зүйлүүдийг засаж байж улс орон хөгжинө шүү.

Л.Мөнхбаатар: Хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж байна. Монгол Улсын Засгийн газрын гишүүн сайдууд танхимд орж ирж гишүүдийн асуултад хариулья.

Одоогийн байдлаар Засгийн газрын 3 гишүүн байна.

Одоо Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

Б.Баттөмөр: Бид нар 2024 оны хөгжлийн төлөвлөгөө ярьж байна.

Энэ төлөвлөгөө 2024 оны төсвийн суурь болж өгнө. Хөгжлийн баримт бичиг.

Энэ төлөвлөгөөг бид хэр зэрэг сайн хийнэ тэр хэмжээгээр төсөв оновчтой болно. Хөгжлийн гараа зөв болно.

Яах вэ, шинэ яамны хувьд янз янзын юм руу ороод үүнийг зөв хийчих гээд нэлээн ажилласныг би хэлье гэж бодож байна. Миний хувьд яамны холбогдох хүмүүстэй холбогдож энэ дээр ажилласан.

Яах вэ, 8 чиглэлд 184 төсөл, арга хэмжээг 13.4 их наяд төгрөгөөр хийх юм байна. Төрөөс гарах мөнгө нь 2.3 их наяд ч юм уу даа. Тийм ээ. 3 их наяд төгрөг юм байна.

Энэ мэдээж зарлага нь 22.9 их наяд төгрөгтэй л холбогдоод хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж байгаа хэлбэр байх л даа.

Ер нь төрөөс хийх хөрөнгө оруулалтууд маш их байгаа шүү. Хувийн хэвшил ашиггүй зүйлд хөрөнгө оруулалт хийхгүй. Нийгмийн сайн сайхны төлөө, нийгмийн тэр паблик сервис гэж хэлдэг тэр нийтийн үйлчилгээнд төр, хувь хөрөнгө оруулалт хийх ёстой гэж.

Зам их барих юм байна. Замаа сайн бодоорой. Тэгээд л давааг тойруулаад л 40 хэдэн тэрбум төгрөгөөр зам тавина л гэнэ. Барилга их барих юм байна. Барилга чинь мэдээж орц нь 100 хувь гадаадаас шүү дээ.

Цемент дотоодоос хангадаг байсан. Гаднаас авдаг болчихсон. Энэ тэрийгээ бодолцох юм байгаа биз дээ. Үүнийгээ ярьж гэж бодож байна.

Би Ч.Хүрэлбаатар сайдаас нэг асуулт байна. Өнгөрсөн 30 жилийн бидний хөгжил ямар байна?

15 тэрбум долларын эдийн засаг. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний 5 мянга гаруйтай доллар сая болж байна.

Гадаад өртөгт 33 тэрбум доллар болчихсон. Ядуурал 27 хувь. Бүтээмж байхгүй. Эдийн засгийн өсөлтийн үр өгөөж алга.

Азийн хөгжлийн банкны репортод “ядуу орон” гэж зарлагдсан.

Ажиллах хүч нь гадагшилсан. Амьдралын доройтлоос гэмт хэргийн өсөлт нэмэгдэж байгаа.

Манай хөгжлийн бодлого, загвар өнөөдөр ер нь ямар байх ёстой юм бэ? Болохгүй байгаад байгаа юмыг болно гээд тэндээс үр дүн хүлээгээд байхыг нөгөө “автобусны буудал дээр онгоц хүлээнэ” гэж үг байдаг шүү дээ.

Энэ бодлого, төлөвлөлт, хөгжлийн загвараа ер нь юу гэж бодож байгаа вэ?

Хувийн хэвшлийг дэмжих нь зүйтэй. Хувийн хэвшилд өнөөдөр Хармагтай, Салхит гээд том том ордуудыг аваад явчих тийм хүч хөрөнгөтэй хувийн хэвшил алга байна.

Төр энэ баялаг дээрээ менежмент хийх юм уу, хийхгүй юм уу? Ер нь цаашдаа хөгжлийн бодлого, хөгжлийн загвар ер нь ямар байх юм бэ? Үүнд хариулт өгөөч ээ гэж нэг дэх асуулт энэ байгаа юм.

Хоёр дахь асуулт, 2024 онд 4 тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирнэ гэж байгаа юм.

Мэдээж уул уурхайн бус салбарт хэд нь орж ирэхээр тооцсон бэ?

Гашуунсухайт, Ганцмодны боомтын 18, 19 километр шилжүүлэн ачих замын 20 хувийг 2024 онд хийнэ гэж байгаа юм. Жил жилд 20 хувиар явах юм бол хэдэн жил үргэлжлэх вэ?

Дараагийн асуулт. Хөрөнгийн зах. Өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүнд, эдийн засагт 13 хувь байгаа. 20 хувь болгоё гэж байгаа юм. Маш зөв. Санал нэг байгаа.

Энэ Засгийн газрын бонд, төгрөгөөр илэрхийлэгдсэн бонд яагаад гаргадаггүй юм бэ?

Ер нь ийм шаардлага байхгүй байгаа юм уу? Үүнийг гаргаад явбал нөгөө өгөөжийн муруй гээд юмнууд байна. Тэгээд хөрөнгийн захыг хөгжүүлэх үр ашигтай баймаар байгаа юм. Үүнийг юу гэж бодож байгаа вэ?

Манай хөдөө аж ахуй, уул уурхайгаас бусад салбарууд бүгд өр үйлдвэрлэж байгаа шүү. Үүнийг эдийн засагжуулах чиглэлд та юу гэж бодож байна аа? Ийм асуултуудад хариулт авья.

Л.Мөнхбаатар: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар.

Ч.Хүрэлбаатар: Монгол Улсын хөгжлийн загвар ямар байх вэ гэдэг асуулт байгаа.

Ер нь манай жилийн төлөвлөгөөн дээр тэр, бусад бодлогын бичиг баримтууд дээр хөгжлийн бодлого тусаад явж байгаа.

Монгол Улс өөрөө хоёр том гүрний дунд оршдог. Далайд гарцгүй улс. Гэхдээ хоёр том зах зээлийн дунд байдаг. Байгалийн баялаг ихтэй. Газар тариалан хүчтэй хөгжих боломжтой. Түүхтэй, соёлтой ард түмэн. Аялал жуулчлалыг бүрэн хөгжүүлэх боломжтой улс.

Тэгэхээр төр нь дэд бүтцийнхээ асуудлуудыг төгс шийдээд, хүчтэй

хувийн хэвшлийг бүрдүүлээд. Тэгээд хүчтэй хувийн хэвшил гэдэг нь төрөөс хараат зүйл багатай, төрийн шахалт дарамт багатай, монгол хүн өөрийнхөө эрх чөлөө, боловсрол, мэдлэг тэр бүх зүйлээ ашиглаад өөрийнхөөрөө бизнесээ хийгээд явдаг, гаднын хөрөнгө оруулалтыг хүчтэй татсан, олон олон орны хөрөнгө оруулалт нь Монгол Улсад хөрөнгө оруулалтаа хийсэн, аливаа нэгэн маргаанууд нь бизнесийн зарчмаар, арбитрын журмаар шийдэгддэг, татварын хувь хэмжээ учиргүй их өндөр биш юм гэхэд бага биш дунд хэмжээтэй. Бага талдаа.

Тэгээд бизнес хийхэд нээлттэй ээлттэй ийм л хөгжлийн загварыг бий болгож явах ёстой.

Харамсалтай нь, ийш тийш нь татаад, дарангуйлал тогтоочих гээд, ийш тийшээ буруу төмөр зам бариад, хөгжлийн бодлогууд дээрээсээ гар хуруу, хумс хийгээд, бүх төрлийн сангуудаас хулгай хийцгээгээд.

Нүүрэн дээрээ гоё шударга юм ярьцгаагаад яваад байх нь Монголын хөгжлийн загвар биш.

Үүнийгээ л өөрчлөх хэрэгтэй, бид нар. Энэ бол ирээдүйн манай улсын хөгжлийн загвар гэж харж байгаа.

Үүний ч төлөө хичээж, чармайж ажиллаж байгаа. Хулгайчдыг Монголын төрөөс шахаж гаргах хэрэгтэй. Дахиж орж ирэхгүй байх арга зам, хаалгыг нь хаах хэрэгтэй. Бүрмөсөн хаах хэрэгтэй.

Монгол гэсэн энэ цөөхөн хүмүүсийн язгуур эрх ашгийг хамгаалдаг, улс орныхоо хөгжүүлдэг ийм загвар хэрэгтэй гэж би дотроо бодож байгаа.

Гашуунсухайтын тэр 20 километр зам яг холбох төмөр зам шүү. Яг холболтын. Нөгөө 9 давхар зөрүүлчихсэн 20 километр дутуу гээд байгаа чинь энэ юм. Үүнийг бид холбож байж төмөр замын үр ашиг гүйцэд гарна. Одоо тэр төмөр замаараа аваачаад машинд ачаад ийшээ гаргана гэхээр чинь бас төвөгтэй шүү дээ.

Тэгэхээр холболтын зам бол тэр 20 километр чинь 20, 20-иор явна гэсэн үг биш. Яг холболтын замаа хэлж байгаа юм шүү гэдгийг хэлье.

Бонд байгаа. Бонд гараад цаашаа явах ёстой. Гэхдээ нэг нөхцөл дутаад байгаа юм. Одоо бонд гаргаад эхлэнгүүт арилжааны банкнууд нөгөө хувийн хэвшилд зээл олгохгүйгээр зөвхөн Засгийн газарт зээл өгчхөөд хувийн хэвшилд зээл олгохгүй л суучихдаг.

Тэгэхээр банкны салбар өөрөө өрсөлдөөнтэй. Гадна, дотнын банкнууд орж ирсэн санхүүгийн хангалттай эх үүсвэр үүссэн үед бид бондоо гаргаад явбал зөв.

Түүнээс биш цөөхөн хэдэн банктай. Хэдэн банкны монопол дотор байж байхад үнэт цаас дотооддоо гаргаад явангуут хувийн хэвшилдээ зээл олгохгүй, Засгийн газартаа олгочхоод л суудаг. Дотор нь хувийн хэвшил хөгжиж өгдөггүй, бизнес хөгждөггүй ийм л юм байгаа юм.

Тийм учраас би үүнийг банкны салбар өргөжиж тэлтэл энэ бондын асуудлыг түр зогсоож л байх ёстой гэж үздэг хүн. Тийм бодлогоор.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Б.Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Тэр Гашуунсухайтын юу чинь хувь гээд, 20 хувь гэж байгаа шүү. Үүнийгээ та нар үзээрэй. Буруу бичигдсэн юм уу, яасан юм.

Дараагийн асуудал юу гэхээр, энэ эрчим хүчний салбарт томоохон хөрөнгө оруулалт хийх юм байна. Санал нэг байгаа.

Сая Ч.Хүрэлбаатар сайдын хэлж байгаа тэр хулгай Монголд нүүрлэсэн. Хулгайг төр хийгээд байгаа юм биш ээ. Тэнд тавьж байгаа боловсон хүчнүүд нь, төрийн тавьсан, эрх мэдэлтэй хүмүүсийн тавьсан хүмүүс хулгай хийгээд байгаа шүү.

Ийм учраас Монгол Улсын хөгжилд хүний хүчин зүйлийг үнэлэх чиглэлийн юмыг хөгжлийн нэг гол асуудал шүү. Энэ дээр сайд анхаарна биз.

Баялгийн сангаа байгуулах ёстой. Баялгийн сангийн хууль өргөн баригдсан байгаа. Үүнийг дэмжинэ.

Шинжлэх ухаандаа мөнгө оруулах ёстой. Мөнгө мэдлэгийг бий болгодог. Мэдлэг инновацыг бий болгодог. Инновац нь буцаад мөнгө олдог.

0.13 хувь байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2 хувь болгох саналыг оруулж байгаа.

Ийм ийм зүйлүүдэд анхаарч ажиллах шаардлага байна.

Л.Мөнхбаатар: Б.Баттөмөр гишүүн үг хэллээ.

Одоо Аюулгүй аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Энэ төвлөрлийг сааруулах, хөдөөгийн хөгжлийг дэмжих тал дээр ер нь яг юу хийх гэж байна аа?

Монголчууд бол одоо ингээд нийт газар нутгийнхаа 0.3 хувь дээр хүн амынх нь 50 хувь ирээд суучихсан. Энэ дөрвөн уулынхаа дунд усны бохирдолтой, хөрсний бохирдолтой, түгжрэлтэй, стресстэй, ингээд газар хөдлөлтийн эвгүй бүсэд амьдарч байна л даа.

Тэгээд хөдөөгийн хөгжлийг дэмжих тал дээр жоохон анхаарал тавихгүй бол энэ зах хязгаар эзгүйдлээ. Цалин, мөнгө нь ч хүрэхгүй юм. Тэтгэвэр, тэтгэмж нь ч хүрэхгүй юм.

Тэгээд дээрээс нь зах хязгаарт чинь бензин тосны үнэ Улаанбаатар хотоос 400-аас 700 төгрөгөөр илүү болчихсон. Юмны үнэ тэнд хоёр дахин илүү болчихсон.

Ингээд тэнд чинь амьдрах хүн үлдэхгүй нь ээ. Бүгд төв рүү нүүгээд, эсвэл гадаадад гараад алга болох нь.

Тэгэхээр зах хязгаараа хөгжүүлэх ямархуу бодлого барих юм? Энэ нөгөө өмнө нь хэрэгжүүлж байсан “**ГОВИЙН НЭМЭГДЭЛ**”, “**БҮСИЙН НЭМЭГДЭЛ**” гэдэг юмнуудыг энэ дээр ингээд ялгавартай тогтоох уу, үгүй юу? Тэгж байж нутгаа бүтэн байлгах юм бодох уу, үгүй юу? Нэг дэх асуудал нь.

Хоёр дахь нь, “**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**” гэдэг юмыг явуулах уу? Ямар тийм бодлого барих вэ?

Одоо жишээлэхэд баруун бүсэд гэхэд нэг аймагт нь арьс ширний үйлдвэр, нөгөө аймагт нь ноос, ноолуур угаах үйлдвэр, нэгэнд нь махны үйлдвэр, нөгөөдөхөд нь өлөнгийн үйлдвэр ч гэдэг

юм уу. Нөгөөдөхөд нь толгой, шийрний үйлдвэр ч гэдэг юм уу ийм байдлаар бүсчилж байгуулж болох уу, болохгүй юу?

Тэгэхгүй бол энэ чинь малын гаралтай бүтээгдэхүүн чинь жалгыг нь нэг хаягдаад дуусах нь ээ. Амны хишгийг нь гөвөөд дуусах нь. Үүнийг бид анхаарч хийхгүй бол болохгүй нь.

Тэгээд битүү цэвэрлэх байгууламж, технологиудыг нутагшуулах тал дээр ямар арга хэмжээ авах вэ?

Дарханы арьс, ширний үйлдвэрээрээ хэчнээн ч жил болов. Энэ “Харгиа”-г яриад хэчнээн ч жил болов. Үүнийг нэг бодлогын өөрчлөлт хийж баруун, зүүн, төвийн бүсийн гэж ангилахгүй бол энэ чинь болохоо байлаа.

Мал сүрэг маань өсөөд байдаг. Бид малын гаралтай түүхий эдийгээ ашиглаж чаддаггүй.

Гурав дахь нь, Бүрэнгийн гүүр гээд нэг гүүр байгаа юм.

Говь-Алтай аймгийн Жаргалант сумд байдаг. Завхан, Говь-Алтайн, 7 сумыг холбодог. Энэ гүүрийг бариулах гээд нэлээн явсан. Энэ төлөвлөгөө, төсөв дээр суух нь уу, суухгүй нь уу?

Энэ баруун босоо тэнхлэгийн авто зам буюу Говь-Алтай аймгийн төвөөс Тайшир, Тайшираас Улиастай, Улиастайгаас Арцсуурь орох нэг замын асуудал дээр Азийн хөгжлийн банкны санхүүжилт олгох нэг төсөл гарсан. Энэ зам маань явах нь уу, явахгүй нь уу? Ямархуу түвшинтэй явж байна? Ийм хэдэн асуултад хариулаадхаач.

Л.Мөнхбаатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар.

Ч.Хүрэлбаатар: Б.Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя.

Бүс нутгуудын хөгжилтэй холбоотой бүсийн нэмэгдлийн тухай асуудал байдаг.

Их Хурал дээр их олон ч удаа яригдаж байгаа. Тэгээд л одоо яг бодитой байдлаа л хэдүүлээ ярья. Баруун аймаг ч байдаг ч юм уу, зүүн аймгууд Улаанбаатар хотоос алслагдсан учраас бараа, бүтээгдэхүүний үнэ өндөртэй учраас нэмэгдэл өгөөч ээ гэж хэлдэг.

Говийн аймгууд маань байгалийн хувьд амаргүй, эрс тэрс, амьдрахад их тийм тааламжтай бус учраас “**ГОВИЙН БҮСИЙН НЭМЭГДЭЛ**” өгөөч ээ гэдэг.

Бусад аймгууд дээр бас нэг иймэрхүү хүн амын төвлөрөл ихтэй, утаа ихтэй, түгжрэл ихтэй учраас бас нэмэгдэл өгөөч ээ гэдэг. Ингээд л ярингуут л бид ерөөсөө бүс болгонд ямар нэгэн нэмэгдэл өгөх тийм шаардлагатай болчхоод байгаа юм.

Тэгээд ярьж байгаад л ерөөсөө больё гээд л ингээд л болиод ирсэн түүхтэй. Тэгээд энэ дахиж сэргээд ярингуут бас л асуудал үүсэх болов уу л гэж би бодож байна Б.Энх-Амгалан гишүүн ээ.

Дараагийн зүйл гэвэл бүсчилсэн хөгжлийн бодлого үнэхээр хэрэгтэй бодлого.

Тэгээд одоо ингээд өнөөдрийг хүртэл бид яваад ирсэн эдийн засгийн бодлогоо үзэхээр та бүгд бод доо. Мах, арьс шир, энэ бүх зүйл ганцхан Замын-Үүдийн боомтоор гарна. Бусад боомтоор боломжгүй байна.

Тэгэхээр бүс нутгийн хөгжлүүдийг авчрахын тулд бид яах ёстой вэ гэвэл тэр тухайн орон нутаг, хажуу талынхаа тэр бүс нутагтай боомттой чөлөөтэй харьцаж худалдаа наймаа хийдэг, зам нь баригдсан ийм байж байж тэр орон нутагт, ялангуяа Монгол шиг өргөн уудам нутагтай газар тэр хилийн цаадууд нь хөгжил ирчихсэн байгаа үед тэд нартайгаа харьцах замаар явбал илүү хөгжил их хурдан ирэх болов уу гэсэн бодолтой, ийм бодлого баримтлаад тэр боомтын шинэчлэл, боомт руу явсан замууд зэрэг дэд бүтцийн асуудлууд дээр Засгийн газар онцгой анхаарал тавиад явж байгаа гэдгийг хэлье.

Арьс ширний үйлдвэрүүдийн хувьд гэвэл Дарханы. Одоо нэг ийм л юм яваад ирсэн байгаа юм. Одоо тэр “Харгиа” гээд хийлгэх гэж байгаа. “Эмээлт” гэж нэрлэгдэж байгаа. Эмээлт хэрэггүй. Дархан дээр нь барина. Эсвэл Дархан хэрэггүй. Эмээлт дээр нь барина гэдэг л юм яригдаад яваад байдаг.

Тэгвэл бодлогын жилийн төлөвлөгөө дээр бид аль аль нь л барь. Аль альныг нь барья. Бие биетэй нь өрсөлдүүлж, бие биеийг нь үгүйсгэж хэрүүл үүсгээд хэрэггүй. Аль альныг нь л бариад л явъя. Аль алин дээрээ л баригддаг. Монголын 70 сая малтай гэж байгаа. Түүний арьс ширийг энэ 2 газар боловсруулаад явахад болох болов уу л гэж бодож байгаа.

Тийм учраас аль альныг нь барья гэдэг шийдвэр байгаа.

Азийн хөгжлийн банкны одоо таныг бас энэ Зам тээврийн сайд байх үеэс эхэлж анх яригдаж эхэлсэн тэр замын төслүүдийг Засгийн газар дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа.

Тэгээд хэлэлцэгдээд явах юм бол бас энэ орон нутгийн замын асуудлууд шийдэгдэх байх гэж бодож байна.

Тэр Мөрөнгийн гүүрийг сайн яасангүй. Манайхаас хариулчих хүн байна уу? Зам, тээврийн яамнаас хүмүүс байна уу? Мөрөнгийн гүүр бодвол байхгүй байх. Байхгүй юм шиг байна дарга аа.

Л.Мөнхбаатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг бид ярьж байгаа юм.

Төлөвлөгөөний хөгжлийн зорилтууд их аятайхан зорилтууд орчихсон. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин хоёроо бид иргэж сайн нягтлахгүй бол зарим тохиолдолд жулдаж байгаа. Одоо үүнийг задлаад ярина гэвэл зөндөө олон юм ярих болно.

Тийм учраас үүнийг би төсөл өргөн баригчийг эргэж нэг хараасай гэж ингэж бодож байгаа. Барилга, угсралтын ажлын гүйцэтгэл 20 хувьтай, 15 хувьтай гээд хүрэх түвшинг нь тавилцсан.

Тэгээд бид хэдийн хүлээгээд байгаа юманд хүрэхэд бас хугацаа орох гээд байгаа нэг зүйлүүд байгаад байна. Нэг.

Хоёр дахь зүйл. Үнэхээрийн бид “Шинэ сэргэлтийн бодлого” гэж яриад

6 үндсэн чиглэл дээр хөгжлийг хязгаарлаад байгаа юмнуудаа арилгах арга хэмжээ авна гээд зүтгэж байгаа. Энэ сайн. Гэхдээ тов тодорхой зүйлүүд дээр тогтож арай илүү ажилламаар санагдаад байгаа.

Одоо жишээ нь наад төмөр замын холболтын асуудлууд яригдаж байна. Бид заяагдмал баялгийнхаа ирээдүйн өгөөж дээр тулгуурлаад Гашуунсухайтыг тавьчихсан. Холбогдоогүй. Одоо хувийн хэвшлээ дэмжиж байгаад Хангиа тавиулчихсан. Холболт шийдэгдээгүй. Одоо Бичигтийн тухай ярьж байгаа. Дахиад энэ баруунтаа бас нэг төмөр замын тухай ярьж байгаа.

Тэгэхээр зэрэг төмөр замын холболтын цэг, тэгээд урд айлтай тэр ерөнхий гэрээнийхээ юмыг бүрэн шийдэж авахгүй бол замууд нь баригдчихаад байдаг, холболтын цэг гэрээнүүд нь хийгдээгүй байгаад хүлээгдэж байгаа зүйлүүд байгаад байна.

Тэгэхээр энэ дээрээ их том дүгнэлт хийж харин бид төрөөс хариуцах бэлтгэл ажлынхаа асуудлуудыг холбогдож байгаа талтайгаа ямар ч асуудалгүй бэлэн болгох ёстой.

Тэгж байж итгэл үнэмшил нэмэгдэж, хөрөнгө оруулалт орж ирэх бололцоо боломж бүрдэнэ. Энэ тал дээр ямар бодлого чиглэлүүд байгаад байгаа юм бэ гэдэг асуудал байна.

Дараагийн нэг зүйл. Хулгай зэлгий зөндөө ярилаа. Цаашид гаргахгүйн тулд эрх зүйн орчингууд сайжруулна. Тэр ойлгомжтой. Өмчийн хууль, Компанийн хууль гээд олон хуулиудыг бид өөрчилнө. Ойлгомжтой. Гэтэл олон нийтийн оролцоо, хяналт, сайн засаглалын асуудал яаж явах юм бэ?

Энд нэг өгүүлбэр байгаа юм. Хүрэх түвшин дээр хоёрхон компанийн тухай тоо байгаад байгаа юм.

Тэгээд энэ томоохон үнэ цэнтэй, заяагдмал орд дээр тулгуурлаад байгуулагдчихсан компаниудын чинь үнэт цаасыг гаргаж борлуулах ёстой юм биш үү.

Дотоодоосоо бид эх үүсвэрээ бүрдүүлэх ёстой юм биш үү. Гаднынхан авчих гээд байна гэж айгаад байгаа бол дотоодынхоо аж ахуйн нэгж, байгууллагуудад борлуулах ийм тусгай хязгаартайгаар үнэт цаасаа гаргах ёстой. Орлогоо бүрдүүлж авах ёстой. Цаана нь баяжуулах үйлдвэр гэдэг юм уу янз бүрийн юм хийх гээд хөрөнгө дутаж байгаа юм бий.

Орж ирсэн орлогоо түүн рүүгээ чиглүүлэх барих энэ юмаа хийж энэ нэг үнэт цаасаар дамжуулж санхүүгийн арга механизмаар эх үүсвэр бүрдүүлэх арга хэмжээг ер нь яаж зохион байгуулж хийнэ гэж хараад байгаа юм бэ?

Ингэж байж л энд яригдаад байгаа ужгирсан хүндрэлтэй асуудлууд зөв цэгцдээ орох ёстой гэж би бол ингэж хараад байгаа.

Тийм учраас энэ дээр ямар бодлогын чиглэл зорилтууд байна вэ гэж. Том том төслүүд байна. Төр хариуцахаар ч юм байна. Дотор нь. Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр буюу хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэх юмнууд байна.

Тэгвэл хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зүйлүүдээ ил тод, нээлттэй зарлаж хөрөнгө оруулагч нараа татах арга хэмжээг хийх ёстой. Одоо жишээ нь энэ Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар.

Ч.Хүрэлбаатар: Ч.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэр шалгуур болон хүрэх зорилттой холбоотой зүйлүүд дээр суугаад тодруулаад ажиллая. Түргэн шуурхай хийх юмнууд дээр санал нэг байна.

Төмөр замын холболтын хувьд ийм юм билээ. 1955 оны Хятадтай байгуулсан тэр төмөр замын хэлэлцээр дээр зөвхөн Замын-Үүдийн боомт байгаа юм. 1955 оны гэрээ учраас нөгөө боомтууд нь ч байх ч аргагүй л дээ.

Тэгээд түүн дээрээ нэмэлт, өөрчлөлт оруулъя гээд 4 боомт нэмж байгаа юм. Одоо. Гашуунсухайт, Сэхээ, Бичигт, Ханги гээд. Энэ 4-ийг нэмж оруулахаар манай Зам, тээврийн яам ажиллаж байгаа. Тэгээд тантай санал нэг байна.

Ер нь бас үе үеийн Зам, тээврийн яам бүтээн байгуулалтын ажлууд хийгдээд дууссан хойноо ярьдаг биш, өмнө нь эд нарыгаа тохирчхоод тэгээд бүтээн байгуулалтын ажлуудаа хийж байдаг байсан бол их л оновчтой зүйл байгаа юм л даа.

Би бол мухар төмөр зам барьчихлаа гээд хүн амьтнаар загнуулаад суухгүй шүү дээ. Загнуулахдаа ч биш. Тийм ч агуулга муутай бүтээн байгуулалтуудыг бид цөөхөн хиймээр байгаа юм.

Логиктой. Эхлээд холбох цэгээ тохирчхоод дараа нь бусад бүтээн

байгуулалтаа хийдэг. Дуусангуут ачаа нь явж байдаг байхаар юмаа зохион байгуулах ёстой шүү гэж Ж.Батжаргал гишүүний хэлж байгаатай санал нэг байна.

Ер нь тэр хулгай зэлгий нэлээд ярьсандаа ч биш. Ер нь Монгол Улс цаашдаа засаглалынхаа үзүүлэлтүүдийг бид сайжруулж байж л хөгжинө. Засаглал дээр алдаатай байх юм бол бид Монгол Улс ер нь нэг их цаашаа хөгжихөд аягүй төвөгтэй шүү дээ.

Тэгэхээр засаглалтын үзүүлэлтүүдийг сайжруулна гэдэг дотроо бид авлигын үзүүлэлтийг сайжруулна, төрийн бүтээмжийг дээшлүүлнэ, төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдийг нэмнэ, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг үе шаттайгаар хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна, хүний эрхийн зөрчлийг бууруулна, иргэний эрхийн тэгш байдлыг хангана, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй иргэдийн тоог бууруулна, хамгаална, шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг сайжруулна, шүүх шинжилгээний лабораториудыг бий болгоно зэрэг иймэрхүү хил орчмын аюулгүй байдлыг сайжруулна.

Эрэн хайх чанарыг нэмэгдүүлнэ зэрэг ийм зүйлүүдийг бид мөн эндээ суулгаж оруулж ирээд явж байгаа гэж хэлье.

Хөшигийн хөндийн бүтээн байгуулалт тусдаа Үндэсний хороо байгуулагдаад ажиллаж байгаа. Урьд өмнө нь ажиллаж байсан. Тэр нь ажлаа үргэлжлүүлээд хийгээд явж байгаа гэж хэлье.

Л.Мөнхбаатар: Та тодруулах уу? Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж

асууя. Дээр нь ажлын хэсэг нэмж хариулж болно шүү.

Ж.Батжаргал: Тийм ээ. Тэгэхээр би засаглалын юман дээр төрийн засаглалын талаасаа биш тэр үнэ цэнтэй заяагдмал баялаг дээр тулгуурлачихсан аж ахуйнуудын засаглалын асуудлыг зориуд хөндөөд байгаа юм.

Үүнийг бид ер нь нэлээн шуурхай зохион байгуулж байж энэ үр өгөөж рүүгээ явна шүү. Энэ талаар энэ дотор орчхоод байгаа тоо хоёр аж ахуйн тухай л тоо тавьчихаа ингээд суугаад байгаа. Үүнийг янзлахгүй бол болохгүй байна гэж.

Дараагийн зүйл. Хуримтлалын тухай асуудал. Үндэсний хуримтлалын тогтолцоогоо эрх зүйн хувьд баталгаажуулж авч тэгээд тов тодорхой заяагдмал баялгийн үр өгөөжөөс хуримтлал үүсгэдэг, түүний тодорхой хэсэг нь иргэдийнхээ нэр дээр хуримтлал болж үлддэг энэ дүнгээр нь буцаад дотоодын хөгжлийн төслүүд, хөгжлөө дэмжсэн эх үүсвэр болж ашиглагддаг энэ асуудлыг бид шуурхай шийдмээр байгаа юм. Үүнийг юу гэж хараад байна вэ? Энэ төлөвлөгөөн дотор яаж ороод байна вэ гэдэг асуудал.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэн хариулах юм? Шадар сайд хариулаад, ажлын хэсэг нэмэх юм уу? Ч.Хүрэлбаатар Шадар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Уул уурхайн салбарт, ашигт малтмалын салбарт ажиллаж байгаа тэр төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой санал нэг байна.

Тэр сайжруулаад, нэмээд, дэлгээд явах нь зөв. Санал нэг байна. Хуримтлалын сангийн тухай гээд.

Манайх уг нь Баялгийн сангийн хуультай. Ирээдүй өв сангийн. 2030 он хүртэл тэндээ зөвхөн гар хүрэхгүй мөнгө хуримтлуулах ёстой. 2030 он.

Одоогийн байдлаар миний буруу санаагүй бол 2.4 их наяд төгрөг хуримтлагдчихсан байгаа.

Тэгээд уг нь үүнийг одоо юу гэдэг юм аваад ингээд зарцуулах тухай зарим газар яригдаад л байгаа. Одоо. Миний байр суурь бол зарцуулахгүйгээр тэр 2030 он хүртлээ гар хүрэхгүйгээр хадгалаад түүнийгээ валют болгоод. Гадаадад биш валют болгоод Монголдоо хадгалаад.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одоо Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороон дарга Батсүхийн Саранчимэг асуултаа асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад бас тодруулах зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр энэ төлөвлөгөөний төслийн 4.1.1.4-д Дундговь аймгийн Цагаан суваргад палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал судалгаа, амралтын цогцолбор байгуулах арга хэмжээ орж ирсэн байна.

Дундговь аймгийн Өлзийт сумд байрлах Цагаан суварга бол байгалийн маш өвөрмөц тогтоцтой, маш үзэсгэлэнтэй газар.

Тэгэхээр сүүлийн жилүүдэд ч гэсэн гадаад дотоодын зочид маш их очдог болсон. Үүнээсээ үүдэлтэй тэр хогийн асуудал, мөн хөрсний бохирдлын асуудал тулгамдсан асууд болоод байгаа.

Тэгэхээр эдгээрийг бид яг бодлогоор цэгцтэй аялал жуулчлалын зорилгоор хөгжүүлэх ёстой.

Тийм ч учраас миний бие Барилга, хот байгуулалтын яаманд санал гаргаад төсөвт суулгуулж ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажлын зургийг нь хийлгэхээр төсөв нь батлагдчихсан ажил нь явж байгаа. Одоо бол энэ аялал судалгаа, амралтын цогцолбор байгуулна гэж байна.

Тэгэхээр энэ маань аялал жуулчлалынхаа ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж орж ирж байгаа юу? Энэ ямархуу шатандаа явж байгаа вэ?

Нөгөө талаар жилд 50 мянга гаруй ирдэг гадаадын зочид жуулчид ирдэг энэ газар Дундговь аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид 2019 онд Цагаансуваргыг байгалийн өвөрмөц тогтцыг хадгалсан байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор тусгай хамгаалалтад авах тухай саналаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.

Мөн манай Засгийн газар ч гэсэн үүнийг тусгай хамгаалалтад авах нь зүйтэй гэж төлөвлөсөн байгаа.

Тэгэхээр иймээс эхний ээлжид Цагаансуваргыг тусгай хамгаалалтад авах нь зүйтэй гэж үзэж байна.

Тэгээд үүнийг хуулиараа хамгаалалтад авч тодорхой хязгаарлалтууд гарах учраас байгалийн өвөрмөц тогтцоо хамгаалах боломжтой учраас Цагаансуваргыг тусгай

хамгаалалтад авах үйл явц ямархуу шатандаа явж байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Нөгөө талаар тусгай хамгаалалттай газар нутгийн ямар ангилалд хамааруулах саналтай байгаа вэ?

Дараагийн нэг асуудал бол ногоон хөгжлийн асуудал байгаа.

Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам бол бас энэ 2024 оныхоо бодлогыг сайхан тодорхойлоод, тэргүүлэх чиглэлүүдээ гаргаж ирсэн нь үнэхээр сайн байна. Тэгээд тэргүүлэх чиглэлд хүнсний хангамж, аюулгүй байдал, мөн ногоон хөгжлийг оруулж ирсэн нь чухал бодлогыг оруулж иржээ гэж харж байна.

Тийм учраас хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах дээр 2024 ондоо хэдэн төгрөг суулгахаар төсөвлөсөн байгаа вэ?

Ер нь 5 жилийн хугацаанд энэ хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахын тулд 7 их наяд төгрөгийг суулгана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Тэгэхээр 2023 оны явц ямар байгаа вэ, 2024 онд ямар төлөвлөлттэй байгаа вэ гэсэн нэг асуулт байна. Нөгөө талаар Улаанбаатар хотын даргаас асуумаар байна.

Тэгэхээр аливаа зүйл төлөвлөлттэй явах ёстой.

Тэгэхээр Улаанбаатар хотын төлөвлөлт ч гэсэн өнөөдөр 500 мянган хүнд зориулж төлөвлөгдсөн байсан нь энэ нь эвдэгдээд ямар байдалдаа хүрчихсэн байгааг Та бүгд мэдэж байгаа.

Тэгэхээр ногоон байгууламжийн ерөнхий төлөвлөгөө гарчихсан явж байгаа.

Тэгэхээр энэ төлөвлөгөө чинь ямархуу явж байгаа вэ? Одоо жишээ нь гэхэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ерөнхий төлөвлөгөө нь батлагдчихсан. Дээрээс нь хийгдчихсэн байсан ногоон байгууламж эвдэгдээд шал өөр тохижилт хийгдэнэ гээд ороод ирчихсэн явж байсныг би онцолж хэлж байсан.

Тэгэхээр дээрээ бодлого шийдвэрүүд нь гарчихдаг. Дунд шатандаа алдагдаад байвал.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг 83. Эдийн засаг, хөгжлийн яам.

Л.Балчинлуvsан: Эдийн засаг, хөгжлийн яам Л.Балчинлуvsан Б.Саранчимэг гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, Дундговь аймагт баригдах гэж байгаа палеонтологийн аялал жуулчлалын цогцолборын тухай яригдаж байна.

Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газраас боловсруулсан 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл 3-т аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэж зааж өгсөн байгаа. Энэ хүрээндээ аялал жуулчлалын бүс нутгуудад дэд бүтэц болон бусад үзүүлбэрийн газруудыг боловсруулж байгуулна гэдэг заалтууд орсон байгаа. Төслүүд.

Тэгэхээр энд маань Дундговь аймгийн энэ цогцолбор орсон байгаа.

Ингээд 2024 онд хэрэгжүүлэх ажлуудын ТЭЗҮ, зураг төслийн ажил Эдийн засаг, хөгжлийн яаманд ирснээр

энэ ТЭЗҮ, зураг төслийн ажлууд нь хийгдэхээр явж байгаа. Мөн жилийн төлөвлөгөөндөө орсон байгаа.

Хоёрдугаарт, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр нэлээн хэдэн ажлуудыг тусгаж өгсөн байгаа. Үүнтэй холбоотойгоор “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр болон гадаргын усны асуудлуудыг тусгаж өгсөн байгаа.

Гуравдугаар асуулт, тэр хүнсний хангамжийн талаар асуулаа. Энэ 2024 оны жилийн төлөвлөгөөнд хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр 5 төсөл, арга хэмжээнд нийтдээ 174.9 тэрбум төгрөг тавигдсан байгаа.

Г.Занданшатар: 95. Ж.Сандагсүрэн дарга хариулах уу?

Ж.Сандагсүрэн: Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн Саранчимэг гишүүний асуултад хариулья.

Өнөөдөр ногоон байгууламж Улаанбаатар хотын нэг иргэнд 5.7 метр квадрат байгаа нь мэдээж тийм хангалттай үзүүлэлт биш.

Тэгэхээр бид хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр болгон дээрээ ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр байнга ажлуудыг тусгаж байна.

Дэд бүтцийн төслүүд байна. Одоо яригдаж байгаа “Сэлбэ сэргэлт” болон Туул голын тохижилт, дээр нь Богд хан уулын орчмын ногоон байгууламж гэх мэт ингээд ногоон байгууламжийн төслүүд нийслэлд нэлээн хангалттай хэмжээнд хийгдэж байгааг Та бүхэн мэдэж байгаа.

Сүүлийн үед нийтийн эзэмшлийн талбайд байгаа гаражуудыг буулгаж,

түүний оронд ногоон байгууламжуудыг бид барьж 5.7 гэсэн хэмжээг өөрчлөхөөр ажиллаж байна.

Ногоон байгууламжийн ерөнхий тэр ирэх 2040 хүртэлх онд төлөвлөгөөнд тусгагдсан заалтууд одоогоор 20, 40 маань батлагдаж амжаагүй байгаа учраас эндэх тоонуудыг энд. Ер нь төлөвлөгөөнүүд батлагдсан байгаа.

Энд арай батлагдаагүй байгаа төлөвлөгөө маань ерөнхийдөө бүрэн батлагдаж дуусаагүй байна. Засгийн газар дээр хэлэлцэгдэх шатдаа байгаа.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Б.Саранчимэг гишүүн өөрөө очиж нөхцөл байдалтай, урьд нь ч даргаар нь ажиллаж байсан нөхцөл байдлыг сайн мэдэж байгаа. Ямархуу төлөвлөгөө байсныг.

Нийслэл дээр тэр байгууллагыг удирдаж байгаа хүмүүс нь тодорхой төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэлээн өндөр дүнтэйгээр тодорхой цэцэрлэгт хүрээлэн байгуулья гэдэг ийм санаачилга гаргаад явсан.

Авсан ойлголтоор ногоон байгууламжийн хэмжээг нь огт бууруулахгүйгээр хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтыг хийе. Энэ нь хүүхэд, залуучуудын амрах, чөлөөт цагаа өнгөрөөх ийм ая тухтай орчин бий болгох ийм үр дүнтэй юм гэдэг ийм байдлаар төлөвлөлт гаргаад энэ ажлыг эхлүүлсэн ийм байдалтай байгаа.

Г.Занданшатар: Батсүхийн Саранчимэг гишүүн тодруулж асууна. 1 минут.

Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууна.

Б.Саранчимэг: Ногоон байгууламж гэдэг өөрөө маш том бүтээн байгуулалт.

Барилга байшингаас ч илүү урт наслах. Үнэхээр арчилж хамгаалаад явбал.

Тэгэхээр би Ж.Сандагсүрэн даргаас асуухдаа ногоон байгууламжийн ерөнхий төлөвлөгөөгөө эвдэхгүй гэсэн баталгаа бий юу? Цаашдаа эвдэхгүй байхын тулд ерөнхий төлөвлөгөөгөө дагаж ажиллах юм уу?

Хэн нэгний хувийн хэвшил, хэн нэгэн компани руу чиглээгүй. Хамгийн гол зүйл бол энэ ажил чинь эргээд төлөвлөгөөгөө эвдэхгүй, ногоон байгууламжаа эргэж устгахгүй байх учиртай.

Устчихсан, устгаад өөр ажлууд хийгдээд байгаа учраас энэ дээр би шүүмжлэлтэй хандаж байгаа.

Цаашдаа энэ ерөнхий төлөвлөгөөгөө бариад явна гэсэн ийм баталгаа байгаа юу?

Нөгөө талаар Баянзүрх дүүргийн манай Улсын Их Хурлын гишүүд санал санаачилга гаргаад Монгол Улсын Ерөнхий сайд Баянзүрхэд очиж ажилласан. Үнэхээр Баянзүрх дүүрэг өөрөө хамгийн их хүн амтай мөртлөө эмнэлэггүй.

Тэгээд үүнийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн. 95 Ж.Сандагсүрэн дарга хариулья.

Ж.Сандагсүрэн: Саяын болсон нөхцөл байдалтай холбоотойгоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн

ерөнхий төлөвлөгөөн дээр тодорхой гажуудал гарч байгаа талаар тодорхой мэдээллүүд яригдсан. Үүнийг үгүйсгэхгүй.

Гэхдээ хойшид төлөвлөгөөг нягт баримталж явна.

Хот бол Б.Саранчимэг гишүүнтэй яг ижилхэн байр суурьтай байгаа. Ер нь бидэнд цементээр цутгасан байшин барилгын илүүдэл бий болчихсон байгаа. Одоо бүх барьж байгаа ногоон байгууламж дээрээ бид барилга байгууламжгүй зөвхөн ногоон зүлэг болон мод тарих гэдэг байдлаар тохижилтуудыг явуулж байгаа.

Тэгэхээр таны санаа зовж байгааг ойлгож байна. Энэ цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөөг цаашид нягт баримталж ажиллах талаар бид анхаарч ажиллана.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: Баярлалаа. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөн дотор бодлогынхоо тэргүүлэх бодлогынхоо гуравдугаарт хүний хөгжлийн талаар дурдсан байна.

Тэр дундаа эрүүл мэндийн асуудлыг тодорхой дурдсан байна.

Монгол Улс дотооддоо эмчилдэггүй 26 өвчин байдаг гэж зарласан байдаг. Үүнийх нь 2-ыг эх орондоо нутагшуулсан гэсэн мэдээ бий. Тэгэхдээ түүнийхээ дараах нөхөн сэргээлтийг бас амжилттай хийж чадахгүй гэсэн гомдол иргэдээс ирсээр байгаа.

Тэгэхээр Монгол Улс дотооддоо эмчилж чадахгүй байгаа энэ өвчнүүдийг

иргэд маань гадагшаа явж бүгд эмчлүүлж байгаа.

Ер нь гаднын улс орнууд, тэр дундаа Солонгосын эмнэлгүүдийг монголчууд өнөөдөр дүүргэж байна.

Асуудал нь юу вэ гэхээр бүгд ерөөсөө өр зээл тавиад өвчтэй хүнийхээ төлөө хамаг байдгаа барж иргэд ядарч байна. Бид хөгжлийн тэргүүлэх чиглэлдээ энэ асуудлыг заавал ч үгүй, зайлшгүй бид ярих ёстой. Байдгаа зарчхаад маш олон тохиолдолд хүнээ үхүүлээд авчирч байна.

Тэгэхээр 26 нэр төрлийн өвчлөл. Ер нь ихэнх улс орнуудад өөрийн орон дотооддоо эмчилдэггүй өвчнүүдийг гадагш нь явуулахад Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн даадаг юм билээ.

Тэгэхээр манайд бүрэн даах байтугай дэмжлэг байхгүй байгаа шүү дээ. Дэмжлэг гэхэд хэцүү.

Тэгэхээр энэ тал дээр нэн яаралтай ямар бодлого баримтлах гэж байгаа вэ? Энэ улсдаа тусалж дэмжих үү? Энэ иргэдээ хайрлаж халамжлах юм уу, яах юм бэ гэдэг нэгдүгээр асуудал байгаа.

Би Эрүүл мэндийн сайдаас асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарх нь, юм нэмж барих, овоолохыг бид хөгжил гэж үзээд байх юм уу, яах юм. Барьсан юмаа бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж ашиглах явдал чухал байна. Ялангуяа эрүүл мэндийн салбарт.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бас аюулын харанга дэлдэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдүүдийн, төрөлхийн гэгдэж байгаа хүүхдүүдийн асуудал байна.

Гэтэл бид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэргээн засах төвийг Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар тэр том төвийг байгуулсан. Одоо хүчин чадлынхаа өчүүхэн хэмжээнд ашиглаж чадахгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань эмнэлэг рүү очиж ч чадахгүй. Очсон хэд нь бүрэн нөөцөөрөө ажиллаж чадахгүй ийм эмнэлэгт байсаар байна. Энэ эмнэлгийн ер нь харьяалал нь зөв юм уу?

Тэгэхээр Эрүүл мэндийн яамны тэргүүлэх чиглэлийн бодлогод энэ харьяаллын талаар ер нь бодож үзсэн үү? Энэ хаанаа байх нь зүйтэй юм бэ?

Хоёр, гурван салбарт харьяалагдчихдаг. Салбар дундын уялдаа холбоогүйгээс энэ олон хүүхдүүд, эхчүүд, эцгүүд хохирч байна. Энэ асуудлыг ер нь тэргүүлэх чиглэлдээ эрүүл мэндийн салбар яаж барьж байгаа вэ гэдэг энэ зүйлийг асуумаар байгаа юм.

Төгсгөлд нь тэргүүлэх чиглэлийн 7 дугаар зүйлд заасан байна. Хувийн хэвشلүүдээ дэмжих гэсэн бодлого байгаад байна.

Яг өнөөдөр шалгаруулсан байх шиг байна. Топ татвар төлөгч аж ахуйн нэгжүүд гээд.

Үүний сайшаалтай нь юу вэ гэхээр анх удаа төрийн өмчит компаниудыг оролцуулаагүйгээр жинхэнэ хувийнхныг шалгаруулсан байна. Энэ бол хувиараа бизнес эрхлэгчдэд маш их урам өгсөн ийм үйл ажиллагаа, алхам болсон болов уу гэж бодож байна.

Тэгээд КОВИД-ын үед ер нь энэ хувийн хэвшлийнхэн өнөөдөр сөхөрч байна. Эд нарыг бүр сөхрүүлж итгэлгүй болгож байгаа юм нь төрөөс төрсөн

тэрбумтнууд. Төрд ажиллаад хажуугаар нь жирийгээд явчихдаг. Өөрсдөө хэчнээн хүн цалинжуулаад өвдгөөрөө сөхөрдөг энэ байдал.

Тэгэхээр бид энэ хувийн хэвшлийнхнийг дэмжинэ гэдэг энэ өгүүлбэрийг яаж нөхцөлдүүлэх гэж байгаа юм бэ гэдэг гуравдугаар асуулт. Асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд хариулья.

Ч.Хүрэлбаатар: Гадна явж хүмүүс эмчилгээ хийлгэдэг. Тэрийг Монголд яаж оруулж ирэх вэ гээд.

Энэ хандлага би жоохон өөрчлөгдөж байгаа болов уу гэж бодож байгаа. Энэ даатгалын санхүүжилтийг нэвтрүүлсэн.

Тэгээд төрийн эмнэлгүүдэд л мөнгө өгдөг, хувийнханд мөнгө өгөхгүй гэдэг байсан.

Дараа нь төрд нь 100 хувь мөнгийг нь өгдөг, хувийн хэвшлийнхэнд нь гаргасан зардалд 50 хувийг нь өгнө гээд.

Дараа нь үүнийгээ адилхан төр ч бай, хувийнх ч бай тэнцүү хэмжээний олгодог болж эхэлснээрээ Монгол Улсад шинэ технологи, шинэ эмнэлэг, шинэ эмчилгээний аргууд, технологиуд орж ирж байгаа болов уу гэж би бодож байгаа юм.

Ер нь л хөгжлийн бодлого, зарчим нь энэ.

Санхүүжилтийн механизмыг нь бид зөв болгочих юм бол бий болно. Түүнээс биш санхүүжилтийн механизм нь буруу байхад бид өчнөөн мянган

барилга бариад тэнд олигтой юм болохгүй шүү дээ.

Тэгэхээр би сүүлийн гурав, дөрвөн жилийн хугацаанд явагдаж байгаа гүйцэтгэлийн санхүүжилт, даатгалын санхүүжилт зөв зарчим руугаа явж байгаа учраас монголд хөрөнгө оруулалтууд орж ирж байна гэж үзэж байгаа.

Тэгээд тэр хэмжээг улам эрчимжүүлж чадвал гадагшаа явдаг монголчуудын тоо буух болов уу л гэж бодож байгаа.

Эрүүл мэндийн зарим салбарууд бусад улсаас Монголд ирж эмчилгээ эмчлүүлдэг тийм зүйлүүд бий шүү дээ. Бий болчихсон байна лээ.

Тэгэхээр бас иймэрхүү зүйлүүдээ дэмжээд явах ёстой байх гэж хэлж байна. Тэр байгаа зүйлүүдээ бүрэн ашиглах ёстой гэж П.Анужин гишүүний хэлж байгаа зүйлтэй санал нэг байна.

Хувийн хэвшлийг яаж дэмжих ёстой вэ гэж. Ер нь бид хувийн хэвшлийг уриа лоозонгоор биш бодитой үйл ажиллагаануудаар дэмжих ёстой. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдийн экспортыг бид чөлөөтэй байлгах тусмаа л энд бизнес хөгжих нь ойлгомжтой болж эхэлж байна шүү дээ.

2013 онд Женко Х.Баттулга арьс, шир экспортлохыг хориглочихсон.

Эцэст нь юу болсон бэ гэвэл Монголын арьс, ширний үнэ унасан. Энэ нь хөдөөгүүр жалгаар нэг л тараагдаж хаядаг болсон. Үүнийг Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар болиулаад гаргаад эхэлж байгаа.

Ноолуур дээр ч гэсэн. Элдэв бусын хүнд суртал шаардлага, босго тавьж хааж боогоод байх шаардлагагүй юм байна лээ.

Бид төр хиймэл тийм хүндрэл бэрхшээлүүд, хүнд суртлаа л болиулчих юм бол энд хувийн хэвшил өөрөө хөгжөөд явчих ийм бүрэн боломжтой юм байна гэдэг нь харагдаж байгаа.

Төмөр зам дээр ч гэсэн хувийн хэвшлийнхэн. Би одоо тэр Ханги руу явсан төмөр замыг 8 сарын дотор 250 километр төмөр зам барьчихаж байна шүү дээ. Ганцхан компани.

Гэтэл төрөөрөө хулгай хийнэ барина. Эрдэнэс Тавантолгойн мөнгийг ашиглана барина. Зах зээл рүү биш хөндлөн тавьсан төмөр зам нь бөөн хулгай л байгаа шүү дээ.

Тэгээд эндээс үзэхээр төр дэд бүтцээ барих зүйл дээр хамгийн оновчтой зөвөөр хувийн хэвшилтэйгээ зөв хамтраад явчих юм бол үр дүн гарна. Энэ чиглэлийг цаашдаа эдийн засаг дээр урьд өмнө нь гаргасан алдаануудаа дамжуулаад явчихвал болно. Тийм.

Би бол Монголын эдийн засаг жижигхэн, сэргэхдээ амархан эдийн засаг гэж хардаг. Энэ амаргүй хүнд үеүд ард үлдэнэ гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байгаа.

Хувийн хэвшил маань, гадаадын хөрөнгө оруулагч нар ихээхэн үүрэг гүйцэтгээ гэдэгт эргэлзэхгүй байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулна.

С.Чинзориг: П.Анужин гишүүний асуултад хариулъя.

2017 онд Эрүүл мэндийн сайдын тушаал гараад дотооддоо оношилж эмчилж чадахгүй байна гэсэн 26 төрлийн өвчний жагсаалт гаргасан юм байна лээ.

Гэхдээ эдгээрийг нь дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа энэ өвчнөөр өвчилсөн иргэддээ төр ямар туслалцаа, дэмжлэг үзүүлж байгаа юм бэ гээд аваад үзэхээр харамсалтай нь үнэхээр бараг л ч тийм дэмжлэг байхгүй байх юм.

Эдгээр иргэд гадаадад эмчилгээнд хамрагдаад яваад ирсэн бол ирсэн хойно нь гадаадад эмчлүүлсэн зардлын төлбөрийнх нь 5 хувийг л төсвөөс санхүүжилт олгож байгаа гэж.

Нэгэнт төр өөрөө дотооддоо оношилж амжиж чадахгүй байна гэж байгаа бол 5 хувийн төлбөрийг шийдэж өгдөг бол нэлээн туйлын хангалтгүй гэж үзэж байгаа.

Тийм учраас бид бодлогын нэлээн томоохон өөрчлөлтийг хийх ёстой гэж үзэж байгаа юм.

Нэг дэх асуудал нь, бид Шинжлэх ухаан, технологийн сан гэж сан жил болгон төсөв сонгон шалгаруулдаг. Шинэ технологи нэвтрүүлэх.

Тэгэхээр Шинжлэх ухаан, технологийн санд төсөл хэлбэрээр дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг оношлох, эмчлэх технологи нэвтрүүлэх, нутагшуулах чиглэлээр, энэ өвчнийг дотооддоо эмчилдэг байх ийм чадавхтай болгох асуудлыг шийдье гэж зорьж байгаа.

Энэ жил бид Шинжлэх ухаан, технологийн санд дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг

технологийг нутагшуулах чиглэлээр 10 төсөл бодлогоор бичүүлээд Шинжлэх ухаан, технологийн санд өгсөн.

Эдгээр төслүүдээс нэлээд нь дэмжигдэх болов уу гэж найдаж байна.

Хоёр дахь асуудал нь, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Эрүүл мэндийг дэмжих гэж сан байгаа юм. Энэ дэмжих санд жилд хуулиараа 9 орчим тэрбум төгрөг төвлөрөх ёстой.

Нөгөө архи, тамхины онцгой татварын тодорхой хувийг төвлөрүүлдэг. Энэ хөрөнгийг зөвхөн нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зарцуулчих.

Тийм учраас иргэний эрүүл мэндийг хамгаална гэдэг бол хоёр талтай гэж би яриад байгаа юм. Нэг тал нь нийгмийн эрүүл мэндийн асуудал.

Тийм учраас нийгмийн эрүүл мэндийн асуудал энэ сангийн хөрөнгийг зарцуулах нь зүйтэй. Гэхдээ эрүүл мэндийг хамгаалах асуудал чинь нөгөө тал нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх асуудал.

Тийм учраас энэ Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн эрүүл мэндийн асуудалд биш эрүүл мэндийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх буюу дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг эмчлэх чиглэлээр шинэ технологи нутагшуулж оруулж ирвэл тэр нутагшуулах зардлыг нь энэ сангаас санхүүжүүлдэг болгоё гээд.

Ингээд Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулаад үзэл баримтлалаа Сангийн сайд, Хууль зүйн сайд нартай

хамтарч боловсруулаад удахгүй бид Засгийн газарт оруулахаар бэлдэж байгаа.

Энэ хууль батлагдчих юм бол дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг шинэ технологи, эмнэл зүйн арга нэвтрүүлсэн бол тэр нутагшуулах зардлыг нь эрүүл мэндийн нөгөө Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлдэг байж гэж.

Одоо яаж байгаа вэ гэхээр шинэ технологи нутагшуулах зардлыг эмнэлгийн байгууллагууд өөрсдөө хариуцаж яваа гэхээр эмнэлгийн байгууллагууд санхүүжилт байхгүй гээд энэ шинэ технологи нутагшуулах үйл ажиллагаа явахгүй байгаа юм.

Тийм учраас цаашдаа үүнийг энд Эрүүл мэндийг дэмжих сангаас нь санхүүжүүлдэг болгоё. Тэгээд тодорхой хугацаагаар нутагшаад эмнэл зүйн дүгнэлт нь гараад Монголд үүнийг эмчилдэг боллоо гэсэн дүгнэлт нь гарсан нөхцөлд цаашдаа бид эрүүл мэндийг даатгалын сангаас санхүүжүүлдэг байх ийм тогтолцоо руу оръё гэж бодлогын өөрчлөлт хийж чадах юм бол энэ асуудал нэлээн тодорхой, бодлогын томоохон.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Чинзориг сайд.

С.Чинзориг: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвтэй холбоотой асуудал байгаа юм.

Одоо бол энэ Сэргээн засалтын төв Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж байгаа.

Манай яамнаас бодлогын дэмжлэг үзүүлээд эрүүл мэндийг дэмжих Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас, даатгалаас гүйцэтгэлээр санхүүжилт авах

боломжийг нь хангаж өгөөд санхүүжилт олгож байгаа.

Энэ төв маань сэргээн засах төв гэсэн статустай байгаа учраас би заавал Эрүүл мэндийн яамны харьяанд байх шаардлага байхгүй болов уу гэж үзэж байгаа.

Харин тэр үйл ажиллагааных нь урсгал зардлыг хэвийн хэмжээнд явах асуудлыг шийдээд өгөх юм бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллынхаа сайдын эрхлэх асуудлын хүрээндээ. Гэхдээ Эрүүл мэндийн даатгалын газартай гэрээ байгуулаад гүйцэтгэлээр санхүүжилт аваад явахад бүрэн боломжтой гэсэн. Би бол ийм бодолтой байгаа.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн тодруулж асууна.

П.Анужин: С.Чинзориг сайдад талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоноос хойш өчнөөн л асуулт асууж байлаа. Өчнөөн л хариулт сонсож байлаа.

Тэгэхдээ яг ийм ард иргэдийн өмнө тулгамдаад байгаа асуудалд эдийн засгийн гаргалгаагаар гаргачихсан ийм хууль өргөн барих гэж байна. Одоо ингээд хэрэгжих юм гэсэн ийм бодитой хариулт сонсож байгаагүй.

Тэгэхээр улс орондоо эмчилж чадахгүй байгаа өвчнүүдийг эмчлүүлэх тал дээр Тусгай сангийн тухай хуулийг нь боловсруулж удахгүй оруулж ирж энэ асуудал бас хөнгөрч ард иргэдийн нуруун дээр байгаа гадагшаа явдаг эмнэлгийн урсгал саарна гэдэг үнэхээр бодитой хариулт байна.

Тэгээд хуулиа хурдан засагтаа өргөн барьж, Их Хурлаар хурдан оруулж ирэхийг танд хүсэж байна.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ оройн амгаланг айлтгая.

2024 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг бид батлах гээд хэлэлцэж байна.

Ер нь бид хөгжлийн төлөвлөгөөг батлахдаа бодит биеллээ олох асуудлуудыг оруулж ирдэг байх гэж би боддог. Гэхдээ биеллээ олдоггүй ийм зүйлүүд яваад байдаг.

Сая П.Анужин гишүүн ярилаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн асуудал.

Тодорхой хэмжээнд шийдэх асуудлууд байгаа. Засаг дээр бас яригдаж байгаа гэдэг ийм зүйл байгаа.

Зүгээр энд бас ажиллах боловсон хүчний асуудал учир дутагдалтай байдаг.

Зүгээр эцэг, эхчүүдийг сургах асуудлыг Л.Энх-Амгалан сайд маань шийдээд төлбөрийн асуудлыг шийдээд явж байгаа.

Гэтэл төрийн бус байгууллагууд маань ажиллах боломжтой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд байгаа. Үүнтэйгээ хамтрах энэ боломж нь ер нь хэр байдаг юм бол оо. Х.Булгантуяа сайд аа.

Тэгээд энэ дээр нэг тайлбар авъя.

Ер нь дутуу орхигдсон барилгагүй байшингуудаа дуусгая гэдэг төлөвлөгөөг жилийн жилд бид гаргадаг.

Би жилийн жилд Геронтологийн үндэсний төвийн барилгаа нэхдэг байгаа.

Тэгээд энэ жил 36 ортой эмнэлгийн барилга дээр оруулья гэдэг ийм асуудал шийдэгдсэн. Гэхдээ одоо болтол ороогүй л байгаа. Энэ асуудлыг ер нь шийдвэрлэх боломж байдаггүй юм уу? Татвар төлөгчдийн мөнгө байдаг.

Тэр 6.8 тэрбум төгрөг хаягдчихаад орхигдоод байгаа. Шүүхийн асуудал дээр шийдвэрлэгдэнэ гээд л орхигдчихдог. Энэ бол бас бидний олон жил ярьж байгаа асуудал. Үүнийг хэрхэн яаж шийдвэрлэх гэж байна вэ гэдэг зүйлийг тодруулья.

3.2.4 дээр нийгмийн халамжийн системийг шинэчлэн халамж зайлшгүй хүртэх зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, халамжийг зөвхөн тусгайлсан картаар олгоно гэдэг ийм заалт байна.

Статистикийн тооцоололдоо тодорхой шинэчлэлийг хийх шаардлагатай гэдгийг өнөөдөр маргаан үүсгээд байгаа хүүхдийн мөнгөний асуудал, Хүний эрхийн Үндэсний Комиссын 2022 оны тайланд ч гэсэн бас харуулсан. Тоон мэдээлэл дандаа зөрдөг гэж.

Тэгвэл нөгөө хүнээ тоолж чаддаггүй бид чинь ер нь энэ дээр тусгайлсан картыг олгох нийгмийн зорилт бүлгээ олж тодорхойлох тэр боломж нь ер нь хэр байгаа юм бэ?

Энэ дээр өөрчлөлт шинэчлэлт хийх энэ ажил ер нь ямар шатдаа явж байгаа юм бэ?

5.1.3 дээр нэмэгдсэн өртгийн албан татварын системд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хянах, бүртгэх, цахим системийг бий болгож, улмаар дэмжлэгийг оновчтой болгоно гэсэн байна.

Их наядын хөтөлбөр батлагдсан.

Гэтэл өнөөдөр нөөцийн мах ямар хэмжээнд байгаа билээ. Үнийн хөөрөгдөл маш дээд цэгтээ хүрсэн.

Бид үнийн судалгаа хийгээд явлаа гээд бас элдвээр хэлүүлсэн. Гэтэл энэ асуудал бодитой биелэлээ олж хүрэх ёстой хүмүүстээ хүрэхгүй байгаа нь өнөөдрийг хүртэл шүүмжлэлийг дагуулсаар байгаа.

Стратегийн гол хүнсний бүтээгдэхүүн болох мах, сүү, гурилдаа бид тодорхой хэмжээний бодлоготой байвал яадаг юм бэ.

Үнэхээр дэмжлэг нь энэ гурван стратегийн гол хүнсний бүтээгдэхүүнүүддээ хүрдэг юм уу, үгүй юу гэдэг асуулт байсаар байдаг.

Яг дээр бодлого байгаа юу?

2.4 дээр соёлын салбарын хөгжил байгаа. Бүтээл байгаа. Бид соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хуулиа хүлээсээр байгаа. Засгийн газар өргөн барьсан боловч хэлэлцэгдээгүй байна.

Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна гээд заасан байна.

У.Хүрэлсүх Ерөнхийлөгч Ерөнхий сайд байх үедээ л Байгалийн түүхийн музейн ажлыг эхлүүлсэн. Өнөөдрийг хүртэл бас байхгүй.

Геронтологийн үндэсний түвшинд тэр арматур нь ашиглагдах боломжгүй болчих вий дээ гээд л би жил болгон яг төсөв яригдах дээр л нэхдэг.

Ингээд бодит биелэлээ олохгүй хөгжлийн төлөвлөгөөнүүд бид батлаад байх уу, үгүй юу гэдэг дээр л би асуух гээд байгаа юм.

Яаж биелдэг болох вэ? Яаж бид төсвөө зөв зарцуулдаг болох вэ? Энэ дээр нэг тайлбар авъя.

Түрүүн гэр хорооллын дахин төлөвлөлт гээд М.Оюунчимэг гишүүн бас ярьсан. Хариултыг авсан гэж ойлгож байгаа. Тэгвэл ашиглах боломжгүй орон сууцнууд байна.

Зөвхөн Сонгинохайрхан дүүрэгт манай тойрогт л гэхэд 360 гаруй, 400 гаруй өрх ийм ашиглах боломжгүй амбаарт амьдарч байгаа. Тэр нь үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй.

Бид төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиа баталчихсан. Яагаад төр, хувь хувийн хэвшлийн түншлэлээрээ энэ айлуудын орон сууцын асуудлыг шийдвэрлэж болдоггүй юм бол.

Дэд бүтэц байхгүй гэж ярьдаг. Ачааллаа цахилгаан станцуудад нь даахгүй гэж ярьдаг. Тэгвэл тэр нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Геронтологийн төвийн барилга гээд урт настай удаан жаргалтай ийм нэг барилга байгаа юм билээ.

2011 онд уг нь энэ Геронтологийн төвийн барилгыг барина гээд улсын төсөв дээр хөрөнгө мөнгө нь тусгагдаад явсан. Төсөв нь багтахгүй байна гэдэг шалтгаанаар олон жил төсвийн нэмэлт хийсэн юм байна лээ.

Хамгийн сүүлд одоогийн байдлаар энэ барилгын төсөв 17 тэрбум төгрөг болчихоод ингээд гацчихсан.

Хоёрдугаарт, одоо баригдсан байгаа барилга нь 6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарчихсан байгаа юм байна лээ. 6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан. Гэхдээ одоо баригдсан байгаа барилгыг гүйцэж бариад ашиглалтад оруулна гэх тийм чанарын баталгаа хангах, шаардлага хангахгүй байна гэдэг асуудал үүсээд энэ барилга үндсэндээ зогсчихсон байгаа.

Одоо бид энэ барилгын гүйцэтгэгчийг нь хууль хяналтын байгууллагууд өгөөд шалгуулдаг. Тэгээд тэр гүйцэтгэгч байгууллага нь заргалддаг юм билээ.

Хоёр удаа шүүхээс гүйцэтгэгч байгууллагын талд нь шүүхийн шийдвэр гараад гүйцэтгэгч байгууллагаар нь дахин тогтоосон байдаг.

Тэгээд би сая сайдаар томилогдоод дахиад энэ барилгынтай холбоотой асуудал, гүйцэтгэгчтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллага шалгаж өгөөч ээ гээд ингээд Авлигатай тэмцэх газарт бүх материалыг нь шилжүүлээд шалгуулах ингээд үйл ажиллагаа явагдаж байгаа.

Одоо бид ямар арга хэрэглэх гээд байна вэ гэхээр одоо оны 7 сард ашиглалтад яг тэр Геронтологийн барилгыг барьж байгаа барилгын тэнд нь энэ 7 сард ашиглалтад орох 36 ортой сэргээн засах төвийн барилгын

зориулалтаар баригдаж байгаа барилга одоо ингээд 7 сард ашиглалтад орно.

Тэгээд Геронтологийн барилгын одоогийн байгаа барилга нь үйл ажиллагаа явуулах шаардлага хангахгүй гэж мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарчихсан байгаа учраас бид одоо тэр хуучин барилгыг гүйцээж барина гэдэг төсөв нь ч дийлдэхгүй юм байна лээ.

Хоёрдугаарт, чанарын шаардлага хангахгүй гэгчихсэн асуудал байгаа учраас тэр барилгыг гүйцээж барих асуудал байхгүй.

Тэгээд одоо энэ оны 7 сард ашиглалтад орох тэр 36 ортой Сэргээн засах төвийн барилгад Геронтологийн төвийг оруулья гэсэн ийм л байдалтай байна.

Тэгээд цаашдаа тэр 6 тэрбум төгрөг газарт булчихсан асуудал байгаа.

Тэгээд тэр барилгыг нь тэгээд яах юм. Цааш нь нураах юм уу, одоо тийм байдал руу л орох байх.

Тэгээд энэ барилгын асуудал, гүйцэтгэгчтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулах гээд бид дахин дахин олон удаа өгсөн юм байна лээ. Өмнөх сайдууд.

Хоёр ч удаа өгсөн байдаг. Тэгээд шүүх дээр яагаад тэгдэг юм. Шүүх дээр гүйцэтгэгчийн талд нь асуудал шийдэгдээд тэгээд энэ барилгыг барина гээд төсвийн тодотголд оруулаад төсвийг нь нэмүүлээд яваад байдаг. Одоо бол бид үүнийг дахиж барих тухай асуудал, төсвийг нь нэмэх асуудал ерөөсөө боломжгүй юм байна гээд ингээд орхиж байгаа.

Тэгээд энэ оны 7 сард ашиглалтад орох тэр 36 ортой сэргээн засах төвийн зориулалтаар баригдаж байгаа барилгад л Геронтологийн төвийг оруулахаас өөр арга боломж байхгүй байна гэсэн л байдалтай байгаа. Б.Жаргалмаа гишүүн ээ.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулья.

Х.Булгантуяа: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

Хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг төрийн бус байгууллагууд дээр гүйцэтгүүлж болох уу гээд.

Яах вэ бид энэ дээр олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гээд үүнийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж байгаа. Төрийн бус байгууллагууд нь итгэмжлэгдсэн байх ёстой гээд бас гүйцэтгүүлэх үйлчилгээний жагсаалт хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд бас байдаг юм байна лээ. Үүнийг бид ер нь төрөөс илүүтэйгээр төрийн бус байгууллагууд, мэргэжлийн төрийн бус байгууллагууд улам нэмэгдэж байгаа.

Тэгэхээр гүйцэтгүүлээд явах нь зөв зүйтэй юм гэж үзэж байгаа.

Энэ 3.2.2-т үр дүнд суурилсан нийгмийн нэгдсэн тогтолцоог бүрэн нэвтрүүлээд, энэ халамжийн үйлчилгээг шинэчлээд халамж зайлшгүй шаардлагатай эсэхэд нь оновчтой тодорхойлж, халамжийг зөвхөн тусгайлсан картаар олгоно гээд.

Энэ хүнсний талоныг Төрийн банкны картыг ашигладаг байгаа. Тэгээд өөрөөр хэлбэл тэр карт нь зөвхөн

хүнсний талоны мөнгө ороод буцаагаад яг картаа уншуулаад 10 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг худалдаж авах боломжтой.

Энэ нь бусад төрлийн архи пиво ч гэдэг юм уу, ийм хүнсний бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулахгүй байх зориулалттайгаар хийж байгаа.

Иргэд, олон нийтээс ялангуяа хүүхдийн мөнгийг ч гэсэндээ үүнтэй адилхан зориулалтыг нь зааж өгөөд хүүхэд хөгжил, мөн зохистой хүнсний хэрэглээнд зарцуулах байдлаар, хүсэх юм бол мэдээж хуримтлал үүсэх байдлаар хийх нь зүйтэй юм биш үү гээд. Энэ дээр бид судалгаа хийгээд яг үүнтэй адилхан яг картаар олгож болох юм гэж үзэж энд оруулсан байгаа.

Ийм хэдэн асуулт байсан. Тийм ээ. Б.Жаргалмаа гишүүн.

Хүн амын тоо статистик мэдээлэл дээр. Бидний авч ашиглаж байгаа тоо бас л гүйцэтгэлийн хувьд дандаа л Статистикийн ерөнхий газраас авч байгаа тоо.

Гэхдээ зарим тохиолдолд ялангуяа энэ статистикийн тоонууд манай тоонууд зөрүүтэй тоонууд байгаад байгаа. Тэгээд үүнийг саяын хүүхдийн мөнгөтэй холбоотой ч гэсэн Төрийн мэдээлэл дээр байгаа мэдээлэл зөв, буруу байна гэсэн асуудлууд байгаа. Үүнийг бид сайн хянаж шалгаж үзэж тоон мэдээллүүдийг нэгтгэх шалгах асуудал байгаа.

Түрүүн халамжтай холбоотой асуулт асууж байсан. Ч.Ундрам гишүүн асууж байсан.

2023 оны хувьд халамж нэмэгдсэн байна гэдэг нь бид нар нөгөө 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр.

Бид энэ дээр оруулж өгсөн байгаа. Хүүхдийн мөнгийг бид хүн амын 100 хувьд бүх хүүхдүүдэд олгоно гэдэг утгаар хүүхдийн мөнгийг нэмэгдүүлж тооцсон нь хүүхдийн мөнгө нөгөө халамж гэж олгогдож байгаа учраас төсвийн зарлага дээр туссан байдал нь халамжаас гэж байгаа учраас энэ бас нэмэгдэж орж ирж 100 хувь гэж олгож байгаа учраас нэмэгдсэн байж байгаа.

Энэ жил гэхэд 160 орчим тэрбум төгрөг хасагдсан байдлаар хүүхдийн мөнгө 9 хувиас хасаж тооцсон.

Төсвийн тодотголоор үүнийг нэмж тооцохоор бид саналыг хүргүүлж байгаа. Соёлын яам уу? Соёлын дэд сайд М.Батбаяр.

М.Батбаяр: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья. Соёлын дэд сайд М.Батбаяр байна.

Тэгэхээр соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэж хөтөлбөрт туссан байгаа.

Тэгэхээр бид 2018 оноос соёлын салбарт Монгол Улсын Засгийн газраас, Монголын төрөөс тодорхой хэмжээний том хэмжээний хөрөнгө оруулалтуудыг хийсний үр дүнгүүд гарч эхэлж байна.

Чингис хаан музейг 2022 оны 10 дугаар сард ашиглалтад орсноос хойш эдүгээ 7 сарын хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд нийтдээ 138 мянган хүн үйлчлүүлсэн байна.

Сардаа 23 мянган хүн үйлчлүүлж байгаа. 138 мянган хүн үйлчлүүлж байгаагаас 60 хувь нь хүүхэд байгаа.

Энэ бол бид эдийн засгийн эргэлтэд оруулахаас гадна хүмүүсийнхээ

оюун санааны хөгжилд, ялангуяа хүүхдийн хөгжилд маш том чухал нөлөө үзүүлж байна гэж ойлгож болно.

Тэгээд Байгалийн түүхийн музейг мөн эдүгээ 8, 9 дэх удаагийн тендер зарлагдсан байгаа.

Бид шалтгааныг олсон. Юу вэ гэхээр 94 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байсан. Энэ дээр орж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд үнэхээрийн төсөв зардал нь хүрэхгүй байсан.

Ингээд 2023 оны улсын төсөв дээр 138.4 тэрбум төгрөг болж туссанаар тендер нь зарлагдаад одоогийн байдлаар 2 байгууллага оролцсон. Үнэлгээ хийгдэж байна. Бид эергээр харж байгаа. Ингээд удахгүй шалгарч дараагийн Байгалийн түүхийн музей гэх энэ музейний хувьд олон улсад яаж ашиглагддаг вэ гэхээр үнэхээрийн гэр бүлээрээ цагаа өнгөрүүлдэг хамгийн дурсамжит ийм газар болж төлөвшиж байгаа.

Тийм учраас Монголын оюуны салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт болно гэдэгт бид эргэлзэхгүй байгаа.

Г.Занданшатар: Б.Жаргалмаа гишүүн тодруулья. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Ер нь хууль байдаг байх л даа. Тендерийг тэдэн удаа зарлаад хүчингүй болгох юм бол тэгнэ ээ гэдэг.

Тэгээд уг нь тэр хуулиа дагаад явмаар байгаа юм. 9 удаа тендер зарлана гэдэг бол арай л гомдолтой.

Тэгээд тэр Их тэнгэрийн аманд байгаа тэр арматур ашиглагдахгүй болоод байна. Геронтологийн түүх шиг

болчих вий гэдэг эмзэглэл маш ихээр байгаа шүү. Энэ дээр анхаарна биз.

Ер нь сая Чингис хааны музей ашиглалтад орсон. Орсон. Үр дүнгээ өгч байгаа эдийн засгийн ач холбогдол өндөр байгаа.

Яг түүний нэгэн адилаар ингэж үр дүнтэй ашиглаач ээ л гэдэг шаардлагыг тавиад байгаа.

Тэр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуультай болсон.

Ч.Хүрэлбаатар сайд аа. Яг үүгээрээ бид ашиглагдахгүй барилгуудаа хувийн хэвшилдээ өгөөд хийж болдоггүй юм уу? Магадгүй Байгалийн түүхийн музейгээ хувийн хэвшилд нь өгөөд. Тийм ээ. Ажиллуулчхаж болдоггүй юм уу? Бид хуультай болчихсон шүү дээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Б.Анар. Ажлын хэсгийн 85.

Б.Анар: Эдийн засаг, хөгжлийн яам Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар.

Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 07 сарын 01-нээс хэрэгжиж эхлэхээр бэлтгэл ажлыг Эдийн засгийн яамны зүгээс хангаад ажиллаад явж байгаа.

Яг манай яамны хариуцан батлуулах нийтдээ 9 журам байгаа юм. Энэ журам боловсруулагдаад 6 сардаа Засгийн газраар батлагдана гэсэн хүлээлттэй. Одоо яамдаас санал авсан байдалтай байгаа.

Яг хуулийнхаа дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв гэдэг шинэ төвөөрөө дамжаад...

Г.Занданшатар: Хариултыг 2 минут болгочих. Энэ хугацаа нь дуусах гээд байна.

Б.Анар: Тэр төвөөрөө дамжаад энэ төслүүдийн бүх бүрэн шинжилгээ хийгдэх ёстой.

Энэ бүрэн шинжилгээрээ хийгдээд ашигтай, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гээд шинжилгээний дүгнэлт гарах юм бол тухайн төслийг хэрэгжүүлэх ийм боломж бүрдэхээр байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би жоохон шүүмжлэлтэй хандана.

Тэгээд авах гээхийн ухаанаар уучилна биз дээ. Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа.

Гэтэл Засгийн газрын гишүүдийн хэд нь байна, хэд нь байхгүй байна гээд. Уг нь зүй ёсоор сайд нар, давхар дээлтэй сайд нар бүгд суугаад ирэх жил манай салбарт ийм ийм юм хийнэ, ийм бодлогыг барьж ажиллана гээд уралдаад гишүүдийн асуултад хариулж байх ёстой.

Гэтэл ганц хоёр сайд л асуултад хариулж байх жишээтэй.

Тэр гол сайд нар Барилга, хот байгуулалтын яам, тэр Зам, тээврийн яам, тэр Уул уурхай, эрчим хүчний сайд нар чинь хаачсан юм. Байгаль орчны сайд нар чинь хаачсан юм.

Тэгээд хэнээс асуух юм. Шадар сайд чинь бүгдийг нь мэдэхгүй шүү дээ.

Тэгээд ийм хариуцлагагүй, хяналтгүй ийм байгаа учраас.

Ард түмэн чинь яагаад Их Хурал, Засгийн газрын гишүүдийг шүүмжлээд, уурлаад, бухимдаад байгаа учир шалтгаан чинь ерөөсөө энэ шүү дээ. Хуралдаа суудаггүй, чуулгандаа ирдэггүй, би үгээ хэлсэн бол болоо гээд гараад явчихдаг.

Хэдий болтол ийм байх юм. Ийм учраас ард түмний итгэл чинь Их Хурал, төр засгийн бодлого, үйл ажиллагаанд итгэх итгэл чинь алдраад байгаа нь энэ.

Нэг их том юмнаас биш. Ийм жижиг юмнаас л итгэл алдраад байна шүү дээ. 152-ыг чинь яагаад дэмжихгүй байгаа гэхээр одоо байгаа 76 чинь ийм хариуцлагагүй байгаа учраас ард түмэн чинь 152 болохыг эсэргүүцээд дургүйцээд байна шүү дээ.

Хариуцлагатай байсан бол ингэхгүй шүү дээ. Ахиад 76 хариуцлагагүй хүн нэмэгдэх гэж байна гэж ингэж шүүмжлээд байгаа байхгүй юу.

Тийм учраас цаашдаа Монгол Улсын бүтэн жилийн хөгжлийн төлөвлөгөө юунд анхаарлаа хандуулах гэж байгаа юм. Татвар төлөгчдийн мөнгийг юунд хуваарилж зарцуулах гэж байгаа юм. Ийм асуудал ярьж байхад ийм хариуцлагагүй байдлаар ингэж ярьж байгаа бол үнэхээр хангалтгүй байна.

Энэ дээрээ дүгнэлт хийгээч ээ, сайд нар аа, гишүүд ээ.

Тэгээд нэг ярьсан болоод, хэлбэрдэж ирсээр 30 жил ингэж явсан

учраас энэ бодлого төлөвлөгөөнүүд чинь хэрэгждэггүй цаасан дээр үлдчихээд байгаа шүү дээ.

Гоё гоё өгүүлбэрүүд байна. Би энэ цаасны ар дээр болдогсон бол **“Их Хурлын гишүүдийг чуулгандаа суулгадаг болгоно, хурал чуулгандаа ирдэг болгоно, ажлаа тасалдаггүй болгоно”** гэж оруулмаар байна.

Ийм юмнаас эхэлмээр байна. **“Хулгай зэлгий хийдэггүй болгомоор байна”** гэж бичмээр байна.

Түүнээс гоё сайхан өгүүлбэрүүд, эдийн засгийн ингэж өсгөнө, үржүүлнэ гэж. Мэдээж байх ёстой асуудлууд.

Ийм ёс зүйгүй, хариуцлагагүй байдал чинь газар авсан учраас, асуудлыг ингэж хариуцлагагүй халтуурдаг учраас ард иргэд чинь төр засагт уурлаад бухимдаад байгаа нь энэ шүү дээ.

Би аялал жуулчлалын салбараас юм асуумаар байна. Бас сайд нь байхгүй юм.

2024 онд 1.3 сая жуулчныг авна гэсэн байх юм. Уг нь аль болгон уул уурхайгаа ухах вэ. Өөр мөнгө олох бололцоо боломж нь аялал жуулчлал юм шиг байгаа юм.

1.3 саяд хүрэх бололцоо боломж нь юу байгаа юм? Хэр бодитой юм? Энэ жил хэдийг авах гэж байгаа юм? Хэрхэн яаж төлөвлөсөн юм? Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээрээ хүрэх бололцоо боломж байна уу, үгүй юу гэдгийг.

Нөгөө талаар Байгаль орчны сайдын гаргасан шийдвэр 6 сарын 01-нээс хэрэгжиж байгаа юм билээ.

Налайх дүүргийн Тэрэлж, Горхийн амралт цогцолбор газар.

Налайх дүүргийн иргэн нэг хорооноос нөгөө хороонд шилжихэд тэр Горхи, Тэрэлжийн гүүрийн пост дээрээс хүн болгоноос мөнгө авна гэсэн ийм шийдвэр гаргачихсан байна.

Үүнийг чинь сая очоод иргэдтэй уулзахад асар ихээр шүүмжилж байна. Амьдралд нийцэхгүй шийдвэр гаргадгийн нэг тод жишээ нь энэ.

Үүнийгээ та бүхэн эргэж хараач. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нэг дүүргийн иргэн нэг хорооноосоо нөгөө хороон дээр очихдоо машинаас 9 мянга, хүний 3 мянган төгрөг төлөөд явж байна гэж юу байдаг юм бэ?

Ийм амьдралгүй шийдвэр гаргачхаад үүнийгээ 6 сарын 01-нээс хэрэгжүүлнэ гээд явж байгаа.

Үүнийгээ та бүхэн тайлбарлаж өгөөч.

Г.Занданшатар: Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар хариулья.

Ч.Хүрэлбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний хэлсэн авах гээхийн ухаанаар хандана уу гээд үг хэлж байна.

Тэгээд гээх юм алга. Хэлж байгаа саналуудыг бүгдийг нь авах л юмнуудыг ярилаа.

Монгол Улсын цаашдаа хөгжил ер нь яаж явах вэ гэхээр хэд хэдэн салбарыг онцолж анхаарч байгаа.

Нэгдүгээрт нь, **уул уурхай**.

Хоёрдугаарт нь, **хөдөө аж ахуй**.

Тэгээд гурав дахь нь, **аялал жуулчлал**.

Тэгээд бүгд дээр боловсруулалтын түвшинг нэмэгдүүлээд явчих юм бол энэ гурван салбар дээрээс эдийн засгийн өсөлтүүд нэлээд гарна гэж үзэж байгаа.

Ингээд энэ оныг оруулаад ирэх хоёр жилийг аялал жуулчлалыг дэмжих жил гэж үзэж нэлээдгүй арга хэмжээнүүдийг Засгийн газрын зүгээс авч байгаа.

2024 онд 1.3 сая жуулчныг авна гэж үзэж байгаа. Энэ ондоо бид 1 саяыг авна гэж төлөвлөж байна. Эхний 4 сарын байдлаар 140 мянган жуулчныг авсан байгаа.

Тэгээд 140 мянган жуулчнаа үзэхээр 75 хувь нь визгүй орноос ирсэн байгаа. 75 хувь нь визгүй. 21.9 хувь нь визтэй орноос.

Эндээс үзэхэд л виз гэдэг зүйлийг бид хэчнээн багасгаж чадаад л хүн орж ирэхэд нь чөлөөтэй болгоод л байх юм бол боломж байна гэж үзэж байгаа.

Дээр нь хил боомтуудын ажлууд нэлээд явагдаж байгаа. Гэхдээ бүрэн дуусаагүй байгаа. Үүнийгээ нэлээд чөлөөтэй болгоод эхлэх юм бол энэ аялал жуулчлалыг нэмчих бүрэн боломжтой юм байна лээ.

Би зүгээр энэ дээр нэг зүйл хэлье. Тойргоо ярилаа гэж битгий шүүмжилцгээгээрэй.

Увс аймгийн хойно байдаг Боршоо гээд боомт байдаг. Нэг их том боомт биш. Тэгсэн мөртлөө одоо яг орж ирж байгаа жуулчныхаа хэмжээгээр Монголдоо гуравт орчхож байгаа юм.

Тэгэхээр жижигхэн газар байна шүү дээ. Баруун хязгаар.

Тэгэхээр боомтын хөгжил дэвшил, тэгээд хилээр чөлөөтэй байх энэ зүйл нь өөрөө эргээд аялал жуулчлалд нэлээд их боломж оруулж ирэх болов уу гэж бодож байгаа гэдгийг хэлье.

Тэгээд цаашдаа бид хөрш орнуудынхаа жуулчдыг яаж сайн татах вэ гэдэг юмаа сайн бодож тэрийгээ нэмэгдүүлж чадвал 1 сая гэдэг боломжийн тоо. 1.3 сая ч гэсэн боломжийн тоо гэж үзэж байгаа гэдгийг хэлье.

Байгаль орчинтой холбоотой хүн нь байгаа юм билээ. Ажлын хэсгийн 86 дугаар микрофон дээрээс хариулъя.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн 86. Сайд чинь хаачсан юм?

С.Цогтгэрэл: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Сая Ч.Хүрэлбаатар сайдын хариулсан дээр нэмээд хариулахад энэ жил 1 сая жуулчин хүлээж авах зорилт тавьсан.

Хөгжлийн төлөвлөгөөнд 1.3 сая жуулчин ирэх жил хүлээж авна гэж зорилтыг тавьсан.

Өнөөдрийн байдлаар бидний зорилт 168 мянга 386 жуулчин хүлээж авна гэсэн ийм зорилттой 5 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар, өчигдрийн байдлаар.

Энэ нь яг гүйцэтгэлээрээ 161 мянга 230 жуулчин Монгол Улсад орж ирсэн байна. Энэ бол тавьсан зорилтын 95.75 хувийг хангаж байна.

Одоо яг Монгол Улсад жуулчны улирал эхэлж байна.

Тэгэхээр бид 1 сая жуулчин хүлээж авах зорилттой энэ жилд хүрэхэд боломжтой гэж үзэж байгаа.

Хоёр дахь асуулт, 6 дугаар сарын 01-нээс эхлээд мөрдөгдөж эхлэх гэж байгаа Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолборт газар луу нэвтрэхэд хураах хураамжийн тухай асуултыг асууж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар тусгай хамгаалалттай газар нутгууд руу нэвтрэхэд хураамжийг авахаар заасан байдаг.

Энэ бол 2001 оноос хойш мөрдөгдөж эхэлсэн. Огт өөрчлөгдөөгүй 22 жил мөрдөгдсөн хураамжийн хэмжээг энэ жил өөрчилсөн.

Тэр өмнөх хураамжаар иргэн 300 төгрөг төлөөд тусгай хамгаалалттай газар нутаг руу нэвтрэдэг байсан. Энэ нь тус зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд нийцээгүй ийм зүйл байсан.

Тэгээд өөрөөр хэлэх юм бол тэр 300 төгрөгийг хураах гэж ажиллаж байгаа ажилтан, тасалбарыг хэвлэх зардал нь тэр 300 төгрөгөөсөө хэтрээд байсан.

Тэгээд өнөөдрийн нөхцөл байдалд нь нийцүүлээд тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийг нэмэгдүүлсэн. Энэ бол зөвхөн Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт биш Монгол Улсад байгаа бүх тусгай

хамгаалалттай газар нутгуудад нэгэн адил мөрдөгдөх хураамжийн хэмжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хэмжээнд тогтоосон байгаа.

Гэхдээ тухайн тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч байгаа нутгийн иргэдэд үүнийг өөр байдлаар тогтоох шаардлага байгаа.

Тэгэхдээ үүнийг бид иргэдэд үйлчлэхгүй байхаар шийдвэрийг хийгээд явна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хөдөө орон нутагт томилолттой байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Наад шийдвэрээ тэгээд эргэж харах юм байна.

Нутгийн иргэдэд арай ингэхгүй байлгүй дээ гэж бодож байгаа.

Би Х.Булгантуяа сайдаас асуух гэж байгаа юм. Танай халамжаар хэрэгждэг ажлын байр нэмэгдүүлэх зээлийнхээ энэ бодлого юмыг цаашдаа яаж өөрчлөх гэж байгаа юм бэ?

Өнөөдрийн байдлаар яг зээлийн бодлого чинь яваад 30 жил боллоо. Ажлын байраар дэмжсэн энэ тэр юм үр дүнд хүрч байгаа зүйл алга. Хүртээмж багатай.

Тийм учраас зээлийн бодлогоо үр дүнд хүргэхийн тулд яавал жинхэнэ бодит утгаараа эзэндээ хүрэх юм бэ гэж.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгож байгаа зээл нь

эзэндээ хүрэхгүй. Дээгүүр нь том компаниуд нь авчихдаг. Хөрөнгөтэй, мөнгөтэй компаниуд нь авчихдаг.

Бага компаниуд нь жижиг, дунд бизнес эрхлэх гээд байгаа нөхдүүд нь болохоор авч чаддаггүй. Босгыг нь давж чаддаггүй.

Н.Учрал сайдаас цахим төрийн бүтээмжийн хүрээнд шилэн ажиллагаагаа цаашдаа хэрхэн яаж үргэлжлүүлэх гэж байна?

Ард иргэдэд маш сайн хүрч байгаа, мэдээлэл өгч байгаа салбар бол танай салбар.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд.

Х.Булгантуяа: Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа асуудал үнэн.

Ялангуяа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хоёр л эх үүсвэрээс ерөнхийдөө бүрддэг юм.

Гадаадаас ажиллах хүчээ авч байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нугалж энэ санд төвлөрүүлдэг.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж чадаагүй аж ахуйн нэгжүүдээс бас төвлөрүүлдэг.

2023 онд гэхэд 92.4 тэрбум төгрөг төвлөрнө гээд зарцуулахаар төлөвлөчихсөн. Зарим зарцуулалтууд нь аль хэдийн хийгдчихсэн байна лээ.

Би энэ жил үнэнийг хэлэхэд манай дээр хөдөлмөрийн зах зээлийн томоохон хэмжээний судалгаа төдийлөн сайн байхгүй байна. Бараг хамгийн сүүлийнх

нь судалгаа нь 2014, 2015 онд гарсан юм билээ.

Сая Ерөнхий сайд, Монголын Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн холбоотой уулзаад нийгмийн гурван талт хэлцлийг хийх дээр ялангуяа хөдөлмөрийн зах зээлийн нэлээн томоохон судалгаа хийе. Өмнөговь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Х.Булгантуяа сайд гүйцээж хариулъя.

Х.Булгантуяа: Тэгээд энэ судалгаандаа үндэслээд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжил сургалт үйлдвэр лүү олгодог бидний санхүүжилт төрөөс боловсрол, хөдөлмөр эрхлэлт рүү чиглэсэн бүх бодлогыг ер нь чиглүүлэх нь зүйтэй юм байна гэсэн саналтай байгаа.

Тэгээд энэ судалгааг бид Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, хувийн хэвшилтэй ер нь хамтран хийе гэдэг саналтай байгаа.

Тэгээд одоогоор энэ яг л дэмжих үйлчилгээ, тэгээд санхүүгийн дэмжлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих түр ажлын байр, эмэгтэйчүүдийн ажлын байр гээд л 2023 оны бодлого ерөнхийдөө яг ийм л байдлаар санхүүжилт нь гарахаар төлөвлөлт нь хийгдээд зарим санхүүжилт нь аль хэдийн гарчихсан явж байгаа юм билээ. Яг л хуучин байдлаар.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: “Shilen.gov.mn” сайт 3 дугаар сарын 27-ны өдөр мэдээлэл хариуцагч нарын мэдээллийг нэгтгэж эхэлсэн цаг үеэс хойш 1 сая 472 мянган

удаагийн хандалт хийгдээд, одоо 57 мянга 123 мөр өгөгдлийг мэдээллийн санд оруулаад байна.

Тэгээд өнгөрсөн хугацаанд 8 Засгийн газрын тусгай санг нээснээс хойш 600 гаруй сая төгрөгийн зээлийн эргэн төлөгдөлт хийгдсэн гээд нэлээдгүй дэвшлүүд гарсан.

Цаашдаа бид шилэн ажиллагааны хүрээнд энэ нэгдсэн платформ илүү “биг дата” буюу өгөгдлийг дахиад нээлттэй мэдээллийг эргэлтэд оруулах боломжоор нь хувийн хэвшлийг хангах чиглэл рүү хандуулья гэж байгаа.

Одоо хамгийн том баялаг бол өөрөө дата болсон. Тэгэхээр датаг ашиглаад хэрхэн бизнес эрхлэх вэ, датаг ашиглаад төр шийдвэр гаргахдаа хэрхэн ашиглах вэ гэдэг чиглэл рүү нь явна.

Г.Занданшатар: Н.Учрал сайд гүйцээж хариулъя. Ням-Осорын Учрал сайд.

Н.Учрал: Тэгэхээр датаг эргэлтэд оруулах чиглэлээр ажиллуулахаар зорьж байгаа.

Тийм учраас Ерөнхий сайдын албан даалгавар 6 дугаар сарын 01 хүртэл гарсан. Энэ хугацаанд мэдээллийг ил тод, нээлттэй болгосон байгууллагуудын мэдээллүүдийг бид Эй Пи Ай-аар нь хооронд нь холбоод **shilen.gov.mn**-ээр мэдээлж байгаа.

Тэгээд иргэд ч бай, сэтгүүлч нар ч бай, хувийн хэвшил ч бай, төрийн байгууллагууд ч бай бид машинд унших байдлаар олон нийтэд нээлттэй болгож байгаа өгөгдлүүд, мэдээллүүдийг ашиглаад шийдвэр гаргахад нь хамгийн бодитой үндэслэл болох бололцоотой гэж харж байгаа.

Энэ ч утгаараа шилэн ажиллагааны хүрээнд мэдээллүүдийг инновацад нэвтрүүлээд хэрхэн хялбаршуулах вэ гээд бие даасан tool системүүдийг хийсэн компаниудтай хүртэл нэлээдгүй ярилцаж байна.

Тэгэхээр хандлага өөрчлөгдөөд цаашдаа ил тод, нээлттэй нийгмийг бүтээж авлигалын төсөөллийн индексийг бууруулахад ч гэсэн тодорхой хувь нэмрээ оруулах байх.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Монгол Улс “Алсын хараа-2050” гээд урт хугацааны бодлогын бичиг баримттай болж түүний эхний арван жил энэ “Шинэ сэргэлтийн бодлого” гэдэг зүйлийг 2022 оны эхнээс авхуулаад ард иргэдэд ярьж хэлж танилцуулж ажилласан.

Энэ “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг өнөөдөр жилийн дараа очиход ард иргэд энэ “Шинэ сэргэлтийн бодлого”-оос чинь ямар ямар зүйлүүд явж байгаа вэ гэдэг дээр нэлээн тийм тайлбар, мэдээлэл хүсдэг болсон байна.

Би бол бүр багийн түвшинд ярьж байгаа учраас.

Энэ дотроос аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд ялангуяа хөдөө аж ахуйтай холбоотой түүхий эдийн үйлдвэрийн асуудал ер нь яг.

Яах вэ барина гэж орсон байна. Тэр битгий хэл хоёуланг нь барина гэсэн байна. Яг ямар түвшинд яваа юм бэ? Хэзээ баригдах юм бэ?

Дарханы хэрүүл ямар шатдаа явж байгаа юм. Төр, хувийн хэвшлийн асуудал.

Дээрээс нь Эмээлтийн асуудлыг би хальт сонсож байсан. Үүнийг малчид маш их хүлээж байна.

Өнөөдөр Монгол улс 20 сая арьс гаргаж байна. 10 саяыг нь боловсруулж байна гэж байгаа боловчиг би үүнд сайн итгэхгүй л байгаа. Гэхдээ л ямар ч байсан боловсруулах нь зүйтэй юм.

Хоёрдугаарт, малын махны экспортын асуудал тодорхой хэмжээнд сэргэж байна.

Хөдөө аж ахуйн яам тэнд байгаа зохиомол янз янзын хүндрэлүүдийг хөнгөвчилсөн ийм зүйлүүд хийж байна. Хөдөө аж ахуйн салбар дээр ялангуяа мал аж ахуйн салбар дээр үүссэн бэлчээрийн хомсдол, энэ олон зүйлийг давж гарахад мал, махны экспортын асуудал туйлын чухал байгаа юм.

Тэгэхээр мал, махны экспорт дээр бид дотоодын зах зээлээ хангалттай хангаад, гадаад руу гаргах, экспортод гаргах малын махны үнэ ханш дээр хүртэл ямар бодлого ер нь баримтлах юм бэ.

Энэ зүгээр зах зээлийнхээ зарчмаар яваг гэсэн байдлаар дотооддоо зарсан ч адилхан, гадаад руу зарсан ч адилхан түвшинд байх уу, үгүй юу?

Энэ бол 250 мянган малчин өрх. Цаашлаад ярих юм бол нэг айлын 3, 4 хүн гэж үзэх юм бол Монгол Улсын сая хүний орлоготой холбоотой асуудлыг би энд ярьж байгаа юм гэдгийг хэлье.

Энэ хоёр дээр хариулт авъя.

Дээрээс нь, аялал жуулчлалын асуудал маш эрчимтэй яригдаж байгаа. Энэ аялал жуулчлалын бүс нутгийн нэг нь манай Хэнтий аймаг.

Тэгээд Хэнтий аймаг төсөв янз бүрийн эх авдаг барьдаг гээд сүүлийн хэдэн жил нэлээн шүүмжлүүлээ. Гэхдээ энэ шүүмжлэлийн хариу би удахгүй гарах байх гэж бодож байгаа.

Хэнтий аймаг, Монгол улс руу аялал жуулчлалын томоохон шалтгаан эзэн Чингис хааны нутаг гэсэн Монгол Улс, тэр дотроо төрсөн нутаг гэсэн энэ том жуулчдын урсгал, монгол туургатан дэлхий нийтэд тархсан 7, 8 сая монгол туургатны очих ёстой, очихыг үргэлж хүсдэг ийм газруудын нэг байгаа юм.

Тэгэхээр одоо нөгөө үхрийн сүүлэн дээр хутга гэж одоо энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд дээр тэр Засгийн газрын шийдвэрийг бүр нэг дуусгаад тэнд жуулчин очиход дэд бүтцийн болон бусад асуудлуудыг дуусгах тал дээр 2024 он дээр төсөв тавьж бодлогынхоо чиглэлд оруулж өгөөрэй.

Ингээд дараа дараагийн бүсүүдээ хөгжүүлээд явах бүрэн бололцоо гарах байх.

Өчигдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Хэнтий аймагт очиж ажилласан. Энэ аялал жуулчлалын бүс нутгийн хөрөнгө оруулалтуудтай танилцаж ажилласан байгаа.

Аялал жуулчлалын энэ асуудлууд дээр Боршоо боомтоор маш их хүн орж ирж байна гэдэг шиг бид хил орчмын аялал жуулчлал, визийхээ асуудлыг шийдвэл Хэнтий аймаг Монгол Улс, тэр дундаа Хэнтий аймаг руу түүхэн аялал

жуулчлалын том зорилт 1 сая гэж өнөөдөр төлөвлөж байгаа жуулчны тоо цаашаа өсөхөд гол нөлөө үзүүлнэ гэж харж байгаа.

Тэгээд энэ дээр ямархуу төлөвлөгөө байгаа вэ? Энэ гурван асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Х.Болорчулуун сайд хаачсан юм.

Ер нь байна шүү дээ. Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа зөв шүү.

Энэ асуулт хариултауд дууссаны дараа энэ асуудлыг үг аваад хойшлуулна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд ч хариуцлагатай байх хэрэгтэй, сайд нар ч хариуцлагатай байх хэрэгтэй.

Ард түмний хэлж байгаа санал бодлыг чихний бөглөөгөө арилгаж сонсох хэрэгтэй. Энэ талаар маргаашийн Үндсэн хууль хэлэлцэхэд би зориуд гишүүдэд ч хандаж хэлнэ.

Дараагийн хэлэлцүүлэг дээр онцгой анхааруулна. Тийм.

Ингээд 93 хариулна. Х.Болорчулуун сайд байхгүй. Өнөөдөр. 93 хариул.

И.Батхүү: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн бодлогын газрын дарга И.Батхүү.

Мах, махан бүтээгдэхүүний экспорт ер нь үнэтэй холбоотой асуудал дээр Монгол Улсын хувьд хөдөө аж ахуй, уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр ойрын хугацаанд Засгийн газар

бодлогоо гаргаад авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ Засгийн газрын тогтоолоор шийдвэрлэсэн байгаа.

Үүний хүрээнд мах махан бүтээгдэхүүнтэй холбоотой, ер нь бусад бүтээгдэхүүнтэй холбоотой экспортыг хөнгөвчлөх, гадаад худалдааны цахим нэг цонхны системийг нэвтрүүлэх ажлыг 2024 онд багтааж хэрэгжүүлнэ.

2023 ондоо уул уурхайн бус экспортыг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, гаалийн үйлчилгээг хөнгөвчлөх асуудлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Монгол Улсын хувьд малын тоо толгой 71 сая толгой малтай гэж яригддаг. Үүнтэй харьцуулахад Шинэ Зеланд Улс 26 сая толгой малтай.

Гэхдээ экспортын хэмжээ, борлуулалтын орлого, малын зөвхөн мах гэлтгүй арьс шир, дайвар бүтээгдэхүүнийг экспортолж байгаа байдлаараа Шинэ Зеланд Улс маш өндөр амжилттай явж байгаа.

Шинэ Зеландын экспортын гол нэг зах зээл нь манай хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улс байдаг.

Өнөөгийн байдлаар Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хөрш зэргэлдээ давуу талаа бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс гадаадад экспорт гаргахтай холбоотой боловсруулах үйлдвэрүүдийг хөрөнгө оруулалт татах, стандартын түвшинд олон улсын худалдан авагч талын стандартад нийцүүлэх талаар бодлогын дэмжлэг гаргаж ажиллаж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: С.Цогтгэрэл.

С.Цогтгэрэл: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл.

Хоёр дахь асуултад хариулъя.

Хэнтий аймаг аялал жуулчлалын нэг бүс болон хөгжих бүрэн боломжтой. Монгол Улсад байгаль, түүх, соёлын дурсгал бүхий олон газрууд байгаа.

Тэгээд сая Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан.

Энэ хуулиар шинээр орж ирж байгаа зохицуулалт нь Монгол Улс улсын аялал жуулчлалын бүстэй байх боломжтой болсон.

Яг хууль батлагдсанаас хойш бид яг Монгол Улсад ямар ямар бүс нутгийг улсын аялал жуулчлалын бүс байх ёстой юм бэ, бүс болгох ёстой юм бэ гэдэг судалгааны ажлууд хийгдээд Засгийн газраар энэ бол улсын аялал жуулчлалын бүсийн хил заагийг тогтоох ёстой. Энэ ажил дээр бид ажиллаж байна.

Тэгээд Хэнтий аймаг түүхийн хувьд, байгалийн хувьд ч гэсэн аль аль талаараа аялал жуулчлалын нэг бүс болон хөгжих боломжтой газар.

Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 4.1.1.3-д тусгай бүсийн аялал жуулчлалын тусгай сонирхлын нөөц, байршлын давуу талд тулгуурлан байгуулах гэдэг ийм төсөл арга хэмжээ туссан байгаа.

Тэгэхээр энэ дээр улсын аялал жуулчлалын бүсүүдийг хөгжүүлээд явах бүрэн боломжтой.

Г.Занданшатар: Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Арьс ширний үйлдвэр дээр жилийн төлөвлөгөө дээр хоёуланг нь оруулж ирсэн. Энэ бол хоёулаа зөвхөн дэд бүтцийг нь барих юм.

Нэгдүгээрт нь, Дарханы.

Хоёрдугаарт нь, Эмээлтийн.

Тэгээд өмнө нь ерөөсөө ингээд л нэг бол Дархан нь Эмээлтээ үгүйсгээд л, нэг бол Эмээлт нь Дарханыгаа үгүйсгээд л яваад байдаг байсан.

Тэгээд 70 сая малтай байна. Арьс ширээ 2 үйлдвэр дээр хийчхэж болох байлгүй. 2 цогцолбор дээр хийчхэж болох байх гээд аль алиныг нь оруулчихсан байж байгаа.

Дарханыхаа цогцолборыг ч барья, Эмээлтийн цогцолборыг ч барья. Гэхдээ энэ бол зөвхөн дэд бүтцүүдийг нь хийнэ. Бусдыг нь өөрсдөө хувийн хэвшлийн компаниуд өөрсдөө хийгээд явна гэдэг ийм бодлоготой байгаа.

Г.Занданшатар: Цагаанхүү Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Дарханы арьс ширний үйлдвэр маш их хүлээлттэй байгаа.

Ямар ч байсан дэд бүтцийг нь бариад хувийн хэвшилтэй хамтраад цаашаа явах юм байна гэж ойлголоо.

Би Х.Булгантуяа сайдаас Ц.Сандаг-Очир гишүүний асуусан бид янз янзын зээл хөтөлбөрүүд

хэрэгжүүлээд байдаг. Хүртээмж багатай, үр дүн багатай байна гээд 30 жилийн түүх байна.

Тэгэхээр цаашдаа ер нь танай яамны зүгээс ажлын байрыг бий болгоод байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого ер нь юмнууд төлөвлөсөн юм байгаа юу? Энэ туйлын чухал байна. Бидний яваад байгаа зарчим болохгүй байгаа учраас өөр зарчим, өөр бололцоонуудыг нээж өгөх талаар ямар зүйлийг хийж байгаа вэ гэж би асуух гээд байгаа юм.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд бид 2023 онд 15 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байж байгаа.

Таны хэлж байгаа үнэн. Ажлын байрыг бий болгож байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжихгүйгээр бид ажлын байрыг бий болгох боломжгүй юм билээ.

Тэгээд үүнтэй холбоотойгоор бид ажил олгоход хүндрэлтэй байгаа иргэдийг ажлын байраар хангаж байгаа аж ахуйн нэгжүүдийг сар бүр 550 мянган төгрөгийг 4 сарын хугацаанд олгоно.

Эдийн засгийн тэргүүлэх салбарт 800 мянган төгрөгийг 4 сарын хугацаанд олгоно.

Орон нутагт болон алслагдсан 3 дүүрэгт байх юм бол сар бүр 800 мянган төгрөгийг 4 сарын хугацаанд олгоно гээд нийтдээ үүгээр бид 5200 хүнийг ажлын байранд зуучлах юм байна аж.

Тэгээд аж ахуйн нэгжүүдэд бид 15 тэрбум төгрөгийн дэмжлэг олгоно гэж төлөвлөсөн байгаа.

Тэгээд ажил маань хэрвээ амжилттай явах юм бол 2024 онд ч гэсэндээ бид үүний үр дүнг нь харж байгаад нэмэгдүүлж болох байх гэж бодож байна.

Бид сургалтаас гадна ажлын байрыг бий болгосон аж ахуйн нэгжүүдэд ялангуяа КОВИД-ын.../минут дуусав/

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ирэх онд түгжрэлийг 80 хувиар бууруулна гээд өдөр бас нэг хүн нь хариулж байх шиг байна лээ.

Тэгээд жил болгон түгжрэлийг өсгөж явсан нөхдүүд ирэх жил 80 хувиар бууруулна гэдэг нь ямар учиртай юм? Тэр ч худлаа зорилт байх.

Аягүй бол 2024 онд Ардчилсан нам ялчихна. Үлдсэн хагас жилдээ бууруулчихна гэж тооцож байгаа юм уу? Би ерөөсөө ойлгосонгүй.

Тэгэхээр түгжрэлийг бууруулах нэлээн асуудлууд энд орсон байгаа. Тэгэхдээ дээр буцаагаад төвлөрлөө сааруулах талаар ерөөсөө асуудал орохгүй байна л даа. Төвлөрлийг сааруулахын тулд бүсчилсэн хөгжлийн асуудлыг эн тэргүүнд тавих ёстой. Гэтэл яг энэ 2024 оны хөтөлбөр дээр чинь бүсчилсэн хөгжлийн асуудлаар ерөөсөө ганц хоёрхон л өгүүлбэр байж байна.

Тэгээд бүс нутгийнхаа хөгжлийг л сайжруулах талаар ерөөсөө ажил хийхгүй бол энэ төвлөрөл чинь буурахгүй. Төвлөрөл буурахгүй бол яах вэ, түгжрэл

буурахгүй ийм л асуудал гараад байгаа юм.

Тэгэхээр яг энэ хүрээндээ эдийн засгийн газар зүйн асуудлыг яаж шийдвэрлэж байгаа юм бэ? Одоо жишээ нь, аль аль бүс нутагт ямар үйлдвэрлэлийг хөгжүүлэх юм. Тэнд ямар ямар сорсууд байна. Тийм ээ. Тэр бүгдийг тооцож байгаад яг тэр бүс нутагт илүү сайн хөгжсөн тэр үйлдвэрлэлийг хөгжүүлээд тэр дагуу энэ боомтоор ийм ийм экспортыг хийнэ, ийм ийм бүтээгдэхүүн гаргана гэдэг зүйлээ шийдэхгүй болохоор өнөөдөр яаж байна. Бүх экспортын чинь бүх хилийн ачаалал чинь бүгдээрээ хоёрхон боомт дээр очоод зогсчхож байна шүү дээ.

Тэгэхээр дээр энэ бүс нутгийн хөгжлийг илүү сайн шийдсэн том бүтээн байгуулалтын ажил. Мөн түүнчлэн үйлдвэрлэлийн асуудлаа шийдэж шийдэж байж л төвлөрөл нэлээн буурна гэж би хараад байгаа юм л даа.

Энэ дээрээ тодорхой хариулт авья. Эдийн Засгийн газар зүйн асуудлаар.

Дээрээс нь нэг зүйл их буруу яваад байна. Засгийн газар ерөөсөө ялангуяа хил рүү уул уурхайгаас хилийн боомт руу чиглэсэн тэр төмөр замын асуудал дандаа хууль бусаар яваад байна шүү. Монгол Улсын хууль зөрчөөд яваад байна. Монгол Улсын төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого, бичиг баримтын эсрэг яваад байна.

Өөрөөр хэлбэл уул уурхайгаас хил рүү чиглэж байгаа тэр төмөр замын царигийн асуудлыг Засгийн газар өргөн барьснаар Их Хурал шийднэ гэж ийм хуультай.

Гэтэл үүнийг зөрчөөд өнөөдөр Гашуунсухайтын боомт хүртэл өргөн

төмөр замаар тавьчихсан. Ханги, Мандал хүртэл өргөн төмөр замаар тавьсан.

Тэгээд энэ бүтээн байгуулалтууд бүгдээрээ Их Хурлын шийдвэргүй яваад байгаа.

Хэн нэгэн хүн Үндсэн хуулийн цэцэд Засгийн газар хууль зөрчсөн гэдэг асуудлаар хандвал тэгээд чинь унах бүрэн магадлалтай шүү дээ.

Дээрээс нь ямарваа нэгэн шийдвэр гараагүй байж байхад дахиад.

Яах вэ, би нарийн царигийг бол жишээ нь нарийн цариг Хятад руу. Өргөн цариг бол. Тийм ээ. Уул уурхайгаас өргөн цариг Орос руу гарах тэр асуудлыг дэмждэг л дээ.

Гэтэл дахиад нөгөө Их Хурлын шийдвэр гараагүй байж байхад Нарийнсухайтаас Шивээхүрэн хүртэл төмөр замын асуудлыг аль хэдийн шийдвэрлээд явчихсан. Бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл өгчихсөн ингээд явж байх жишээтэй.

Энэ чинь одоо ерөөсөө Засгийн газар бүр ингээд Их Хурлынхаа толгой дээр гараад суучихсан ийм нөхцөл байдалтай байж байна шүү дээ.

Тэгэхээр асуудлуудыг яг хуульд.../минут дуусав/

Г.Занданшатар: Эхлээд Сандагийн Бямбацогт сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд.

С.Бямбацогт: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулья.

2010 онд Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого баталсан.

Энэ бодлогын баримт бичигт хил рүү чиглэсэн, боомтод чиглэсэн төмөр замын царигийн асуудлыг Их Хурал тухай бүрд нь шийднэ. Засгийн газар оруулж ирсэн ийм заалттай.

Энэ заалтын дагуу 2014 онд байх. Н.Алтанхуягийн Засгийн газрын үед Гашуунсухайтын төмөр замыг нарийн царигаар тавихаар билүү дээ. Би буруу ч хэлж магадгүй шүү. Тийм шийдвэр гараад нарийн царигийн төмөр зам баригдах гээд явж байх үед Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргаад үндсэндээ нарийн царигийн төмөр зам барьж болохгүй ээ гэсэн шийдвэр гараад үндсэндээ боомтын чиглэлд өргөн царигийн төмөр замууд тавигдсан. Төмөр зам тавигдсан. Гашуунсухайтын. Ийм байдлаар үндсэндээ өргөн царигийн төмөр зам тавигдсан асуудал ийм байдлаар шийдэгдсэн.

Та сая ярьж байгаа. Уг нь таны зөв өө. Тийм.

Ер нь хилээс боомт руу, Хятад руу нарийн царигтай бол нарийн царигаараа, Орос руу өргөн царигтай бол өргөн царигаар тавиад явсан бол илүү юу гэдэг юм тээвэрлэх хүчин чадал нэмэгдээд, уул уурхайн бүтээгдэхүүн илүү их хэмжээгээр гаргах бололцоо боломж бүрдэх байсан.

Харамсалтай нь, нэгэнт Үндсэн хуулийн цэцээр шийдвэр ингээд гарчихсан учраас өргөн царигаар тавих аргагүй болсон.

Хятад, Монголын хил дээр. Тийм үү. Хилийн зурвас дээр өргөн нарийн царигийг огтлолцуулах, өргөн нарийн царигийн холболтын төмөр замыг барих ийм шаардлага гарсан.

Энэ хүрээндээ үндсэндээ Гашуунсухайтын боомт дээр өргөн, нарийн царигийн төмөр замын хил холболтын төмөр зам барихаар Монгол Улсын Засгийн газар дээр шийдвэр гаргаад.

Яагаад гэвэл ачиж байгаа өргөн цариг, нарийн цариг хоорондоо уулзахгүй учраас үүнийг зөрүүлж хил холболтын төмөр зам барих шаардлага гарсан.

Энэ хүрээнд Гашуунсухайтын төмөр зам дээр үндсэндээ хил холболтын мухар төмөр зам гэж ярьдаг төмөр замыг өргөн, нарийн царигаар холбох зураг төслийн ажлыг хийгдээд тендер шалгараад явж байгаа.

Үүний хажуугаар Бичигт-Зүүнхатавч, нөгөө талдаа Шивээхүрэн-Сэхээ.

Энэ боомтуудын хил холболтын төмөр замуудыг барих. Мөн Оросын Холбооны Улсыг Хятад Улстай Монгол улсаар дайруулж холбох баруун босоо, зүүн босоо төмөр замыг барьж байгуулах ийм ажлууд хийгдэж байгаа. Энэ ажлуудаас сонгон шалгаруулалт хийгдэж байгаа.

Энэ хүрээндээ нэн яаралтай бид энэ ажлыг эхлүүлэх үүднээс Хил холболтын төмөр замын нэг хэсэг нь буюу Шивээхүрэн-Сэхээ боомтыг холбосон 7 километр хил холболтын төмөр замыг эхлүүлэх ажлыг эхэлж байгаа.

Үүнтэй зэрэгцээд босоо. Одоо Шивээхүрэнгээс-Нарийнсухайт-Арцсуурь чиглэлийн өргөн царигийн төмөр зам зэрэгцээд баригдана.

Өөрөөр хэлэх юм бол таны ярьж байгаа энэ асуудал нарийн царигийн

төмөр зам барьж байгаа биш хил холболтын төмөр зам барьж байгаа. Хил холболтын холболтын төмөр замын нэг хэсэг нь юм гэдгийг та ингээд ойлгочхоорой. Баярлалаа.

Г.Занданшатар: Ч.Хүрэлбаатар Шадар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Эдийн засгийн бүсчлэлийн талаар асуусан Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яаман дээр бүсийн хөгжилтэй холбоотой нэлээд хэмжээний судалгаа хийгдчихсэн байгаа.

Яг үүнийг хариуцсан газар ч байгаа. Тэгээд ер нь бүсчлэлийн асуудлуудыг эдийн засгийн агуулга талаас нь аваад үзчихсэн байгаа. Тухайлбал, энэ хэсэгт нь газар тариаланг хөгжүүлбэл илүү оновчтой. Энэ хэсэгтээ аялал жуулчлал. Түүний дотор түүхтэй, соёлтой холбоотой, палеонтологитой холбоотой ийм бүс нь хэрэгтэй байна. Энэ хэсэгтээ уул уурхай хөгжүүлэх хэрэгтэй байна зэрэг бүгдийг нь бүсчлээд нарийвчлаад хийчихсэн зүйл байгаа.

Мөн үүнийгээ уялдуулаад бүс нутгийнх нь хөгжил. Тухайлбал, Хятадтай, Оростой яаж боомтуудаараа харьцаж байж энэ хөгжлүүд явах вэ гээд энэ бүх судалгаануудаа хийгээд бэлэн болгочихсон байгаа юм.

Тэгээд удахгүй бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Тэгэхдээ хамтад нь оруулж ирнэ гэж бэлтгэл ажлаа хийж байгаа.

Үүнийг хийхдээ бас ЖАЙКА-тай хамтраад манай эрдэмтэн мэргэд суугаад нэлээдгүй ажил хийчихсэн байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Б.Пүрэвдорж гишүүн тодруулъя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн 1 минут.

Б.Пүрэвдорж: Гашуунсухайтын төмөр замыг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгосон нь өөрөөр хэлбэл Л.Гансүх гээд тухайн үеийн сайд байсан хүн Засгийн газарт асуудал оруулаагүй байна гэж процедурын зөрчил гарсан байна гээд л үүнийг хүчингүй болгосон.

Тэгэхдээ буцаагаад тэр Засгийн газар юу оруулж ирэх ёстой байсан бэ гэхээр энэ замыг цэц хүчингүй болгосон тохиолдолд дахиад өргөнөөр тавих уу, нарийнаар тавих уу гэдгээ тухайн үед дахиж Их Хурлаар оруулж ирэх ёстой байсан байхгүй юу даа.

Харамсалтай нь тэрийгээ хийхгүй. Одоо ингээд л тийм нэг хувь хүний бодлоор улсын хуулиас дээгүүр асуудалд ханддаг г хэсэг нөхдүүд төрийн өндөрлөгүүддээ байж байсан. Тэр алдааг дахиад битгий давтаад яваад бай. Өөрөөр хэлбэл хөршүүдтэйгээ найрсаг харилцаатай байя, хамтдаа хөгжье л гэдэг энэ зарчим дээр асуудлаа тавиад явах нь хамгийн чухал шүү гэдгийг л хэлье.

Г.Занданшатар: Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тийм. Б.Пүрэвдорж гишүүний хэлж байгаа үнэн.

Гашуунсухайтын төмөр замын тухайд нарийнаар тавьчих бүрэн бололцоотой байсан. Ингэсэн бол улс орны эдийн засагт үр өгөөжтэй байх байсан байх.

Нэгэнтээ тавьчихсан өргөн царигийн төмөр замыг хуулж байгаад

буцаагаад нарийн болговол илүү их зардал гарах байх л даа.

Зүүн босоо, баруун босоо гэж ярьж байгаа бидний Чойбалсан-Хөөт-Бичигт, нөгөөдөх нь Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн гэсэн төмөр зам Оросын Холбооны Улстай шууд холбогдож байгаа учраас өргөн царигаар тавигдаад, нөгөө талаасаа Хятадаас орж ирж байгаа төмөр замтай ачаа бараагаа солилцох учраас өргөн, нарийн царигийн холболтын төмөр замыг хоёуланг нь хилийн бүсэд хилийн зурвас дээр ингэж зөрүүлж барихаас өөр аргагүй болж байгаа юм.

Тийм учраас нэг талдаа нарийн цариг орж ирж байгаа, нөгөө талдаа өргөн цариг маань Хятад Улсын нутаг руу орж байгаа. Ийм байдлаар зөрж тавигдаж байгаа.

Хэрвээ боомтоос шууд Хятад руу чиглэсэн төмөр замаас нарийнаар тавьчих бололцоотой. Ийм ялгаа байгаа.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Эдийн засгийн хөгжлийн сайд нь Шадар сайд болоод ер нь улс орны хөгжлийн төлөвлөгөөг зангидаж орж ирж байгаа би анхны төлөвлөгөө гэж ойлгож байгаа.

Энэ агуулгаараа эдийн засгийн бүхий л салбаруудыг хамруулж оруулж ирсэн байна гэж ингэж харж байна.

Энэ хүрээнд би ирэх жилийн төсөөлөл мэдээж энэ жилийн борлуулж байгаа нүүрстэй холбоотой нүүрсний борлуулалт нэлээн өндөр байна гэж төсөөлж их олон том төслүүд төлөвлөжээ.

Нүүрсний борлуулалттай холбоотой би нэг зүйл асуух гээд байгаа юм.

Одоо манайх яах вэ, ингээд хилийн бүсэд байгаа коксжих нүүрсээ гаргаж байна.

Төвийн бүсэд жишээлэх юм бол энэ Баянтээгийн уурхай, одоо нөгөө Хөвсгөлийн Могойн голын уурхай гээд орон нутгийн эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор тоннын 40 хэдхэн мянгаар борлуулж байгаа нүүрсээ 400, 500 километр шороон зам, засмал замаар тээвэрлээд.

Дээр нь төмөр замын ачааллыг нэмээд асар их хэмжээгээр гаргаж байна. Нөгөө Тавантолгойн нүүрстэйгээ өрсөлдөөд.

Энэ бодлогыг ер нь цаашдаа бид яаж явах юм бэ? Хайран биш үү. 40, 50-хан мянгаар тэндээс нь аваад өчнөөн замаа эвдээд.

Тэгж гаргалаа гээд энэ чинь Монгол Улс ер нь мөнхийн өвөл гэдэг юм байнга байх юм бол.

Орон нутгийн эрчим хүчний нүүрсийг яагаад хямдхан байлгаж байгаа юм гэхээр аймаг болгонд дулааны станц барина. Одоо байгаа дулааны жижиг оврын станцуудын үнийг хязгаарлах зорилгоор л бага үнээр барьж байгаа шүү дээ.

Гэтэл үүнийхээ эсрэг нөөцөө ч бүрэн тогтоогоогүй баахан нүүрс зөөгөөд байгааг ер нь цаашдаа яг яах юм бэ? Энэ яг зөв бодлого мөн үү? Энэ дээр би сайдаас хариулт авмаар байна.

Хоёрт нь, би Н.Учрал сайдаас асуулт асуух гээд байна.

2020 оны сонгуулиар бид Монгол Улсын хэмжээнд бүхий л улсын хэмжээний газруудыг үүрэн холбооны сүлжээгээр аалзны тор шиг хэрнэ гээд амлалт өгсөн. Танай яам үндсэндээ хуучин Харилцаа холбооны яам, Дэд бүтцийн яам.

Өнөөдөр нэг жижигхэн байгууллагуудын мэдээлэл ил гаргах тухай асуудал яриад явж байтал хөдөө орон нутагт сүлжээ байхгүй газрууд асар олон байна.

Уулзалтад очихоор бүх л сумд, багууд дээр сүлжээ байхгүй. Үүрэн холбооны үйлчилгээ авч чадахгүй. Тэр хэмжээндээ цахим мэдээллийг чинь авч чадахгүй байна шүү дээ.

Гэтэл 2024 оны хөгжлийн төлөвлөгөө дээр танай яамтай холбоотой хөрөнгө оруулалт ерөөсөө байхгүй.

Энэ үүрэн холбооны сүлжээнүүдийг түгээхэд улсын төсөв дээр нэлээн хэмжээний мөнгө тавьж байж алслагдсан сум, багуудыг чинь үүрэн холбоонд хамруулах зайлшгүй шаардлага байна.

Тэгэхээр дээр сайд яагаад 2024 оны төлөвлөгөөн дээр олигтой юм тусгасангүй вэ?

Одоо нэгэнт бид төлөвлөгөө хэлэлцэж байгаа юм чинь ер нь зайлшгүй энэ дээр нэлээн хэмжээний мөнгө тавьж байж иргэдийг холбооны сүлжээгээр хангах тал дээр Онцгой анхаарах ёстой. Энэ дээр нэг хариулт авмаар байна.

Дараагийн асуудал нь, Зам тээврийн сайдаас Богд хаан төмөр замын асуудал тавигджээ.

Өмнө нь нөгөө нууц гэрээн дотор бараг 1.5 тэрбум долларын гэрээ хийгдчихсэн явж байгаа. Урьдчилгаа төлбөр ч өгөгдчихсөн. Гэтэл одоо энэ дээр төлөвлөгөөн дээр 368 тэрбум төгрөг тавиад эхлүүлнэ гэсэн байна л даа.

Өмнөх гэрээ хүчингүй болсон уу? Хүчингүй болоод шинээр 368 тэрбум төгрөгийг тавиад тендер зарлах уу? Энэ дээр тодорхой хариулт авмаар байна.

Дараагийн асуудал, энэ мухар төмөр замуудыг та яг хэзээ холбогдохыг нь хэлж өгөөч ээ.

Яг Хятадын талтай Гашуунсухайт төмөр зам дээр яг албан ёсоор тохиргоонд хүрчихсэн үү? Хүрээгүй бол наана тавьсан хайран төмөр зам чинь өчнөөн мөнгө төгрөг.../минут дуусав/

Г.Занданшатар: Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт.

Дараа нь Н.Учрал сайд хариулна.

С.Бямбацогт: Богд хаан төмөр зам 1.4 тэрбум доллароор үндсэндээ барина гээд тодорхой ажлууд хийгдээд эхэлчихсэн байсан.

Тодорхой тооцоо судалгаа хийгээд үзэхээр 1.4 тэрбум доллар биш 600 орчим сая долларт барьчих бололцоо байгаа юм байна гэдэг тийм урьдчилсан тооцоо гарсан.

Гэхдээ үүнийг нарийвчлахдаа тооцоо судалгаа хийгдэж байгаа. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа Улаанбаатар төмөр замаас салаалаад Улаанбаатар төмөр зам буцаад нийлэх ийм төмөр зам. Богд хаан төмөр зам бол.

Энэ төмөр замыг Улаанбаатар төмөр замын 50 хувь нь оросууд эзэмшдэг, 50 хувь нь монголчууд эзэмшдэг. Хоёр улсын 50, 50 хувийн хөрөнгө оруулалттай, өмчлөлтэй.

Тийм болохоор хамтарч хоорондоо ярьж зөвшилцөж байж энэ төмөр замыг барьж ашиглалтад оруулахгүй бол цаашдаа энэ төмөр зам ашиглагдахгүй байх, эргээд эдийн засгийн үр өгөөж муутай байх эрсдэлтэй байсан учраас гэрээг царцаасан байгаа. Урьд нь хийгдсэн үндсэндээ Бодь групптэй хийсэн гэрээг царцаасан байгаа.

Оросын Холбооны Улстай Оросын Холбооны Улсын төмөр замын байгууллагатай харилцан ярилцаад ойлголцоод үндсэндээ урьдчилсан байдлаар Улаанбаатар төмөр зам маань хийлгэе. Харилцан хамтарч энд хөрөнгө оруулалт хийж барья гэсэн иймэрхүү байдлаар урьдчилсан байдлаар тохироонд хүрсэн. Засгийн газрын тогтоол ч ингэж гарсан байгаа.

Энэ хүрээндээ хийхэд мэдээж улсын төсөв дээр тавигдсан 368 тэрбум төгрөг юу гэдэг юм, энэ ажлыг эхлүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгө болохоос энэ төмөр замыг бүрэн барьж байгуулахад шаардлагатай хөрөнгө биш.

Энд гадна дотнын эх үүсвэр, тийм хөнгөлөлттэй зээл, аль болох бололцоо боломжоороо Монгол Улсын эдийн засагт дарамт болохгүй байдлаар шийдэх шийдлүүдийг ийм Монгол Улсын Засгийн газар, Эдийн засгийн хөгжлийн яам бид хамтраад хайж байгаа гэдгийг танд хэлье.

Дараагийнх нь, тэр мухар төмөр зам гээд ярьж байгаа төмөр замуудыг.

Гашуунсухайтын төмөр зам дээр үндсэндээ Ганцмодны төмөр замын хил холболтын төмөр замыг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах тендер шалгараад гүйцэтгэгч компани тодорсон. Богино хугацаанд 3 сарын хугацаанд зураг төслийг нь боловсруулаад үндсэндээ энэ жилдээ багтаад барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Энэ бол 2 жилийн хугацаа шаардах байх юм. Яагаад гэвэл өндөржилт зөрсөн, хил холболтын цэг зөрсөн. Нэлээд ажиллагаа ихтэй байгаа учраас энд хөрөнгө ч их зарцуулна, цаг ч их зарцуулах юм билээ. 2 жил орчмын хугацаа зарцуулах байх.

Одоо баригдсан байгаа Ханги-Мандалын төмөр зам бол харьцангуй богино хугацаанд хурдан хугацаанд Хятадын төмөр замтай мэдээж өргөн, нарийн царигаараа хил холболтын төмөр зам баригдаад хурдан хугацаанд холбогдох бололцоотой байгаа.

Шивээхүрэн-Сэхээгийн төмөр зам үндсэндээ эхний ээлжид бид энэ сардаа багтаагаад хил холболтын төмөр зам Хятадаас наашаа орж ирэх нарийн царигийн төмөр замын ажлыг эхлүүлэх гэж байна. Энэ зундаа багтаагаад бид гуравдугаар улиралдаа багтаагаад өргөн царигийн буюу Оросын Холбооны Улсаас Хятадын хил хүртэлх Монгол Улсын нутгаар дайрсан энэ барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Мөн нөгөө Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ажил үндсэндээ энэ зундаа багтааж төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа. Иймэрхүү байдалтайгаар төмөр замын бүтээн

байгуулалтын ажлуудын явц иймэрхүү байдалтай байгаа гэдгийг танд хэлье.

Г.Занданшатар: Ч.Хүрэлбаатар сайд хариулья. Шадар сайд Ч.Хүрэлбаатар.

Ч.Хүрэлбаатар: Эдийн засгийн хөгжлийн сайд Орос, Монголын Засгийн газрын комиссын хоорондын Монголын талын ахлагч байдаг.

Тэгээд төмөр замтай холбоотой асуудлууд нэлээд яригдаж байгаа. Богд хаан төмөр зам бол тэр нэг аравны хэд ч билээ, 4 тэрбум долларын өртөгтэй хийнэ гэж байгаа энэ зүйлийг Оросын тал огтхон хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.

Яагаад гэвэл нэгдүгээрт үнэтэй. Тэр жоохон замыг их өндөр өнтгөөр барьчихаар нийт Улаанбаатар төмөр замаар тээвэрлэгдэх тээврийн бараа, таваарын үнэ өснө. Энэ нь эргээд их сөрөг нөлөөтэй байна.

Тэгэхээр нэгдүгээрт үнэ буулгана.

Хоёрдугаарт, Улаанбаатар төмөр зам өөрөө барих ёстой. Бид хэрвээ хэн нэгэн хүн барьчхаад холбоно гэвэл холбуулахгүй ээ гэж байгаа юм.

Тэгэхээр бодитой байгуулсан гэрээ бүтэхгүй гэсэн үг. Энэ дээр цэг тавигдсан гэж ойлгож болно.

Тэгээд Улаанбаатар төмөр зам нь үүнийгээ өөрөө хийнэ. Улаанбаатар төмөр зам хийхийн тулд одоогийнх шиг тэр төмөр зам нь өөрөө өчнөөн тэрбум төгрөгийн алдагдалтай. Нэг хурган даргынх нь гэрээс тэрбум тэрбум төгрөг гараад ирээд байдаг. Тэр үнэ тарифынхаа нөхцөлөө л өөрчил гэж байгаа юм.

Тэгээд Улаанбаатар төмөр зам ашигтай ажиллах юм бол тэнд банкууд санхүүжилт өгнө шүү дээ.

Хэн нэгэн нүүрсний компанийг царай алдаад байх шаардлагагүй. Хэн нэгэн компанийг гуйгаад байх шаардлагагүй. Өөрөө ашигтай ажиллаад түүгээрээ замаа хийгээд тэлээд явчих бизнесийн зарчмаараа л ажиллаг. Ийм зарчмыг Засгийн газар барьж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам барьж байгаа гэдгийг хэлбэ.

Дараагийн хоёр дахь асуудал. Эхлээд нүүрс зөөх тухай ярьчихлаа.

Миний өөрийн бодол гэвэл тэр тэгж зөөгөөд ашигтай байж байвал тэгээд буянаараа болог л гэж ойлгож байна. Ашгаа өөрсдөө хувийн хэвшил нь хийнэ. Хувийн хэвшил өөрөө ашгаа олж чадаж байгаа бол бид ороод энэ чинь болно, болохгүй гэх шаардлага байхгүй юм байна л гэж ойлгож байгаа.

Тэгээд нэг л зүйл байгаа. Хувийн хэвшлийнхэн өөрсдөө юмаа хийгээд явуулж байхад бидний зүгээс энэ чинь болно, болохгүй гээд ийм юм хэрэггүй болов уу л гэж ойлгож байгаа.

Тэгээд буянаараа болог.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

Манай улсын хувьд харилцаа холбооны дамжуулах сүлжээ нийтдээ 41 мянга гаруй километр шилэн кабель татагдсан байдаг. Хот хооронд 7200.

Тэгэхээр энэ мэдээж гадаад дотоодын зээлээс гадна тусгай зөвшөөрөл

эзэмшиж байгаа дамжуулах сүлжээг эрхэлж байгаа компаниудын хамтын оролцоотойгоор нийт улсын гуравны нэгд л шилэн кабель хүрсэн гэсэн үг.

Тэгэхээр өнгөрсөн жилийн хугацаанд бид 2022 онд хот хооронд 477 километр, хот суурин газарт 184 километр шилэн кабелийг л шинээр байгуулсан.

Тэгэхээр цаашдаа багуудаар, ялангуяа боомтуудаар шилэн кабелийг байгуулж, интернэтийн хурдыг сайжруулах ажлууд хийгдэх зайлшгүй шаардлагатай. Гэхдээ бид бас энэ оны хувьд улсын хэмжээнд шилэн кабель хүрээгүй 4 сум л байгаа юм.

Тэгэхээр энэ 4 сумыг шилэн кабельд холбож дуусгана.

Тэгэхээр энэ бол бас гадаадын зээлээр хийгдэж байна. Хийгдэж эхэлж байна. Дээрээс нь мэдээж бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаар ч гэсэн зарим багуудыг холбох ажлуудыг хийнэ.

Гэсэн хэдий ч яг энэ алслагдсан багуудаар, зарим боомтуудаар шилэн кабель хүргэх ажил зайлшгүй л төсөв мөнгөтэй холбоотой.

Тэгэхээр үүн дээр ч гэсэн яг хөгжлийн 2024 оны төлөвлөгөөн дээр харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах гэдэг зорилт орсон хэдий ч төсөв мөнгөний хувьд тийм хангалттай биш байгаа.

Тэгэхээр ялангуяа орон нутгаас сонгогдсон гишүүд тэр алслагдсан багуудад шилэн кабелийг хүргээч ээ гэдэг хүсэлтүүдийг их ирүүлдэг.

Тэгэхээр үүн дээр бид их анхаарах зайлшгүй шаардлагатай.

Тэгэхээр нэг ёсондоо дэд бүтцээ сайжруулаагүйгээр цаашдаа цахимжилтийг эрчимжүүлэх мэдээж бэрхшээлтэй.

Гэхдээ салбарын бодлогын хувьд бараг малчны өвөлжөөнд шилэн кабель хүргэх бололцоо байхгүй. Одоо цөөн хүн амтай тэр багт шилэн кабелийг хүргэлээ гээд цаашлаад тэр урсгал зардлыг нь хариуцаад авч явахад нэлээд бэрхшээлтэй учраас харилцаа холбооны салбарт шинэ дэд бүтцийг бий болгох шаардлагатай гэж үзээд нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэх бололцоог олон улсын “SpaceX”, “Starlink”. Цаашлаад бид олон жил ярьсан үндэсний хиймэл дагуул хөөргөх гэсэн шинэ дэд бүтцийн орчныг бий болгоход зайлшгүй бид төрийн эрх барих дээд байгууллага анхаарч ажиллаж байж энэ дэд бүтцийн шинэчлэлийг хийхгүй бол бүх багт шилэн кабелиар дамжуулж хүргэх бол тийм зөв бодлого биш.

Тийм учраас манай салбар сансрын хиймэл дагуул хөөргөх, нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхэлж байгаа олон улсын байгууллагуудын дэмжлэгийг эх орондоо оруулж ирэх ажил дээр нэлээдгүй анхаарал хандуулж ажиллаж байгаа.

Тэгээд тун удахгүй Их Хурлаар энэ асуудлуудыг оруулж танилцуулж, шинэ дэд бүтцийг бий болгох ажил дээр онцгой анхаарна гээд хэлмээр байна.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууна.

Г.Ганболд: Ч.Хүрэлбаатар сайдын хэлснээр би одоо ингээд Бодийн гэрээ цуцлагдсан юм байна. Урьдчилгаа өгсөн 60 сая доллароо эргүүлж авах юм байна гэж ойлголоо.

Тэгэхдээ Эдийн засаг, хөгжлийн сайд саяын хариултад тэр орон нутгийн нүүрсийг гаргана гэдгээр аягүй буруу юм ярьж байна. Та. Жоохон нөөцтэй юмаа одоо зөөгөөд орхичхоор дараа нь бүгдээрээ дулааны станцууд бариад хөлдөөд үхнэ шүү дээ. Энэ Монголчууд чинь.

Тийм учраас нөөцийг нь тогтоож байж төр нэгдсэн бодлогоор явахгүй бол 10-хан сая тонны нөөцтэй нүүрсийг одоо гаргаад явчихаар чинь сүүлд нь бүгдээрээ орон нутагтаа төлөх нүүрсгүй болно шүү дээ. Үүнийг төр бодлого гаргахгүй бол одоо яагаад ч болохгүй.

Та хариуцлагагүй юм ярьж болохгүй шүү.

Би С.Бямбацогт сайдаас та яг одоо энэ мухар төмөр замуудыг яг хэзээ оруулахыг та хугацааг нь хэлээч.

Хятадын тал яг зөвшөөрсөн юм уу? Яг зөвшөөрсөн үү? Хэзээ гэхэд яг ашиглалтад орох вэ? Тэрийг яг та хугацаатай надад хэлээд өгөөч.

Г.Занданшатар: Эхлээд Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

Ч.Хүрэлбаатар: Яах вэ, хариуцлагагүй гэж.

Орон нутгийн юм бол орон нутагтаа яриад шийдчихмээр байх юм. Зүгээр хувийн хэвшлийнхний хийж байгаа зүйл би хувийн хэвшлийнхний юмыг хааж боогоод хэрэггүй болов уу л гэж үзэж байгаа юм.

Төрийнх бол төрийнхөө шийдвэрийг гаргачихна биз. Бодвол орон нутгийн өмчит компани байгаа байх. Тэндээ орон нутагтаа асуудлаа шийднэ

биз дээ. Бүгдийг нь энэ танхимд ярьж шийднэ гэж байхгүй шүү дээ. Ийм л юм хэлье.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Яг мухар гэж хэлж байгаа төмөр зам бол Гашуунсухайт, Ганцмодны төмөр зам байгаа.

Нөгөөдөх нь Ханги, Мандалын төмөр зам байгаа. Одоо баригдчихсан байгаа.

Гашуунсухайт, Ганцмодны төмөр зам бол яг бүрэн терминалаар баригдаад ашиглалтад ороод бүрэн хүчин чадлаар үйл ажиллагаа явуулахад 2 жилийн хугацаа хэрэгтэй.

Энэ жилдээ бүтээн байгуулалтын ажил эхэлнэ. Ханги, Мандалын төмөр замын тухайд бид Хятад Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1955 онд төмөр замын хэлэлцээр байгуулсан байдаг.

Энэ хэлэлцээрт нэмэлт оруулж Ханги, Мандалын төмөр зам, Шивээхүрэн, Сэхээгийн төмөр зам, нөгөө Бичигт, Зүүнхатавчийн төмөр зам гээд Гашуунсухайт, Ганцмод, энд 4 боомтын төмөр замыг нэмэх ёстой.

Энэ хэлэлцээрийг Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үед үндсэндээ бүгдийг нь төмөр замын хэлэлцээрт тусгах бодолтой байгаа.

Ингэсний дараа үндсэндээ хэрвээ тусгаж айлчлал амжилттай болж, хэлэлцээр амжилттай болох юм бол Ханги, Мандалын төмөр зам энэ жилдээ ер нь ашиглалтад орно.

Г.Занданшатар: Гүйцээж хариулах уу? С.Бямбацогт сайд. Сандагийн Бямбацогт сайд гүйцээж хариулъя.

С.Бямбацогт: 1955 оны хэлэлцээрт бид нэмэлт, өөрчлөлт оруулаад хэлэлцээрээ байгуулж чадвал энэ жилдээ Ханги, Мандалын төмөр зам ашиглалтад орно. Маш богинохон хугацаанд ашиглалтад орно.

Яагаад гэвэл эхнээсээ төлөвлөлт нь зөв байсан учраас хурдан хугацаанд бага зардлаар ашиглалтад орох бололцоотой байгаа.

Гашуунсухайт, Ганцмодны төмөр зам холболтын цэг зөрсөн, өндөржилт зөрсөн, маш богинохон хоёр талаасаа төмөр зам ойрхон ирчихсэн байгаа мөртлөө маш өндөр зардал гарахаар, их хугацаа зарцуулахаар.

Гүүрэн байгууламж, стакадтай. Нэлээд их хөрөнгө зарахаар байгаа учраас энд 2 жилийн хугацаа шаардлагатай байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Даваажанцангийн Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгээд сая сайд нарын мэдээлэл дотроос нэг зүйлийг харж байхад тэр мухар замууд. Жишээ нь, Гашуунсухайтын төмөр зам 2 жилийн дараа холбогдоно гэж ярьж байна шүү дээ.

Тэгээд бидний ялангуяа коксожсон нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр унаад байгаа. Цаашдаа унаж магадгүй байна. Тэгээд энэ тохиолдолд бид тэгээд тэр нэг мухар төмөр замын төлбөрийн тэр нүүрсийг өнөөдрийг хүртэл хилээр ачсан хэвээрээ л байгаа шүү дээ.

Тэгээд тэр төмөр замын өртөг нь хэд дахин нугалчихсан тийм өндөр өртөгтэй. Дээр нь луйвар явчихсан.

Энэ чинь бас тэгээд нэгэнт л тэр нэлээн хэсгийг нь гаргаад авчихсан тэр нөхдүүдийн нүүрсийг нь зогсоох хэрэгтэй шүү дээ. Тэгээд нөгөө офтэйкийн гэрээнд төлж байгаа тэр нүүрсийг нь зогсоох хэрэгтэй шүү дээ.

Тэр төмөр замаа хэзээ ашиглалтад оруулж тээврээ хийнэ. Тэр үед тэр Бодийн нүүрсийг нь зөөх ёстой байхгүй юу. Тийм хатуу байр суурьтай байхгүй тэгээд л ингээд аргалаад л, Засгийн газрын нөхдүүдийг л аргалаад л. Тэр дагуу тээврээ хийгээд яваад байх юм бол дараа дараагийнхаа том бүтээн байгуулалт.

Ер нь маш тийм буруу жишиг тогтоогоод л явна шүү дээ.

Ер нь өнөөдрийн хувьд эдийн засаг хүндэрчихсэн, хүмүүсийн амьдрал хэцүү, орлого хэцүү ийм нөхцөлд тэр төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд ялангуяа энд тэндхийн төлбөр биш яг төсөвт орж ирэх ёстой тэр 1072 хувьцаанд ногдож ард иргэдэд хувьцаа болж очих ёстой, ногдол болж очих ёстой тэр орлогоо л сайжруулах нь бидний хувьд чухал байгаа шүү дээ.

Тэгээд өнөөдөр өндөр үнэтэй байгаа үед бүх нүүрс тэр нэг ганцхан компанийн төлбөр болоод ингээд гараад

байдаг. Гэтэл ард түмэн нь амьдрал хэцүүдээд байдаг. Ийм сувдаг сэтгэлээр асуудалд хандаж болохгүй шүү дээ.

Тэгээд би энэ Засгийн газрын нөхдүүд нэг ийм томоохон компанийн том мөнгөн дээр очоод л бүдрээд байх шиг харагдаад байх юм. Жоохон хатуу бай л даа. Хангалттай ашгаа олчихсон шүү дээ.

Тэгээд дахиад л тэр тээврээ хийгээд л дайраад байх юм. Төмөр зам нь хэзээ ашиглалтад орно тэр үед хамгийн түрүүн нүүрсээ өдөр болгон зөөсөн ч хамаагүй түүгээрээ зөөгөөд л тэгээд мөнгөө олцгоо.

Бусдаар өнөөдөр тэр төмөр замаар нүүрс явахгүй тохиолдолд тэр төмөр замын төлбөрийг хийгээд бид Монголын ард түмэнд орох ёстой, очих ёстой тэр хөрөнгө мөнгө бүгдээрээ нэг тийм сувдаг нөхдүүдийн орлого болоод байж болохгүй шүү дээ.

Энэ дээрээ Засгийн газар хатуу байгаарай л гэж хэлмээр байна.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа.

2024 онд улс орноо хэрхэн яаж хөгжүүлэх вэ гэдэг бодлогоо өнөөдөр бид ярьж байна.

Мэдээж хэрэг бүтээн байгуулалтууд, зам харгуй, байшин барилга олон амжилтууд байна.

Дээр нь 2023 оны эхний улиралд төсвийн орлого 600 тэрбумд хүрч, эдийн засгийн өсөлт 7.6 хувьд хүрсэн ийм сайхан мэдээлэл байна.

Одоо бид 2024 оныхоо хөгжлийн бодлогодоо хүн амынхаа ахуй амьдрал, авч байгаа цалин, ахмадын тэтгэвэр гээд олон асуудалд анхаарахгүй бол өнөөдөр сүүлийн үед өрнөж байгаа асуудлууд ард түмний ахуй амьдрал их хүндэрснийг харуулж байна. Энэ бол ямар нэгэн улс төр, ямар нэгэн поприлт биш ээ.

Ээжүүд хүүхдийн мөнгийг жигд өгөхийг шаардаж байна.

Түүнээс гадна өнгөрсөн хугацаанд өгөөгүй мөнгөнүүдийг нөхөн олгохыг шаардаж байна. Соёлын салбарынхан маань цалин, мөнгөний асуудал ярьж байна. Ахмадууд маань тэтгэврийн зөрүүг мөн ярьж байна. Тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх асуудлыг шаардаж байна.

Энэ бол зөвхөн шаардлагын асуудал биш. Эдгээр асуудлыг шийдвэрлэхгүй бол ард түмний амьдрал маш хүндэрсэн. Энэ бол сая сонгуультай, сонгуулийн тогтолцоотой холбоотой Үндсэн хуульд оруулах гэж байгаа өөрчлөлтийн асуудлаар ард иргэдтэй уулзахад энэ Үндсэн хуультай холбоотой асуудал гэхээсээ илүүтэй ард түмэн, ахуй амьдрал, авч байгаа цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө. Энэ асуудлаа их ярьж байна.

Тийм учраас бид нэгэнтээ эдийн засаг маань өсөж байгаа, төсвийн орлого маань 600 тэрбум, эхний улиралд ийм дэвшил байгаа цаг үед төсвийн тодотголыг яаралтай хийж саяын асуудлуудыг шийдвэрлэхээс өөр арга зам байхгүй.

Одоо тэвчээрийн хүлээс тайлагдаж байгаа юм байна. Цаашдаа энэ чигээрээ байгаад байх ямар ч боломжгүй болсон учраас иргэд маань хөдөлж байна, асуудлыг тавьж байна, шаардаж байгаа.

Тэр дундаа ахмадын тэтгэврийн доод хэмжээг 350 мянгыг 500 мянга болгосон.

Ингэхдээ 450-иас 80 мянга 500 гаруйг авч байсан ахмадуудын маань тэтгэвэр тэтгэврийн доод хэмжээтэй ижилхэн болсон.

Ингээд 80 мянган хүний асуудал байна. Саяын уулзалтууд дээр мөн үүнийгээ нэлээн гаргаж тавьж байна лээ.

Тэгээд бид бүлэг дээрээ асуудлыг ярьж байна. Манай нам бол бас бодлоготой, эдийн засгийнхаа нөхцөл байдлыг харьцангуй гайгүй болоод ирэхээр нь энэ асуудлыг ярьж гээд одоо ярьж эхэлсэн. Үүнийг ард иргэд маань мэдээлэл авсан байх гэж бодож байна.

Тэгэхдээ цаг хугацаа алдмааргүй байна. Төсвийн тодотголын асуудлыг яаралтай оруулж ирж ахмадын тэтгэвэр, хүүхдийн мөнгө, энэ цалингийн асуудал. Эдгээрийг шийдвэрлэх шаардлагатай. Х.Булгантуяа сайд гараад явчихлаа.

Х.Булгантуяа сайд соёлын салбарынхны цалинг эрүүл мэндийн салбарынхантай дүйцүүлж шийднэ гэж балай юм ярьж байна лээ.

Эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, энэ салбарын ажилтнуудын ажлын онцлог, мэргэжлийн эрсдэл, ажлын хүнд хэцүү нөхцөлтэй холбоотой байдаг юм.

Үүнийг соёл, урлагийн салбартаа тэгшитгэн дүйцүүлнэ гэдэг ийм зүйл хэрхэвч ярьж болохгүй.

Тийм учраас үүнийг Засгийн газар би анхааралдаа аваасай гэж хүсэж байна.

Миний хэлэх гэж байгаа гол зүйл бол 2024 онд хөгжлийн бодлогодоо хүнийхээ бодлогыг илүүтэй харах, төсвийн тодотголоо яаралтай оруулж ирж, ард иргэдийн энэ шаардаж байгаа асуудлыг яаралтай шийдвэрлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Уг нь сайд нарын оролцоог шаардаад хойшлуулчихъя гэж бодсон юм.

Маргааш өглөө 09.00 цагт Эдийн засгийн байнгын хороо анхны хэлэлцүүлэг хийхээр зарлагдчихсан юм байна. Шийдвэрлэсэн.

Тэгээд анхны хэлэлцүүлгээрээ сайн ярих хэрэгтэй. Сайд нар энэ дээрээ ажил хэрэгч оролцох хэрэгтэй.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Мэдээлэх нэг асуудал байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу хуулийн төслийг хэлэлцүүлгийн

Хуралдаан 7 цаг 25 минут үргэлжилж, 22 цаг 55 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

аль ч шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг ирүүлснээр татан авсанд тооцно гэж тооцсон.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Энэ асуудал дууссан.

Засгийн газраас хуулийн төсөлд татан авах тухай бичиг ирүүлж Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Улсын Их Хуралд 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг татан авч байгаагаа үгээр мэдэгдэж байна.

Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ гэсэн байна.

Ингээд хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо. /алх цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Ц.АЛТАН-ОД